



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЖУРАМ, ЗААВРЫН ЭМХЭТГЭЛ 2017-2020

Газрын харилцааны салбарын мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага

Улаанбаатар хот

2020 он

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЖУРАМ, ЗААВРЫН ЭМХЭТГЭЛ 2017-2020

Газрын харилцааны салбарын мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага

Хянан тохиолдуулсан: ГЗБГЗЗГ-ын ГЗБХ-ийн мэргэжилтэн
С.Энх-Эрдэнэ,
ХТБХ ТББ-ын ажилтан Б.Сувд

Дизайнер: Ч.Амарзаяа

Хэвлэлийн эх бэлтгэгч: Г.Лхамжав

Цаасны хэмжээ: 70x100/16

Хэвлэлийн хуудас: 8.3 хх



“Соёмбо Принтинг” ХХК-д
хэвлэв.

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хэвлэн олшруулахыг хориглоно.

ГАРЧИГ

1. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй
2. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах явцад олон нийттэй зөвлөлдөх гарын авлага
3. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам
4. Аймаг, Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөмж
5. Баг, хорооны хилийн заагийг тодорхойлох, баталгаажуулах заавар
6. Хилийн цэсийн маргаан шийдвэрлэх заавар
7. Хилийн цэсийн зургийг хадгалах, ашиглах, өөрчлөлтийг тусгах журам

СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГАЗҮЙ



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/134


Улаанбаатар хот

Арга зүйг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23.2.12 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй"-г хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. "Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй"-г аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон мэргэжлийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Газар зохион байгуулалтын хэлтэс /Ж.Батсайхан/-т даалгасугай.
3. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахдаа энэхүү арга зүйг мөрдөж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын Газрын даамалд тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулсан Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/278 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ц.ГАНХҮҮ

03 191604

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө гэсэн түвшинд боловсруулагдан хэрэгжиж байгаа бөгөөд эдгээр төлөвлөгөөнүүдэд хоорондын уялдаа холбоо муу, хэрэгжилт хангалтгүй зэрэг асуудлууд амьдрал дээр байсаар байна.

Мөн газар, байгалийн нөөц баялгийг ашиглаж буй олон хэлбэр шинээр үүсч, эдийн засгийн эргэлтэд орж, орон нутгийн хөгжил, ард иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлж байгаа боловч экологийн хувьд эмзэг тогтоцтой газарт үзүүлэх аливаа ачаалал, сөрөг нөлөөлөл нэмэгдсээр байна.

Иймд газар, байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалтыг хамгийн үр ашигтай, зүй зохистой байлгах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлсэн, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичиг боловсруулах зайлшгүй шаардлага бий болж, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйг боловсруулав.

1.1 “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө” боловсруулах эрх зүйн үндэслэл

МУ-ын “Газрын тухай хууль”-ийн 24 дэх зүйлийн 24.1-д заасан Газар зохион байгуулалтын цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх, “Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль”-ийн 18 дахь зүйлийн 18.1.2-ын “з”-д заасан Нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглах, үржил шимийг нь дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах бусад арга хэмжээний цогцолбор хөтөлбөрийг батлах, “е”-д заасан Бүсчилсэн хөгжлийн стратегитэй нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжил, хэтийн төлөвийг уялдуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх зэрэг заалтуудыг үндэслэл болгов.

1.2 Арга зүйн зорилго.

Тухайн сумын байгалийн нөөц, нөхцөл, газар ашиглалтын онцлог, нийгэм, эдийн засаг, соёл, амьдралын уламжлалт хэв маяг, онцлогийг судлан тодорхойлж, газар ашиглалтын хэрэгцээт болон тохиромжтой байдлын үнэлгээнд үндэслэн иргэд, олон нийтийн оролцоотойгоор нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, бусад бодлогын баримт бичигт тулгуурласан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад энэхүү аргазүйн зорилго оршино.

1.3 Нэр томьёоны тайлбар

“Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө” гэж Улс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан

газар, байгалийн нөхцөл, нөөц, нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, орон нутгийн уламжлалт онцлогт нийцүүлэн олон төрөлт газар ашиглалтыг хөгжүүлэх, газрын нөөцийн үр өгөөж, бүтээмжийг дээшлүүлж урт хугацаанд тогтвортой ашиглахын зэрэгцээ экологийн тэнцвэрт байдлыг хангах замаар нутаг дэвсгэрийн тогтвортой хөгжлийг дэмжсэн дунд хугацаанд хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлнэ.

“Зүй ёсны эрх” гэж уламжлалт мал аж ахуйд голлон түшиглэж тухайн нутаг дэвсгэр дахь байгалийн бүхий л төрлийн нөөцийг түүний нөхцөлд дасан зохицож, арвижуулан, өсгөж, хамгаалж зүй зохистойгоор хэрэглэж ирсэн хараахан баталгаажгаагүй байгаа уламжлалт эрх, албан бус эрх /төрийн болон иргэдийн хэрэглэж буй эрхүүд/, тэдгээрийн дагалдах эрхүүдийг ойлгоно.

“Байгалийн нөөц” гэж байгаль орчны бүрэлдэхүүний хэсэг болох эрчим хүч, ус, эрдэс баялаг, ургамал, амьтныг хэлнэ. Байгалийн нөхцөл” гэж байгалийн аливаа юмс үзэгдлийн үүсэх, хөгжих, оршин байхад нөлөөлөх хүчин зүйлсийг хэлнэ.

1.4 Хамрах хүрээ

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө нь тухайн сумын газар нутгийг бүрэн хамарна.

1.5. Хугацаа

Тухайн сумын нийгэм эдийн засгийн нөхцөл, хөгжлийн бодлого болон дээд шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилттэй уялдуулж сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө /Цаашид нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө гэх/-г 5-7 жилд шинэчлэн боловсруулна.

1.6. Баримтлах зарчим

- а. Иргэдийн аюулгүй орчинд, сайн сайхан амьдрах нөхцөлийг хангах;
- б. Иргэд, олон нийтийн оролцоотой, хэрэгжихүйц байх;
- в. Байгаль орчинд ээлтэй байх;
- г. Үр ашигтай байх;
- д. Орон нутгийн болон хувь хүний өрсөлдөх чадварыг дэмжсэн байх;
- е. Ил тод нээлттэй байх;
- ё. Хяналт, үнэлгээ хийх боломжтой байх;

Улс, орон нутгийн хөгжлийн бодлого, хэтийн зорилт, хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ, үр дүнг хангахад чиглэсэн байх;

- ж. Оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөсөн байх;
- з. Төлөвлөгөөний зураг төсөл түүнтэй холбоотой бусад суурь

судалгааны мэдээллүүд нь геодезийн байрлал, өндрийн нэгдсэн тогтолцоонд зохиогдсон байх.

1.7. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, тодотгох, өөрчлөлт оруулах асуудлыг сумын газрын даамал, аймгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлын захиалагч нь ажлын даалгавар боловсруулахдаа аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай хамтран боловсруулах бөгөөд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг албан ёсоор авна.

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий мэргэжлийн байгууллага /цаашид “мэргэжлийн байгууллага” гэх/ гүйцэтгэнэ.

Аймгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон сумын даамал нь Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг боловсруулах явцад хээрийн судалгаа, тодруулгын ажилд газар дээр нь хяналт тавих, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймаг, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулах талаар гүйцэтгэгчийг заавар, удирдамжаар хангаж, орон нутагт хурал, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулахад гүйцэтгэгчтэй хамтран ажиллана.

ХОЁР. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ҮЕ ШАТ

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил нь дараах үе шаттай байна. Үүнд:


1. Бэлтгэл ажил;
2. Хээрийн судалгаа (Олон нийтийн оролцоотой судалгаа, хэмжилт зураглал, тодруулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ);
3. Судалгааны үр дүнг нэгтгэх, төлөвлөгөөний эхний хувилбар /төсөл/-ыг боловсруулах;
4. Багийн Иргэдийн нийтийн хурлаар төслийг хэлэлцүүлэх;
5. Төлөвлөгөөний сүүлийн хувилбар /төсөл/-ыг боловсруулах, төслийг иргэдэд нээлттэй байршуулж санал авах;
6. Улсын газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад төслийг хүргүүлж, дүгнэлт гаргуулж холбогдох засварыг хийх;
7. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлаар батлуулах, холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөх;

8. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, мониторинг хийх.

ГУРАВ. БЭЛТГЭЛ АЖИЛ

Бэлтгэл үе шатанд дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний материалуудыг цуглуулах, уялдуулах;
2. Улс, бүс, аймаг, орон нутгаас баталсан хөгжлийн бодлогын баримт бичигболон гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны тайланг судлах, уялдуулах;
3. Байгалийн нөхцөл, нөөцийг судалж, үнэлэх;
4. Газар ашиглалтын судалгаа, үнэлгээ хийх;
5. Нийгэм, эдийн засгийн мэдээ цуглуулах;
6. Иргэд, олон нийтийн оролцоог хангах асуулга, санал авах хуудас, суурь зураг, бичгийн хэрэгслийг бэлтгэх гэх мэт ажлууд багтана. Бэлтгэл ажлын үе шатыг схем/1/-ээр харуулав.



Схем 1.Бэлтгэл ажлын үе шат 1

Эдгээр ажлуудтай холбоотой баримт бичиг, тайлан, өгөгдөл, суурь, зураг, мэдээллийг баталгаатай албан ёсны эх сурвалжаас, хамгийн сүүлийн үеийн байдлаар, орон нутаг болон холбогдох байгууллагуудаас авна.

3.1. Байгалийн нөөц, нөхцөл, төрх байдлыг судлах

1. Улс, аймаг, сумын нутаг дэвсгэр дээр хийгдэж байсан бүх төрлийн байгалийн нөөц, нөхцөл, төрх байдлын судалгааг судалж, нэгтгэн

газарзүйн мэдээллийн системийг ашиглаж, тоон хэлбэрт оруулж, сэдэвчилсэн зургийн эхний хувилбарыг бэлтгэнэ.

2. Сэдэвчилсэн зураг хийхдээ дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу зураглана. Үүнд:

а. Уур амьсгалын үзүүлэлтэд олон жилийн дундаж хур тунадас /мм/, агаарын болон хөрсний температур / $^{\circ}\text{C}$ /, агаарын чийгшил, агаарын даралт, шороон болон цасан шуургатай өдрийн тоо, ерөнхий салхины чиглэл, жилийн дундаж хурд, цасан бүрхүүлтэй өдрийн тоо, нартай өдрийн тоо багтана. Олон жилийн дунджийг 10-аас дээш жилийн дунджаар, жилийн үзүүлэлтийг сүүлийн 5 жилээр тооцож зураглана.

б. Газрын гадаргын төрх байдлын үзүүлэлтэд өндөржил, налуужилт, байршлын зүг чигийг үзүүлэх бөгөөд 30 метр болон түүнээс өндөр нарийвчлалтай тоон өндрийн загвар /DEM/-ыг ашиглаж өндөржилтийн зургийг 100 метрийн интервалтайгаар, зүг зовхисийг 45 градус /жишээ нь зүүн хойд зүг 22.5-67.5 градус/-ын интервалтайгаар, налуужилтыг 0-3, 3-5, 5-10, 10-12, 12-оос дээш гэсэн градусуар тус тус зураглана.

в. Усан хангамжийн үзүүлэлтэд гадаргын болон гүний усны мэдээлэл, усны ай сав, хагалбар, гол мөрний урсцын эх бүрэлдэх газар зэрэг усан сан бүхий газрын мэдээллийг байр зүйн зураг, агаар, сансрын зураг болон холбогдох судалгаа шинжилгээний материалаас авч зураглана.

г. Зэрлэг амьтны төрөл, зүйл, ерөнхий тархац, байршлын үзүүлэлтээр зураглана.

д. Ургамлын үзүүлэлтэд эмийн, үйлдвэрлэлийн, ахуйн /арц/, хүнсний /зэрлэг сонгино, мөөг, таана хүмүүл, зэрлэг жимс, жимсгэнэ, самар гэх мэт/ зориулалтаар ашигладаг ургамлын тархцыг зураглана.

е. Малын бэлчээр, ан амьтдын идээшлэх, шилжилт хөдөлгөөн, өсч үржих газар нутаг, бэлчээрийн төрөл, ургамлын экологийн үндсэн хэв шинж, чадавхын хил заагийг зураглана.

ё. Хөрсний үзүүлэлтэд хөрсний хэв шинж, механик бүрэлдэхүүн зэргийг зураглана. Монгол орны 1:100000 масштабтай хөрсний зургийг ашиглана.

ж. Бэлчээрийн экологийн чадавхийг зураглана. “Монгол орны бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварууд” болон “Бэлчээрийн экологийн чадавхийг зураглах заавар”-ын дагуу зураглана.

з. Газар хөдлөлт, байгалийн гамшиг, аюултай үзэгдлийн давтамжийг зураглана. Үүнд гамшигт үзэгдэл болж байсан байршлууд, үер, ган, зуд, газар хөдлөлт гэх мэт зүйлсийг хамруулна.

3.2. Газар ашиглалтын судалгаа

Сумын нутагт өмнө хийгдэж байсан газар ашиглалттай холбоотой судалгааны тайлан, газрын нэгдмэл сангийн тайлан, газрын кадастрын мэдээллийн сангийн бүртгэл, бусад мэдээллийг цуглуулж, хөдөө аж ахуй, тусгай хэрэгцээ, ой, усны сан бүхий газар, зам шугам сүлжээний газар ашиглалтыг зориулалт бүрээр 1:100000, 1:50000, 1:25000, 1:10000 масштаб, хот суурингийн газар, аялал жуулчлалын газар, уул уурхайн газар, хөдөө аж ахуйн суурин газарт 1:10000, 1:5000, 1:1000 масштаб зэрэг харгалзах хамгийн том масштабтайгаар сэдэвчилсэн зургийн эхний хувилбарыг бэлтгэнэ.

Дараах газар ашиглалтын төрлүүдийг тогтсон масштабтайгаар зураглана.

- Тухайн хот, суурин газар нь улс, бүс нутгийн дэд бүтцийн сүлжээнд холбогдсон байдал, байршлын тойм зургийг 1:25000 масштабтай,
- Ухагдаж эвдэрсэн газар, хог хаясан газар, оршуулгын газар, нийтийн эдэлбэрийн газар зэрэг хот, суурин газрын хил заагт ашиглагдаж байгаа газрын мэдээллийг 1:2000 масштабтай,
- Улсын болон орон нутгийн чанартай замыг сансрын зураг ашиглан 1:10000 масштабтай,
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчилж, ашиглаж, эзэмшиж байгаа газрын /нэгж талбар бүрийн/ байршил хэмжээ, төрийн байгууллагуудын эзэмшил газрын байршлыг 1:1000-1:5000 масштабтайгаар зураглана.

Эрх зүйн харилцаа үүссэн газар ашиглалттай холбоотой мэдээллийг “Газрын кадастрын мэдээллийн сан ажиллуулах журам”-ын дагуу авна. Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй, эсвэл шинээр бий болсон газар ашиглалтыг бүртгэж, зурагжуулах кадастрын нэмэлт судалгааг “Кадастрын зураглалын аргачилсан заавар”-ын дагуу хийж гүйцэтгэж болно.

3.3. Нийгэм, эдийн засгийн мэдээ цуглуулах

Хээрийн судалгааны үе шатанд хийгдэх нийгэм, эдийн засгийн судалгаанд ашиглагдах мэдээг байрлалд суурилсан “Нийгэм, эдийн засгийн мэдээллийн сан” болон холбогдох байгууллагуудаас авч, цуглуулна.

3.4. Хээрийн судалгаанд бэлтгэх

Хээрийн судалгаанд ашиглагдах дараах тоног төхөөрөмж, програм хангамж, хэвлэмэл хуудсыг бэлтгэнэ. Үүнд:

Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл:

- Зөөврийн компьютер;
- Проектор;
- Зургийн аппарат;
- Байршил тодорхойлогч багаж /GPS/ гэх мэт.

Програм хангамж:

- ArcGIS 10.0 <;
- AutoCAD 2010 <;
- QGIS 2.0 < гэх мэт.

Суурь зураг:

Сумын газар ашиглалтын зургийг 1:100000-1:1000 масштабтай байр зүйн зураг болон агаар, сансрын зураг дээр нууцлалын шаардлагад нийцсэн зургийг сум, баг бүрээр хэвлэж бэлтгэнэ.

- Аймаг, сум, багийн хил, зааг;
- Хот, суурин газрын нэгж талбарын зураг;
- Авто замын зураг;
- Тариалан, атаршсан газрын зураг;
- Хадлангийн газар ашиглалтын зураг;
- Уул уурхайн ашиглалт, хайгуулын талбайн зураг;
- Өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны байршил;
- Гадаргын ус /худаг, булаг, шанд, гол горхи, нуур тойром, хөв цөөрөм/;
- Улсын болон орон нутгийн хамгаалалтай газрын байршил;
- Улсын тусгай хэрэгцээний газрын зураг;
- Элэгдэл эвдрэлд орсон газар;

Сумын бэлчээр ашиглалтын зургийг 1:100 000 масштабын байр зүйн зураг болон сансрын зураг дээр сум, баг бүрээр хэвлэсэн байна.

- Аймаг, сум, багийн хил, зааг;
- Хадлангийн газар ашиглалт;
- Тариалан, атаршсан газрын зураг;
- Уул уурхайн ашиглалт, хайгуул;
- Улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар;
- Өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны байршил;
- Ан амьтны тархац, байршил;
- Ойн сан бүхий газрын зураг;
- Гадаргын ус /худаг, булаг, шанд, гол горхи, нуур тойром, хөв цөөрөм/;
- Бэлчээрийн ашиглалтын хэсгийн зааг;
- Бэлчээрийн улирлын зураг;
- Эрчимжсэн аж ахуйн зураг;

Хэвлэмэл хуудас:

- Хээрийн хэмжилт, судалгаа хийх хуудас;
- Санал, асуулгын судалгааны хуудас;
- Уулзалт, ярилцлагад оролцсон хүмүүсийн бүртгэлийн хуудас;
- Хэлэлцүүлэгт оролцсон хүмүүсийн бүртгэлийн хуудас;

ДӨРӨВ. ХЭЭРИЙН СУДАЛГАА, ТОДРУУЛАЛТ, УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГА, ИРГЭД ОЛОН НИЙТИЙН САНАЛ АСУУЛГА, БҮЛГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Иргэдийн оролцоог төлөвлөлтөд тусгах, оролцоог хангах чиглэлээр хээрийн судалгаанд хийх ажлыг тоймлон схем/2/-ээр дүрслэн харуулав.



Схем 2. Иргэд, олон нийтийн оролцоо

4.1. Иргэд, олон нийтийн оролцоо

Хээрийн судалгаа хийхдээ нутгийн удирдлагуудтай уулзалт, иргэд, олон нийттэй ярилцлага зохион байгуулж, тэдэнд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний талаар мэдээлэл өгч, үүнээс гарах үр дүн, ач холбогдол, үр өгөөжийг танилцуулж ойлгуулна.

Иргэд, олон нийтийн саналыг нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгахдаа, уулзалт, ярилцлага, бүлгийн хэлэлцүүлэг, санал асуулгын судалгаа авах зэрэг аргуудыг ашиглах ба “Социологийн судалгааны арга зүй, аргачлал”-ыг ашиглана.

1. Уулзалт: Уулзалтыг сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, төлөөлөгчид, газрын даамал, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, цаг уурын мэргэжилтэн, мал үржлийн тасгийн мэргэжилтэн /малын эмч/ болон сумын холбогдох мэргэжилтнүүд зэрэг албаны хүмүүс болон нутаг орноо сайн мэддэг зарим иргэдтэй урьдчилан тохиролцсоны дагуу зохион байгуулна. Уулзалтад оролцсон хүмүүсийн бүртгэлийг дараах загвар/1/-аар, мөн иргэд, олон нийтээс гарсан санал, хүсэлтийг дараах загвар/2/-ын дагуу авна.

..... аймгийн/нийслэлийн сумын/дүүргийн уулзалтад оролцогчдын бүртгэл

Бүртгэл хөтөлсөн: / / 20__оны __сар__
 гарын үсэг овог, нэр

№	Овог нэр	Нас	Хүйс	Албан тушаал	Утасны дугаар	Гарын үсэг
1						
2						
3						
4						
5						
6						
7						

Загвар 1. Уулзалтад оролцогчдын бүртгэл

..... аймгийн/нийслэлийн сумын/дүүргийн уулзалтын тэмдэглэлийн хуудас

Тэмдэглэл хөтөлсөн: №..... 20__оны __сар__ өдөр
 Овог, нэр

Уулзалт ... цаг ... минутад эхэлж, ... цаг ... минутад дуусав.
 Уулзалтад хүн оролцов. газарт зохион байгуулав.
 Асуулт 1:
 Хариулт 1:
 Санал 1: албан тушаал овог, нэр:
 Санал 2: албан тушаал овог, нэр:.....

Тэмдэглэлтэй танилцсан: / /
 /гарын үсэг/ /овог, нэр/

 /албан тушаал/

Загвар 2. Уулзалтын тэмдэглэлийн хуудас

2.Ярилцлага: Орон нутгийн иргэдийг төлөвлөлтөд нээлттэй, өргөн хүрээнд ярилцлага хийнэ. Ярилцлага хийх бэлтгэлийг урьдчилан хангаж, хэнээс ямар асуулт асуухаа нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах зорилго, зарчим, тэргүүлэх чиглэлүүдэд тулгуурлаж асуултыг бэлтгэнэ. Ярилцлагад оролцогчдын саналыг тэмдэглэлээр баталгаажуулна /Загвар 3, 4/.

..... . . аймгийн сумын ярилцлагад оролцогчдын бүртгэл

Бүртгэл хөтөлсөн: / / 20__оны __сар__
 өдөр гарын үсэг овог, нэр

№	Овог нэр	Нас	Хүйс	Албан тушаал	Гар утас	Гарын үсэг
1						
2						
3						
4						
5						
6						
7						

Загвар 3. Ярилцлагад оролцогчдын бүртгэл

..... **аймгийн/нийслэлийн** **сумын/дүүргийн ярилцлагын тэмдэглэлийн хуудас**

Тэмдэглэл хөтөлсөн: №..... 20__ оны __ сар __ өдөр

Овог, нэр

Уулзалт ... цаг ... минутад эхэлж, ... цаг ... минутад дуусав.

Уулзалтад хүн оролцов. газарт зохион байгуулав.

Асуулт 1:

Хариулт 1:

Санал 1: албан тушаал овог, нэр:

Санал 2: албан тушаал овог, нэр:

Тэмдэглэлтэй танилцсан: / /
/гарын үсэг/ /овог, нэр/

Загвар 4. Ярилцлагын тэмдэглэлийн хуудас

3. Хэлэлцүүлэг: Тухайн сумын газар ашиглалтын өнөөгийн нөхцөл байдалд нөлөөлж буй дотоод, гадаад хүчин зүйлийг үнэн зөв тодорхойлох, газрын хэрэгцээ болон газар ашиглалтын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж газар ашиглалтын онцлогийг тодруулах үүднээс зорилтод бүлгүүдийг хамарсан хэлэлцүүлгийг зохион байгуулна. Хэлэлцүүлгийг дараах бүлгүүдтэй хийнэ.

Багийн Иргэдийн нийтийн хурал:

Багийн Иргэдийн нийтийн хуралд дараах иргэдийн төлөөллийг оролцуулна. Үүнд:

- а. Малчид;
- б. Аж ахуйн нэгж эрхлэгч /Бизнесийн үйл ажиллагаа/;
- в. Төрийн албан хаагч;
- г. Ахмад настан;
- д. Залуучууд;
- е. Бусад;

Зорилтот бүлгүүд:

- а. Сумын Засаг даргын тамгын газрын ажилтан /Удирдах болон гүйцэтгэх түвшний албан хаагчид/;
- б. Төрийн үйлчилгээний ажилчид /Багш, эмч, туслах үйлчилгээний ажилтан гэх мэт/;
- в. Төрийн бус байгууллагууд /Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, залуучуудын эрх ашгийг хамгаалдаг байгууллагын төлөөлөл гэх мэт/;
- в. Банк, санхүү, үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэгчид;
- д. Нийгмийн эмзэг бүлгийн иргэд /Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон иргэд, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрх, иргэд гэх мэт/;

Хэлэлцүүлэгт оролцогчдоор газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрх эдлэгчдийн хил заагийг тэдний харилцан зөвшилцлөөр баталгаажуулж, зуруулна.

Нийгэм, эдийн засгийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан шинээр бий болгох жуулчны бааз, отог, амралт, сувиллын газрын байршлыг тогтоох, зураглах болон тухайн сумын онцлогоос хамаарсан бусад асуудлуудыг нэмж тодорхойлж, зураглана.

Асуулгын судалгаа: Сумын нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааг нийт өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөллөөс авна. Тэднээс газар ашиглалт, байгалийн нөөц, баялгийн ашиглалттай холбоотой саналыг загвар/5/-ын дагуу авна.

Санал авах хуудас	
№...	
Овог, нэр:...../иргэн, хуулийн этгээд/ <u>доогуур зурах</u>	20__оны__сар__өдөр
Аймаг:.....сум:.....баг:.....Утас:.....	
Санал:.....	
.....	
Тэмдэглэл:.....	
.....	
САНАЛ ӨГСӨН:	/
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:.....	/

Загвар 5. Санал авах хуудас

Уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг, санал асуулгын судалгаанд тухайн сумын нийт иргэд, айл өрх, хөдөлмөр эрхлэгчдээс /Хүснэгт 1/-эд үзүүлсэн хувиас багагүй хүмүүсийг оролцуулна.

Хүснэгт 1. Иргэд, олон нийтийн оролцоо

№	Иргэн/хуулийн этгээд	Оролцуулах хувь
1	Малчин өрх	15 %
2	Сумын төвийн өрх	5 %
3	Тариалан эрхлэгчид	15 %
4	Үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид	25 %
5	Засаг даргын тамгын газрын албан хаагчид	60 %
6	Бусад төрийн албан хаагчид	15 %
7	Нийгмийн эмзэг бүлгийн иргэд	30 %

4.2. Хил зааг, байршил тогтоох, зураглах

- Газар дээр нь очиж ажиллах, хэмжилт, зураглал, тодруулалт хийх чиглэлүүд, баг бүрэлдэхүүнийг тогтооно. Хээрийн хэмжилт, тодруулалтын ажилд сумын удирдлага, газрын даамал, багийн Засаг дарга нарыг оролцуулах ба шаардлагатай бусад мэргэжилтнүүдийг тэд нартай тохиролцсоны үндсэн дээр оролцуулж, газрын нэгдмэл сангийн ангиллын дагуу байршил, заагийг нарийвчлан зураглана.
- Газар дээр нь хэмжилт, зураглал, тодруулалт хийхдээ байршил тогтоох /GPS/ багаж, зарим тохиолдолд өндөр нарийвчлалтай хэмжилтийн багаж, агаар, сансрын зураг зэргийг ашиглана.
- Хиймэл дагуулын зураг 10 метр болон түүнээс өндөр нарийвчлалын, 6 сар болон түүнээс богино хугацаанд авсан мэдээг ашиглана.
- Газар ашиглалт, байгалийн нөхцөл, нөөцийн байршил, заагийг бэлтгэл үе шатанд бэлтгэсэн суурь зураг, сэдэвчилсэн зураг дээр тодруулан гараар болон компьютерээр нэмж зураглана.
- Газар ашиглалтын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээний зургийн таарцыг газар дээр нь шалгах, шаардлагатай хэмжилтийг хийнэ.
- Бусад салбарын үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн баримт бичиг, тайлан, өгөгдөл, суурь зураг зэрэг хоёрдогч мэдээллийг албан ёсны эх сурвалжаас, хамгийн сүүлийн үеийн байдлаар авч ашиглана.

а. Хөдөө аж ахуйн газар

- Малчин өрхийн өвөлжөө, хаваржааны байршлыг газар дээр нь хэмжиж тодорхойлох, зуслан, намаржааны газрын бүсийг тогтоох. Шинээр нэмэгдсэн өвөлжөө, хаваржааны байршлыг Газрын даамлаас тодруулж, солбицлыг авч зурагт оруулах, гарсан захирамж, шийдвэртэй нь тулган нягтална. Байршлыг нь тодорхойлоогүй

өвөлжөө, хаваржааг газар дээр нь очиж хэмжин зурагт оруулж, тухайн малчны овог нэр, засаг захиргааны харьяалал, малын тоо, толгойг төрлөөр нь, байршлыг газрын нэр болон солбицлоор нь, гэрчилгээтэй эсэх гэх зэрэг мэдээллийг бүртгэнэ.

- Улирлын бэлчээрийн заагийг тогтоох, зураглах. Малчдын 4-н улирлын байршлыг тодорхойлохдоо малчин өрхөд дугаар өгнө. Малчин өрхийн дугаар нь сумын хэмжээнд дахин давтагдашгүй байна. Өрх бүрийн 4 улирлын байршлыг зурагт тэмдэглэнэ. Ингэхдээ өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны таних тэмдгийн хажууд өрхийн дугаарыг давхар тэмдэглэж өгнө. Энэ нь тухайн сумын улирлын бэлчээрийн заагийг тогтоох үндэс болно. Мөн үүний зэрэгцээ дөрвөн улирал тус бүрт ашиглагддаг усны эх үүсвэрийг тодорхойлж, ашиглалтын байдлыг нь судалж бүртгэнэ.
- Бэлчээр ашиглалтын улирлын хуваарийг тодорхойлох, зураглах. Тухайн сумын бэлчээр дэх уст цэг /худаг, булаг, шанд, гол горхи, нуур, хөв цөөрөм/-ийн тооллого, ашиглалтын байдлын судалгааг Хөдөө аж ахуй болон байгаль орчин хариуцсан мэргэжилтнээс авах, шинээр нэмэгдсэн худаг, уст цэгийн байршлыг газар дээр нь очиж тогтоон, зурагт тэмдэглэхийн зэрэгцээ уст цэгийн усны нөөц, ундарга, хүчин чадал, уст цэгийг ашиглаж байгаа малчин өрх, хот айл, малын тоо, худаг хариуцсан эзний талаарх мэдээллийг бүрдүүлнэ.
- Эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй байдлыг зураглах цаашид эрхлэх боломжтой газрыг газар дээр нь очиж тодорхойлох, зураглах. Тухайн суманд одоогийн байдлаар эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн судалгааг авч, аж ахуйн төрөл, хүчин чадал, зах зээлийн талаарх мэдээллийг бүрдүүлнэ. Мөн сумын төвийн ойролцоо хагас эрчимжсэн болон уламжлалт аргаар мал маллаж өвөлжөө, бууц эзэмшиж байгаа малчин өрхийн байршлыг газар дээр нь хэмжин зурагт тэмдэглэнэ. Үүний зэрэгцээ малчин өрхийн малын гаралтай мах, сүүн бүтээгдэхүүний хэмжээ, борлуулж ашиг олдог эсэх, цаашдын бодол зэргийг судална.
- Одоогийн ашиглаж байгаа отрын нутгийг тодорхойлж зураглах, цаашид отрын зориулалтаар ашиглах газрын байршлыг зураглах. Тухайн суманд одоо байгаа отрын бүс нутаг дахь малын тоо, 1 га талбайн ургацын хэмжээ, даац, багтаамж, төлөв байдал, уст цэгийн тоо, ашиглалтын байдлыг тодорхойлж, зурагт оруулна.
- Мал тууврын зам маршрут, заагийг зураглах. Сумын нутаг дэвсгэр дээгүүр дайран өнгөрдөг мал тууврын замын чиглэлийг зурагт тэмдэглэх, уг тууврын замыг аль улиралд ашигладаг эсэх, замын маршрутын дагуух газар нутгийг нутгийн малчин өрх ямар улиралд

ашигладаг эсэх, хэчнээн тооны малчин өрх болон мал хамрагддаг эсэх талаарх судалгааг гүйцэтгэнэ.

- Тариалангийн газар ашиглалтын өнөөгийн байдлыг тодорхойлох, хэмжилт, зураглал хийх, тариалан эрхлэхэд тохиромжтой газрын таарцыг шалгах /таримал ургамлын төрлүүд тус бүрээр/. Сумын хэмжээгээр сүүлд шинээр нэмэгдсэн тариалан эрхлэлт байгаа бол талбайн солбицол, таримал ургамлын төрөл, талбайг өмчилж, эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл гэх мэт судалгааг бүрдүүлнэ. Мөн одоо тариалангийн эргэлтэд ашиглаж байгаа болон бүртгэлтэй боловч атаршиж хаягдсан талбайн эргэлтийн цэг, хил заагийг тулгах, талбайн төрх байдал болон төлөв байдлын дэлгэрэнгүй судалгааг газар дээр нь нарийвчлан гүйцэтгэж, тэмдэглэл хөтөлнө.
- Усалгаатай газар тариалангийн байршил, заагийг зураглах. Усалгаатай газар тариалангийн талбайн солбицол, хил заагийг газар дээр нь тулгахаас гадна усалгааны ямар арга хэлбэр ашиглаж байгаа талаар судална. Хуучин ашиглагдаж байсан услалтын системийн барилга байгууламж, түүний бүрэн бүтэн байдал, хүчин чадал, хариуцах эзэн зэрэг мэдээллийг бүрдүүлнэ.
- Одоо ашиглаж байгаа хадлангийн газрын байршлыг зураглах, цаашид хадлангийн зориулалтаар ашиглах газрын байршлыг зураглах, ургацыг тодорхойлох. Тухайн сумын газрын нэгдмэл сангийн тайланд бүртгэлтэй хадлангийн талбайн одоогийн ашиглалтын байдлыг газар дээр нь тулган хил зааг, хэмжээ байршлыг тодорхойлж зураглахаас гадна 1 га талбайн ургацын дээж авч, ургамлын бичиглэл үйлдэнэ. Мөн хур бороо ихтэй жилд өвс ургамал сайн ургадаг ургацын хэмжээ ихтэй хадлан авахад тохиромжтой бэлчээрийн талбайн хэмжээ, байршлыг газар дээр нь тодорхойлж, зурагт буулгана.
- Хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн зориулалтаар ашиглаж буй газрын заагийг зураглах. Хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаа барилга, байгууламжийн байршил, хэмжээ, зориулалтыг тулган шалгах, одоогийн ашиглалтын байдлыг тодорхойлж, бүрэн бүтэн эсэх, эвдэрч тоногдсон эсэх, байгууламжийг барьж байгуулсан огноо, хүчин чадал, багтаамж, хариуцдаг этгээд зэрэг мэдээллийг тодруулан судална.
- Усжуулах шаардлагатай бэлчээрийн байршлыг тодорхойлох, зураглана.
- Нүүдлийн зам маршрут, заагийг зураглана.
- Атаршсан газрын эргэлтийн цэг, заагийг зураглана.

- Хамгаалах, нөхөн сэргээх газрын талбай, байршлыг тогтоох, зураглана.

б. Хот, тосгон бусад суурины газар

- Хот, тосгон бусад суурины газар: шинээр нэмэгдсэн газар ашиглалтыг нэг бүрчлэн мэдээллийн сантай тулгаж, мэдээллийн санд ороогүй өөрчлөлтүүдийг хэмжиж, оруулна. Үүнд:
 - Суурьшлын бүс: амины орон сууц, нийтийн орон сууц, гэр хороолол;
 - Үйлдвэр, үйлчилгээний бүс: нийтийн үйлчилгээний газар, жижиг, дунд үйлдвэрийн газар;
 - Засаг, захиргааны бүс: төрийн үйлчилгээ, захиргааны байгууллага, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, банк зэрэг газар;
- Гэр хорооллын суурьшлын бүсэд ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг хангах дэд бүтэц барих газрын хил заагийг хэмжинэ.
- Дахин төлөвлөлт хийх газрын байршлыг газар дээр нь хэмжиж, тохиромжтой эсэхийг газар дээр нь судална.
 - Аялал жуулчлалын газар: жуулчны бааз, амралт, сувиллын газар, хүүхдийн зуслан, түүх, соёлын дурсгалт газар, соёлын өв бүхий газрын байршил, заагийг зураглана.
- Байгалийн үзэсгэлэнт газар, түүх, соёлын дурсгалт газар, үнэт ховор үзмэр бүхий газруудыг тэмдэглэх, зураглана.
- Шинээр бий болсон жуулчны бааз, отог, амралт, сувиллын газрын байршил, хил заагийг тогтоох, зураглана.
- Шашны ач холбогдолтой дурсгалт газрын байршлыг тодорхойлон зураглана.
- Уул уурхай: ашиглалтын лицензтэй, хайгуулын лиценз бүхий ашигт малтмалын газар, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын байршил, заагийг зураглана.
- Уул уурхайн нөлөөгөөр эвдэрч, доройтсон газрыг бүртгэж, газар дээр нь хил заагийг хэмжих, шаардлагатай тохиолдолд хөрсний дээж авна.
- Гар аргаар алт олборлосон, бохирдсон газрыг тодорхойлон зураглана.

в. Ойн сан бүхий газар

- Ой тэлэн ургах тохиромжтой газрын таарцыг газар дээр нь шалгах, зураглана.
- Ойн төрөл, байршил, хэмжээ, заагийг зураглана.
- Ойн менежмент хийгдэж буй газрын байршил, заагийг зураглана / Ойн цэвэрлэгээ, түймэр, хортон шавьжид идэгдсэн ойн хил заагийг тогтоох/.
- Хамгаалалтын болон ашиглалтын ойн хил заагийг зураглана.

г. Усны сан бүхий газар

- Гол, горхи, мөрөн, нуур, мөсөн голын эзлэх талбайг зураглана.
- Ширгэсэн, тасарсан гол, нууруудыг нэг бүрчлэн зураг дээр тэмдэглэнэ.
- Уст цэгийн төрөл, байршил, ашиглалт, хүчин чадлыг тодорхойлно.
- Хөв цөөрмийн байршил, хүчин чадал /цаашид хөв цөөрөм байгуулах боломжтой газрын судалгаа/-ын тодорхойлно.

д. Тусгай хэрэгцээний газар

- Улсын тусгай хамгаалалттай газрын байршил, заагийг зураглана /Дархан цаазат газар, байгалийн нөөц газар, байгалийн цогцолборт газар, дурсгалт газар/.
- Улсын тусгай хэрэгцээний газрын байршил, заагийг зураглана /Улсын хилийн зурвас газар, батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах газар, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар; шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилтын болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай, цөмийн төхөөрөмж барих зориулалтаар олгосон газар, аймаг дундын отрын бэлчээр, чөлөөт бүсийн газар, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай, мал тууврын зам, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай, бичил уурхайн зориулалтаар олгосон газар, хилийн боомтын бүс, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар/.
- Аймгийн болон сумын орон нутгийн тусгай хэрэгцээний газрын байршил, заагийг зураглана /Тусгай хамгаалалтад авсан газар, аймаг дундын отрын бэлчээр, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай, бичил уурхайн зориулалтаар олгосон газар/.

е. Зам, шугам сүлжээний газар

- Авто замын газрын зориулалтаар ашиглаж байгаа газрын байршил, заагийг зураглана /Хатуу хучилттай зам, засаж, сайжруулсан зам, хээрийн хөрсөн зам/.
- Төмөр замын газрын зориулалтаар ашиглаж байгаа газрын байршил, заагийг зураглана.
- Агаарын тээвэр, нисэх буудлын зориулалтаар ашиглаж буй газрын байршил, заагийг зураглана.
- Цахилгааны шугам газрын байршил, заагийг зураглана.
- Харилцаа, холбооны шугам сүлжээний газрын байршил, заагийг зураглана /шилэн кабел, агаарын шугам гэх мэт/.

- Дулаан, ус хангамжийн газрын байршил, заагийг зураглана.
- Ариутгах татуургын газрын байршил, заагийг зураглана.

ё. Газар, байгалийн нөөц, дагалт баялаг, ашиглалт

- Жимс, жимсгэнийн байршил, нөөцийг тодорхойлно /Нэрс, чацаргана, мөөг, хушны самар гэх мэт/.
- Загасчлал, амьтан, ан агнуурын байршил, нөөцийг тодорхойлно.
- Эмийн болон ховор ургамлын байршил, нөөцийг тодорхойлно.
- Түгээмэл болон ховор тархацтай ашигт малтмалын байршил, нөөцийг тодорхойлно.

ж. Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл

Урьд өмнө болж байсан байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн улмаас эвдэрч, өөрийн төрөлх хэв шинжийг алдсан болон ямар нэгэн байдлаар хортой, аюултай нөхцөл байдал үүсч байсан буюу ийм байдалд байгаа газрын байршил, хил заагийг хэмжиж, талбайгаар болон цэгээр зураглана /Газар хөдлөл, үер, цас их унадаг, нөөлөг салхи, хөрсний бохирдол, гулсалт болон бусад гамшиг, аюулт үзэгдлүүд/.

з. Мал, амьтны гоц халдварт өвчний голомттой газар

Мал, амьтны гаралтай гоц халдварт өвчнүүд гарч байсан голомт бүхий газруудын байршлыг тэмдэглэх, тархцыг тодорхойлох, малын сэг, зэм устгалын газрыг тэмдэглэнэ.


и. Хог хаягдлын цэг

Хог хаягдлын цэг, уурхайн болон ахуйн аюултай хог хаягдал, оршуулгын газрын байршлыг тэмдэглэх, цаашид хор нөлөөг багасгаж, тогтвортой ашиглах судалгаа хийнэ.

й. Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрх

“Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг бүртгэн баталгаажуулах түр заавар”-ын дагуу зүй ёсны эрхийн зориулалтын төрлүүд болон газар, байгалийн нөөцийн тархцыг төрөл тус бүрээр нь газар дээр нь тогтоож, бүртгэн зураглана.

Жич: Тухайн сумын онцлогоос хамааран газар ашиглалтын төрөл өөрчлөгдөж болно. Хээрийн судалгааны хил зааг тогтоох зураглах ажлыг схем/З/-ээр тоймлон харуулав.



Схем 3. Хил, зааг, байршил тогтоох, зураглах

4.3. Нийгэм, эдийн засгийн судалгаа

Хээрийн судалгаагаар газар, байгалийн нөөц ашиглалттай холбоотой болон нийгэм, эдийн засгийн төлөвлөлтийн арга хэмжээнүүдэд шаардлагатай дараах нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдээр сүүлийн 5-аас доошгүй жилийн мэдээг байрлалд суурилсан “Нийгэм, эдийн засгийн мэдээллийн сан”-гаас авах ба илүү нарийвчилсан мэдээллийг холбогдох аргачлал, зааврын дагуу тооцоолж авна.

ҮҮНД:

а. Хүн ам зүй:

- Жилийн эцсийн хүн амын тоо;
- Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь;
- Хүн амын ердийн цэвэр өсөлт/бууралт;
- Хүн амын нас, хүйсийн суварга;
- Хүн амзүйн ачаалал;
- Хүн амын нягтрал;
- Дотоод шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент;
- Өрхийн ам бүлийн дундаж тоо;

б. Хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшин:

- Хөдөлмөрийн насны хүн ам;
- Эдийн засгийн идэвхтэй хүн ам /Ажиллах хүч/;

- Эдийн засгийн идэвхгүй хүн ам;
- Хөдөлмөрийн чадвартай, хөдөлмөр эрхлээгүй хөдөлмөрийн насны хүн ам;
- Хөдөлмөрийн насны суралцагч;
- Ядуурлын түвшин;

Дээрх хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт болон амьжиргааны статистикийн үзүүлэлтүүдийг “Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал”-ын дагуу тогтооно.

в. Мал аж ахуй:

- Малчин өрхийн тоо /сум, баг, бэлчээр ашиглалтын бүлэг, хэсгээр/;
- Малын төрөл, тоо, толгой /сум, баг, бэлчээр ашиглалтын бүлэг, хэсгээр/;
- Сүргийн бүтцийн өнөөгийн байдал;

Судалгаанд хамруулах малчин өрхийн тоог жишээ байдлаар /Хүснэгт 2/-ээр харуулав.

Хүснэгт 2. Малчин өрхөөс судалгаа авах тоо

Малчин өрхийн ангилал	Нийт өрхийн тоо	Судалгаа авах өрх	
		хувь	Тоо
100 хүртэл малтай	150	15%	22-23
101-200 малтай	200	15%	30
201-500 малтай	60	15%	9
501-1000 малтай	30	15%	5
1001-ээс дээш малтай	10	15%	2

Малтай өрхийн тоо;

- Сумын хэмжээнд малтай нэг өрх болон малчин нэг өрхөд ногдох малын тоо;
- Төллөлт болон төл бойжилтын хувь;
- Бэлчээрийн даац, багтаамж /сум, багаар, бэлчээр ашиглалтын бүлэг, хэсгээр/;
- Тэжээл хангамж;
- Хадлан /байгалийн хадлан, тэжээлийн ургамал, таримал бэлчээр г.м/ авч буй иргэн, аж ахуйн, нэгжийн тоо, тэдгээрийн ашиглаж буй талбайн хэмжээг том, дунд, жижиг гэсэн ангиллаар тухайн аж ахуйн орлого, зарлагын дүнгийн мэдээ болон хураан авч буй ургацын хэмжээг /Хүснэгт 3/-ийн дагуу тодорхойлно.

Хүснэгт 3. Хадлангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, ААН-ын судалгаа

№	Хадлан эрхэлж буй иргэн, ААН-ын нэр	Талбайн хэмжээ	Хадлангийн зориулалт				Ургацын хэмжээ	Орлого /төг/	Зарлага /төг/
			Байгалийн хадлан	Тэжээлийн ургамал	Таримал бэлчээр	Бусад			
1									
2									
3									
Нийт хэмжээ									

г. Газар тариалан:

- Аж ахуйн нэгжийн тоо;
- Газар тариалангийн үйлдвэрлэл /үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, усалгаатай тариалан гэсэн ангиллаар/ эрхэлж буй иргэн, аж ахуйн, нэгжийн тоо, тэдгээрийн ашиглаж буй талбайн хэмжээг үр тариа эрхлэгчдийн хувьд 300 хүртэл га талбай, 300-700 га, 700 га-гаас дээш талбайтай гэсэн ангиллаар тухайн иргэн, аж ахуйн нэгжийн орлого, зарлагын дүнгийн мэдээ болон хураан авч буй ургацын хэмжээг таримлын төрөл болон нийт хэмжээг /Хүснэгт 4/-ийн дагуу тодорхойлно.

Хүснэгт 4. Газар тариалан эрхэлж буй иргэн, ААН-ын нэр

№	Газар тариалан эрхэлж буй иргэн, ААН-ын нэр	Талбайн хэмжээ	Тариалангийн зориулалт				Ургацын хэмжээ	Орлого /төг/	Зарлага /төг/
			Үр тариа	Төмс, хүнсний ногоо	Жимс, жимсгэнэ	Бусад			
1									
2									
3									
Нийт хэмжээ									

- Байгалийн болон таримал тэжээл бэлтгэл, тэдгээрийн хэрэгцээт хэмжээ;
- Сумын хэмжээнд 1 га-гийн ургац /таримлын төрөл бүрээр/;
- Хүлэмжийн тариалалт хийсэн талбай;
- Усалгаатай талбай;

Мал аж ахуй, газар тариалангийн статистик үзүүлэлтүүдийг “ХАА-н салбарын статистик үзүүлэлтийг тооцох” аргачлалын дагуу тогтооно.

д. Материаллаг бус орлого бүхий газар ашиглалт:

- Аялал жуулчлал эрхэлдэг газрын тоо, жуулчдын тоо, амралт сувиллын газар, түүх, соёлын дурсгалт газрын тоо;

“Аялал жуулчлалын статистикийн үзүүлэлт, тооцох аргачлал”-ын дагуу ТОГТООНО.

е. Үйлдвэр үйлчилгээ:

- Нийтийн үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо, тэдгээрийн орлого, зарлага;
- Үйлдвэр, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийтийн үйлчилгээний газар, жижиг дунд үйлдвэрлэл болон бусад бизнесийн байгууллагын мэдээллийг /Хүснэгт 5/-ийн дагуу авна.

Хүснэгт 5. Үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийн судалгаа

№	Үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд	Үйл ажиллагааны төрөл	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хүчин чадал	Орлого /Зарлага	Хөрөнгө оруулалтын хэмжээ
1						
2						
3						

ё. Уул уурхайн үйл ажиллагаа:

- Түгээмэл болон ховор тархацтай ашигт малтмалаас олж буй орлого;
- Уул уурхайн ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газрын байршил, тоо, хэмжээг /Хүснэгт 6/-ийн дагуу авна.

Хүснэгт 6. Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн судалгаа

№	Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ
1			
2			
3			

ж. Аялал жуулчлал:

- Аялал жуулчлал, түүх, соёлын дурсгалт газрыг иргэд, аж ахуйн нэгж ашиглаж, орлого олж буй газруудын үйл ажиллагааны хэлбэр, байршлын мэдээллийг /Хүснэгт 7/-ийн дагуу нэгтгэнэ.

Хүснэгт 7. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийн судалгаа

№	Аялал, жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, ААН-ын нэр	Үйл ажиллагааны хэлбэр					Байршил		Аялал, жуулчлалын бүтээгдэхүүний хэлбэр, төрөл	Үйл ажиллагаа тогтмол явуулдаг эсэх / улирлын шинж чанартай бол хугацааг тодорхой бичих/	Орлого /төг/
		Жуулчны бааз	Амралтын газар	Рашаан, сувилал	Хүүхдийн зуслан	Гэр буудал, бусад	Х	Ү			
1											
2											
3											
Нийт хэмжээ											

3. Байгалийн дагалт баялгийн ашиглалт:

- Жимс жимсгэнэ;
- Самар;
- Загас агнуур;
- Ан, амьтан;
- Эмийн ургамал;
- Цайны ургамал;
- Байгалийн дагалдах баялаг болох жимс жимсгэнэ, самар, ан, амьтан, загас агнуур болон бусад баялаг ашиглаж байгаа иргэд, бүлэг, хэсэг, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн байршил, ашиглаж буй нөөц, баялгийн хэмжээ, орлогын хэмжээг /Хүснэгт 8/-ийн дагуу авна.

Хүснэгт 8. Байгалийн дагалт баялгийн судалгаа

№	Иргэн, хуулийн этгээдийн нэр	Ашиглаж буй дагалт баялгийн төрөл	Тоо, хэмжээ	Орлого /төг/
1				
2				
3				

и. Газрын харилцаа:


1. Тухайн суманд хэрэгжиж буй газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан шийдвэр, газар ашиглагч, эзэмшигч, өмчлөгчийн тоо, зүй ёсны эрхийн тоо, олж буй орлого, газрын төлбөр, татвартай холбоотой мэдээ, байршлын судалгаа хийнэ. Үүнд:

- Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч, газар, байгалийн нөөцийн эдэлбэрийн зүй ёсны эрх ашиглагчдын тоо;
- Газрын төлбөр, татвар;
- Дуудлага худалдаанаас олж буй орлого;
- Газар ашиглалтыг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт зэрэг болно.

“Байгаль орчны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу тогтооно.

2. Хүн ам, мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, үйлдвэр үйлчилгээ, байгалийн дагалдах баялгийг ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгжийн мэдээлэл, материаллаг бус газар ашиглалт, орлого, зарлагатай холбоотой статистик мэдээллийг ашиглан сумын нийгэм, эдийн засгийн өнөөгийн нөхцөлд дүн шинжилгээ хийж, сум, орон нутгийн цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлно.


3. Хээрийн судалгаагаар нийгэм, эдийн засгийн мэдээ цуглуулахдаа бэлтгэл ажлын хүрээнд бэлтгэсэн хүснэгт, загварын дагуу авна. Гэхдээ сум бүр өөрийн онцлогтой тул дээрх мэдээнд хязгаарлагдахгүй байж болно. Хээрийн судалгаагаар цуглуулах нийгэм, эдийн засгийн мэдээний жагсаалтыг схем/4/-ээр тоймлон харуулав.



Схем 4. Нийгэм, эдийн засгийн мэдээ

4.4. Тохиромжтой байдлын үнэлгээ

“Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргагүй”-н дагуу тухайн сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд буюу том масштабын шаардлагад нийцсэн мэдээллийн нарийвчлалыг хангаж ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг дээрх арга зүйд орсон 8 ангиллын дагуу хийнэ.



Схем 5. Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ


4.5. Сумын хөгжлийн байдалд дүн шинжилгээ хийх

Сумын нийгэм, эдийн засаг, байгаль орчин, дэд бүтэц, газрын харилцааны чиглэлүүдээр CBOT /SWOT/ шинжилгээ буюу гадаад, дотоод орчны судалгаа болон ПЭСТЭЛ /PESTEL/ болон асуудлын шинжилгээний аргуудыг хослуулан хэрэглэж одоогийн байдал, тулгамдаж буй бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх нөөц чадавхи боломжуудыг тодорхойлно.

CBOT шинжилгээний асуултыг тухайн сумын орон нутгийн онцлогт тохируулж боловсруулах ба нийгэм, эдийн засгийн судлаачид, социологчид зэрэг мэргэжлийн хүмүүсийг оролцуулна.

ПЭСТЭЛ шинжилгээ нь улс төр, нийгэм эдийн засаг, технологи, хууль эрх зүй, байгаль орчны хүчин зүйлсийн ерөнхий төлөв байдал зэрэг макро орчны нөхцөл байдлыг судлан шинжилнэ.

Асуудлын шинжилгээ нь асуудлыг үүсгэж буй байж болох бүх шалтгаанууд тэдгээр шалтгаануудын цаадах шалтгаануудыг тодорхойлсны үндсэн дээр сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд өөрчилж, сайжруулах боломжтой шалтгаануудыг нь тодруулж шийдлүүдийг тодорхойлох аргачлал юм. Мөн үүнээс гадна “Асуудлын мод” аргачлалыг ашиглан сумын хөгжилд тулгарч буй асуудал тус бүрээр нь схем 6-д үзүүлсний дагуу асуудлыг үүсгэж буй шалтгаан, хүчин зүйл тэдгээрийн үр дагаваруудыг сумын засаг даргын тамгын газрын удирдлага, ажилтнууд, газрын даамал, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, байгаль орчны байцаагч, малчин өрх гэх мэт тодорхой зорилтод бүлгүүдийн оролцоотойгоор тодорхойлно. Үүний дараа асуудлууд тэдгээрийн шалтгаан, үр дагаварыг арилгах арга хэмжээнүүдийг оролцогчдын тусламжтайгаар тодорхойлж, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хэн ямар оролцоотой байх талаар оролцогч талуудын үүрэг хариуцлагыг хувиарлана.



Схем 6. Асуудлын шинжилгээ.

Эдгээр шинжилгээний аргууд нь хамрах хүрээ, хүрэх үр дүнгээр харилцан адилгүй, өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой /Хүснэгт 9/.

Хүснэгт 9. Шинжилгээний аргууд

Аргууд	Хэрэглэх хүрээ	Онцлог	Үр дүн
СВОТ шинжилгээ	Гадаад болон дотоод орчин	Төлөвлөгөөний хэрэгжилтэд нөлөөлөх гадаад дотоодын орчныг цогц байдлаар шинжлэх бөгөөд төлөвлөлт хийх, хэрэгжилтийн үед бий болох боломж, аюул, занал, давуу, сул талыг тодорхойлсноор бүх боломжуудаа ашиглах нөхцөлөөр хангагдана.	Сумын нутаг дэвсгэр, газар, байгалийн нөөц ашиглалтын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлж, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх боломж, арга замуудыг илрүүлнэ.
ПЭСТЭЛ шинжилгээ	Гадаад макро орчин	Гадаад макро орчны нөхцөл байдал өнөөдөр ямар байна вэ? гэдгийг тодорхойлдог бөгөөд цаашид төлөвлөгөө бүрэн хэрэгжих нөхцөл хангагдана.	Өнөөгийн нөхцөл байдал ямар байгааг тодорхойлно.
Асуудлын мод	Асуудлын шинжилгээ	Энэ нь асуудлыг тодорхойлох, илүү нарийвчлан ойлгох бүх талын хүчин зүйлийг тодорхойлон авч үзэх боломжийг олгодог бүтээлч сэтгэлгээний аргын нэг юм	Тулгамдаж буй асуудлууд тэдгээрийг шийдвэрлэх боломж, арга замуудыг иргэд олон нийтийн илрүүлнэ.

Нутаг дэвсгэрийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тогтоох

Улс, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиглэлүүдтэй нягт уялдуулсан тухайн сумын онцлог, хэв маяг, шинж чанарыг агуулсан 1-2 тэргүүлэх чиглэлүүдийг нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тодорхойлж өгнө. Үүнд:

- Мал аж ахуй;
- Газар тариалан;
- Уул уурхай;
- Аялал жуулчлал;
- Байгалийн нөөц баялгийг түшиглэн байгальд ээлтэй үйлдвэрлэл хөгжүүлэх орон нутагтаа баялаг бүтээх;
- Бусад.

Мөн тухайн сум орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгасан тэргүүлэх чиглэлийг нутаг дэвсгэрийн газар, байгаль, нийгэм, эдийн засгийн нөхцөл нөөц, онцлогыг шинжлэн судалсаны үндсэн дээр мэргэжлийн зүгээс хэрэгжүүлэх боломж нөөцийг тодорхойлж, уг чиглэлийг газар зохион байгуулалтын төлөвлөлтөөр дамжуулан хэрэгжилтийг хангах, дэмжих төлөвлөлтийг боловсруулна.

4.7. Газрын чанарын өөрчлөлт, доройтол

Бэлчээр, тариалан болон атаршсан газар, хот, тосгон бусад суурины газар, улсын тусгай хамгаалалттай газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа судалгааны хамгийн сүүлийн үеийн үр дүн, зөвлөмжийг судлана. Мөн бэлчээрийн газрын фотомониторингийн үр дүнд гарсан бэлчээрийн сэргэх чадавхын зэрэглэлийг тогтоох ажлыг гүйцэтгэнэ.

Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтоох

Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг харьцангуй бодитойгоор тогтоох нь ямар хэмжээний газарт, ямар төрлийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг, ямар хугацаанд хэрэгжүүлэх зэрэг асуудлуудыг тодорхойлно.

Хот суурин газар, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй газар, дэд бүтцийн газарт дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газар нутгийн байршил, зааг, хэмжээг тогтооно.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ тогтоох, төлөвлөлтийн арга хэмжээнд тусгахдаа “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтална.

ТАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ НЭГТГЭХ, БОЛОВСРУУЛАХ

Энэ үе шатанд хээрийн судалгаагаар олж авсан бүх төрлийн мэдээллийг нэгтгэх, боловсруулах ажлууд хийгдэнэ. Үүнд:

- Цаасан дээр гараар зурсан газар, байгалийн нөөц ашиглалтын байршил, хил заагийг газар зүйн мэдээллийн систем /GIS/-ийн програм хангамжийг ашиглан тоон хэлбэрт оруулж зураглах,
- Байршил тогтоох багаж /GPS/-аас хэмжилтийн үр дүн компьютерт оруулах, боловсруулалт хийх,
- Иргэд, олон нийтээс өгсөн санал, асуулгыг нэгтгэх.

Боловсруулалт хийсний дараагаар сумын байгалийн нөөц, төрх байдал, нийгэм, эдийн засаг, газар ашиглалтын мэдээллүүдийг нэгтгэж, дүн шинжилгээ хийнэ.

Судалгааны үр дүнг нэгтгэх, боловсруулах шатанд дараах давхаргуудыг тоон байдлаар /Shapefile/ заавал бэлтгэсэн байна. Үүнд:

1. Сумын мал тооллогын “А” дансанд бүртгэлтэй малын тоог төрөл тус бүрээр, тухайн өвөлжөө, хаваржааны газрын эзэмших гэрчилгээтэй эсэх мэдээллийг агуулсан атрибут бүхий малчдын өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны байршлын тоон зураг /Shapefile/;
2. Сумын мал тооллогын “А” дансанд бүртгэлтэй малын тоог төрөл тус бүрээр, бэлчээрийн даац, ачааллын мэдээллийг тус тус агуулсан атрибут бүхий баг, улирлын хил, бэлчээр ашиглалтын хэсгийн хилийн тоон зураг /Shapefile/;
3. Бэлчээрийн даац, ачааллын мэдээллийг агуулсан атрибут бүхий отрын нөөц бэлчээрийн газрын тоон зураг;
4. Нийт малын тоог төрөл тус бүрээр, бэлчээрийн даац, ачаалал, хүн амын тоо, нягтралын мэдээлэл агуулсан атрибут бүхий багийн хил заагийн тоон зураг /Shapefile/;
5. Элэгдэл, эвдрэл, доройтлын зэрэг, талбайн хэмжээний мэдээллийн агуулсан атрибут бүхий элэгдэл эвдрэлд орсон газрын тоон зураг.

ЗУРГАА. ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТ

Газрын тохиромжтой байдлын үнэлгээ, нийгэм, эдийн засгийн хэрэгцээт байдлын үнэлгээнд үндэслэн газар ашиглалтын төрөл бүрээр сумын газар ашиглалтын тэргүүлэх чиглэлийг үндэс болгон байгалийн нөөц, нийгэм, эдийн засгийн үнэлгээнд үнэлэлт, дүгнэлт хийж, оновчтой газар ашиглалтын хувилбарыг гаргана.

Газар, байгалийн нөөц, баялгаас олж буй аливаа орлогоос энэхүү төлөвлөгөө хэрэгжүүлэх болон газрын чанар, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд зориулж тодорхой хэмжээний хувийг зарцуулах, орон нутгийн иргэдийн амьжиргаа, нийгэм, эдийн засгийн нөхцөлийг сайжруулах зэрэг эдийн засгийн тооцооллыг боловсруулна.

6.1. Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон хөгжлийн бодлогын баримт бичиг, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны тайланг судлах, уялдуулах

1. Улс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө тэдгээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулна.
2. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа улс, бүс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэслэлтэй нарийвчлан тодруулж, сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд шууд тусгаж, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

3. Улс, бүс, аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан дунд болон урт хугацааны төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэр дээр хэрэгжиж буй хөгжлийн бодлого, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулна.

Тухайн сум, орон нутагтай холбоотой газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах ХАА, хот байгуулалт, дэд бүтэц, үйлдвэр, уурхай, ойн сан, усан сан, аялал жуулчлал, байгаль хамгаалал, тусгай хэрэгцээний чиглэлээр авах арга хэмжээг Хүснэгт 10-д үзүүлсэн загварын дагуу түүвэрлэж үзүүлнэ. Мөн эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжих боломжийг газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээнд тулгуурлан хэрэгжүүлэх оновчтой байршил, хэмжээ, хил заагийг сумын түвшний масштабын нарийвчлалын шаардлага хангасан хэмжээнд зураглаж төлөвлөнө.

Хүснэгт 10. Баримт бичгийн жагсаалт

№	Баримт бичгийн нэр	Холбоотой арга хэмжээ
	Улсын ГЗБЕТ	
	Аймгийн ГЗБЕТ	
	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	
	Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө;	
	Үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр	
	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр.	

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Дэд бүрэлдэхүүн хэсэг 1.1. Ерөнхий зүйл

Тухайн сумын хөдөө аж ахуйн нийт үйлдвэрлэлийн хэмжээг мал, амьтдыг өсгөн үржүүлэх болон үр тариа, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо тарьж ургуулсны үр дүнд бий болох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өртгөөр тооцож, төлөвлөнө.

Хүн амын өсөлтөөс хамааран хөдөө аж ахуйн гаралтай хүнсний эрэлт хэрэгцээг тодорхойлж, тэрхүү нийлүүлэлтийг бий болгохын тулд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд шаардлагатай газар нутгийн хүрэлцээ, талбайн хэмжээ, зориулалтыг төлөвлөнө.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 1.2. Бэлчээрийн газрын төлөвлөлт

Бэлчээрийн газрыг суурин болон нүүдлийн аж ахуйн хэлбэрээр зохион байгуулах, тэдгээрийн хил заагийг тогтоох, кадастрын мэдээллийн санд нэгж талбарын ерөнхий хил, заагийг зураглаж, оруулах зэрэг ажлууд хийгдэнэ.

Багийн хил, бэлчээрийн хэсгийн хил, улирлын бэлчээр, бэлчээр ашиглалтын хэсэг, отрын нөөц бэлчээр тус бүрээр бэлчээрийн даац, ачааллыг тооцно./Хүснэгт 11/

Хүснэгт 11. Малыг хонин толгойд шилжүүлэх итгэлцүүр

Малын төрөл	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа
Хонь толгойд шилжүүлэх итгэлцүүр	6.0	5.0	6.0	1.0	0.9

Хүснэгт 12. Хонины өдөрт идэх өвс /кг/

Улирал	Зун	Намар	Өвөл	Хавар
Өдөрт идэх хэмжээ	1.9	1.6	1.1	1.1

Хүснэгт 13. Бэлчээрээс хонины хоногт идэх хуурай өвс /кг/

Жилийн улирал	Ойт хээр	Хээрийн бүс	Цөл, цөлөрхөг хээрийн бүс
Зун – намар	2.5	2.3	1.9
Өвөл – хавар	1.8	1.6	1.5

Хүснэгт 14. Бэлчээрийн ургац /ц.га/

Байгалийн бүс	Зун-намар	Өвөл-хавар
Ойт хээр	5.3	3.1
Хээр	3.8	2.5
Цөлийн хээр	2.2	1.6

Ажилбар 1.2.1. Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн бүс газрын төлөвлөлт

Мал, гэрийн тэжээвэр амьтдын тоо толгойн өсөлт, бууралтаас мал сүргийн нөхөн үйлдвэрлэлийн үзүүлэлтийг тооцож хэтийн өсөлтийг тодорхойлох, мөн тухайн сумын бэлчээрийн мал аж ахуй эрхэлж буй байршил нутаг, зонхилох хувиар уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн бүсийг тогтоож болно. Мал аж ахуй эрхлэх үйл ажиллагааг нийгэм, эдийн засаг, экологийн талаас нь иж бүрэн харгалзан үзэж, тодорхой хязгаарлалттайгаар бүсчлэн хөгжүүлэх зорилтыг дэвшүүлэх нь зүйтэй. Мал аж ахуйг тодорхой бүс нутагт өсгөн үржүүлэх, малын гаралтай түүхий эдийг тусгайлсан газар хүлээн авах замаар нийгэм-эдийн засагт үлэмж хохирол учруулж болзошгүй мал, амьтны гоц халдварт болон халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлж хүн амын эрүүл орчинд амьдрах баталгааг хангах, байгаль-экологийн тэнцвэрийг хадгалах чиглэлийг агуулсан төлөвлөлтийг боловсруулна.

Ажилбар 1.2.2. Бэлчээрийн улирлын хуваарийн төлөвлөлт

Уламжлагдан ирсэн бэлчээр ашиглах хуваарь, газар нутгийн онцлог, байгаль цаг уурын нөхцөл зэргийг харгалзан, малчид, иргэдийн санал багийн иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг үндэслэн нийтээр баг, хот айлаар хуваарилж ашиглах зуслан, намаржааны бэлчээр, гэрээгээр ашиглах өвөл, хаврын бэлчээрийн газрын хил зааг, байршлыг 4 улирлын ялгавартайгаар тогтоон зураглаж даац, багтаамж, ашиглах хугацааны хуваарь, бэлчээрийн төлөв байдал болон төрх байдал, ус хангамжийн талаар хэрэгжүүлэх асуудлуудыг төлөвлөнө.

Ажилбар 1.2.3. Отрын бэлчээрийн газар

Цаг агаар хүндэрч ган, зуд тохиолдсон үед ашиглах нөөц нутгийг төлөвлөж өгөх ба отрын нөөц нутгийн байршил, хэмжээ, даац багтаамж, аль улиралд ашиглах, оторлох хугацаа, усан хангамж зэргийг тусгана.

Ажилбар 1.2.4. Мал тууврын зам, дамжин өнгөрөх бэлчээр

Сумын нутаг дэвсгэр дээгүүр дайран өнгөрдөг мал тууврын замын чиглэл, байршил, хэмжээ, хил заагийг тогтоон төлөвлөнө.

Ажилбар 1.2.5. Нөхөн сэргээх бэлчээрийн газрын төлөвлөлт

Тухайн сумын доройтсон, талхлагдсан, цөлжилтөд өртсөн бэлчээрийг өнжөөж амрах, сэлгээтэй ашиглах, тордон сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөж, байршил хэмжээ, хил зааг, хугацаа, төсөв зардал, түүний эх үүсвэр, хариуцах эзнийг тодорхой тусгана.

Ингэхдээ тухайн сумын хамгийн сүүлийн үеийн байдлаарх бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт болон бэлчээрийн фотомониторингийн үр дүнд тогтоогдсон бэлчээрийн сэргэх чадавхын зэрэгт нийцсэн сэлгэх, өнжөөж амрах арга хэмжээг төлөвлөлтийн нийт хугацаанд сайжруулах, хамгаалах зөвлөмжийн хамт төлөвлөнө.

Ажилбар 1.2.6. Усжуулах бэлчээр

Уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэх бүс нутагт өвс ургамал сайтай хирнээ ашиглалтгүй бэлчээрийн талбайг эргэлтэд оруулах, сумын төвөөс алслагдсан бэлчээр нутагт худаг, уст цэг бий болгож малчин өрхийг суурьшуулах, бэлчээрийн даац ачааллыг бууруулах зорилгоор усжуулах шаардлагатай бэлчээрийн талбайг төлөвлөж өгөх хэрэгтэй. /Хүснэгт 15/

Хүснэгт 15. Монгол орны байгалийн бүсэд мал усалгааны радиусыг

Бэлчээрийн байдал	Услалтын радиус, км		
	Бог мал ба үхэр	Адуу	Тэмээ
Уулын дунд зэрэг ургацтай	2.5	5.0	-
Хээрийн дунд зэрэг ургацтай	2.5	5.0	8.0
Нугын дунд зэрэг ургацтай	3.5	7.0	8.0
Цөлийн тачир ургацтай	4.0	8.0	10.0

Ажилбар 1.2.7. Эрчимжсэн суурин мал аж ахуйн бүс газрын төлөвлөлт

Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослуулан хөгжүүлэх хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор мал аж ахуйг эрчимжүүлэх үндсэн нөхцөл болох малын үүлдэрлэг байдлыг сайжруулан, ашиг шимийг нэмэгдүүлэх, одоо байгаа цэвэр, эрлийз малд тулгуурлан малын үүлдэр, угсааг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээг төлөвлөж өгөхийн зэрэгцээ хөгжүүлэх бүс нутгийн байршил, хэмжээ, хил заагийг тодорхойлно.

Ажилбар 1.2.8. Сүргийн эргэлт, бүтцийн төлөвлөлт

Сүргийн эргэлт, бүтцийн төлөвлөхдөө мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, ХААИС-ын хамтран гаргасан “Сүргийн нөхөн үйлдвэрлэлийн төлөвлөлт, сүргийн бүтэц эргэлтийг тооцох заавар”-ын дагуу дараах байдлаар төлөвлөнө.

Тайлант хугацаанд нэг төрлийн малын толгойн тоо, нас, хүйсний бүтцэд гарах өөрчлөлтийг сүргийн эргэлтээр харуулдаг. Сүргийн эргэлтийг үндэслэн уг салбараас үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээ, үйлдвэрлэлийн зардал, орлого, ашгийг тооцох тул мал аж ахуйн салбарын эдийн засгийн тооцоог сүргийн эргэлтээс эхлэнэ.

Сүргийн эргэлт нь тухайн аймаг, орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталгаажсан мал аж ахуйн талаар баримтлах бодлого, урт, богино хугацааны зорилтуудыг хэрэгжүүлэх, зах зээлийн эрэлтийг хангахуйц бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг хангасан сүргийн бүтцийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байх шаардлагатай. Мөн ямар төрлийн хэдэн толгой малтай байх нь бүс нутгийн бэлчээрийн даац, багтаамж, усан хангамжийн хүрэлцээ, малчин өрх, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэлээс хамаарна. Сүргийн эргэлтийг зохиоход дараах мэдээллүүд шаардагдана. Үүнд:

1. Өнгөрсөн оны эцэст тоологдсон малчин өрх, аж ахуйн нэгжийн малын тоо, нас, хүйс (мал тооллогын “А” данснаас авах)
2. Нас гүйцсэн үржлийн малын заазлалтын хувь
3. Төлөвлөгөөт онд гаднаас худалдаж авахаар төлөвлөсөн малын тоо
4. Гадагш борлуулахаар төлөвлөсөн малын тоо.
5. Малын зүй бусын хорогдолын хувь
6. Төлөвлөгөөт оны эцэст байх нийт малын дотор эх малын эзлэх хувь
7. Хээлтүүлэг, төллөлтийн төлөвлөгөө.
8. Хээлтэгч, хээлтэгч малын зохистой харьцаа

Сүргийн эргэлтийг тооцохдоо батлагдсан норм, норматив үзүүлэлтүүдийг удиртгал болгоно. Тухайлбал, 1986 оны улсын төлөвлөгөөний комиссын 283-р тогтоолоор баталсан төлөвлөлтийн нормативаас малын зүй бус хорогдлын хувь, 100 эхээс бойжуулах төлийн хувийг, 1996 онд Хүнс, хөдөө аж ахуйн яамны баталсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ашиглах норм, нормативын эмхэтгэлээс үржлийн малын хээтүүлэгт орох орох нас, хээлтэгчийн хээл тээх хугацаа, үржлийн малын заазлалтын хувь, сүү үйлдвэрлэлийн төлөвлөлтийг, ХХАА сайдын 2008 оны 97 тоот тушаалын 3-р хавсралтаар баталсан хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог тус тус авч ашиглана.

Сүргийн зохистой бүтэц: Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нь маш олон хүчин зүйлээс хамаарч, жил бүр харилцан адилгүй байдаг. Ялангуяа малчин өрхийн нэг жилд үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээ, нэгж бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд гарах зардал, ашиг, ашигт ажиллагаа зэрэг нь сүргийн бүтцээс хамаардаг. Тухайн төрлийн сүргийг бүрдүүлж байгаа янз бүрийн нас, хүйсний малын эзлэх хувийн жинг сүргийн бүтэц гэнэ. Сүргийн бүтэц нь тухайн бүс нутгийн байгаль цаг уурын онцлог, бэлчээрийн хүрэлцээ, тэжээлийн хангамж, малын төрөл, ашиг шимийн чиглэл, малын тоог өсгөх шаардлага, зах зээлийн эрэлт, хэрэгцээ зэргээс шалтгаалан хувьсан өөрчлөгдөж байдаг. Сүргийн бүтэц нь оны эхэнд болон байгаа нийт малын дотор тухайн нас, хүйсний мал хэдэн хувийг эзэлж байгааг илэрхийлсэн тоон үзүүлэлт юм. Гэхдээ сүргийн бүтцэд нийт малын доторх хээлтэгч малын эзлэх хувийн жин хамгийн чухал үүрэг гүйцэтгэнэ. Нийт мал сүргийн дотор хээлтэгч малын эзлэх хувийн жин зохистой байх нь сүргийн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн явуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зохицуулах үндсэн тулгуур нөхцлийг бүрдүүлнэ. Сүргийн бүтцийг бүрэлдэн тогтсон бүтэц зохистой бүтэц гэж ангилдаг. Бүрэлдэн тогтсон бүтэц нь удаан хугацааны туршид аяндаа бүрэлдсэн бүтэц юм. Харин сүргийн зохистой бүтэц гэдэг нь малын үүлдэр угсаа, үйлдвэрлэлийн чиглэлд зохицсон хамгийн их хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хамгийн их ашиг өгөх шаардлагад нийцсэн малын нас хүйсний харьцаа юм. /Хүснэгт 16/

Хүснэгт 16. Зохистой бүтэц, хувиар

№	Малын төрөл	Ашиг шимийн чиглэл	Нас, хүйсний бүтэц			
			Хээлтүүлэгч	Хээлтэгч	Сүрэг сэлбэх өсвөр эм	Эр, сувай
1	Тэмээ	Хосолмол	2.0	38	5	56
2	Адуу	Үржлийн	4.0	40	6	51
		Хэрэгцээний	3.0	35	6	56
3	Үхэр	Нутгийн	2.0	38	7	53
4	Сарлаг	Нутгийн	2.0	38	7	53
5	Хонь	Махны	2.0	70	13	15
		Ноосны	1.0	45	8	46
		Хосолмол	1.0	55	11	33
6	Ямаа	Ноолуурын	1	45	8	46
		Сүүний	2	70	13	15

Хүснэгт 17. Хээлтүүлэгч, хээлтэгчийн тохироо (толгой)

№	Малын төрөл	Хээлтүүлгийн арга		
		Ердийн	Гардан	Зохиомол
1	Тэмээ	1:20	1:30	-
2	Адуу	1:10	1:40	-
3	Үхэр	1:25	1:60	1:300
4	Сарлаг	1:25	1:60	-
5	Хонь	1:50	1:100	1:800
6	Ямаа	1:50	1:100	1:800

Хүснэгт 18. Үржилд анх орох нас (сараар)

№	Малын төрөл	Хүйс	Хээлтүүлэгт анх орох нас
1	Тэмээ	Буур	58
		Ингэ	46
2	Адуу	Азрага	48
		Гүү	36
3	Үхэр	Бух	25
		Үнээ	25
4	Сарлаг	Бух	28
		Үнээ	28
5	Бог мал	Хээлтүүлэгч	18
		Хээлтэгч	18

Хүснэгт 19. Хээлтэгчийн хээл тээх хугацаа, (сараар)

№	Хээлтэгчийн төрөл	Хоног	
		Дундаж	Хэлбэлзэл
1	Ингэ	400	390-405
2	Гүү	335	330-341
3	Үнээ (монгол)	285	280-288
4	Үнээ (сарлаг)	252	248-257
5	Эм хонь, ямаа	150	145-155

Сүргийн эргэлтийн төлөвлөлт: Сүргийн эргэлт нь оны эхэнд ба эцэст байх малын тоо, орлого, зарлага гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд орлого талд тухайн жилд эх сүргээс бойжуулах төл, худалдан авах, нас дэвшиж ирэх, бусдаас бэлэглэсэн, шилжиж ирсэн малын тоог, зарлага талд зах зээлд борлуулсан, маханд борлуулсан, үржилд худалдсан, нас дэвшсэн, зүй бусаар хорогдсон, хүнсэнд хэрэглэсэн малын тоог харуулна. Нас дэвшилтийн орлого, зарлага тэнцүү байна. Тухайн төрлийн малыг төллөх насанд нь нас гүйцсэнд тооцно.

1. Оны эхний мал: Төлөвлөгөөт оны эхний малын тоог А дансанд бүртгэгдсэн малын тоог үндэслэн тэдгээрийн төрөл, нас, хүйсээр нь ялган харуулна.
2. Орлого: Тухайн жилд эх сүргээс бойжуулах төл, худалдан авах, нас дэвшиж ирэх, бусдын хандивласан, бэлэглэсэн, малыг оруулан тооцно.
 - Худалдаж авах: Нийт малынхаа тоог өсгөх, чанарыг сайжруулах зорилгоор гаднаас худалдан авсан малын тоо.
 - Бойжуулах төл: Оны эхний хээлтэгч (ингэ 5+, гүү 4+, үнээ 3+, хонь, ямаа 2+ настай эм) малаас хээл авсан нийт малаас бойжуулахаар тооцсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлэх замаар төл бойжилтын хувийг тодорхойлно. Тухайн жилд хүлээн авсан төлийн эр, эмийн харьцааг 50:50 хувиар тооцно.

Хүснэгт 20. Оны эхний 100 хээлтэгчээс бойжуулах төлийн доод хэмжээ (Хувиар)

№	Малын төрөл	Бүс нутаг				
		Өндөр уулын	Ойт хээрийн	Тал хээрийн	Говийн	Их нуурын хотгор, говийн алтай
1	Ингэ	37	37	38	40	39
2	Гүү	62	60	65	55	55
3	Үнээ (монгол)	65	70	70	68	67
4	Үнээ (сарлаг)	65	70	60	60	65
5	Эм хонь	88	83	85	90	90
6	Эм ямаа	80	80	82	88	85

Тайлбар: 1986 оны улсын төлөвлөгөөний комиссын 283-р тогтоолоор баталсан төлөвлөлтийн нормативыг баримтлав.

- Нас дэвшиж ирэх: Оны эхний малын тооноос зарлагадсан тодорхой нас, хүйсний малын тоог хасч, үлдсэн малыг нас дэвшүүлнэ.
- Бусад орлого: Тухайн жилд бусдаас бэлэг, хандив, мөн өмнө жилүүдийн авлага зэргээс нэмэгдсэн малыг малын бусад орлого болгон харуулна.
- Орлогын дүн: Тайлант жилд эх сүргээс бойжуулах төл, худалдан авсан, нас дэвшиж ирсэн, бусдын хандивласан, бэлэглэсэн орлогын дүн тооцно.

Зарлага: Зах зээлд амьдаар болон нядалж борлуулсан, нас дэвшсэн, зүй бусаар хорогдсон, хүнсэнд хэрэглэсэн, үржилд худалдсан малын тоог зарлага талд харуулна.

- Зүй бусын хорогдол: Халдвартай, халдваргүй өвчин, ган, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, худаг, хавцалд унах зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг зүй бусаар хорогдсон малд тооцно. Малын нас, хүйс, бүс нутгийн онцлогийг харгалзан сүүлийн 3-5 жилд дээрх шалтгаануудаар хорогдсон малын тоог харгалзан зүй бусаар хорогдох малын тоог тооцож болох боловч бид энд оны эхний малаас 1986 оны улсын төлөвлөгөөний комиссын 283-р тогтоолоор баталсан төлөвлөлтийн норматив үзүүлэлтийг үндэслэн тооцохоор тусгав./Хүснэгт 21/

Хүснэгт 21. Малын зүй бус хорогдлын дээд хэмжээ (Хувиар)

№	Бүсийн нэр	Малын төсрөл											
		Тэмээ		Адуу Монгол		Үхэр				Хонь		Ямаа	
						Сарлаг							
		Нас гүйцсэн	Өсвөр	Нас гүйцсэн	Өсвөр	Нас гүйцсэн	Өсвөр	Нас гүйцсэн	Өсвөр	Нас гүйцсэн	Өсвөр	Нас гүйцсэн	Өсвөр
1	Өндөр уулын	3	5	2	3	3	4	3	4	3	4	3.5	4.5
2	Ойт хээрийн	4	6	3	4	3	5	3	5	3.5	4	4	5
3	Тал хээрийн	3.5	4.5	3	4	4	5	4	5	4.5	5	4.5	5
4	Говийн	2	3	3	4	3	4	3	4	3	4	3	4
5	Их нуурийн хотгор, говийн алтай	2	3	3	4	3	4	3	4	3	4	2	3

Хүснэгт 22. Мал заазлалтын жилийн норматив үзүүлэлт, (Хувиар)

№	Малын төрөл	Заазлалтын хэмжээ			Эр, сувай
		Хээлтүүлэгч	Хээлтэгч	Сүрэг сэлбэх өсвөр эм	
1	Тэмээ	7	7	Сүрэг сэлбэх эрэлт, хэрэгцээнд тулгуурлан заазлалтыг хийнэ.	*
2	Адуу	10	8		*
3	Үхэр	15	14		*
4	Сарлаг	15	14		*
5	Бог мал	20	15		*

Үржилд худалдах мал: Баталгаажсан цөм сүргийн малтай малчин тухайн нас, хүйсний малыг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан дараа үржилд зориулан худалдаж болно.

- Маханд борлуулах мал: Тайлант хугацаанд нядлаж зах зээлд борлуулах малын тоог энэ бүлэгт хамааруулна.
- Зах зээлд амьдаар худалдах мал: Үржлийн бус зориулалтын малыг амьдаар нь (худалдаалах, бэлэглэх, хандивлах гэх мэт) борлуулах малыг энэ бүлэгт хамааруулан тооцно.
- Дотоодын хэрэгцээнд: Малчин болон мал бүхий өрх, аж ахуйн нэгж өөрийн хүнсний хэрэгцээнд нядлаж ашигласан малын тоог дотоодын хэрэгцээнд хэрэглэсэн малд хамааруулна. Дотоодын хэрэгцээнд ашигласан малын арьс, ширийг худалдана хэмээн үзэж мал аж ахуйн орлогод оруулан тооцох хэрэгтэй.
- Нас дэвших мал: Оны эхний малаас зарлагууд (үржилд худалдах, зүй бус хорогдол, зах зээлд амьдаар болон маханд борлуулах, дотоодын хэрэгцээнд нийлүүлэх мал)-ыг хасаад үлдсэн хэсгээс малын тоог өсгөх шаардлагад нийцүүлэн сүрэг сэлбэхээр авч үлдсэн малыг нас дэвшүүлнэ гэж тооцно.
- Зарлагын дүн: Тухайн төрлийн малаас үржилд худалдах, зүй бусаар хорогдох, зах зээлд амьдаар болон маханд борлуулах, дотоодын хэрэгцээнд нийлүүлэхээр тооцсон нас хүйсний малын нийт дүнг зарлагын дүн болгон харуулна.
- Оны эцсийн мал
- Тоо толгой: Оны эхний малын тооноос малын нийт орлогыг нэмж нийт зарлагыг оны эцэст үлдэх малын тоог малын нас хүйс тус бүрээр гаргана.
- Сүргийн бүтэц: Оны эцэст байгаа малын нийт дүнд тухайн нас, хүйсний малын тооны эзлэх хувийг харуулсан үзүүлэлт юм.

Сүргийн эргэлтийн жишээ: Оны эхний 100 толгой малын сүргийн бүтцийг 2018 оны жилийн эцсийн улсын дундаж хээлтэгчийн эзлэх хувийн жингийн үзүүлэлтэд үндэслэн тооцсон жишээ.

Хүснэгт 23. Тэмээний аж ахуйн сүргийн эргэлтийн загвар

Нас, хүйс	Толгойн тоо оны эхэнд Худалдан авах	Орлого					Зарлага						Толгойн тоо оны эцэст	Сүргийн бүтэц %
		Төл	Нас дэвшин ирэх	Бусад	Орлогын дүн	Зүй бус хорогдол	Үржилд	Маханд	Захзээлд амьдаар	Дотоод хэрэгцээ	Нас дэвшин явах	Зарлагын дүн		
Хээлтүүлэгч	20								1			1	19	1.8
5 настай	Эр	80		76		76	2		5	2		9	147	13.9
	Эм	290		87		87	6		17		3	26	351	33.2
4 настай	Эр	80		85		85	2		1	1		76	80	8.0
	Эм	90		77		77	2		1			87	90	7.3
3 настай	Эр	90		58		58	3		2			85	90	5.5
	Эм	80		68		68	2			1		77	80	6.4
2 настай	Эр	60		68		68	2					58	60	6.4
	Эм	70		68		68	2					68	70	6.4
1 настай	Эр	70		58		58	2					68	70	5.5
	Эм	70		58		58	2					68	70	5.5
Төл	Эр		58			58						58	58	
	Эм		58			58						58	58	
Бүгд	1000	116	703			819	25	0	27	4	3	703	762	100.0

Хүснэгт 24. Адууны аж ахуйн сүргийн эргэлтийн загвар

Нас, хүйс	Толгойн тоо оны эхэнд Худалдан авах	Орлого					Зарлага						Толгойн тоо оны эцэст	Сүргийн бүтэц %
		Төл	Нас дэвшин ирэх	Бусад	Орлогын дүн	Зүй бус хорогдол	Үржилд	Маханд	Захзээлд амьдаар	Дотоод хэрэгцээ	Нас дэвшин явах	Зарлагын дүн		
Хээлтүүлэгч	30										2	2	28	2.4
4 настай	Эр	250		80		80	3		15	5		23	307	26.7
	Эм	350		100		100	7		18		2	27	423	36.8
3 настай	Эр	85		43		43	1	2	1	1		80	85	3.7
	Эм	105		48		48	1	2	1		1	100	105	4.2
2 настай	Эр	45		39		39	1		1			43	45	3.4
	Эм	50		44		44	1			1		48	50	3.8
1 настай	Эр	40		109		109	1					39	40	9.5
	Эм	45		109		109	1					44	45	9.5

Төл	Эр			109			109					109	109			
	Эм			109			109					109	109			
Бүгд		1000		218	572		790	16	4	36	7	5	572	640	1150	100.0

Хүснэгт 25. Үхрийн аж ахуйн сүргийн эргэлтийн загвар

Сарлаг - 2019 он															
Нас, хүйс		Толгойн тоо оны эхэнд Худалдан авах	Орлого					Зарлага						Толгойн тоо оны эцэст	Сүргийн бүтэц %
			Төл	Нас дэвшин ирэх	Бусад	Орлогын дүн	Зүй бус хорогдол	Үржилд	Маханд	Захз ээлд амьдаар	Дотоод хэрэгцээ	Нас дэвшин явах	Зарлагын дүн		
Хээлтүүлэгч		16					0	1	3				4	12	1.0
3 настай	Эр	76			146		146	3		48		2	53	169	14.0
	Эм	320			131		131	13		45			58	393	32.6
2 настай	Эр	152			144		144	6					146	152	14.0
	Эм	136			144		144	5					131	136	12.0
1 настай	Эр	150			171		171	6					144	150	14.2
	Эм	150			171		171	6					144	150	14.2
Төл	Эр			171			171						171	171	
	Эм			171			171						171	171	
Бүгд		1000		342	907		1249	40	3	93		2	907	1045	100.0

Хүснэгт 26. Хонины аж ахуйн сүргийн эргэлтийн загвар

Нас, хүйс		Толгойн тоо оны эхэнд Худалдан авах	Орлого					Зарлага						Толгойн тоо оны эцэст	Сүргийн бүтэц %
			Төл	Нас дэвшин ирэх	Бусад	Орлогын дүн	Зүй бус хорогдол	Үржилд	Маханд	Захзээлд амьдаар	Дотоод хэрэгцээ	Нас дэвшин явах	Зарлагын дүн		
Хээлтэгч		12							2				2	10	0.9
2 настай	Эр	140			53		53	4		49		2	55	138	12.0
	Эм	550			89		89	17		70	8	6	101	538	46.5
1 настай	Эр	158			234		234	5		100			53	158	20.3
	Эм	140			234		234	6	15		30		89	140	20.3
Төл	Эр			234			234						234	234	
	Эм			234			234						234	234	
Бүгд		1000		468	610		1078	32	17	219	38	8	610	924	100.0

5.4. Бүтээгдэхүүн, түүхий эд үйлдвэрлэлийн төлөвлөлт

Хүснэгт 27. Нядалж борлуулсан малын мах үйлдвэрлэлийн төлөвлөгөө

№		1	2		3		4		5		6		Бүгд
Малын нас, хүйс		Хээлтүүлэгч Эр	5+ настай		4+ настай		3+ настай		2+ настай		1+ настай		
			Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм		
Тэмээ	Нядлах малын тоо												
	1 малын амьдын жин, кг	550	540	460	425	415	380	330	310	290	210	200	
	Нядлагын гарц, хувь	47	50	50	52	51	51	50	49	48	48	47	
	Борлуулах нийт мах, кг												
Адуу	Нядлах малын тоо												
	1 малын амьдын жин, кг	350			300	285	250	235	215	200	180	175	
	Нядлагын гарц, хувь	48			50	51	47	48	45	46	45	46	
	Борлуулах нийт мах, кг												
Үхэр	Нядлах малын тоо												
	1 малын амьдын жин, кг	500					350	330	300	270	230	200	
	Нядлагын гарц, хувь	50					52	52	50	49	49	48	
	Борлуулах нийт мах, кг												
Сарлаг	Нядлах малын тоо												
	1 малын амьдын жин, кг	450					240	230	175	173	117	113	
	Нядлагын гарц, хувь	51					46	51	46	44	44	44	
	Борлуулах нийт мах, кг												

Хонь	Нядлах малын тоо												
	1 малын амьдын жин, кг	65						60	55	48	43		
	Нядлагын гарц, хувь	50						48	48	44	44		
	Борлуулах нийт мах, кг												
Ямаа	Нядлах малын тоо												
	1 малын амьдын жин, кг	50						45	42	30	27		
	Нядлагын гарц, хувь	50						44	44	40	40		
	Борлуулах нийт мах, кг												

Тайлбар: Тэмээний амьдын жинг говийн бүс нутгаар, адуу, хонины амьдын жинг тал хээрийн бүс нутгаар, сарлагын амьдын жинг өндөр уулын бүс нутгаар, үхрийн амьдын жинг ойт хээрийн бүс нутгаар, ямааны амьдын жинг их нуурын хотгор, говийн алтай бүс нутгаар тус тус авлаа. /Хүснэгт 27/

Хүснэгт 28. Мал борлуулалтын орлого (мян.төг)

Нас, хүйс Тоо хэмжээ		Үржилд худалдах			Амьдаар нь зах зээлд борлуулах		
		Нэг бүрийн үнэ	Бүгд орлого	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд орлого	
Хээлтүүлэгч							
5 ба дээш настай	Эр						
	Эм						
4 настай	Эр						
	Эм						
3 настай	Эр						
	Эм						
2 настай	Эр						
	Эм						
1 настай	Эр						
	Эм						
Төл							

Хүснэгт 29. Дайвар бүтээгдэхүүний борлуулалтын орлого (мян.төг)

№	Малын төрөл	Арьс, шир			Толгой, шийр			Цувдай		
		Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд орлого	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд орлого	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд орлого
1	Тэмээ									
2	Адуу									
3	Үхэр									
4	Сарлаг									
5	Хонь									
6	Ямаа									

Тайлбар: арьс, ширийг жин болон талбайгаар үнэлэх бол боловсруулаагүй арьс, ширний (MNS0060:2013) техникийн ерөнхий шаардлагыг дагаж мөрдөнө.

Хүснэгт 30. Ноос, ноолуур, хөөвөр үйлдвэрлэлийн төлөвлөгөө, (мян.төг)

№		1	2		3		4		5		6		Бүгд дүн, кг	Нэг бүрийн үнэ	Бүгд орлого
Малын нас, хүйс		Хээлтүүлэгч Эр	5 + настай		4 настай		3 настай		2 настай		1 настай				
			Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм				
Тэмээ	Ноос	8.1	5.3	5.6	4.9	4.7	4.7	4.6	3.7	3.9	2.6	2.8			
Адуу	Хялгас	0.3			0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3			
	Хөөвөр	0.4			0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4			
Сарлаг	Хөөвөр	2.6			1.9	1.6	1.9	1.6	1.8	1.6	1.6	1.5			
Хонь	Ноос	1.9							1.9	1.6	1.5	1.3			
Ямаа	Ноолуур	0.5							0.5	0.4	0.3	0.3			

Хүснэгт 31. Сүү үйлдвэрлэлийн төлөвлөгөө, (мян.төг)

Нийт хээлтэгчийн тоо	Төл малын тоо	Саалинд хамрагдах малын хувь	Нэг малаас жилд саах сүү, л	Нийт саах сүү, л	Нэг бүрийн үнэ	Бүгд орлого
Ингэ		100	300			
Гүү		40	250			
Үнээ (монгол)		80	350			
Үнээ (сарлаг)		80	280			
Эм хонь		70	15			
Эм ямаа		70	25			

Тайлбар: 1986 оны улсын төлөвлөгөөний комиссын 283-р тогтоолоор баталсан төлөвлөлтийн норматив. /Хүснэгт 28 - Хүснэгт 31/

Дэд бүрэлдэхүүн хэсэг 1.3. Хадлангийн газрын төлөвлөлт

Ажилбар 1.3.1. Нэмэгдэл тэжээлийн хэрэгцээ тооцох

Малын нэмэгдэл тэжээлийн хэрэгцээг тооцсоноор хадлангийн газрын хүрэлцээ хангамжийг тооцох үндэс

Нэмэгдэл тэжээлийн хэрэгцээг тооцохдоо малын тарга хүчийг аль болох бууруулахгүй байх, турж доройтсон малыг онд бүрэн оруулах зорилтыг гол болгоно.

Бэлчээрийг маллагааны нөхцөлд малыг жил бүрийн арванхоёрдугаар сараас тавдугаар сар хүртэл говийн бүсэд 60, тал хээрт 90, ойт хээрт 120 хоног тэжээх шаардлагатай.

Нэмэгдэл тэжээлийн хэрэгцээ хангамжийг тодорхойлохдоо юуны өмнө тэжээх малын тоог зөв тогтооно. Хонь, ямаа, үхрийн 50 хувь, тэмээний 10 хувь, адууны 4 хувийг нэмэгдэл тэжээлд хамруулна.

Өвөл, хаврын улиралд хоногт бэлчээрийн маллагааны нөхцөлд 1 хонин толгойд 5.5 МДж, байран маллагааны нөхцөлд 13.2 МДж солилцлын энергитэй ерөнхий шимт чанартай тэжээлийг өгөх шаардлагатай

Таримал тэжээл ашиглахад малыг хонин толгойд шилжүүлэх коэффициентыг хүснэгт 23-д үзүүлсний дагуу тооцно. /Хүснэгт 32/

Хүснэгт 32. Таримал тэжээл ашиглахад малыг хонинд шилжүүлэх коэффициент

Үзүүлэлт	Хонь		Үхэр		Ямаа	Адуу	Тэмээ	Бодын төл	Богийн төл
	Нут-гийн	Цэвэр эрлийз	Нут-гийн	Цэвэр эрлийз					
Хонин толгойд шилжүүлэх коэффициент	1.0	1.2	6.0	8.0	0.9	6.6	5.7	1.4	0.2

Сумын зохистой сүргийн бүтэц бүхий бэлчээрийн даацад тохирсон малын тоог хонин толгойд шилжүүлсэн дүнг 1 хонин толгойд шаардлагатай нэмэгдэл СоЭ-ийн хэмжээ болон байгалийн бүсээс шалтгаалсан тэжээх хоногийн тоогоор үржүүлж тухайн сумын бэлчээрийн даацад тохирсон нийт малд шаардлагатай нэмэгдэл тэжээлийн хэрэгцээг тооцно. Сумын бэлчээрийн даацад тохирсон нийт малд шаардлагатай нэмэгдэл тэжээлийн СоЭ-ийн хэмжээг 1 кг өвсөнд агуулагдах дундаж СоЭ хэмжээ буюу 4.95 МДж-д харьцуулан шаардлагатай өвсний хэмжээг тооцно.

Дээрх аргачлалын дагуу төлөвлөлтийн хугацаан дахь сүргийн эргэлт, бүтцийг жил бүрээр тооцсон малын тоотой уялдуулан шаардагдах тэжээлийн хэрэгцээг жил тус бүрээр ялгаатай тооцно.

Ажилбар 1.3.2. Хадлангийн талбайн төлөвлөлтийг хийх

Хадлангийн талбайн байршил, нөөц, хүрэлцээ, нэмэгдэл тэжээлийн хэрэгцээ, төлөв байдал болон ашиглалт зэргийг үндэслэн хадлангийн газрын ашиглалтыг эрчимжүүлэх, хамгаалах, тордон сайжруулах ба нөхөн сэргээх, аймаг дундын болон сум дундын хадлангийн газар бий болгох, хадланд тохиромжтой бэлчээрийн газраас байгалийн хадлан бэлтгэх, таримал хадлан

эрхлэх талбайнуудын байршил, хэмжээ, хил зааг, 1 га талбайгаас авах ургацын хэмжээ, ургамлын шимт чанар гэх зэрэг үзүүлэлтээр тооцож төлөвлөгөөнд тусгаж өгнө.

- а. Байгалийн хадлан;
- б. Таримал хадлан;
- в. Хөцөөлсөн хадлан /хашаалсан/;

Ойн зах, цоорхой, голын булан, тохой болон чийгийн хангамж сайтай буюу олон жилийн хур тунадасны үзүүлэлт өндөр, ургамлын төрөл, зүйлийн бүрдэл элбэг, харьцангуй тэгш талбайд, цаашид уг талбайг тордож сайжруулах боломжтой байх нөхцөлүүдийг хангаж байгаа газрыг шинээр хадланд ашиглана. Хадлангийн талбай нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Нэг га-гын ургац 4.0 цн-ээс доошгүй;
- Ургамлын иш навч нь хадгалагдах чадвар сайтай;
- Ургамлын өндөр 15-20 см-ээс доошгүй;
- Дов сондуул, бут сөөг, чулуугүй;
- Машин, техник ажиллах боломж бүхий гадаргатай талбай байна.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 1.4. Тариалангийн газрын төлөвлөлт

Ажилбар 1.4.1. Тариалангийн газрын хэрэгцээт байдлыг тодорхойлох

Төлөвлөлтийн хугацаанд шаардагдах үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тосны ургамал зэрэг таримал ургамлын хэмжээг талбайн нэг нэгжээс авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээгээр тодорхойлж болно.

Хүн амын хүнсний хэтийн хэрэгцээг гаргахад хүн амын тоог төлөвлөлтийн хугацаагаар тодорхойлсон байна. Тариалангийн газрын хэрэгцээт байдлын үнэлгээг ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/02 тоот тушаалаар батлагдсан “Тариалангийн газрын хэрэгцээт байдлын үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийнэ.

Ажилбар 1.4.2. Тариалангийн газрыг төлөвлөх

Хот, суурины хүн амын хүнсний аюулгүй байдал болон хэрэгцээг баталгаатай хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хот орчмын тариаланд тохиромжтой газрын нөөцийг тогтоож байршил, хэмжээг зурагт буулган харуулна.

Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээнд үндэслэн тариаланд тохиромжтой газруудыг тодорхойлж зураглана.

Тухайн сумын нутаг дэвсгэрт усалгаатай болон усалгаагүй газар тариалан хөгжүүлэх бүс газрын хөрсний нөхцөл, усалгааны нөхцөл, гадаргын төрх байдал, байршил, хэмжээ, хил зааг, тариалах ургамлын төрөл зэргийг төлөвлөгөөнд тусгана.

Мөн атаршсан талбайн цаашдын ашиглалт, элэгдэл эвдрэлд орсон хөрсийг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг дээшлүүлэх, услалтын системийн сэргээн засварлалт гэх зэргээр төлөвлөж байгаа арга хэмжээний байршил, хэмжээ, шаардагдах хөрөнгийн эх үүсвэр ба хэмжээ, хариуцах эзнийг тодорхой тусгана.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 1.5. Хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн газар

Аймаг, сумаас баримталж байгаа хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөдөө аж ахуйн барилга, байгууламжийг бий болгох газрын байршил, хэмжээг төлөвлөгөөнд тусгаж өгнө. Ингэхдээ хуучин ашиглаж байгаад орхигдсон, тоногдож эвдэрсэн барилга байгууламжийн суурийг ашиглах бодлого баримтлах нь зүйтэй.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 1.6. Хөдөө аж, ахуйн газрын төлөвлөлтийн тоон зураг боловсруулах

Хөдөө аж, ахуйн газрын төлөвлөлтийн тоон зураг боловсруулахдаа энэ арга зүйн хавсралт 3-ын дагуу боловсруулна.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2. ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИН ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Дэд бүрэлдэхүүн хэсэг 2.1. Ерөнхий зүйл

Хот, тосгон, бусад суурин газрын төлөвлөлтийг хийхдээ Монгол улсын “Хот байгуулалтын тухай”, “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай” хууль болон бусад хууль, тогтоомжийг үндэслэн төлөвлөнө. Энэхүү газрын төлөвлөлтийг тухайн хот, суурин газрын хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөнө.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 2.2. Хот, тосгон, бусад суурин газрын ашиглалт, бүсчлэлийг тогтоох

Ажилбар 2.2.1. Одоогийн байдалд дүгнэлт хийх

Газар ашиглалтын одоогийн байдлын давуу болон сул талуудын харьцуулалт, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүдийн тодорхойлолт, суурьшлын бүсийн экологи зэрэгт үнэлгээ хийнэ.

- Газар ашиглалтын одоогийн байдал

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь газрыг үр ашигтай ашиглаж байгаа эсэхийг дараах шалгуур үзүүлэлтийг харгалзан үнэлнэ.

- Тухайн газарт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд нь орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгаа, ажлын байр нэмэгдүүлсэн эсэх;
- Газар хамгаалах, үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авсан эсэх;
- Газрыг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх;

- Суурьшлын бүс дэх орц, гарц гаргах шаардлагатай байршлыг тодорхойлох;
- Маргаантай асуудлууд байгаа эсэхийг тодорхойлох;

Хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүд

- Үйлдвэрлэл, үйлчилгээний үр нөлөө, үзүүлж байгаа үр дүн;
- Зам, дэд бүтэц;
- Хүн ам;

Эдгээр үзүүлэлтийг “Хот суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар”-ын дагуу үнэлнэ.

Тухайн суманд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зохиогдсон тохиолдолд нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой эсэх, бодит байдалтай нийцсэн эсэхэд Хот суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, хот байгуулалтын хэрэгцээт байдлын үнэлгээнд тус тус үндэслэн дүн шинжилгээ хийнэ.

Одоо байгаа хот суурин газрын эдэлбэр газрын хил зааг, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл тогтоож, төлөвлөлт хийсэн газрын хил заагийг тэлж хот суурины ангилалд шилжүүлэх шаардлагатай эсэхийг судална.

Мөн сумын төвийн хот суурины эдэлбэр газрын гадна хөдөөгийн суурин, багийн төв, улсын чанартай авто зам дагуу газар өмчлүүлэх газар шинээр төлөвлөх тохиолдолд ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А04 дугаар тушаалаар батлагдсан “Шинээр суурьшил үүсгэх газарт газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу төлөвлөнө.

Ажилбар 2.2.2. Хот суурины газрын хэрэгцээт байдлын үнэлгээ.

Хот суурины газрын хэрэгцээ, шаардлагыг үнэлэхдээ төлөвлөлтийн хугацааны хүн амын өсөлтийг тооцно. Хүн амын өсөлтийг тооцохдоо Үндэсний статистикийн хорооноос гаргасан статистик тоон мэдээллийг ашиглан дараах аргачлалын дагуу боловсруулна.

$$N_t = N_0(1 + Kt)$$

N_t - төлөвлөлтийн хугацааны хүн амын тоо, хүн

N_0 - Одоо байгаа хүн ам, хүн

K - Хүн амын жилийн дундаж өсөлтийн итгэлцүүр

t - Төлөвлөлтийн хугацаа, жил

Хүн амын жилийн дундаж өсөлтийн итгэлцүүрийг тооцохдоо тухайн онд төрсөн нийт хүүхдийн тооноос нас барсан нийт хүний тоог хассан дүн дээр хугацааны эхнээс эцэс хүртэлх шилжиж ирсэн хүн амын тооноос хугацааны эхнээс эцэс хүртэлх шилжиж явсан хүн амын тоог хассан дүнг нэмээд жилийн эцсийн хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$K = ((TT - НБТ) + (In - Out)) / XA$$

К - Хүн амын жилийн дундаж өсөлтийн итгэлцүүр

ТТ - Төрсөн нийт хүүхдийн тоо

НБТ - Нас барсан нийт хүний тоо

ХА - Жилийн эцсийн хүн амын тоо

In - Хугацааны эхнээс эцэс хүртэлх шилжин ирэлт

Out - Хугацааны эхнээс эцэс хүртэлх шилжин явалт

Төлөвлөлтийн хугацааны хүн амын тоог чиг үүргийн бүсэд 1 хүнд шаардагдах газрын хэмжээгээр үржүүлэх замаар тооцно. 1 хүн, өрхөд ноогдох шаардлагатай талбайн хэмжээг “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНбД 30.01.03-д заасны дагуу тогтооно. Тухайлбал:

- Гэр хороолол, нам давхрын сууцны бүс газрын хэмжээ - 1000 хүнд 22 га-гаас багагүй нутаг дэвсгэр (Талбайн хэмжээг тогтоохдоо тухайн сумын ИТХ-аас тогтоосон нэг иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын дээд хэмжээ харгалзана. Хэрэв өмчлүүлэх газрын дээд хэмжээг ИТХ-аар тогтоогоогүй тохиолдолд тухайн сумын иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлж ирсэн нийтлэг хэмжээг харгалзан үзнэ);
- Ногоон байгууламжийн бүс - 1 хүнд 5-6 м²;
- Олон нийтийн бүс – Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, биеийн тамирын талбай, соёл урлагийн байгууллага, худалдаа нийтийн хоол, ахуйн үйлчилгээ гэх мэт газруудын эдэлбэр газрын хэмжээ;
- Инженерийн байгууламж, шугам сүлжээ – цэвэрлэх байгууламж, хог хаягдлын цэгийн эдэлбэр газрын хэмжээ гэх мэт.

Ажилбар 2.2.3. Газар ашиглалтын бүсчлэлийг тогтоох

Хот, тосгон, бусад суурины газрын төлөвлөлтөд чиг үүргийн бүсүүдийг хот байгуулалтын тухай хуульд нийцүүлэн “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНбД 30.01.04-ийн дагуу тухайн сумын газар ашиглалтын онцлогт нийцүүлэн дараах агуулгад уялдуулан тогтооно. Үүнд:

1. Орон сууцны бүс, олон нийтийн бүс
2. Үйлдвэрийн бүс
3. Инженерийн шугам, сүлжээний бүс
4. Ногоон байгууламжийн бүс
5. Хот орчмын хөдөө аж ахуйн бүс
6. Тусгай зориулалтын бүс
7. Зуслангийн бүс
8. Холимог бүс

Чиг үүргийн бүсүүдийн зургийг хамрах талбайг 1:1000-1:10000 масштабаар “Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг MNS 6736:2018”-ийн стандартын дагуу зураглаж төлөвлөнө.

Ажилбар 2.2.4. Нам давхрын орон сууцны болон гэр хорооллын бүсийн дотоодын зохион байгуулалтын төлөвлөгөө

Тухайн суманд Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө зохиогдоогүй тохиолдолд Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсэгт заасны дагуу Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг эзэмшүүлж, өмчлүүлэх газрыг газар ашиглалтын бүсчлэлд нийцүүлэн төлөвлөнө.

Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх, өмчлүүлэх газрын дотоод зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах зөвлөмж.

1. Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх, өмчлүүлэх газрыг нэгж талбар бүрээр төлөвлөх бөгөөд нэгж талбарын талбайн хэмжээг холбогдох, хууль тогтоомжийн дагуу болон тухайн орон нутгийн ИТХ-аар тогтоосон иргэнд өмчлүүлэх газрын хэмжээтэй нийцүүлэн тогтоох;
2. Нэг гудамж буюу эгнээ үүсгэн байрласан хашаануудын тоо 10-аас ихгүй байх 5-аас багагүй байх, 5-10 хашаа бүхий урт гудамж үргэлжилсний дараа 18 метрээс багагүй босоо өргөн чөлөө үүсгэн дараагийн гудамж үүсгэж төлөвлөх;
3. Босоо өргөн чөлөөний захад байршилтай хашаа, айл өрхүүд хашаандаа босоо, чөлөөний зүг харсан худалдаа үйлчилгээний барилга байгууламж барихаар буюу аж ахуйн зориулалтаар ИААНБ-ын эзэмшил, өмчлөлд олгохоор төлөвлөх;
4. Нэг гудамж буюу эгнээ үүсгэн байрласан хашаануудын нийт урт хашаануудын талбайн хэмжээнээс шалтгаалан 5 эгнээ хашааны дунд 8 метр хүртэл өргөнтэй туслах босоо гудамж гаргах;
5. Инженерийн шугам сүлжээний гол магистрал шугамыг босоо гудамж, чөлөөний дагуу схемчлэн төлөвлөх;
6. Гэр хорооллын хоёр эгнээг нийлүүлэн урагш, хойш харсан байдлаар давхар эгнээ гудамж байхаар төлөвлөнө. Давхар эгнээ хоорондын зай 12 метрээс багагүй байх;
7. Хэрэв хашаа, эдлэн газрын доторх барилга байгууламжийг төлөвлөх тохиолдолд барилга байгууламжийг хашаанаас хамгийн багадаа 1.5 метр зайтай байхаар төлөвлөх;
8. Иргэдийн хэрэгцээ, шаардлага, тухайн байршлын хөрс, ургамлын шинж чанар, газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, тохиромжтой байдлын үнэлгээнд үндэслэн өрхийн хэрэгцээний жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхлэхэд шаардагдах талбайг эдлэн газрын хэмжээнд нэмж тооцон төлөвлөж болно;

9. Тухайн байршилд байгуулах цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн нийт талбайг ирээдүйд суурьших хүн амын нэг хүнд $5-6 \text{ м}^2$ –с дээш талбай ногдохоор тооцоолно;
10. Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх, өмчлүүлэх газрын дотоод зохион байгуулалтыг хийж гудамж, авто болон явган хүний замыг нэгж талбарын төлөвлөлтийг гүйцэтгэсний дараа Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ын дагуу баримтлан гудамж, зам талбай хашааны хаягжилт, дугаарлалтыг агуулсан хаягийн төслийн зураг хийнэ.
11. Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх, өмчлүүлэх газрын тоон зургийг боловсруулахдаа ГХГЗЗГ-ын даргын 2013 оны 140 дүгээр тушаалаар батлагдсан “Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зурган мэдээлэл боловсруулах заавар”-ыг баримтална.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Дэд бүрэлдэхүүн хэсэг 3.1. Ерөнхий хэсэг

Зам, шугам сүлжээний газрын эрх нь нийтээр ашиглах төрийн өмчийн эрхийн харилцаагаар зохицуулагдах ба “Газрын тухай”, “Авто замын тухай” хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэж төлөвлөлтийг хийнэ.

Зам, шугам сүлжээний газрын нөөц, ашиглалт, хамгаалалт, газар зохион байгуулалтыг шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдал болон хэрэгцээт байдлын үнэлгээнд тулгуурлан салбаруудын бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулна.

Зам, шугам сүлжээний газрын төлөвлөлтийг боловсруулахдаа хот суурины эдэлбэр газрын доторх болон гаднах гэсэн 2 түвшинд төлөвлөнө.

Хот, суурины эдэлбэр газрын доторх зам, шугам сүлжээний газрыг төлөвлөхдөө холбогдох норм дүрэм, стандартын дагуу тухайн шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоосон хамгаалалтын зурвас газрын хамт төлөвлөнө.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 3.2. Төмөр замын газрын төлөвлөлт

Ажилбар 3.2.1. Шинээр төмөр зам, төмөр замын объектийг шинээр барьж байгуулах

Төмөр зам баригдах үндэслэл, хэрэгцээ, төмөр замын суурь бүтцийн газар, ложистик, терминал байгуулах газрын байршил, хамрах газрын хэмжээг тогтоож төлөвлөнө.

Ажилбар 3.2.2. Төмөр замын зурвас газар

Төмөр замын зурвас газрын өргөн нь төмөр замын өртөөн дээр 300 м, өртөөнүүдийн хооронд 120 м байна. Энэхүү зурвас газарт хоорондын болон салбар зам шугам, үйлдвэрлэл технологийн барилга, төмөр замын холбоо дохиолол, замын далан, гарам, гүүр, үерийн хамгаалалт зэрэг байгууламжууд байрлахаас гадна төмөр замын шугамын дагуу тээврийн аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай орон зайг багтаана. Төмөр замын зурвас газарт дараах үйл ажиллагааг төлөвлөхийг хориглоно. Үүнд:

- а. малын бэлчээр;
- б. төмөр замд холбогдолгүй үйлдвэрлэл, үйлчилгээ;
- в. аюул хөнөөлтэй бодис үйлдвэрлэх;
- г. хадгалах, ачих буулгах объект барих;
- д. суурьшлын бүс, төмөр замын байгууллага;
- е. орд карьер нээж ашиглах;
- ё. өндөр хүчдэлийн болон холбооны баганат шугам барих, кабелин шугам тавих;
- ж. жимсний мод суулгах;

Дэд бүрэлдэхүүн хэсэг 3.3. Авто замын газрын төлөвлөлт

Ажилбар 3.3.1. Шинээр авто зам барьж байгуулах

Тухайн аймгийн нийт ачаа эргэлт, зорчигч тээврийн үйлчилгээ, замын чанар, инженер-геологийн нөхцөлд үнэлэлт өгч хатуу хучилттай болон сайжруулсан зам барих, засаж сайжруулах замын чиглэл, маршрут, барьж байгуулах гүүрийн байршил, төрөл, хэмжээг тогтооно.

Авто замын төрлийн ангилал болон хучилтын төрлөөр нь Хүснэгт 33-д үзүүлсний дагуу ангилж, зурвас газрын хамт төлөвлөнө. Ингэхдээ Хүснэгт 34-т үзүүлсэн автозамын хөндлөн огтлолын үндсэн хэмжээнүүдийг харгалзан замын өргөний хэмжээг тогтооно.

Хүснэгт 33. Авто замын зурвас газрын хэмжээ

№	Авто замын төрөл	Хамаарагдах зам	Зурвас газрын өргөн /м/
1	Улсын чанартай авто зам	Улс хооронд Нийслэлийг аймгийн төвүүдтэй Аймгийн төвүүдийг хооронд Хилийн боомтуудтай холбосон	100
2	Орон нутгийн чанартай авто зам	Аймгийн төвийг сумын төвтэй	60
3	Аж ахуйн дотоодын гол зам	Сумын төвийг багийн төвтэй Төмөр замын өртөө зөрлөгтэй холбосон зам	20
4	Хээрийн гол зам	Аж ахуйн төвийг үйлдвэрлэлийн төвтэй холбосон / зуслан, намаржаа, өвөлжөө/	
5	Байнгын хээрийн зам	Хадлан, тариалангийн зам	

6	Хөдөөгийн тосгон суурингийн доторх зам	Аймгийн болон сумын төвийн тэг гортиг доторх зам	4-8
---	--	--	-----

Хүснэгт 34. Хөндлөн огтлолын үндсэн хэмжээнүүд

Замын төрөл	Хөдөлгөөний зурвас, м		Хөвөөний хэмжээ, м		Зааглах зурвасны хамгийн бага өргөн, м
	Тоо	Өргөн	Бүрэн өргөн	Хучлагатай хэсэг	
Хурдны зам	≥4	3.75	3.75	0.75	5
I зэргийн	≥4	3.75	3.5	0.75	2
II зэргийн	2-3	3.75	3.0	0.75	0
III зэргийн	2	3.5	2.0-2.5	0.5	0
IV зэргийн	2	3.0	1.5-2.0	0.5	0
V зэргийн	1	4.5-5.0	1.0	0	0

Зам барихад шаардагдах материал олборлох карьер, замын барилга байгууламжийн материал бэлтгэх зориулалтаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах газрын байршил, хэмжээг тогтооно.

Аймаг, сумын хурдан морины уралдааны зам, маршрутын газрыг төлөвлөж зураглана.

Ажилбар 3.3.2. Авто зам, барилга байгууламжийг засаж, сайжруулах

Тухайн аймгийн нийт ачаа эргэлт, зорчигч тээврийн үйлчилгээ, замын чанар, инженер-геологийн нөхцөлд үнэлэлт өгч хатуу хучилттай болон сайжруулсан зам барих, засаж сайжруулах замын чиглэл, маршрут, барьж байгуулах гүүрийн байршил, төрөл, хэмжээг тогтооно.

Ажилбар 3.3.3. Бусад

Зам, шугам сүлжээний газарт сервитут тогтоох газар, хүн, мал, ан амьтан нүүдэллэх, нэвтрэх, дайран өнгөрөх гарц, коридор гаргах газрын байршил, хэмжээг төлөвлөнө.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 3.4. Агаарын тээврийн газрын төлөвлөлт

Ажилбар 3.4.1. Шинээр байгуулах агаарын тээврийн газар

Нисэх буудал, хөөрч буух хамгаалалтын бүсийн газрын байршил, хамрах газрын хэмжээг төлөвлөнө.

Агаарын тээврийн тусгай бүсийг нисэх онгоц хөөрөх буух зурвасын дагуу нэг болон хоёр чиглэлд 4300 м, түүний зэрэгцээ 2 тийш 1000 м байхаар тус тус тооцож төлөвлөнө.

Нисэх буудлын зориулалтаар ашиглагдах газрын хэмжээг аэродромын тусгай бүсийн талбайн хэмжээн дээр агаарын тээврийн үйлчилгээний барилга, байгууламжийн цогцолбор түүний эдэлбэр газрын хэмжээг нэмж тооцно.

Агаарын тээврийн тусгай бүсэд мал нядалгаа, ус цэвэрлэх байгууламж, хогийн цэг, дунд болон өндөр давхрын барилга, мод үржүүлэг, зам, цахилгаан дамжуулах болон агаарын холбооны шугам гэх мэт шувуу ихээр цуглуулах объект төлөвлөхийг хориглоно.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 3.5. Эрчим хүч, харилцаа холбоо газрын төлөвлөлт

Ажилбар 3.5.1. Цахилгаан эрчим хүчний хэрэгцээ шаардлагыг тооцох

Тухайн сумын эрчим хүчний хэрэгцээ шаардлагыг төлөвлөлтийн хугацаанд “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04-ийн дагуу тооцож одоогийн хүрэлцээ хангамжтай уялдуулан шинээр эрчим хүчний барилга байгууламж, шугам сүлжээний дэвсгэр газар болон түүний хамгаалалтын зурвас газрын хэрэгцээ шаардлагыг тооцно.

Ажилбар 3.5.2. Шинээр байгуулах эрчим хүч, харилцаа холбооны газар

Эрчим хүчний барилга байгууламж, цахилгаан дамжуулах шугам сүлжээ, байгалийн хий, нефть дамжуулах хоолой, харилцаа холбооны шугам сүлжээ барих газрын трасс, дайран өнгөрөх, нэвтэрч гарах сервитут тогтоох газар, хөрөнгө оруулалтын хэмжээг тооцож төлөвлөнө.

Цахилгаан дамжуулах шугам, холбооны шугам болон бусад орон нутгийн зориулалттай шугамуудыг зам дагуулж, тариан талбай, ойн зурвасын хил дагуу аль болохоор хөдөө аж ахуйн эдэлбэр газар дундуур дайрахгүй нутаг дэвсгэрт байрлуулж төв шугамтай чөлөөтэй холбогдохоор төлөвлөнө.

Цахилгаан дамжуулах шугам, холбооны шугам болон бусад орон нутгийн зориулалттай шугамуудыг **хамгаалалтын зурвас газрыг өргөнийг** агаарын баганат шугамаас тал бүртээ 10 метр, кабелийн шугамаас тал бүртээ 5 метр байхаар тооцож газар ашиглалтын талбайн хэмжээг тогтооно. Шугам сүлжээний зурвас газруудын төлөвлөлтөд инженерийн дэд бүтцийн сүлжээ, барилга байгууламжийн зураг төсөл, гүйцэтгэлтэй холбоотой норм, дүрэм стандартуудад заасан шаардлагатай хэмжээсүүдийг уялдуулна.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 3.6. Усан боомтын газрын төлөвлөлт

Ажилбар 3.6.1. Шинээр байгуулах усан боомтын газар

Усан замын зогсоол байгуулах газар, зорчих маршрутыг төлөвлөхдөө усан боомтыг барих үндэслэл, хэрэгцээ, тээвэр ложистик байгуулах газрын байршил, хамрах газрын хэмжээг тогтоож төлөвлөнө.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 4. ОЙН САН БҮХИЙ ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дэд бүрэлдэхүүн хэсэг 4.1. Ерөнхий зүйл

“Ойн тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагдаж байгаа ойн сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын

чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудаас шаардлагатай доорх мэдээллийг авч ойн сан бүхий газрын газар зохион байгуулалтын төлөвлөлтөд ашиглана. Үүнд:

- Ойн сан бүхий газрын ашиглалт;
- Ойг түймрээс хамгаалах;
- Ойн хөнөөлт, шавьж, өвчнөөс хамгаалах;
- Ойг нөхөн сэргээх арга хэмжээнүүд гэх мэт.

Ойн сан бүхий газрын төлөвлөгөөг боловсруулахад дараах төрийн бодлого, чиглэлийн баримт бичигт туссан арга хэмжээ, заалтуудыг үндэслэнэ /Хүснэгт 35/.

Хүснэгт 35. Баримт бичгийн жагсаалт

№	Баримт бичгийн нэр	Хэрэглэх заалтууд
1	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	2.3.3-ын Зорилт 1
2	Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	3.5.2.4, 3.5.3.1, 3.5.3.3
3	МУ-ын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого	Аж үйлдвэрийн хөгжлийн бодлогын Стратегийн зорилт 2, Байгаль орчны бодлогын Стратегийн зорилт 4
4	Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөр	4.3.1, 4.3.2,
5	Монгол улсын ойн үндэсний бодлого	3.1, 3.2,
6	Ойн тухай үндэсний хөтөлбөр	Тус хөтөлбөрийн 1, 2, 3 дахь зорилтуудад туссан үйл ажиллагаа
7	"Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөр	Хөтөлбөрийн үндсэн зорилт
8	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр	1.2, 9.5.2, 9.5.2.4.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 4.2. Ойн сан бүхий газрын нөөц болон ашиглалт, хамгаалалт

Ажилбар 4.2.1. Ойн сан бүхий газрын нөөц

Тухайн сумын нутаг дэвсгэрийн ойн сан бүхий газар, ойгоор бүрхэгдсэн талбай, ойн төрөл зүйл, нөөцийг улсын хэмжээнд хийгдсэн судалгаа болон орон нутагт хэрэгжсэн төсөл, хөтөлбөр, болон бусад яам, агентлагийн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн судалгааны материалыг үндэслэн тодорхойлно.

Ажилбар 4.2.2. Ойн сан бүхий газрын ашиглалт, хамгаалалт

Ойн сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын арга хэмжээг улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөө болон Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан хөгжлийн бодлого, үндэсний хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийн тайланд үндэслэн ашиглалт, хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлно.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 4.3. Ойн сан бүхий газрын хэрэгцээт болон тохиромжтой байдлын үнэлгээ

Ажилбар 4.3.1. Ойн сан бүхий газрын хэрэгцээт байдал

Ойн хэрэгцээт байдлыг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

а. Түлшний хэрэгцээнд ашиглах ой модны хэрэглээ

Ой модны эрэлт хэрэгцээг тооцоолохдоо хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, нэгдсэн дулаан хангамжид холбогдох цаашдын хандлагатай уялдуулж сумын иргэд, айл өрх, албан байгууллагын түлшинд хэрэглэгдэх ой модны хэмжээг тооцоолно.

б. Мод үржүүлгийн газрын хэрэгцээ

Ойн зурвас, ногоон төгөл байгуулж бэлчээрийн талхлагдал, цөлжилтөөс хамгаалах, доройтсон баянбүрдийг нөхөн сэргээх, манхан элсний нүүлт хөдөлгөөнийг ургамалжуулан тогтворжуулах, төв суурин газрыг элсний нүүлт хөдөлгөөнөөс хамгаалах, хот суурин газрын төвийг цэцэрлэгжүүлэх, авто зам, төмөр замыг элсний нүүлтээс хамгаалах ойн зурвас байгуулах хэрэгцээг тооцож, шаардлагатай тарьц, суулгац бэлтгэх газрын хэмжээ, байршлыг тооцоолно.

в. Үйлдвэрлэлд ашиглах ой модны хэрэгцээ

Мод бэлтгэлийн үйлдвэрлэл, модон зүсмэл материал, төрөл бүрийн бэлдцийн үйлдвэрлэлд ашиглагдах ой модны хэрэгцээг тооцоолно.

Ажилбар 4.3.2. Ойн сан бүхий газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргазүйн дагуу тухайн сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээг шинэчлэн хийнэ.

Дээрх үнэлгээний зураг дээр ойжуулахаар төлөвлөсөн газар, тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн төлөвлөлтийн зургуудыг давхцуулж, нэгдсэн зураг, харьцуулсан хүснэгт гаргана.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 4.4. Ойн сан бүхий газрын төлөвлөлт

Ажилбар 4.4.1 Ойн сан бүхий газрын хил заагийг тогтоох

Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2 дахь хэсэгт заасны дагуу хот суурины 30 км доторх ойн сан, ашиглалтын болон хамгаалалтын бүсийн хил заагийг тогтоон зураглана.

Ажилбар 4.4.2 Ойг нөхөн сэргээх, ойн зурвас байгуулах

“Ойн менежментийн улсын ерөнхий төлөвлөгөө” болон “Ойн үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд нөхөн сэргээх, ойн зурвас байгуулах арга хэмжээг төлөвлөнө.

Ажилбар 4.4.3. Ой ашиглалт

Ой ашиглалтын төлөвлөгөөг Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд туссан арга хэмжээтэй уялдуулж, тухайн сумын ойн нөөц, хэрэгцээ шаардлага, үйлдвэрлэлийн хүчин чадалд тохируулан төлөвлөнө.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 5. УСАН САН БҮХИЙ ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Дэд бүрэлдэхүүн хэсэг 5.1. Ерөнхий хэсэг

Усны сан бүхий газрын эрх нь нийтээр ашиглах төрийн өмчийн эрхийн харилцаагаар зохицуулагдах ба “Иргэний хууль”, “Газрын тухай” хуулийг үндэслэн нийтээр дундаа, нийтээр хэсгээр гэрээний үндсэн дээр ашиглах эрхтэй байхаар төлөвлөлтөд тусгана.

Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт, усан сан бүхий газрын төлөвлөгөөг тохиромжтой байдал болон хэрэгцээт байдлын үнэлгээнд тулгуурлан салбаруудын бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээг, хэрэгжүүлэхээр боловсруулна.

Ажилбар 5.1.1. Усны нөөц болон усны сан бүхий газрын нөөц

Гадаргын болон газрын доорх усны нөөцийг тодорхойлохдоо усны нөөц /нуур, мөсөн гол, голын ус, газрын доорх ус гэх мэт/, голын ай сав, тэжээлийн горим, нөхөн сэлбэгдэх байдал зэргийг хүснэгт/26/-ийн дагуу улсын хэмжээнд хийгдсэн судалгаа болон орон нутагт хэрэгжсэн төсөл, хөтөлбөр, болон бусад яам, агентлагийн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн судалгааны материалыг үндэслэн тодорхойлно. /Хүснэгт 36/

Хүснэгт 36. Улсын хэмжээний усны нөөцийн судалгаа /Жишээ/

Эдийн засгийн бүсүүд	Усны сан бүхий газрын хэмжээ	Усны сан бүхий газрын эзлэх хувь	Байгалийн усны нийт нөөц шоо.км	Гадаргын ус, шоо.км				Газрын доорх ус		1км2 буюу 100 га-д ногдох усны нөөц, шоо.м
				Гол мөрний усны нөөцийн хэмжээ шоо.км	Үүнээс ашиглаж болох	Нуурын усны нөөцийн хэмжээ	Мөстөл, мөсөн голын усны нөөц	Ул хөрсний	Ашиглах боломжит	
Улсын дүн	681543	0.44	609.6	34.6	5.0	500.0	62.9	12.1	5.61	7896

Дэд бүрэлдэхүүн хэсэг 5.2. Усны сан бүхий газрын хэрэгцээт байдал болон тохиромжтой байдлын үнэлгээ

Ажилбар 5.2.1. Усны хэрэгцээт байдал

Усны хэрэгцээт байдлыг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

а. Хүн амын унд ахуйн усны хэрэглээ

Усны эрэлт, хэрэгцээг тооцоолохдоо цаашдын хүн амын өсөлттэй уялдуулж тооцно. Ингэхдээ хүн амын унд, ахуйн усны хэрэглээний Монгол улсын стандарт хэмжээг харгалзан үзнэ. Ирээдүйн унд ахуйн усны эрэлт хэрэгцээг хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөний хандлага, усны хүртээмж, хангамжийн өөрчлөлт болон нэг хүний хоногийн усны хэрэглээ зэрэгт үндэслэн тодорхойлох ба унд ахуйн ус хэрэглээний ирээдүйн төлөв байдлыг тодорхойлохдоо гурван хувилбарыг /хүн амын өсөлтийн төсөөллийн дээд, дунд, доод хэмжээнд үндэслэн/ тооцож гаргана.

Мөн хот суурин газрын цэвэрлэх байгууламжийн хэрэгцээ шаардлагыг тооцно.

6. МАА салбар, бэлчээр усжуулалт

Малын тоо толгойн өсөлтөөс үүссэн усны хомстлыг бууруулахад шаардлагатай байгаа шинээр худаг барих, эвдэрсэн худгийг сэргээн засварлах газрын байршил, хүчин чадал, хөрөнгө оруулалтын хэрэгцээг тооцоолно.

в. Усалгаатай газар тариалан хөгжүүлэх хэрэгцээ

Тариалангийн аж ахуйн таримал бүрт усалгааны систем шинээр байгуулах эсвэл ажиллагаагүй, эвдэрсэн усалгааны системийг засаж сэргээх газрын байршил, хүчин чадал, технологийн шийдэл, хөрөнгө оруулалтын хэрэгцээг тооцоолно.

г. Уул уурхай, аж үйлдвэрийн салбарын ус хангамж ба цаашдын хэрэгцээ

Уул уурхайн үйл ажиллагаанд ашиглах шаардлагатай усны хэмжээ хэрэгцээг тооцоолно. Мөн хүдэр боловсруулах, төмөрлөгийн болон газрын тосны зэрэг хүнд үйлдвэрүүдэд шаардлагатай ус хангамжийн хэрэгцээг тооцоолно.

д. Усны эрчим хүч

Усан цахилгаан станц байгуулснаар үйлдвэрлэж чадах цахилгаан эрчим хүчний дээд хэмжээ болон сум, бүс нутаг, аймаг, улсын хэмжээнд усны эрчим хүчнээс ашиглах шаардлагатай байгаа эрчим хүчний хэрэгцээ, шаардлагыг тооцоолно.

Ажилбар 5.2.2. Хөв цөөрөм байгуулахад тохиромжтой байдлын үнэлгээ

Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргазүйн дагуу тухайн сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд шинээр хөв цөөрөм байгуулах тохиромжтой байдлын үнэлгээг шинэчлэн хийнэ.

Дээрх үнэлгээний зураг дээр усан сан бүхий газрын төлөвлөлтийн зургуудыг давхцуулж, нэгдсэн зураг, харьцуулсан хүснэгт гаргана.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 5.3. Усны сан бүхий газрын төлөвлөлт

Ажилбар 5.3.1. Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалах

Тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлттэй уялдуулж усны урсцын эх бүрэлдэх газар нутгийг тусгай хамгаалалттай газарт авах газрын байршил, тоо хэмжээг төлөвлөнө.

Ажилбар 5.3.2. Усархаг намгархаг газруудыг хамгаалах

Олон улсын конвенцод бүртгэгдсэн газар нутгийн ашиглалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах талаар Монгол улс хүлээсэн үүргээ биелүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөнө.

Ажилбар 5.3.3. Усалгаатай газар тариаланг хөгжүүлэх

Хөдөө аж ахуйн газрын суурин аж ахуйн төлөвлөлттэй уялдуулж шинэ техник, технологийг нэвтрүүлэх, газрын чанарыг сайжруулах, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэмжээ, чанарыг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч, төлөвлөнө.

Ажилбар 5.3.4. Хүн амын ундны усны хангамжийг сайжруулах, цэвэрлэх байгууламжийг сайжруулах

Ус хангамжийн шинээр ашиглах эх үүсвэрийг холбогдох байгууллагаас хийсэн судалгааны үр дүнд үндэслэн, цаашдын ашиглалтын горим, шаардлагыг тодорхой тусгаж өгнө.

Ажилбар 5.3.5. Усан сан, хөв, цөөрөм байгуулж усан хангамжийг сайжруулах

Хөв цөөрөм байгуулах тохиромжтой газрын үнэлгээгээр тогтоогдсон газруудад нарийвчлан судалгаа, шинжилгээ хийж, шинээр хөв цөөрөм байгуулсан газрын байршил, хүчин чадал, хөрөнгө оруулалтыг тооцоолж бэлчээр, тариалангийн газрын төлөвлөлттэй уялдуулан төлөвлөнө.

Мөн томоохон гол мөрний усны түвшин нэмэгдэх үед бий болсон илүүдэл усыг ашиглаж, нуур, цөөрөм байгуулах, усжуулалтын суваг, шуудуу байгуулах ажлын техник, технологийн нарийвчилсан судалгааг хийж, шаардлагатай зардал, хүн хүчний тооцоог хийж, гарах үр өгөөжийг тооцоолж, төлөвлөнө.

Усан сан бүхий газрын шинээр хөв цөөрөм байгуулах тохиромжтой байдлын үнэлгээний зурагтай хөв цөөрөм байгуулахаар төлөвлөсөн газар, тусгай хамгаалалттай газар нутаг дахь усан сангийн төлөвлөлтийн зургуудтай давхцуулж, нэгдсэн зураг, харьцуулсан хүснэгт гаргана.

Ажилбар 5.3.6. Усан сан бүхий газрын хамгаалалтыг сайжруулах

Усны сан бүхий газрын хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэм, хил заагийг тодорхой харуулсан самбар, тэмдэглэгээ, хамгаалалтын хашаа, хайс байгуулах ажлын хэмжээ, шаардлагатай зардал, хүн хүч, хугацаа зэргийг нарийвчлан төлөвлөнө.

Усны сан бүхий газрын хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд иргэн, аж

ахуйн нэгж байгууллагад олгосон газар ашиглалтын судалгаанд үндэслэн тэдгээрийн байршлыг шилжүүлэх, нүүлгэх арга хэмжээг төлөвлөнө.

Ажилбар 5.3.7. Усан сан бүхий газарт аялал жуулчлал хөгжүүлэх

Аялал жуулчлал, зам, шугам сүлжээний газруудын төлөвлөлтүүдтэй уялдуулж усан замын аялал, спорт загасчлал, мөсөн шагай, цана, тэшүүрийн спорт, наадам, фестиваль зохион байгуулах, онгон зэрлэг байгалиар аялж буй гадаад, дотоодын жуулчдын хэрэгцээ, шаардлагыг хангасан усан замын маршрут, отоглох байр, амрах газар болон гол мөрний дагуух угтуул баазуудыг төлөвлөнө. Мөн гол мөрний дагуу аюулгүй байдлыг хангах анхааруулга, самбар, тэмдэглэгээг байршуулах, хог хаягдлыг цуглуулах цэг зэрэг газрын байршлыг тодорхой зайд төл өвлөнө. Ингэхдээ шаардлагатай хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа эрхлэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын нөөц боломжийг харгалзаж үзнэ.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 6. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Дэд бүрэлдэхүүн хэсэг 6.1. Ерөнхий зүйл

Тусгай хэрэгцээний газрын ашиглалт, хамгаалалт, мөрдөх дэглэм, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” болон бусад холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 6.2. Тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт

Ажилбар 6.2.1. Улсын тусгай хамгаалалттай газар

Улсын тусгай хамгаалалтад авах газрыг төлөвлөхдөө Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр, Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөнө.

Ажилбар 6.2.2. Тусгай хэрэгцээний газар

Улсын тусгай хамгаалалттай газраас бусад тусгай хэрэгцээний газар болох улсын хилийн зурвас газар, шинжлэх ухаан сорилт туршилтын газар, цаг уур орчны шинжилгээний газар, цөмийн төхөөрөмж барих зориулалтаар олгох газар, аймаг дундын отрын бэлчээр, чөлөөт бүс, хилийн боомтын бүс, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газрын байршлыг тогтоож, төлөвлөхдөө “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журам”, “Газар зохион байгуулалт хийх журам”-ыг тус тус баримтална.

Ажилбар 6.2.3. Орон нутгийн тусгай хэрэгцээний газар

Сум, орон нутгийн тусгай хэрэгцээний газрыг тэлэх, шинээр авах, гаргах газрын хэмжээ, байршил, зориулалт, түүнийг ашиглах, хамгаалах арга хэмжээг төлөвлөнө.

Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний газрын төлөвлөлтийн арга хэмжээнүүдтэй нийцүүлж төлөвлөнө.

Орон нутгийн тусгай хэрэгцээний газрын байршлыг тогтоож, төлөвлөхдөө “Газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх заавар”-ыг баримтална.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 7. АЯЛАЛ, РЕКРЕАЦИЙН НӨӨЦ БҮХИЙ ГАЗРЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дэд бүрэлдэхүүн хэсэг 7.1. Ерөнхий зүйл.

Аялал, рекреацийн нөөц бүхий газрын ашиглалтын эрх, үүргийг Монгол улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай хуулиудаар тодорхойлно.

Аялал, рекреацийн нөөц бүхий газрын төлөвлөгөөг боловсруулахдаа дараах төрийн бодлогын баримт бичгүүдэд туссан арга хэмжээ, заалтуудыг үндэслэнэ /Хүснэгт 37/.

Хүснэгт 37. Баримт бичгийн жагсаалт

№	Баримт бичгийн нэр	Хэрэглэх заалтууд
1	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030	2.1.2
2	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2.1.19, 2.2.21, 3.2.47, 4.2.2, 4.4.1-4.4.6, 5.6.6, 5.6.7
3	Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	Бүхлээрээ
4	Рашаан сувиллыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	2.2-ын д, ж, 2.3-ын а, б, г
5	Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр	4.5.1, 4.14.2
6	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр	4.1.8, 4.1.9, 4.1.10, 4.2.5

Аялал жуулчлалын үндсэн ангиллууд:

Аялал жуулчлалын ангиллыг газар зүйн зарчим, шинж чанар, аялал жуулчлалын урсгал, аяллын зорилго, аялах хөдөлгөөн, тээврийн хэрэгсэл, жуулчдын буудаллах газар, аялах хугацаа зэргийг харгалзан дараах байдлаар ангилна. Үүнд:

1. Газар зүйн зарчмаар нь: 1.1. Дотоодын, 1.2. Олон улсын
2. Аяллын зорилгоор нь: 2.1. Рекреацийн, 2.2. Рекреаци-амралт, 2.3. Танин мэдэхүйн амралт (экскурсийн), 2.4. Мэргэжил - ажил хэргийн,

- 2.5. Шинжлэх ухааны, 2.6. Спорт амралт, 2.7. Худалдааны аялал, 2.8. Экстрим-экзотик-адал явдлын, 2.9. Шашин зан үйлийн.
3. Аялах хөдөлгөөн, тээврийн хэрэгслээр нь: 3.1. Явган аялал, 3.2. Нисэх онгоцны, 3.3. Усан тээврийн, 3.4. Авто тээврийн, 3.5. Галт тэрэгний, 3.6. Унадаг дугуйн, 3.7. Ердийн хөсгийн 3.8. Холимог;
4. Буудаллах газраар нь: 4.1. Зочид буудлын, 4.2. Отелийн, 4.3. Сувиллын газрын, 4.4. Кемпинг (гэр), 4.5. Майхан, асрын, 4.6. Малчны гэрийн;
5. Аялах хугацаагаар нь: 5.1. Түр хугацааны, 5.2. Удаан хугацааны,

Дэд бүрэлдэхүүн хэсэг 7.2. Аялал рекреацийн нөөцийн үнэлгээ, тохиромжтой байдлын үнэлгээ, бүсчлэл

Ажилбар 7.2.1. Аялал-рекреацийн нөөцийн ерөнхий үнэлгээ

Байгаль, цаг уурын суурь судалгааны сэдэвчилсэн зураг, статистик мэдээ, нийгэм эдийн засгийн мэдээллүүдийг ашиглан дараах аялал рекреацийн нийтлэг нөөцийг тогтооно. Үүнд:

Байгаль, уур амьсгалын нөөц: Ландшафтын бүрдлүүд (ландшафтын төрөл, ландшафтын тааламжтай тухтай байдал гэх мэт), цаг хугацааны нөөц (аялахад тохиромжтой сар, улирал), орон зайн нөөц (газар зүйн өргөрөг, нарны радиац гэх мэт) спорт цогцолбор, ресорт байгуулахад тохиромжтой газар (цана, биатлон, уулын цана, сноуборд, ууланд авирах, мөсөнд авирах, мөсний тэшүүр, усан завины бааз, спортын цогцолбор, ресорт гэх мэт),

Ус зүйн нөөц: Гадаргын усны сүлжээ (булаг, шанд, гол, мөрөн, баянбүрдын байршил, тархац гэх мэт),

Рашаан ус болон усны экосистемийн үйлчилгээний нөөц: эмчилгээний рашаан ус, булаг, гол, нуурын эмчилгээний шавар, бусад байгалийн эмчилгээний нөөцүүд, наран шарлагын газар гэх мэт,

Ойн экосистемийн үйлчилгээний нөөц: тусгай хамгаалалттай газар нутгийн ой, байгалийн дурсгалт газрын ой, хамгаалалтын бүсийн ой, хот, суурины ой, нуур, гол, мөрний дагуух ой, бургас, бут сөөгөн ой гэх мэт,

Уул зүйн сүлжээний нөөц: уул, уулархаг, тал газар, гуу жалга, хэрчигдэл бүхий газар, түүх, соёлын дурсгал бүхий газар, элсэн сувилал, курорт гэх мэт,

Биологийн нөөц: амьтны аймаг, ургамлын аймаг,

Нийгэм, соёлын нөөц: амралтын газар, амарч байрлах бусад газар, дэд бүтэц, түүх соёлын өв, дурсгал, хүний хүчин зүйлээр бий болсон хиймэл ландшафтын бүрдэл (үндэс, угсаатан, зан үйл, хоолны соёл, гар урлал, музей, галерей, төрөл бүхийн соёлын хөшөө дурсгал гэх мэт); зугаа цэнгээний үйлчилгээ (соёлын ордон, ресторан, баар, шөнийн клуб, боулинг, спорт клуб, автомат тоглоомын танхим гэх мэт),

Зам тээврийн нөөц: агаарын тээвэр (онгоцны буудал, онгоц нисэх буух хугацаа, улирлын цагийн хуваарь гэх мэт төмөр замын тээвэр (Төмөр замын сүлжээ, галт тэрэгний ирэх, буцах хугацаа, улирлын цагийн хуваарь гэх мэт) авто замын тээвэр (авто замын сүлжээ, хот хооронд болон орон нутгийн шуудан үйлчилгээ, цагийн хуваарь, шатахуун түгээх станц, авто засвар, хоолны газар, амрах газар гэх мэт).

Аялал рекреацийн нөөцийн ерөнхий үнэлгээг хүснэгт/28/-ийн дагуу тодорхойлно. /Хүснэгт 38/

Хүснэгт 38. Аялал рекреацийн нөөцийн ерөнхий үнэлгээ

Сумын товч мэдээлэл	
Сумын газар нутгийн хэмжээ	 км ²
Хүн ам	 мянга
Сумын нэр	 сум
Аялахад тохиромжтой хугацаа	 - сар (Уур амьсгалын хувьд)
Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын тоо	
Жуулчны баазын тоо	Нийт жуулчны бааз, гэр, байшин, ортой
Амралтын газрын тоо	Нийт амралтын газар, гэр, байшин, ортой
Рашаан, сувиллын үйлчилгээ үзүүлдэг газрын тоо	Нийт рашаан, сувиллын газар, гэр, байшин, ортой
Хүүхдийн зуслан	Нийт хүүхдийн зуслан, хүүхэд нэг зэрэг авах хүчин чадалтай
Зочид буудлын тоо	Нийт зочид буудал, өрөө, ортой
Дэд бүтэц	
Зам тээвэр	Хатуу хучилттай зам: байрш ил....., хэмжээ км, Агаарын тээвэр: нисэх буудал, байршил, Усан тээвэр: боомтын байршил чиглэл....., хүчин чадал Авто зам дагуух үйлчилгээний газар: ШТС Авто засвар Хоолны газар Амрах газар
Усан хангамж	Усан хангамжийн эх үүсвэрийн тоо, усны чанар ямар эсэх? Сайн / Дунд / Муу

Цахилгаан хангамж	Төвийн эрчим хүчний системд холбогдсон эсэх? Тийм / Үгүй
Соёлын нөөц /Нөөц боломжуудыг бичнэ/	
Түүх соёлын дурсгалт газар	
Хиймэл ландшафт бүхий газар	
Зугаа цэнгээний үйлчилгээний газар	
Аялал жуулчлалын боломжит нөөц /Нөөц боломжуудыг бичнэ/	
Түүх, соёлын нөөц	
Байгалийн нөөц / Тусгай хамгаалалттай газар нутаг/	
Биологийн нөөц / амьтан, ургамал/	
Уул зүй, ус, ойн экосистемийн нөөц	
Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндсэн нөөц /Нөөц боломжуудыг бичнэ/	
Голлох үзмэр	
Амралтын цэгүүд	
Давуу тал	
Дагалдах бизнесүүд	
Хөгжүүлэх боломжтой аяллууд	

Ажилбар 7.2.2. Аялал, рекреацийн нөөц ашиглалтын чанарын үнэлгээ

Аялал, рекреацийн төрөл бүрээр тухайн суманд байгаа гол, гол аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэг бүрчлэн бичиж харгалзах чанарын үнэлгээг 1-5 оноогоор /Хүснэгт 39/-ийн дагуу үнэлнэ.

Хүснэгт 39. Аялал рекреацийн нөөц ашиглалтын чанарын үнэлгээ хийх

Аймаг	Сум	Аялал рекреацийн төрөл	Аялал-рекреацийн нөөцийн гол бүтээгдэхүүний нэр төрөл	Чанарын үнэлгээ	Нийт оноо
		Эко аялал жуулчлал	1. 2. ...	 (1-5 оноо) (1-5 оноо)	
		Олзворын ангийн аялал жуулчлал	1. 2. ...	 (1-5 оноо) (1-5 оноо)	
		Түүх соёлын аялал жуулчлал	1. 2. ...	 (1-5 оноо) (1-5 оноо)	
		Рашаан сувиллын аялал жуулчлал	1. 2. ...	 (1-5 оноо) (1-5 оноо)	
		Бусад аялал жуулчлал	1. 2. ...	 (1-5 оноо) (1-5 оноо)	

Ажилбар 7.2.3. Аялал рекреацийн бүс нутгийн тохиромжтой байдлын үнэлгээ

Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргазүйн дагуу тухайн сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд аялал рекреацийн нөөцийн үнэлгээ, тохиромжтой байдлын үнэлгээг шинэчлэн хийнэ.

Ажилбар 7.2.4. Аялал, рекреацийн нөөцийн үнэлгээнд тулгуурласан бүсчлэл

Аялал рекреацийн нөөцийн ерөнхий үнэлгээ болон нөөц ашиглалтын үнэлгээгээр өндөр үнэлгээ авсан 2-3 аялал рекреацийн нөөцийг дангаар болон холимог байдлаар тухайн сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бүсчилж зураглана. Аялал рекреацийн бүсчлэлийн зураглалыг /Хүснэгт 40/-ийн дагуу тохиромжтой байдлын үнэлгээний зурагтай харьцуулж, дүн шинжилгээ хийнэ.

Хүснэгт 40. Аялал рекреацийн ерөнхий бүсчлэл

Аялал рекреацийн ерөнхий бүсчлэл	Талбай мян.га	Хамрагдах газар нутаг
Нийт		

Дэд бүрэлдэхүүн хэсэг 7.3. Аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх төлөвлөлт

Ажилбар 7.3.1. Экологийн аялал /экотуризм/-ын бүс нутгийг хөгжүүлэх төлөвлөлт Экологийн аяллын бүс нутгийн төлөвлөлт хийхдээ хүрээлэн буй

орчиндоо ээлтэй, хариуцлагатайгаар аялж эвдэрч сүйрээгүй газар нутаг дэвсгэрт байгалийн үзэмжит тансаг байдал, байгаль түүх соёлын дурсгалын үнэ цэнийг таньж мэдэх, судлах, таашаал авах, хүрээлэн буй орчинд “зөөлөн” нөлөө үзүүлэх, орон нутгийн иргэдийн аж ахуй амьдрал, нийгэм-эдийн засгийг байдлыг дэмжсэн арга хэмжээнүүдийг төлөвлөнө. Экотуризм нь дараа төрлүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Байгалийн танин мэдэхүйн аялал;
2. Байгалийн нөөцөд суурилсан экстрим аялал;
3. Эрүүлжих аялал;
4. Онгон байгальд аялах аялал;
5. Хосолмол аялал;

Экстрим аялал жуулчлалын газар нутгийн хөгжүүлэхдээ байгалийн хүнд нөхцөлд хүний хүч чадлыг сорих, хатуужил суух зорилго бүхий аяллуудыг дараах экстрим аяллуудын хүрээнд төлөвлөнө. Үүнд:

Усны экстрим аялал:

- Усны цанаар усан дээгүүр гулгах;
- Дайвинг буюу нуурын гүнд шумбах;
- Уулын ширүүн урсгалтай голоор хөнгөн хийт завиар аялах гэх мэт;

Газрын экстрим аялал:

- Хаданд авирах аялал;
- Бартаат замын авто аялал;
- Уулын цанаар гулгах;
- Сноуборд;
- Агуйн аялал гэх мэт;

Агаарын экстрим аялал:

- Сонгодог шүхрийн аялал;
- Группийн акробат;
- Фристайл гэх мэт;

Онгон байгалийн аялал жуулчлал нь нийтлэг түгээмэл аялал, тусгай зөвшөөрлийн аялал гэж ангилагддаг байна. Нийтлэг түгээмэл аялалд тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд геологийн өвөрмөц тогтоц, байгалийн дурсгал бүхий хүний сонирхлыг татах өндөр түвшний газруудыг хамруулна.

Онгон байгалийн тусгай зөвшөөрлийн аялал нь тусгай хамгаалалттай газар нутагт ихэвчлэн явагддаг, огт хөндөгдөөгүй эсвэл маш бага хөндөгдсөн байгалийн иж бүрдэл, геологийн өвөрмөц тогтоц, байгалийн дурсгал бүхий хүний сонирхлыг татах өндөр түвшний онгон газар нутаг, усны мандал дахь аяллын зөвшөөрлийн тодорхой хугацааны давтамжтайгаар (5 жилд 1 удаа

гэх мэт) аялах эрхийн тусгай зөвшөөрөлтэй, аялагчдын тооны хязгаарлалтай, экологийн танин мэдэхүйн аяллыг төлөвлөнө.

Ажилбар 7.3.2. Түүх соёлын дурсгалт газрыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх бүс нутгийн төлөвлөлт

Нэгдсэн үндэстний байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллагын баталсан "Соёлын өв"-ийн 3 ангиллын дагуу түүх соёлын дурсгалт газрыг төлөвлөнө. Үүнд: - Хөшөө дурсгал (түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд нэрд гарсан, бүх талын үнэт ач холбогдол бүхий уран барилга, сүрлэг чимэглэлийн уран баримал, уран зургийн бүтээл, археологийн олдвор, бичээс, агуй болон цогцолбор дурсгал)

- Архитектурын чуулга (түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд нэрд гарсан бүх талын үнэт ач холбогдол бүхий салангид буюу нэгдмэл барилга байгууламж, уран барилгын цогцолбор)
- Дурсгалт газар (хүний болон хүн, байгалийн хамтарсан бүтээлүүд, мөн түүх, гоо зүй, угсаатны судлалын хувьд нэрд гарсан бүх талын үнэт ач холбогдол бүхий археологи, түүхийн дурсгалт газрыг багтаасан бүс нутаг) гэж ангилсан байна./Хүснэгт 41/

Хүснэгт 41. Хархорин сумын төвд байрлах түүх соёлын дурсгалт газрын

№	Бүрэлдэхүүн хэсэг	Элементүүд	Байршил	Солбицол	
				х	у
1	Өгөөдэй хааны байгуулсан Хархорум хотын эдэлбэр газар болох хааш хаашаа 4 километр урт хэрэмний эргэлтийн цэгийн байгууламж	Хэрэмний эргэлтийн цэгийн 4 өнцөгт хамгаалагч бурхан болох 4 яст мэлхий бүхий сүрлэг чимэглэлийн уран баримал.	Хархорин сумын төвд	102° 50' 45.030" E	47° 12' 29.793" N
2					

Ажилбар 7.3.3. Рашаан сувиллын аялал рекреацийн бүс нутгийн төлөвлөлт

Тухайн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа байгаа рашаан сувиллын газрууд, тэдгээрийн хүрэлцээ, хангамж болон рашаан сувиллын тусламж үйлчилгээ авах хэрэгцээ шаардлагад нийцүүлж дараах төлөвлөлтүүдийг хийнэ. Үүнд:

- Олон улсын, улсын, бүсийн, аймгийн, сумын түвшинд ашиглагдах рашаан, сувиллын нөөц, боломжийг хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийг төлөвлөх /харилцаа холбоо, зам тээвэр, цахилгаан, инженерийн шугам, сүлжээ, барилга байгууламж гэх мэт/;
- Орчны тохижилт, ногоон байгууламж, ландшафтын төлөвлөлт хийх;
- Эдийн засгийн үр өгөөжийг тооцож, шаардлагатай хөрөнгө оруулалтыг төлөвлөх /эрүүл мэндийн салбарт үзүүлэх нөлөө, улсын болон орон нутгийн төсөвт үзүүлэх нөлөө гэх мэт/;

- Газрын кадастрын судалгаа хийх, шаардлагатай зардал тооцоо, ажиллах хүчийг төлөвлөх;
- Рашаан, сувиллын аялал рекреацийн бүсийн эрүүл, аюулгүй байдлыг хангах, хамгаалах хашаа, хайс барих зэрэг арга хэмжээнүүдийг төлөвлөх зэрэг ажлууд багтана.

Ажилбар 7.3.4. Олзворын ангийн аялал-рекреацийн бүс нутгийн төлөвлөлт

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас тогтоосон агнуурын бүсэд холбогдох хууль, тогтоомж, тухайн салбарын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөлтийг хийнэ.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 8. ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Дэд бүрэлдэхүүн хэсэг 8.1. Ерөнхий зүйл

Хамгаалалтын бүсийн газрын ашиглалтын эрх, үүргийг Монгол улсын Иргэний хууль, Газрын тухай, Усны тухай, Ойн тухай, Эрчим хүчний тухай, Авто замын тухай хуулиудаар тодорхойлно.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 8.2. Хамгаалалтын бүсийн төрөл, дэглэм, хэмжээ.

Усан сан бүхий газар, ойн сан бүхий газар, зам, шугам сүлжээний газарт холбогдох хууль, асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон дэглэмийг баримтална.

Ажилбар 8.2.1. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн төрөл, дэглэм, хэмжээ

а. Усан сан бүхий газрын хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг дараах төрөл, хэмжээгээр тогтооно. Үүнд

- Эрүүл ахуйн бүс;
- Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс;
- Үерийн хамгаалалтын бүс;

б. Усны эх, ундарга, нөөцийг хомстох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны аюулаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтооно. Хамгаалалтын бүсийг дотор нь онцгой хамгаалалтын бүс ба энгийн хамгаалалтын бүс гэж хоёр ангилна /Хүснэгт 42/.

Хүснэгт 42. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс

№	Хамгаалалтын бүс	Хамгаалалтын бүсийн өргөн	Хууль, эрхзүйн үндэслэл
Онцгой хамгаалалтын бүс			
1	Булаг, шанд	50 м <	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
2	Гол, горхи	50 м <	
3	Нуур, урсцын тохируулгатай усан сан	100 м <	
4	Гол мөрний урсац бүрэлдэх эх хэсэгт	Усны хагалбарын хилээр	
5	Хот суурин газрын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газар	100 м <	
6	Үерийн хамгаалалтын далангаас	50 м <	
7	Үерийн хамгаалалтын суваг, түүний хамгаалалтын далангаас	< 30 м	
Энгийн хамгаалалтын бүс			
8	Булгийн энгийн хамгаалалтын бүс	200 м <	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
9	Голын энгийн хамгаалалтын бүс	200 м <	
10	Нуурын энгийн хамгаалалтын бүс	200 м <	
11	Нийслэл болон аймгийн төвийн хот суурины нутаг дэвсгэр дэх усан сан бүхий газар	< 500 м	

в. Хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн нөөц хомстох, бохирдохоос хамгаалах зорилгоор төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтооно. Эрүүл ахуйн бүс нь хориглолтын ба хязгаарлалтын бүсээс тогтоно /Хүснэгт 43/.

Хүснэгт 43. Ус хангамжийн эрүүл ахуйн бүс

№	Эрүүл ахуйн бүс	Эрүүл ахуйн бүсийн өргөн	Хууль, эрхзүйн үндэслэл
Хориглолтын бүс			
1	Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр	100 м <	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
2	Хот суурин газрын төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр	50 м <	
Хязгаарлалтын бүс			
3	Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт гадаргын усыг ашиглавал түүний эргээс	200 м <	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
4	Нийт урт нь 40 км-ээс бага урсгал усны ус хангамжийн эх үүсвэрт	Ус хурах талбайг бүхэлд нь хамааруулна	
5	Төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугам хоолойн тэнхлэгээс хоёр тийш	5 м	
6	Хот суурин газрын төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр	200 м <	

Ажилбар 8.2.2. Ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсийн төрөл, дэглэм, хэмжээ

Ойн сангийн хамгаалалт, ашиглалтын хэлбэр, экологи эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан хамгаалалтын бүсийн ой, ашиглалтын бүсийн ой гэж ангилна /Хүснэгт 44/.

Хүснэгт 44. Ойн сан бүхий газрын хамгаалалтын бүс

№	Хамгаалалтын бүсийн ойн төрөл	Тайлбар	Хууль, эрхзүйн үндэслэл
1	Цармын бүслүүрийн ой	Усны хагалбар дахь байгаль орчны тэнцлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх зорилгоор цармын бүслүүрийн хил заагийг тогтооно	Ойн тухай хууль
2	Тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой		
3	Хориотой зурвасын ой	Нуур, рашаан, булаг, шандны ундаргын эргэн тойрон болон голын эргээс хоёр тийш 1000 метрийн доторх ой, улсын чанартай авто болон төмөр замын дагуу хоёр талын 100 метрийн доторх ой	
4	Заган ой		
5	Баянбүрдийн ой		
6	100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг		
7	30 хэмээс илүү налуу газрын ой		

Ажилбар 8.2.3. Шугам, сүлжээний газрын хамгаалалтын бүсийн төрөл, дэглэм, хэмжээ

Эрчим хүчний шугам сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, хүн, амьтан осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор /Хүснэгт 45/-д туссаны дагуу хамгаалалтын зурвас тогтооно.

Хүснэгт 45. Шугам сүлжээний газрын хамгаалалтын зурвас

№	Шугам сүлжээ	Хүн оршин суудаггүй газраар өнгөрөх нөхцөлд	Хүн оршин суудаг газраар өнгөрөх нөхцөлд	Дэд станц, дулаан дамжуулах төв, хуваарилах байгууламж	Газар дээр ил байрласан	Газар дор байрласан	Усан дор байрласан	Ой мод цэцэрлэг дундуур өнгөрөх нөхцөлд
		Шугамын захын утаснаас хоёр тийш		Тал бүр тийш	Шугамаас хоёр тийш			Шугамын захын утаснаас хоёр тийш
1.	Цахилгаан дамжуулах шугам: а/ 10 хүртэл кв б/ 35 кв в/ 110 кв г/ 220 кв д/ 440-500 кв	10 м 15 м 20 м 25 м 30 м	2 м 4 м 5 м 6 м 10 м	10 м 15 м 20 м 25 м 30 м				15 м 15 м 15 м 15 м 15 м
2.	Кабель шугам				10 м	2 м	100 м	
3.	Дулааны шугам: а/ 400 мм хүртэл голчтой б/ 400 мм-ээс дээш голчтой			10 м 10 м	4 м 5 м	3 м 4 м		

Ажилбар 8.2.4. Төмөр замын хамгаалалтын бүсийн төрөл, дэглэм, хэмжээ

Төмөр замын хөдөлгөөн, ачилт буулгалтын ажлыг хэвийн байлгах, төмөр замыг осол сүйрлээс хамгаалах, орчин тойронд нь учирч болох хохирлыг багасгах, хүн ам, мал амьтны аюулгүй бүсийг гол замаас 2 тийш 500 хүртэл метрийн өргөнтэй тогтооно.

Төмөр замын аюулгүйн бүсэд малын бэлчээр; төмөр замд холбогдолгүй үйлдвэрлэл, үйлчилгээ; аюул хөнөөлтэй бодис үйлдвэрлэх, хадгалах; ачих буулгах объект барих; суурьшлын бүс, төмөр замын байгууллага байгуулах үйл ажиллагаа төлөвлөхийг хориглоно. Суурьшлын бүс, төмөр замын байгууллага байгуулах үйл ажиллагааг хот суурины тэг гортигоос гадна төлөвлөхийг зөвшөөрнө.

Дэд бүрэлдэхүүн хэсэг 8.3. Хамгаалалтын бүсийн төлөвлөлт

Холбогдох хууль, журам, дүрмээр тогтоосон хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсүүдийн талаар хийсэн судалгаануудыг үндэслэж /хэрвээ хийгдээгүй бол шинээр хамгаалалтын бүсүүдийг тогтоож, зураглах/ түүн дотор дагаж мөрдөх дэглэмийг сахиулах арга хэмжээ болон газар, байгалийн нөөцийг ашиглах зориулалт, хэмжээг тус тус тодорхой зааж өгч, төлөвлөнө.

Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар, байгалийн нөөцийн ашиглалтын байдалд хийсэн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хязгаарлалт, хориглолтын арга хэмжээг төлөвлөнө.

Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд аливаа хууль, тогтоомж зөрчсөн шинээр газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах болон бусад арга хэмжээг төлөвлөхийг хориглоно.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 9. ГАЗАР, БАЙГАЛИЙН НӨӨЦ ЭДЭЛБЭРИЙН ЗҮЙ ЁСНЫ ЭРХИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Дэд бүрэлдэхүүн 9.1. Зүй ёсны эрх

Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийн бүртгэлийг газар, ус, ой, бэлчээр, хадлан зэрэг байгалийн нөөцийг арвижуулан өсгөж, ашиглан хамгаалах, аялал жуулчлал эрхлэх, эрчимжсэн аж ахуй эрхлэх, үйлдвэр, үйлчилгээг түүхий эд үйлдвэрлэл, бэлтгэн нийлүүлэлтийн гинжин хэлхээнд шаардлагатай нутаг дэвсгэрийг засаг захиргааны нэгжийн хил хязгаараас үл хамааруулан төрөлжүүлэн, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөнө.

Иргэд олон нийтийн оролцоотой тухайн нутаг дэвсгэр дэх зүй ёсны эрхийн зориулалтын төрлүүдийг нарийвчлан тодорхойлж, санал асуулга авна. Үүнд “Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг зориулалтаар нь бүртгэн баталгаажуулах түр заавар”-ыг баримтална.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 10. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

Дэд бүрэлдэхүүн 10.1. Ерөнхий зүйл

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлтийг “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр” болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийнэ.

Ажилбар 10.1.1. Үндэслэл

Ашиглалтын нөлөөллийг зохистой бууруулахын тулд нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай. Ландшафтын төвшний төлөвлөлт буюу экологийн бүс нутгийн үнэлгээ нь нөлөөллийг бууруулах эдгээр алхмуудыг зохистой хэрэгжүүлэх үндэс болно.

Ажилбар 10.1.2. Дүйцүүлэн хамгааллын дараах зарчим

1. Нөлөөллийг бууруулах дарааллыг ашиглах: Нөлөөллөөс зайлсхийх, бууруулах/нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах;
2. Нөлөөллийг бууруулах дарааллыг ашиглахад экологийн бүс нутгийн буюу ландшафтын байгаль хамгаалах зорилтыг авч үзэх;
3. Биологийн олон янз байдлын хувьд урт хугацааны үр дүнд хүрэх;
4. Талуудын оролцоог хангах;
5. Экологийн хувьд “ижил” буюу “дүйцэхүйц” байх;
6. Дүйцүүлэн хамгаалал нь нөлөөлөлд өртсөн бүс нутагт хэрэгжих.

Дэд бүрэлдэхүүн 10.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг нөлөөлөл илрэх, онцгой үр дагавар үүсэх чухал эрсдэл илэрсэн тохиолдолд төлөвлөнө.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь дараах төрөлтэй байна. Үүнд:

1. Ургамалжуулах /экологийн үнэ цэнийн тодорхой зорилтод хүрэхийн тулд доройтсон газрыг дахин ургамалжуулах/ болон талбайн гадна нөхөн сэргээх /экосистемийн үйл явцыг засах, хөл газрын ургамал, өвчин, зэрлэг амьтны менежментийг хэрэгжүүлэх/ талбайн менежмент
2. Газар худалдан авах /хамгаалах зорилгоор газар худалдаж авах, хамгааллын гэрээ хэлэлцээр болон бусад эрхзүйн гэрээнд нэгдэх/
3. Судалгаа /нөлөөлөлд өртсөн байгаль орчны үнэ цэнийг хадгалах менежмент, шийдвэр гаргах үйл явцад шууд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн байх/

Ажилбар 10.2.1. Ургамалжуулах болон талбайн менежмент

Энэ төрөлд дахин ургамалжуулах /доройтсон газарт байгалийн ургамал нөмрөгийг дахин ургуулах/ болон нөхөн сэргээх /экосистемийн үйл явцыг засч сайжруулах, хөл газрын ургамал, өвчин, зэрлэг амьтны менежмент/ зэрэг үйл ажиллагаа багтана. Дүйцүүлэн хамгаалж буй газрын байгаль орчны үнэ цэнийг биетээр сайжруулах зорилготой.

Ажилбар 10.2.2. Судалгаа

Судалгааны төсөл нь санал болгож буй төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл тодорхойгүй байх нөхцөлд мөн тодорхой нөлөөллийг бууруулах эсвэл зайлсхийх болон багасгах арга хэлбэрийг тодорхойлоход шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа мэдээлэл шаардлагатай байх нөхцөлд дүйцүүлэн хамгааллын арга хэмжээнд тооцогдоно. Судалгааны хүрээнд шинэ мэдээлэл хуримтлагдах нь төсөл санаачлагч нарт одоо байгаа дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгцээг бууруулах эсвэл ирээдүйд хэрэгжиж болох төслийн дүйцүүлэн хамгааллаас зайлсхийхэд ач холбогдолтой.

Дэд бүрэлдэхүүн 10.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлтөд дараах асуудлуудыг тусгана. Үүнд:

- Дүйцүүлэн хамгаалалд анхаарах биологийн олон янз байдал, тэдгээрийн төсөл хэрэгжихээс өмнөх суурь нөхцөл байдал,
- Биологийн олон янз байдлын хувьд ямар эерэг үр дүнд хүрэх, хэмжих шалгуурууд, биологийн олон янз байдлын мониторингийн төлөвлөгөө,
- Биологийн олон янз байдлын хувьд эерэг үр дүнд хүрэх арга хэмжээ, үйл ажиллагааны төлөвлөгөө,
- Арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зам, үйл ажиллагааг санхүүжүүлэх төсөв /Хүснэгт 46/

Хүснэгт 46. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний загвар

Дүйцүүлэн хамгаалах газрын байршил, хэмжээ / га/	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хариуцах эзэн

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 11. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТООН МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний суурь судалагааны тоон мэдээллийг боловсруулахдаа сэдэвчилсэн зургийн онцлог, масштабын хэмжээг харгалзан аймаг, сум, багийн хилээр тасдан холбогдох заавар стандартын дагуу бэлтгэнэ.

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний төлөвлөлтийн тоон мэдээллийг боловсруулахдаа төлөвлөлтийн төрөл тус бүрээр давхаргуудын нэр, атрибут өгөгдлүүдийг бүрэн бөглөж, Хүснэгт 47-д үзүүлсэн арга зүй,

стандартын баримт бичгүүдийг баримтална. Төлөвлөгөөний зургийн эхийг бэлтгэхдээ холбогдох стандарт, зааврын дагуу бэлтгэх бөгөөд зургийн эхийг бэлтгэсэн прожект файл /MXD/-г сэдэвчилсэн зургуудын төрөл тус бүрээр үүсгэж хадгална.

Хүснэгт 47. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний тоон зураг боловсруулах, зургийн хэвлэлийн эх бэлтгэхэд ашиглах арга зүй, стандартын баримт бичгүүд.

Д/д	Төлөвлөгөөний төрөл	Тоон мэдээлэл боловсруулахад баримтлах арга зүйн баримт бичгүүд	Тоон мэдээллийн зургийн эх бэлтгэх стандартын баримт бичгүүд
1.	Хөдөө аж ахуйн газрын төлөвлөлт.	Энэ арга зүйн 2 дугаар хавсралтын дагуу.	"Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний том, жижиг, дунд масштабын зургийн таних тэмдгийн стандарт" MNS 6315:2012, MNS 6316:2012, MNS 6317:2012;
2.	Хот, тосгон бусад суурины газрын төлөвлөлт.	1. "Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг MNS 6736:2018" 2. ГХГЗЗГ-ын даргын 2013 оны 140 дүгээр тушаалаар батлагдсан "Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зурган мэдээлэл боловсруулах заавар"	"Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг MNS 6736:2018"
3.	Зам, шугам сүлжээний газрын төлөвлөлт.	ГХГЗЗГ-ын даргын 2016 оны А/206 дугаар тушаалаар батлагдсан "Улс, бүс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зургийн тоон мэдээлэл боловсруулах заавар"	"Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний том, жижиг, дунд масштабын зургийн таних тэмдгийн стандарт" MNS 6315:2012, MNS 6316:2012, MNS 6317:2012;
4.	Ойн сан бүхий газрын төлөвлөлт		
5.	Усны сан бүхий газрын төлөвлөлт		
6.	Аялал жуулчлал, рекреацийн газрын төлөвлөлт		
7.	Тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт, дүйцүүлэн хамгаалах газрын төлөвлөлт		

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд шинээр үүсгэх тоон мэдээллийн бүх давхаргууд нь Хүснэгт 48-д үзүүлсэн атрибут өгөгдлүүдийг заавал агуулсан байна.

Хүснэгт 48. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний давхаргуудын атрибут мэдээлэл

Талбарын			Тайлбар
Name	Type	Length	
Aimag_name	Text	30	Аймгийн нэр
Soum_name	Text	30	Сумын нэр
Aimag_code	Long	10	MNS 5641-3 : 2006 стандартын дагуу аймаг, сумын код
Soum_code	Long	10	MNS 5641-3 : 2006 стандартын дагуу аймаг, сумын код
Area_ha	Double	10 2	Талбай, гектар
Urt_m	Double	10 2	Урт, метр
Tailbar	Text	50	Тайлбар
TT_code	Long	10	ГЗБТ-ны таних тэмдгийн код
MD_source	Text	30	Мэдээний эх үүсвэр
MD_Guits	Text	50	Гүйцэтгэгч байгууллага
MD_date	Text	30	Мэдээг үүсгэсэн огноо

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 12. СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр энэхүү аргачлалын дагуу төлөвлөсөн нийт арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн, хариуцах эзэн, шаардагдах төсөв зардал зэрэг мэдээллийг агуулсан үйл ажиллагааны төлөвлөгөөг энэ арга зүйн хавсралт 2-ын дагуу боловсруулж нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хамт сумын ИТХ-аар хэлэлцүүлж батлуулна.

Долоо. Багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж, гарсан саналуудыг тусгах

Мэргэжлийн байгууллагын боловсруулсан нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг багуудын Иргэдийн нийтийн хурал болон иргэд, олон нийтээр хэлэлцүүлж, тэднээс нэмж өгсөн санал, өөрчлөлтүүдийг төлөвлөлтийн байршил бүрээр хэлэлцүүлэн олонхын саналаар шийдүүлж, төлөвлөгөөний төслийг дэмжсэн тухай багийн Иргэдийн нийтийн хурлын тогтоол гаргаж баталгаажуулна. Багийн хурлаас тогтоол гарч нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний төсөлд оруулах санал, өөрчлөлтүүдийг тусгана.

Төлөвлөгөөний төсөлд санал авах: Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичгийн төсөл, төлөвлөлтийн зургуудыг А0 хэмжээгээр хэвлэн ИТХ-аар хэлэлцүүлэхийн өмнө сумын засаг даргын тамгын газрын байранд олон нийтэд харагдахуйц газарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байршуулж иргэд, олон нийтээс санал авна.

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичгийн төсөл болон бусад холбогдох зураг, материалыг ИТХ-аар хэлэлцүүлэхийн өмнө Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын газрын

мэдээллийн сангийн веб системд 30 доошгүй хоног байршуулан иргэд, олон нийт, бусад төрийн байгууллагаас нэмэлт саналыг авна.

Найм. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт гаргуулах

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэхийн өмнө Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон сумын газрын даамал нь нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хээрийн судалгаа, тодруулалт, уулзалт, ярилцлага, иргэд олон нийтийн санал, асуулга, бүлгийн хэлэлцүүлгийн шат, төлөвлөлтийн үе шат, сум, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг, аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй хэрхэн уялдуулсан байдалд хамтарсан дүгнэлт гаргана.

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан мэргэжлийн байгууллага нь төлөвлөгөөний төслийг Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон сумын газрын даамлын гаргасан дүгнэлтийн хамт Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж мэргэжлийн дүгнэлт гаргуулна.

Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дүгнэлт гаргуулах хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногт багтаан шийдвэрлэнэ. Нэмэлт судалгаа, мэдээлэл шаардлагатай тохиолдолд уг хугацааг 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай хүсэлт гаргагчид мэдэгдэнэ. Төлөвлөгөөний тайлан тоон зургийн иж бүрдлийг дутуу ирүүлсэн тохиолдолд дүгнэлт гаргалгүй буцаана.

Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний төслийн гүйцэтгэлийн ажилд хяналт тавих, дүгнэлт гаргах ажлыг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дээр ажлын хэсэг байгуулах замаар гүйцэтгэж болно. Ажлын хэсэг 5-7 гишүүнтэй байх ба дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар;
- Ажлын хэсгийн гишүүд:
- Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга эсвэл газар зохион байгуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн.
- Сумын даамал;
- Газар зохион байгуулалтын мэргэшсэн болон зөвлөх инженер;
- Төрийн бус байгууллагын төлөөлөл. Жич: Газар зохион байгуулалтын мэргэшсэн /зөвлөх/ инженер байх.

Хэрвээ төлөвлөгөөний төсөл шаардлага хангасан гэж үзвэл нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг батлуулах тухай албан бичгээр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд мэдэгдэнэ. Харин төлөвлөлтийн үе шатны

гүйцэтгэл хангалтгүй, төлөвлөгөөний төсөл мэргэжлийн шаардлага хангахгүй бол шаардлагатай засвар өөрчлөлтүүдийг нэг бүрчлэн гаргаж, засварлан сайжруулах талаар дүгнэлт гарган төлөвлөлтийн гүйцэтгэгчид болон сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд албан бичгээр мэдэгдэнэ.

Ес. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг баталгаажуулах, хүлээлгэн өгөх

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн тогтоол гаргаж, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг баталгаажуулна. Тогтоолын агуулгад сумын Засаг даргад нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэх талаар тусгана.

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний иж бүрдлийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын газар зохион байгуулалтын нэгдсэн веб систем, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн мэдээллийн санд холбогдох журам, зааврын дагуу байршуулна.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор батлагдсан нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг жил бүр төлөвлөж, хэрэгжүүлэх талаар сумын Засаг даргын захирамж гаргана.

Батлагдсан нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний иж бүрдлийг 4 хувь хэвлэж, сумын Засаг даргын тамгын газар, Сумын Газрын даамал, аймгийн газрын асуудал эрхэлсэн байгууллагад тус бүр нэг хувийг, улсын газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 1 хувийг тус тус хүлээлгэн өгнө.

Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу төрийн архивд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний иж бүрдлийг цаасан болон тоон хэлбэрээр холбогдох хууль, журмын дагуу хүлээлгэн өгнө.

Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, бүртгэх ба бүртгэлийн дугаарыг өгнө.

Төлөвлөгөөний иж бүрдэлд дараах баримт бичиг багтана. Үүнд:

- Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичиг – 1 боть
- Газар, байгалийн нөхцөл, нөөцийн болон төлөвлөлтийн зургийн эмхтгэл – 1 боть
- Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө - 1
- Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичиг болон газар, байгалийн нөхцөл, нөөцийн судалгаа болон төлөвлөлтийн зургийн тоон мэдээлэл, зургийн эхийг бэлтгэсэн прожект /Shapefile, MXD,/ – 1 DVD

- Суурин судалгаа болон хээрийн судалгааны ажилд ашиглагдсан судалгааны материал (иргэдийн санал асуулгын хуудас), зураг гэх мэт.


Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичиг болон газар, байгалийн нөхцөл, нөөцийн болон төлөвлөлтийн зургийн тоон хувилбарыг хүлээлгэн өгөхдөө Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргасан тухайн үеийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох заавар, стандартын дагуу оруулж хүлээлгэн өгнө.

Арав. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд аймгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны хяналт тавьж, аймгийн хэмжээнд нэгтгэж, жил бүрийн 12 сарын 15-ны дотор аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хамт улсын газрын асуудал эрхэлсэн байгууллагад хүргүүлнэ.

Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний нэгдсэн мэдээллийн санг удирдаж, хяналт мониторинг, дүн шинжилгээний ажлыг хариуцан хийнэ.

СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮЕ ШАТ



ХАВСРАЛТ 1

Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулахад ашиглах аргачлал, заавар, стандарт, материалууд

Аргачлал, стандартын нэр	Тайлбар
Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам	Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
Газар зохион байгуулалт хийх журам	Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт
Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журам	Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт
Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ боловсруулах аргачлал	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2015 оны А/200 тоот тушаалын хавсралт
ГЗБТөлөвлөгөөний таних таних тэмдгийн стандарт	MNS 6315:2012, MNS 6316: 2012, MNS 6317:2012 стандарт
Монгол орны бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварууд	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2015 оны А/104 тоот тушаалын хавсралт
Бэлчээрийн экологийн чадавхийг зураглах заавар	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны А/268 тоот тушаалын хавсралт
Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг зориулалтаар нь бүртгэн баталгаажуулах түр заавар	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2016 оны А/22 тоот тушаалын хавсралт
Нийгэм-эдийн засгийн судалгаа	Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн боловсруулсан “Социологийн судалгааны арга зүй, аргачлал” УБ. 2008
Бэлчээрийн ургац тодорхойлох арга зүй	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2011 оны А114 дүгээр тушаалын хавсралт
Бэлчээрийн хөрсний элэгдэл эвдрэл, зэрэглэл тогтоох	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль тогтоомжийн хялбаршуулсан лавлах Улаанбаатар. 2012
Бэлчээрийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, талхлагдал, зэрэглэл тогтоох	“Бэлчээрийн хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага” MNS 5546:2005
Газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх заавар”	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны А/73 дугаар тушаалын хавсралт
“Кадастрын зураглалын ажил” БНБД	БХБ-ын сайдын 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 121 дүгээр тушаалын хавсралт БНБД 11-11-16
ГКМС-г ажиллуулах журам	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны А/139 дугаар тушаалын хавсралт

Хот суурины газарт хот газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар	УББ 30-201-09
Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал	Үндэсний статистикийн газрын даргын 2013 оны 1/149 тоот тушаалын хавсралт
Хөдөө аж ахуйн салбарын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал	Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/142 тоот тушаалын I хавсралт
Байгаль орчны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал	Үндэсний статистикийн газрын даргын 2010 оны 1/173 тоот тушаалаар батлагдсан
Аялал жуулчлалын статистикийн үзүүлэлт, тооцох аргачлал	Үндэсний статистикийн газрын даргын 2011 оны 01/180 тоот тушаалаар батлагдсан
Ургамалан нөмрөгийн тусгаг бүрхэцийг тодорхойлох	Л.Г.Раменскийн квадрат торыг ашиглах арга. /Избранные работы. Проблемы и методы изучения растительного покрова/ Изд. Наука. 1971 г
Хөрсний бохирдолт	Хөрсний бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
Хар тугалга, Кадмы, Хром, Зэс Никель, Кобальт, Цайр	Атом шингэлтийн спектрометрийн арга MNS ISO 11047:2001
Ургамлын арви үнэлэх	О. Друдегийн 1913 В ведение в геоботанику Изд. Ленинградского университета. 1964 г
Усжуулагдсан бэлчээрийн талбайг тодорхойлох	Усны аж ахуйн яам, УХСЗТИ “Усжуулагдсан бэлчээрийн талбайг тодорхойлох аргачлал”. Улаанбаатар. 1971 он
Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх аймаг, сумын жагсаалт	Засгийн газрын 2002 оны 160-р тогтоолын 2-р хавсралт
Малын төрлийг хонин толгойд шилжүүлэх	1997 оны Газрын төлбөрийн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь заалт, Үндэсний Статистикийн хорооны хөдөө аж ахуйн салбарын тайлан. 2013
Шатсан ой, хортон мэрэгчид идэгдсэн ой	Ой зохион байгуулалтын материал.
Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам	Засгийн газрын 2009 оны 227 дугаар тогтоолоор
“Цөлжилтийн хяналт, шинжилгээний заавар”	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны А-144 тоот тушаалын хавсралт
Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2014 оны А-177 тоот тушаалын хавсралт
Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм	БНБД 30.01.04

Рамсарын конвенц	Иран улсын Рамсар хотод батлагдсан “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Конвенц”
Монгол Алтайн нуруу болон Алтайн –Ар говийн экологийн бүс нутгийн үнэлгээнд шаардагдах экосистемийн ангилал ба амьтны зүйлийн тархцын загвар	“TNC” байгууллагын мэдээ

ХАВСРАЛТ 2

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх үйл ажиллагааны
төлөвлөгөө.

	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Гарах үр дүн			Төсвийн төсөөлөл /сая төг/	Эх үүсвэр	Хариуцах эзэн
			Шалгуур үзүүлэлт / хэмжих нэгж/	Суурь үзүүлэлт	Хугацаа- ны эцэст			
0	1	2	3	4	5	6	7	8
	Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа /Хянан баталгаа, байрзүйн зураг хийх, хэсэгчилсэн төлөвлөгөө хийх гэх мэт/	Төлөвлөлтийн хугацаанд	Төлөвлөлтийн хүрээнд хүрэх үр дүнгийн	Одоогийн нөхцөл байдлын үзүүлэлт				ЗДТГ, Газрын даамал,
	Нэгдмэл сангийн үндсэн ангилал хооронд шилжүүлэх арга хэмжээ / хот суурины газрыг тэлэх, шинээр үүсгэх, шинээр атар газрыг эргэлтэд оруулах, зам шугам сүлжээний газрыг бий зорилгоор газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэх санал гаргах, Аймгийн ИТХ-д хүргүүлэх гэх мэт/	Төлөвлөлтийн хугацаанд жил бүр гэх мэт	Ангилалд шилжүүлэх газрын хэмжээ, га					

	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Гарах үр дүн			Төсвийн төсөөлөл /сая төг/	Эх үүсвэр	Хариуцах эзэн
			Шалгуур үзүүлэлт / хэмжих нэгж/	Суурь үзүүлэлт	Хугацаа-ны эцэст			
	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой сумын ИТХ, Засаг даргын зүгээс гаргах журам, бодлого шийдвэрийн баримт бичгүүд /бэлчээр ашиглах, суурин болон бэлчээрийн мал аж ахуйн бүс, эрчимжсэн аж ахуйд гэрээгээр ашиглуулахтай холбоотой журам боловсруулж батлах, шинэчлэх гэх мэт/							ЭДТГ, Газрын даамал, ХАА-н мэргэжилтэн, Байгаль орчны байцаагч гэх мэт
	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой сумын ИТХ, Засаг даргын зүгээс хил зааг, бүс нутаг тогтоох шийдвэр гаргах /Багийн хил зааг, улирлын бэлчээр, бэлчээрийн болон суурин мал маллагааны бүс нутаг, тууврын зам, дамжин өнгөрөх бэлчээрийн хил зааг, хуваарийг батлах/							

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Гарах үр дүн			Төсвийн төсөөлөл /сая төг/	Эх үүсвэр	Хариуцах эзэн
		Шалгуур үзүүлэлт /хэмжих нэгж/	Суурь үзүүлэлт	Хугацааны эцэст			
Газрыг нөхөн, сэргээх, хамгаалах арга хэмжээ /Бэлчээр, хадлангийн өнжөөж, амраах, сайжруулах, сэлгэх арга хэмжээ, хортон мэрэгчтэй тэмцэх, элэгдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх гэх мэт/		Шалгуур үзүүлэлтийг төлөв байдал чанарыг тодорхойлох аргачлал, сэргэх чадавхын дагуу					
Газрыг зүй зохистой ашиглах, өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргах арга хэмжээ							
Төлөвлөлтийн хугацаанд малын тоо толгойг бэлчээрийн даац, чадавхид тохируулах сүргийн эргэлтийг сум, багийн хэмжээнд төлөвлөх		Малын тоо, хонин толгой					
Сүргийн зохистой бүтцийг болгох бий болгох чиглэлээр авах арга хэмжээ							
Отрын нөөц нутаг бий болгох /Шинээр отрын нөөц нутаг бий болгох, орон нутгийн тусгай хэрэгцээнд авах/							
Газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах							

	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Гарах үр дүн			Төсвийн төсөөлөл /сая төг/	Эх үүсвэр	Хариуцах эзэн
			Шалгуур үзүүлэлт / хэмжих нэгж/	Суурь үзүүлэлт	Хугацаа-ны эцэст			
	Усжуулах бэлчээрийн газар /Шинээр худаг гаргах, засварлах, хөв цөөрөм байгуулах/							
	Ашиглалтгүй бэлчээрийг ашиглах							

ХАВСРАЛТ 3

Хөдөө аж, ахуйн газрын төлөвлөлтийн давхаргуудын нэр, талбарын загвар

Үндсэн давхаргын нэр, тайлбар	Дэд давхаргын нэр	Талбар				Тайлбар
		Name	Type	Length		
Belcheer_ MAABus_A /Бэлчээрийн мал аж ахуйн бүс/		Eco_Bus	Text	30		Экологийн бүс нутгийн ангилал
		Belc_Daats	Double	10	2	Даац ашиглалт / хонин толгой/
		Niit_mal	Long	10		Нийт малын тоо / хонин толгой/
		Temee	Long	10		тоо толгой
		Aduu	Long	10		тоо толгой
		Uher	Long	10		тоо толгой
		Honi	Long	10		тоо толгой
		Yamaa	Long	10		тоо толгой
		Area_ha	Double	10	2	Талбайн хэмжээ / га/
Suurin_MAABus_A /Суурин мал аж ахуйн бүс/	1. Хагас суурин мал аж ахуй	Turul	Text	50		Эрчимжсэн МАА-н хөгжүүлэх чиглэл
	2. Суурин мал аж ахуй	Area_ha	Double	10	2	Талбайн хэмжээ / га/
Belcheer_ UAshiglalt_A / Бэлчээр улирлын хуваарийн төлөвлөлт/	1. Өвөл-хаврын 2. Зун-намрын 3. Өвлийн 4. Хаврын 5. Зуны 6. Намрын 7. Ашиглалтгүй	B a g - name	Text	30		Багийн нэр
		A s h - Turul	Text	30		Дэд давхаргуудыг оруулж өгнө.
		Urgats_ga	Double	10	2	Бэлчээрийн ургац, га
		Belch - Chad	Long	10		Б э л ч э э р и й н чадавхи /хонин толгой/
		B e l c - Daats	Double	10	2	Даац ашиглалт / хонин толгой/
		B e l c h - bagt	Double	10	2	Б э л ч э э р и й н багтаамж хонин толгой/талбай,га
		T u l - baidal	Text	30		Бэлчээрийн газрын төлөв байдал
		Niit_mal	Long	10		Нийт малын тоо / хонин толгой/
		Temee	Long	10		тоо толгой
		Aduu	Long	10		тоо толгой
		Uher	Long	10		тоо толгой
		Honi	Long	10		тоо толгой
		Yamaa	Long	10		тоо толгой
		Area_ha	Double	10	2	Талбайн хэмжээ / га/

Үндсэн давхаргын нэр, тайлбар	Дэд давхаргын нэр	Талбар				Тайлбар
		Name	Type	Length		
Belcheer_Ahem-jee_A /Бэлчээр ашиглалтын арга хэмжээ/	1.Даац тохируулах 2.Ашиглалтаас чөлөөлөх 3.Сэлгэж ашиглах 4.Өнжөөж амраах 5.Элсний нүүлтээс хамгаалах 6.Нөхөн сэргээх	B a g - name	Text	30		Багийн нэр
		A s h - Turul	Text	30		Дэд давхаргуудыг оруулж өгнө.
		Urgats-ga	Double	10	2	Бэлчээрийн ургац, га
		Belch - Chad	Long	10		Б э л ч э э р и й н чадавхи /хонин толгой/
		B e l c - Daats	Double	10	2	Даац ашиглалт /хонин толгой/
		Belch - bagt	Double	10	2	Б э л ч э э р и й н багтаамж хонин толгой/талбай,га
		S e r g - Chad	Long	10		Сэргэх чадавхын зэрэглэл
		T u l - baidal	Text	30		Бэлчээрийн газрын төлөв байдал
		Niit_mal	Long	10		Нийт малын тоо /хонин толгой/
		Area_ha	Double	10	2	Талбайн хэмжээ /га/
Otriin_Belcheer_A /Отрын бэлчээрийн газар/	1. Аймаг дундын отрын нөөц бэлчээр 2. Сум, дундын отрын нөөц бэлчээр 3. С у м ы н отрын нөөц бэлчээр	B a g - name	Text	30		Багийн нэр
		Urgats-ga	Double	10	2	Бэлчээрийн ургац, га
		Belch - Chad	Long	10		Б э л ч э э р и й н чадавхи /хонин толгой/
		B e l c - Bagt	Double	10	2	Б э л ч э э р и й н багтаамж хонин толгой/талбай,га
		B e l c - Daats	Double	10	2	Даац ашиглалт /хонин толгой/
		T u l - baidal	Text	30		Газрын төлөв байдал
		Area_ha	Double	10	2	Талбайн хэмжээ /га/
Hadlan_tal-bai_tuluult_A /Хадлангийн талбайн төлөвлөлт/	1.Хадлангийн талбай 2.Хадах боломжтой бэлчээр	B a g - name	Text	30		Багийн нэр
		Gaz_ner	Text	30		Газрын нэр
		Urgats-ga	Double	10	2	Ургацын хэмжээ /га/
		Gaz_erh	Text	30		Э з э м ш ү ү л э х , ашиглуулах төрөл
		Turul	Text	30		Дэд давхаргуудыг оруулж өгнө.
		Zereglel	Text	30		Аймаг, сум, баг, хот айлын тэжээлийн сангийн хадлан

Үндсэн давхаргын нэр, тайлбар	Дэд давхаргын нэр	Талбар				Тайлбар
		Name	Type	Length		
Hadlan_saijruulah_A / Сайжруулах хадлан/	1.Тордон сайжруулах 2.Хаших хадлан 3.Таримал хадлан бий болгох 4.Сэлгээтэй ашиглах 5.Өнжөөх	B a g _ name	Text	30		Багийн нэр
		Gaz_ner	Text	30		Газрын нэр
		Urgats_ga	Double	10	2	Ургацын хэмжээ /га/
		Gaz_erh	Text	30		Э з э м ш ү ү л э х , ашиглуулах төрөл
		Turul	Text	30		Дэд давхаргуудыг оруулж өгнө.
Usjuulah_Belcheer_A / Усжуулах бэлчээр/	-	B a g _ name	Text	30		Багийн нэр
		Gaz_ner	Text	30		Газрын нэр
		hariut_sah_hun	Text	30		Хариуцах эзэн
		A_Hem-jee	Text	50		Усжуулах арга хэмжээ.
		Urgats_ga	Double	10	2	Ургацын хэмжээ /га/

Үндсэн давхаргын нэр, тайлбар	Дэд давхаргын нэр	Талбар			Тайлбар
		Name	Type	Length	
НААBarilgaB_A /Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн газар/	1. Мал эмнэлгийн үйлчилгээний цэг	B a g - name	Text	30	Багийн нэр
	2. Үтрэмийн аж ахуй ХАА-н машин, механизмын хашаа, гараж барих газар	Gaz_add	Text	30	Газрын нэр
	3. Тэжээл, бордооны агуулах	h a r i u t - sah_hun	Text	30	Хариуцах эзэн
	4. ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах газар	Turul	Text	30	Дэд давхаргуудыг оруулж өгнө.
	5. Хүлэмж, дарлагын аж ахуй байгуулах газар	X hugtsaa -	Text	30	Х э р э г ж ү ү л э х хугацаа
	6. Бэлчээрийн газарт шинээр гаргах уст цэг	sanhuu-jilt_eh	Text	30	Санхүүжилтийн эх үүсвэр
	7. Шинээр байгуулах зоорийн аж ахуйн газар	Hurung_hem	Text	30	Хөрөнгийн хэмжээ
	8. Шинээр услалтын систем байгуулах газрын төлөвлөлт				
	9. Сэргээн засварлах услалтын систем				
	10. Худаг, уст цэг шинээр гаргах болон засварлах газар				
BUstTseg_P /Худаг, уст цэг шинээр гаргах болон засварлах төлөвлөлт/	11. ХАА-н бүтээгдэхүүний ложистикийн төв байгуулах газар	B a g - name	Text	30	Багийн нэр
	12. Хөдөө аж ахуйн чөлөөт бүс байгуулах газар	Gaz_add	Text	30	Газрын нэр
	13. ХАА-н машин техникийн засвар, үйлчилгээний төв	Turul	Text	30	Дэд давхаргуудыг оруулж өгнө.
		X hugtsaa -	Text	30	Х э р э г ж ү ү л э х хугацаа
		sanhuu-jilt_eh	Text	30	Санхүүжилтийн эх үүсвэр
Тариалангийн газрын төлөвлөлт.					

Үндсэн давхаргын нэр, тайлбар	Дэд давхаргын нэр	Талбар			Тайлбар
		Name	Type	Length	
TarimTurNuuc_A /Тариалангийн нөөц газар таримлын төрлөөр/	1. Үр тариа 2. Төмс, хүнсний ногоо 3. Жимс, жимсгэнэ 4. Тэжээлийн ургамал 5. Тосны ургамал 6. Техникийн ургамал 7. Эмийн, цэцэг, гоёл чимэглэлийн ургамал	B a g _ name	Text	30	Багийн нэр
		Gaz_add	Text	30	Газрын нэр
		Turul	Text	30	Дэд давхаргуудыг оруулж өгнө.
		X hugtsaa _	Text	30	Х э р э г ж ү ү л э х хугацаа
		sanhuu-jilt_eh	Text	30	Санхүүжилтийн эх үүсвэр
Atarshsan-GazErg_A /Дахин эргэлтэд оруулах атаршсан газар/		B a g _ name	Text	30	Багийн нэр
		Gaz_add	Text	30	Газрын нэр
		Turul	Text	30	Дэд давхаргуудыг оруулж өгнө.
		X hugtsaa _	Text	30	Х э р э г ж ү ү л э х хугацаа
		sanhuu-jilt_eh	Text	30	Санхүүжилтийн эх үүсвэр
Atarshsan-GazErg_A /Дахин эргэлтэд оруулах атаршсан газар/		Hurung_hem	Text	30	Хөрөнгийн хэмжээ
		B a g _ name	Text	30	Багийн нэр
		Gaz_add	Text	30	Газрын нэр
		Turul	Text	30	Дэд давхаргуудыг оруулж өгнө.
		X hugtsaa _	Text	30	Х э р э г ж ү ү л э х хугацаа
NuhAtarGaz_A /Байгалийн аясаар болон нөхөн сэргээлтээр бэлчээр хадланд шилжүүлэн ашиглах атаршсан газар/		sanhuu-jilt_eh	Text	30	Санхүүжилтийн эх үүсвэр
		Hurung_hem	Text	30	Хөрөнгийн хэмжээ
		B a g _ name	Text	30	Багийн нэр
		Gaz_add	Text	30	Газрын нэр
		T u l u v _ Baid	Text	30	Төлөв байдал чанарын мэдээлэл
Atarshsan-GazErg_A /Дахин эргэлтэд оруулах атаршсан газар/		X hugtsaa _	Text	30	Х э р э г ж ү ү л э х хугацаа
		sanhuu-jilt_eh	Text	30	Санхүүжилтийн эх үүсвэр
		Hurung_hem	Text	30	Хөрөнгийн хэмжээ
		B a g _ name	Text	30	Багийн нэр
		Gaz_add	Text	30	Газрын нэр
Atarshsan-GazErg_A /Дахин эргэлтэд оруулах атаршсан газар/		Urgats_ga	Double	10 2	Ургацын хэмжээ, га
		X hugtsaa _	Text	30	Х э р э г ж ү ү л э х хугацаа
		sanhuu-jilt_eh	Text	30	Санхүүжилтийн эх үүсвэр
		B a g _ name	Text	30	Багийн нэр
		Gaz_add	Text	30	Газрын нэр

Үндсэн давхаргын нэр, тайлбар	Дэд давхаргын нэр	Талбар			Тайлбар
		Name	Type	Length	
NuhAtar_A /Байгалийн аясаар болон нөхөн сэргээлтээр бэлчээр хадланд шилжүүлэн ашиглах атаршсан газар/		Gaz_ner	Text	30	Газрын нэр
		X_hugtsaa	Text	30	Хэрэгжүүлэх хугацаа
		Tuluu_Baid	Text	30	Төлөв байдал чанарын мэдээлэл
		Urgats_ga	Long	10	Ургацын хэмжээ, га
		sanhuu-jilt_eh	Text	30	Санхүүжилтийн эх үүсвэр
TarHamZur_A /Тариалангийн талбай орчмын мал бэлчээх, өвөлжөө, хаваржаа, хашаа саравч барихыг хориглох 500м хамгаалалтын зурвас/		Gaz_ner	Text	30	Газрын нэр
AtarGazTar_A /Тариаланд тохиромжтой атар газар/		Gaz_ner	Text	30	Газрын нэр
		X_hugtsaa	Text	30	Хэрэгжүүлэх хугацаа
		Urgats_ga	Long	10	Ургацын хэмжээ, га
		sanhuu-jilt_eh	Text	30	Санхүүжилтийн эх үүсвэр

--oOo--

СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЯВЦАД ОЛОН НИЙТТЭЙ ЗӨВЛӨЛДӨХ ГАРЫН АВЛАГА

*Сумын хөгжлийн төлөвлөгөөг иргэдийн оролцоотой
боловсруулахад дөхөм болох нь*



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Хүн Төвтэй Байгаль Хамгаалал үндэсний ТББ нь 2016 оноос хойш Англи улсын судалгааны байгууллага болох Мокоротой хамтран “Эмэгтэйчүүдийн Эдэлбэрийн Эрхийн Баталгаат Байдал” (ЭГЭЭББ) практик үйл ажиллагаанд суурилсан төслийг хэрэгжүүлж газар, уул уурхай, иргэдийн амьжиргаа, жендер зэрэг хөдөө орон нутагт тулгараад буй асуудлуудад чиглэн үйл ажиллагаа явуулж байна.

Энэхүү гарын авлага нь “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй”-н дөрөвдүгээр бүлэг болох “Хээрийн судалгаа, тодруулалт, уулзалт, ярилцлага, иргэд, олон нийтийн санал асуулга, бүлгийн хэлэлцүүлэг” хэсгийн 4.1 дэх заалтад тусгасан үйл ажиллагааг нарийвчлан боловсруулж орон нутагт туршиж хэрэгжүүлэхэд бодитой загвар жишээ болж байна. Мөн газрын мэргэжлийн байгууллагууд Сумын Нутаг Дэвсгэрийн Хөгжлийн Төлөвлөгөө боловсруулахад тус загвар жишээг үйл ажиллагаанд ашиглаж иргэд олон нийтийн санал санаачлагийг илүү дэлгэрэнгүй тусгахад чулах нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Мөн энэхүү гарын авлагад тусгасан загвар жишээг орон нутгийн иргэд олон нийттэй уулзалт зохион байгуулах бүх төрлийн үйл ажиллагаанд ашигласнаар нийгмийн чухал асуудлууд болох эрүүл мэнд, иргэдийн оролцоо, жендэрийн асуудлуудыг нарийвчлан тодорхойлох боломжтой юм.

Гарын авлагыг боловсруулж, СНДХТ-ны аргачлалын тодорхой хэсгийг загвар жишээ байдлаар дэлгэрэнгүй тусгаж товхимол байдлаар хэвлүүлэн олны хүртээл болгож байгаа Хүн Төвтэй Байгаль Хамгаалал байгууллага болон ЭГЭЭББ төслийн багийнханд гүн талархлаа илэрхийлье.

ДАРГА



Ц. ГАНХҮҮ

ТАЛАРХАЛ

Энэхүү баримт бичгийг “Эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн эрхийн баталгаат байдал” судалгааны төслийн хүрээнд “Хүн Төвтэй Байгаль Хамгаалал” ТББ-ын (ХТБХ) захирал Н.Лхамдулам, гүйцэтгэх захирал Я.Нарангэрэл, “Мокоро” компанийн Э.Далей нар бэлтгэсэн бөгөөд уг компанийн К.Кронин, Ж.Габхам, П.Листер, ХТБХ ТББ-ын мэргэжилтэн Б.Мөнхтүвшин, Б.Сувд, Н.Янжиндулам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ж.Батсайхан, мэргэжилтэн С.Энх-Эрдэнэ, “Эрин кадастр” ХХК-ийн захирал П.Энхтөр, гүйцэтгэх захирал Т.Оюундэлгэр нар туслалцаа үзүүлэн ажилласан юм.

Тус гарын авлагыг Даланжаргалан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах хамтын ажлын үр дүнд бий болсон бөгөөд Зохиогчдын зүгээс Дорноговь аймгийн ЗДТГ, Даланжаргалан сумын ЗДТГ болон Даланжаргалан сумын нийт иргэдэд гүн талархал илэрхийлж байна.

Ишлэл: Н.Лхамдулам, Я.Нарангэрэл, Э.Далей, 2019, Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах явцад олон нийттэй зөвлөлдөх гарын авлага. Англи улс: “Мокоро компани”, Монгол улс: “Хүн Төвтэй Байгаль Хамгаалал” ТББ

Гарчиг

Хэсэг 1. Танилцуулга.....	98
1.1. Гарын авлагын тухай.....	98
1.2. Гарын авлагын зорилго.....	98
1.3. Олон нийттэй зөвлөлдөх зорилго.....	98
1.4. Зорилтот бүлгийн уулзалтын тухай.....	99
Хэсэг 2. Бэлтгэл ажлын төлөвлөгөө.....	100
2.1. Суурь мэдээллийг уншиж судлах.....	100
2.2. ЗБУ –д оролцогчдыг сонгох.....	101
2.3. Чиглүүлэх баг сонгож, сургалт хийх.....	102
2.4. Тайлан, тэмдэглэл хөтлөхөд бэлтгэх.....	103
2.5. Удирдамж, хөтөлбөр бэлтгэх	103-104
2.6. Олон нийттэй зөвлөлдөх ажлын уулзалтын материал бэлтгэх, төлөвлөх.....	107
Хэсэг 3. ЗБУ-д ашиглах оролцооны аргууд.....	107
3.1. Нийгмийн зураглал.....	108
3.2. Байгалийн нөөцийн зураглал.....	110
3.3. Нүүдлийн зураглал.....	114
3.4. Н-хүснэгт: байгаль орчин болон амьжиргааны асуудлуудын тухай.....	116
3.5. Уулзалтын үеэр сөхөгдсөн асуудлуудын тухай хэлэлцүүлэг хийж, боломжит шийдэл гаргаж төлөвлөгөөнд оруулах санал боловсруулах.....	120
Хэсэг 4. Дараагийн алхмууд	120
4.1 Зөвлөлдөх уулзалтуудын (ЗБУ, хувь хүний ярилцлагууд) дараагийн алхмууд.....	120
4.2. Төлөвлөгөөг иргэдэд таниулж, баталгаажуулах уулзалтууд.....	121
Хавсралт 1. Загварууд.....	125

ХЭСЭГ 1. ТАНИЛЦУУЛГА

1.1 Гарын авлагын тухай

Энэхүү гарын авлага нь Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын даргын 2019 оны А/134 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй”-н дөрөвдүгээр бүлэг болох “Хээрийн судалгаа, тодруулалт, уулзалт, ярилцлага, иргэд, олон нийтийн санал асуулга, бүлгийн хэлэлцүүлэг” хэсгийн 4.1 дэх заалтад тусгасан үйл ажиллагааны дэлгэрэнгүй загвар жишээ баримт бичиг юм.

Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагч Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын (цаашид “агентлаг” гэх) санаачилгаар Дорноговь аймгийн ЗДТГ, Даланжаргалан сумын ЗДТГ, Хүн Төвтэй Байгал Хамгаалал (цаашид ХТБХ) ТББ, Англи улсын Мокоро компанийн ЭГЭЭББ төслийн баг хамтран 2018-2019 онд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг (цаашид “төлөвлөгөө” гэх) боловсруулсан туршлага дээр үндэслэн энэхүү гарын авлагыг боловсруулсан.

Гарын авлагыг боловсруулахад ХТБХ ТББ болон ЭГЭЭББ төслийн “иргэдийн оролцоог хангах” үйл ажиллагаанд хэрэглэгддэг арга, аргачлалд суурилсан бөгөөд төлөвлөгөө боловсруулах явцад олон нийтийн оролцоог хангах аргачлалыг нарийвчлан боловсруулан практикт туршиж үзэн баталгаажуулсан болно.

Иймд энэхүү аргачлал, процессийг ашиглан олон нийттэй зөвлөлдөж, тэдний саналыг харгалзан үзэж боловсруулсан анхны бичиг баримт нь Даланжаргалан сумын нутаг дэсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болж байгаа юм.¹

1.2 Гарын авлагын зорилго

Энэхүү гарын авлагын зорилго нь төлөвлөгөө боловсруулж буй мэргэжлийн байгууллага, газрын харилцааны мэргэжилтнүүд нь /аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэн, Сумын газрын даамлууд/ олон нийттэй зөвлөлдөх, тэдгээрийн саналыг нарийвчлан тусгах үйл ажиллагааг зохион байгуулах алхам бүрийг зааварчилгаагаар хангах бөгөөд зорилтот бүлгийн уулзалт хэлбэрээр (ЗБУ) хамтын оролцоотой зөвлөлдөх уулзалтуудыг хэрхэн зохион байгуулах тухай дэлгэрэнгүй тайлбарласан. Зорилтот бүлгийн уулзалтууд нь сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах зөвлөлдөх процессын үндсэн хэсэг юм.

1.3 Олон нийттэй зөвлөлдөх зорилго

Олон нийттэй зөвлөлдөх уулзалт хийж буй үндсэн зорилго нь Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний нийгэм, байгаль орчин, эдийн засгийн

¹ ХТБХ байгууллагын вэбсайт (www.pcc.mn), ГЗБГЗЗГ-ын вэбсайт (www.gazar.gov.mn)

асуудлуудын талаарх олон нийтийн саналыг иргэдийн оролцоотой, нийтийг хамруулж, жендерийн мэдрэмжтэй авахад оршино. Ийм процессоос гарсан санал, олж илрүүлсэн зүйлсийг энд тусгасны дагуу чиглүүлэгчийн баг нэгтгэн төлөвлөгөөнд тусгах юм.

Хоёр дахь зорилго нь төлөвлөгөөний тухай мэдлэг, мэдээллийг олон нийтэд түгээж, ингэснээр боловсруулагдаж гарсан төлөвлөгөөг нутгийн иргэд өөриймсгөөр хүлээн авч хэрэгжүүлэхэд түлхэц өгөх учиртай.

1.4 Зорилтот бүлгийн уулзалтын тухай

Олон нийттэй зөвлөлдөх үндсэн хэлбэр нь зорилтот бүлгийн уулзалтууд юм. Зөвлөгөөн зорилтот бүлгийн уулзалт хэлбэртэй байгаа нь сумын нийгмийн янз бүрийн бүлгийн төлөөллийг оролцуулах гэсэн гол зорилготой юм. Жишээлбэл: эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, залуучууд, ахмадууд гэх мэт.

2018-2019 онд Даланжаргалан сумын төлөвлөгөөг боловсруулах ажилд 12 Зорилтот бүлгийн уулзалт зохион байгуулсан байна. Чиглүүлэгч баг 4 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан (Тус бүр нэг чиглүүлэгч, нэг тэмдэглэл хөтлөгчтэй 2 тусдаа дэд баг болон ажилласан). ЗБУ-ыг чанартай, саадгүй явуулахын тулд ЗБУ бүрийг хамгийн багадаа 2 хүн хариуцан явуулах хэрэгтэй юм.

Сумын ЗБУ-г зохион байгуулахад анхаарах зүйлс:

- ЗБУ-ын тоо нь сумын нөхцөл байдал, хүн амын тоо, байршил, хэмжээнээс шалтгаалдаг.
- Нэг ЗБУ-д ихэвчлэн 10-12 хүнийг урин оролцуулах бөгөөд янз бүрийн нийгмийн бүлгийн төлөөллүүд байдаг. Оролцогчид зөвхөн нэг багаас эсхүл өөр өөр багаас байж болно. Мөн нийгмийн нэг бүлгийг төлөөлөл эсхүл олон янзын бүлгийн төлөөлөл байж болно.
- ЗБУ бүр хоёроос гурван цаг үргэлжилдэг.
- ЗБУ бүрт зөвхөн 2-3 “дасгал” буюу аргыг ашиглах хэрэгтэй. 3-р хэсэгт эдгээр дасгалын тухай тайлбарласан болно (Нийгмийн зураглал, Байгалийн нөөцийн зураглал, Нүүдлийн зураглал, Байгаль орчны асуудлуудын тухай хэлэлцэх Н-хүснэгтийн арга, Амьжиргааны тухай хэлэлцэх Н-хүснэгтийн арга).
- ЗБУ бүрийн төгсгөл үед асуудлуудын тухай харилцан ярилцаж, гарах арга замын тухай хэлэлцэнэ.

ЗБУ бүрт яагаад зөвхөн 10-12 хүн байх хэрэгтэй вэ?

- Багийн түвшинд зохиогдож байгаа ихэнх ЗБУ гэрт эсхүл багийн байранд болдог. Энэ үед тухтай сууж, ярилцаж болох хүний тоог бид 12 гэж үзэж байгаа юм.
- Энэ нь нэг чиглүүлэгч, нэг тэмдэглэл хөтлөгч ажиллахад тохиромжтой орчин ба бүх оролцогчид үгээ хэлэх орон зай, хангалттай хугацааг олгож байгаа юм.

ХЭСЭГ 2. БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сумын нөхцөл байдал янз бүр байдаг. Жишээ нь, Хангайн бүсийн өрх айлууд хоорондоо ойролцоо амьдардаг байхад Говийн бүсийн өрхүүд нэг нэгнээсээ хол зайтай нутагладаг. Иймээс энд тусгасан санал зөвлөгөөг зөвхөн чиглэл гэж үзэн орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулах хэрэгтэй. Ажлын төлөвлөгөө гаргахдаа тухайн суманд амьдардаг туршлагатай хүнийг чиглүүлэх багт зөвлөхөөр оролцуулах шаардлагатай. Зөвлөлдөх уулзалтуудад бэлтгэх алхмууд:

1. Сумын байршил, газар зохион байгуулалтын асуудлууд, суурь мэдээллийг уншиж судлах.
2. Оролцогчдыг сонгох.
3. Чиглүүлэх багийн гишүүдийг бүрдүүлж, сургалт хийх.
4. Тэмдэглэл хөтлөх, ажлын бэлтгэлийг хангах.
5. Хурлын удирдамж, хөтөлбөр бэлтгэх.
6. Суман дахь хамтын оролцоотой зөвлөлдөх уулзалтын төлөвлөлт, материал бэлтгэх.

2.1 Суурь мэдээллийг уншиж судлах

Чиглүүлэх баг сумын нийгэм, эдийн засгийн мэдээллийг уншихаас ажлаа эхлэх хэрэгтэй. Энэ тухай мэдээллийг төлөвлөгөө боловсруулах эхний шатанд төвийн болон орон нутгийн мэдээллийн нээлттэй эх сурвалжуудаас цуглуулсан байх шаардлагатай. Эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн байгууллага эсхүл ТББ-ын суманд хийсэн судалгаа, шинжилгээний тайлан зэрэг бусад бүх эх сурвалжаас авч болно. Энэхүү мэдээллийг ЗБУ-ын бүлэг сонгох, зөвлөлдөх уулзалтын хуваарь гаргах зэрэг ажлын төлөвлөлт хийхэд ашиглана. Ихэвчлэн төлөвлөгөө хийж буй газрын мэргэжилтнүүд суурь мэдээллийг олж цуглуулах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Хүн ам;
- Газар зүйн төлөв байдал, байгаль орчны тулгамдаж буй асуудлууд;
- Орон нутгийн эдийн засгийн салбар, сумын эдийн засгийн хөгжлийн түүх;
- Малын тоо;
- Ажил эрхлэлт, эрүүл мэнд;
- Орон сууц, тээвэр, дэд бүтэц гэх мэт.

2.2 ЗБУ –д оролцогчдыг сонгох

ЗБУ -ын нийгмийн бүлгийг тодорхойлохдоо суурь мэдээллийн үр дүнг ашиглаж болно.

Нийгмийн бүлгүүдийн жишээ:

- | | |
|-------------------------------------|-----------------------------------|
| - Эрэгтэй малчид | - Чинээлэг өрхүүдийн төлөөлөл |
| - Эмэгтэй малчид | - Шилжиж ирсэн өрхүүдийн төлөөлөл |
| - Албан ажил эрхлэгчид | - Тариаланчид |
| - Уурхайд ажиллагсад | - Мал бүхий иргэдийн төлөөлөл |
| - Өрх толгойлсон өрхүүдийн төлөөлөл | - Залуу хүмүүс |
| - Бага орлоготой өрхүүдийн төлөөлөл | - Ахмад хүмүүс |

Орон нутгийн алслагдмал байдлаас шалтгаалан хүн бүрт хүрэхэд хэцүү байдаг. Багийн засаг дарга нар чиглүүлэх багт тусалж, сонгогдсон нийгмийн бүлгүүдийн төлөөллийг оролцуулахад анхааран ажиллана.

Хувь хүний ярилцлага

ЗБУ-уудаас гадна сумын хөгжил дэвшилд дорвитой хувь нэмэр үзүүлж байгаа хэд хэдэн хүнтэй (барагцаагаар 10-12) ярилцлага хийх хэрэгтэй. Ярилцлага хийх хүмүүсийг сонгохдоо эхний шатанд газрын мэргэжилтний цуглуулсан нийгэм - эдийн засгийн мэдээлэлд үндэслэнэ (2.1-ыг үзнэ үү). Хувь хүний ярилцлага хийх хүмүүсийг сонгох жишээ:

- Иргэний нийгэм, төрийн бус байгууллагуудын төлөөлөл, байгаль орчин, нийгмийн сайн сайхны төлөө ажилладаг бүлгүүд;
- Орон нутгийн бизнесийн байгууллагуудын төлөөлөл; хувийн хэвшил, уул уурхайн компани, төрийн өмчийн компаниудын төлөөлөл гэх мэт;
- Сумын захиргааны холбогдох албан хаагчид (байгаль хамгаалагч, байгаль орчны байцаагч, багийн засаг дарга, сумын иргэдийн хурлын тэргүүлэгч гэх мэт);
- Суманд олон жил амьдарч буй олны хүндлэл хүлээсэн ахмадууд гэх мэт.

Ярилцлагын асуултуудыг газрын мэргэжилтний баг, зөвлөлдөх уулзалтуудыг чиглүүлэх баг хамтран боловсруулна. Ярилцлагаар суурь мэдээлэлд ороогүй нэмэлт мэдээллийг олж авах зорилготой юм. Тухайн сумын онцлогоос шалтгаалан янз бүрийн нэмэлт мэдээлэл олж авдаг. Цуглуулсан мэдээллийг төлөвлөгөөний анхны хувилбарт оруулж, эцсийн шатанд хянаж үзэх болно (4-р хэсэг, дараагийн алхмууд –ыг харна уу).

2.3 Чиглүүлэх баг сонгож, сургалт хийх

Дээр тайлбарласанчлан нэг ЗБУ-ыг чиглүүлэх баг 2 хүний бүрэлдэхүүнтэй байх хэрэгтэй бөгөөд нэг нь чиглүүлэгч хийж, нөгөө нь тэмдэглэл хөтлөх

хэрэгтэй юм. Чиглүүлэгч оролцооны аргаар хурал зөвлөгөөн чиглүүлж байсан туршлагатай хүн байх нь зүйтэй.

Чиглүүлэх багийг бие даасан зөвлөхүүдээс бүрдүүлж байгаа тохиолдолд төлөвлөгөө боловсруулж буй газрын мэргэжилтний болон чиглүүлэгч багууд хоорондоо уулзаж нэг нэгнээ мэддэг болох хэрэгтэй. Сургалтын үеэр газрын мэргэжилтний баг чиглүүлэгч багт хандаж зөвлөлдөх уулзалтуудаас ямар мэдээлэл нэмж олж авах шаардлагатай байгаа тухайгаа мэдэгдэнэ. Энэ хоёр баг нийлж ЗБУ-ууд, хувь хүний ярилцлагуудаас цуглуулах мэдээллийн жагсаалт гаргах хэрэгтэй юм.

Чиглүүлэгчдэд зориулсан сургалтын цар хүрээ чиглүүлэгчдийн туршлага, ур чадвараас шалтгаалан янз бүр байх учир энд бүрэн тайлбарлах боломжгүй юм.²

Гэвч ямар ч тохиолдолд чиглүүлэгч багынхан дараах 3 энгийн дүрмийг баримтлах ёстой:

1. Хүмүүст эелдэг сайхан хандах
2. 1-р дүрмийг баримтлах
3. 2-р дүрмийг баримтлах

Мөн сургалтаар багийн бүх гишүүн дараах хандлага, зан байдлыг эрхэмлэн биеэ зөв авч явах ёстойг заавал тайлбарлах хэрэгтэй:

1. Нутгийн иргэдийг хүндлэх;
2. Нутгийн зан заншил, соёлд тааруулан биеэ авч явах;
3. Нутгийн хүмүүсийн мэдлэг, хэлж ярьж, үзүүлж, хийж байгаа үйлдэл зүйлсийг нь сонирхож байгаагаа харуулах;
4. Тэвчээртэй байх, жишээ нь оролцогчдыг яаруулан үймүүлэхгүй байх;
5. Лекц уншихгүй гол нь сонсох ('оролцогчидод заагуур мод өгөх');
6. Харилцан бие биенээсээ суралцах явдлыг дэмжих;
7. Мэдээлэл солилцох явдлыг хөхүүлэн дэмжих;
8. Нутгийн иргэдийн санал бодлоо хуваалцан, илэрхийлж, хамтдаа төлөвлөлт хийх явдлыг урамшуулан дэмжих;
9. Орон нутгийн иргэдийн мэдлэг, мэдээлэлд цогц байдлаар дүн шинжилгээ хийх.

Хамтын оролцоотой зөвлөлдөх арга хэмжээнд зориулсан нэмэлт зөвлөгөө

- ЗБУ болон хувь хүний ярилцлага хийх аль болох тухтай газар сонгож, болж өгвөл оролцогчдын цаг завт тохируулах нь зүйтэй. Тайван, соёлын мэдрэмжтэй, өөрийн байр байдлыг хянаж, ялангуяа төв газраас орон нутагт ирж ажиллаж байгаа бол "мэргэжилтэн" байдлаар

² Чиглүүлэх ур чадварын тухай нэмэлт мэдээллийг дараах хаягаар аваарай: https://www.kas.de/documents/252038/253252/7_dokument_dok_pdf_43458_18.pdf/44d3ecf1-ca81-27ff-0e96-9de840de9aab?version=1.0&t=1539651564380 болон <http://www.oroltsoo.mn/file/4.pdf>

харьцахаас зайлсхийх хэрэгтэй. Хүмүүсийг ичээж сүрдээхгүй, харин тэднийг тайван, тухтай, нээлттэй байхад туслах хэрэгтэй. Чиглүүлэгч оролцооны аргаар ажиллаж байхдаа мэдээлэл хуваалцаж, идэвхтэй ажиллахыг оролцогчдод уриалж, хэн нэгэн давамгайлж ярихгүй байх орчин бүрдүүлж, хүн бүрт бодсоноо хуваалцах орон зай гаргах хэрэгтэй. Ингэхдээ чимээгүй суусан нэгний яриаг сонсох гэх мэт.

- Эмзэг бүлгийн хүмүүстэй ярилцахад багийн бүтэц чухал байдаг. Багийн гишүүд эмзэг бүлгийн хүмүүстэй уулзаж ярилцах үедээ нарийн мэдрэмжтэй байх хэрэгтэй. Боломжтой бол эмзэг бүлгийн эмэгтэйчүүдтэй уулзаж байгаа чиглүүлэгч багт нэг эмэгтэй хүн байх хэрэгтэй юм.

2.4 Тайлан, тэмдэглэл хөтлөхөд бэлтгэх

Зураглал, флипчарт дээрх болон бусад мэдээллийг нарийн тэмдэглэж авах нь зөвлөлдөх үйл ажиллагааны чухал хэсэг бөгөөд сургалтын үеэр энэ тухай сайн таниулах хэрэгтэй. Учир нь эцсийн дүнд зөвлөлдөх процессын тэмдэглэл, тайлан дээр үндэслэж төлөвлөгөөнд оруулна.

Тэмдэглэл хөтлөгч уулзалт бүрийн дараа тэмдэглэлээ анхааралтай хянаж, компьютерт шивнэ. Мөн чиглүүлэгч тухайн тэмдэглэлийг шалгаж алдааг хянана. Уулзалтын дараа аль болох хурдан компьютерт оруулахыг хичээх хэрэгтэй. Ингэвэл ямар нэгэн асуулт, ойлгомжгүй зүйл байвал шинэ сэргэг байгаа дээр нь засаж залруулахад хялбар болно.

Тэмдэглэл дээр уулзалт болсон газар, огноо, оролцогчдын нэрсийг заавал бичих хэрэгтэй. Хэрэв тухайн үед нь шивэх боломжгүй бол дараа нь багаараа ярилцаж гар тэмдэглэлээ нэгтгэнэ. Мөн өөрийн хийсэн ажиглалтыг тэмдэглэнэ. Үүнийг тайлан бичихэд ашиглана.

Файл, зургуудыг зүй зохистой дугаарлаж, нэрлэх нь бас чухал.

Мэдээлэлд дүн шинжилгээ хийх хангалттай цаг гаргах хэрэгтэй. ЗБУ юмуу хувь хүний ярилцлагад оруулах мэдээллийн янз бүрийн эх үүсвэрийг хооронд нь тулган шалгаж, дутуу мэдээллийг олж, зураглал, диаграмаас мэдээлэл олж авах хэрэг гарч болно. Мөн төлөвлөгөөний анхны хувилбарт оруулах тоо мэдээ, диаграмыг хуулбарлахад цаг зарцуулна.

2.5 Удирдамж, хөтөлбөр бэлтгэх

Удирдамж

Удирдамж нь чиглүүлэх багийн зорилго, үүргийг тайлбарласан баримт бичиг юм. Зөвлөлдөх үйл явцын зорилгыг тайлбарласан байдаг учир энэ нь маш чухал бичиг баримт. Энэ бичиг баримтаас оролцогчид олон нийттэй зөвлөлдөх энэхүү арга хэмжээг хэн ивээн тэтгэж байгаа хийгээд юуны тулд ЗБУ-д орж цаг заваа зарцуулж байгаагаа тодорхой мэдэх болно.

Загвар жишээ: Даланжаргалан сумын төлөвлөгөөг боловсруулах ажлын олон нийттэй зөвлөлдөх уулзалтын удирдамж.

Сумын нэр, хөтөлбөр: Даланжаргалан, СНДХТ боловсруулах олон нийттэй зөвлөлдөх үйл явц
Гишүүд/Оролцогчид: ХТБХ-н баг, Газрын мэргэжилтний баг, ГЗБГЗЗГ, Аймгийн газрын алба, сумын ЗДТГ, бүх багаас нийтдээ 120 хүн оролцуулсан 12 удаагийн ЗБУ.
Ивээн тэтгэгчид: ХТБХ, Мокоро байгууллагын ЭГЭЭББ төсөл, Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Сумын ЗДТГ
Зорилго: СНДХТөлөвлөгөөг ГЗБГЗЗГ, Аймгийн ЗДТГ, сумын ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр боловсруулж байгаа. Ажлын санжүүжилтийн 50%-ийг Аймгийн ЗДТГ, үлдсэн 50%-ийг ЭГЭЭББ төслөөс гаргаж байна. Энэхүү ажлыг барагцаагаар 6 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ. СНДХТ-ний чухал хэсэг нь олон нийттэй зөвлөлдөх юм. Бид энэ удаа олон нийттэй зөвлөлдөх шинэ арга туршиж үзэж байгаа. Энэ нь зөвлөлдөх оролцоог аль болох нийтийг хамарсан, жендерийн мэдрэмжтэй болгох гэсэн оролдлого юм. Эдгээр аргыг Хүн Төвтэй Байгаль Хамгааал ТББ хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхдээ ашигладаг ба ЭГЭЭББ төслийн ажилд туршиж үзсэн.
Гол зорилго нь Даланжаргалан сумын иргэдтэй зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулах юм. Бид 12 удаагийн ЗБУ хийх төлөвлөгөө гаргасан (ЗБУ-д оролцох хүмүүсийн хуваарийг харуулах). ЗБУ бүрийг 2-3 цагын хугацаанд 2-3 оролцооны арга ашиглаж явуулна. Бид бүх үйл явцыг тэмдэглэн авч СНДХТ-д тусгах зорилготой. Сумын захиргаанаас СНДХТ-г эцэслэн батлахаас өмнө, анхны хувилбарыг олон нийтэд нээлттэй дэлгэн үзүүлнэ. Та энэ үед үүнийг нягтлан үзэж, саналаа хэлэх боломжтой. Мөн бид эргэн ирж баталгаажуулах уулзалт зохион байгуулан СНДХТ-ийн эцсийн хувилбарыг танилцуулах ба таны санал төлөвлөгөөнд хэрхэн туссан гэдгийг харуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хэрхэн явуулах тухай ярилцах болно.
Үр дүн: СНДХТ-г боловсруулахад хэрэглэх зөвлөлдөх уулзалтуудаас гарсан тэмдэглэл, тайлан.
Үүрэгт ажил: Танилцуулга, Асуулт - хариулт, оролцооны аргаар 2-3 дасгал ажиллах, нэгдсэн хэлэлцүүлэг, хаалт.
Уулзалтын дүрэм: Оновчгүй санаа гэж байхгүй, янз янзын санал гарч болно. Бид эцэст нь нэгдсэн санаанд хүрнэ. Бусад дүрмийг оролцогчид тодорхойлж батална. Жишээ нь: Утсаа чимээгүй болгох; бие биенээ хүндэлж, сонсох; цаг барих, уулзалтын төгсгөл хүртэл байх гэх мэт.

Удирдамжыг ашиглан ЗБУ бүрийг эхлэхдээ танилцуулга хийж, оролцогчдын асуултад хариулна. Иймд үүнийг урьдчилан бэлтгэх хэрэгтэй. (Хавсралтад байгаа загвар 1-г харна уу.)

Хөтөлбөр

Нэг уулзалт хоёроос гурван цаг үргэлжлэх ЗБУ-ын хөтөлбөр бэлтгэнэ. Чиглүүлэх багийн бэлтгэл ажлын нэг хэсэг нь хөтөлбөр боловсруулах юм. Мөн чиглүүлэх баг ЗБУ-д оролцох хүмүүсийн нийгмийн бүлгээс шалтгаалан оролцооны ямар дасгалууд ашиглахыг сонгоно. Энэ гарын авлагын 3-р хэсэгт 4 янзын оролцооны аргыг танилцуулсан байгаа: Нийгмийн зураглал,

Байгалийн нөөцийн зураглал, Нүүдлийн зураглал, Н-хүснэгтийн арга (байгаль орчны асуудал, амьжиргааны асуудал). Тухайн ЗБУ-ын бүлэгт тохирсон дасгал ажиллана. Жишээ нь, нүүдлийн зураглал дасгалыг туршлагатай малчидтай хийхэд илүү дөхөм байдаг. Учир нь тэд мэдлэг сайтай, мэдлэгээ хуваалцах сонирхолтой байдаг. ЗБУ бүрт 2-3 дасгал ажиллахад хангалттай. (Хавсралтаас загвар 2-г харна уу.)

Загвар жишээ: Даланжаргалан сумын төлөвлөгөө боловсруулах үйл явц, ЗБУ-н хөтөлбөрийн жишээ.

ЗБУ 1: Элдэв багийн эмэгтэй малчид

Уулзалтын зорилго: Сндхт боловсруулахад олон нийттэй зөвлөлдөж санал авах

Уулзалт болох газар: Элдэв багийн малчны гэрт

Огноо: (Жил/Сар/Өдөр)

Зарласан цаг 10:00 А.М, **Эхлэх цаг** 10:30

Чиглүүлэгчийн нэр:

Тэмдэглэл хөтлөгчийн нэр:

Хийх ажил:	Хугацаа	Үр дүн
Танилцуулга, асуулт - хариулт (удирдамж харах)	10 мин	Бүртгэлийн хуудас бөглөсөн байна
Нийгмийн зураглал мөн/эсхүл Байгалийн нөөцийн зураглал	1 -1,5 цаг	Нийгмийн зураглал, фото зураг, тэмдэглэл
Байгалийн нөөцийн зураглал	30 мин	Байгалийн нөөцийн зураглал, фото зураг, тэмдэглэл
Нийгмийн асуудлуудын талаар шинжилгээ хийх, хэлэлцүүлэг	1-1,5 цаг	Асуудлын дүн шинжилгээ хийсэн том цаас, тэмдэглэл
Уулзалтын хаалт	10 мин	

Загвар жишээ: Даланжаргалан сум. ЗБУ-д оролцсон нийгмийн бүлэг, ажилласан дасгалын нэрс (Хавсралтаас загвар 3-г харна уу.)

Бүх баг	ЗБУ 1	Малчин эрэгтэйчүүд	Байгалийн нөөцийн зураглал Нүүдлийн зураглал Н-хүснэгт: байгаль орчны асуудал
	ЗБУ 2	Малчин эмэгтэйчүүд	Байгалийн нөөцийн зураглал Нүүдлийн зураглал Н-хүснэгт: байгаль орчны асуудал
	ЗБУ 3	Гэрлээгүй залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд	Нийгмийн зураглал Н-хүснэгт: амьжиргаа
	ЗБУ 4	Өрх толгойлсон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд	Нийгмийн зураглал Н-хүснэгт: амьжиргаа
Элдэв	ЗБУ 5	Гэрлэсэн малчин эмэгтэйчүүд	Нүүдлийн зураглал Н-хүснэгт: амьжиргаа
	ЗБУ 6	Гэрлэсэн малчин эрэгтэйчүүд	Нүүдлийн зураглал Н-хүснэгт: байгаль орчны асуудал
Өнгөт	ЗБУ 7	Мянгат малчин эрэгтэйчүүд	Нүүдлийн зураглал Н-хүснэгт: амьжиргаа
	ЗБУ 8	Мал цөөтэй малчин эмэгтэйчүүд	Нийгмийн зураглал Н-хүснэгт: байгаль орчны асуудал
Бичигт	ЗБУ 9	Малчин эрэгтэйчүүд, өөр ажил эрхэлдэг хүмүүс	Нүүдлийн зураглал Н-хүснэгт: амьжиргаа
Олон-Овоо	ЗБУ 10	Бичил уурхайчид	Нийгмийн зураглал Н-хүснэгт: байгаль орчны асуудал
	ЗБУ 11	Өөр сумаас ирж суурьшсан эрэгтэй, эмэгтэй хүмүүс	Нийгмийн зураглал Н-хүснэгт: амьжиргаа
Цомог	ЗБУ 12	Эрэгтэй, эмэгтэй ахмадууд	Нийгмийн зураглал Н-хүснэгт: байгаль орчны асуудал

2.6 Олон нийттэй зөвлөлдөх ажлын уулзалтын материал бэлтгэх, төлөвлөх

Оролцооны аргаар уулзалт явуулахад олон төрлийн материал хэрэгтэй ба бэлтгэл ажил нэлээдгүй шаардлагатай. Жишээ нь, чиглүүлэх баг орон нутгийн цаг агаар, хүмүүсийн боломжтой цаг завт зохицуулан аялалаа төлөвлөх хэрэгтэй болдог.

Сум дахь аяллын турш хүрэлцэхүйц хэмжээний материал бэлтгэж явах нь чухал.

Уулзалтын материалын жагсаалт:

- | | |
|---|--|
| - Дэлгэмэл том цаас
(флипчартын цааснууд) | - Оролцооны зураглал хийх өөр янз
бүрийн материал |
| - Гэрэлтдэг дэлгэмэл том цаас
(калькан цаас) | - Флипчарт (машин зайтай бол) |
| - Өнгийн цааснууд | - хайч |
| - Самбарын үзэгнүүд | - Пост-ит наадаг цаас, ардаа
цавуутай цаас |
| | - Скоч |

ХЭСЭГ 3. ЗБУ-Д АШИГЛАХ ОРОЛЦООНЫ АРГУУД

ЗБУ-д дараах оролцооны аргуудаас сонгож ашиглах буюу дасгал хийж болно. Чиглүүлэх багийн зүгээс зорилтот бүлгийн нэг уулзалтанд (ЗБУ) оролцогчдын нийгмийн бүлэг, боломжтой хугацаанд үндэслэн 2-3 дасгал сонгоно (Удирдамж, хөтөлбөрийн тухай 2.5-р хэсгийг харна уу). Хамгийн ихдээ 3 оролцооны арга сонгохыг зөвлөж байна.

- Нийгмийн зураглал
- Байгалийн нөөцийн зураглал
- Нүүдлийн зураглал
- Н-хүснэгт: байгаль орчны асуудал
- Н-хүснэгт: амьжиргаа

Эдгээр аргыг доор дэлгэрэнгүй тайлбарлав. Уулзалтын төгсгөлд сөхөгдсөн асуудлуудын тухай нэгтгэн хэлэлцэж, боломжит шийдлийг хамтдаа гаргаж, төлөвлөгөөнд оруулах санал гаргана.



Жишээ: Даланжаргалан сум. Зорилтот бүлгийн уулзалт

3.1 Нийгмийн зураглал

Нийгмийн зураглал³ нь нутгийн хүн ам, айл өрхийн байрлалыг ойролцоогоор харуулж, эрэгтэй, эмэгтэй хүмүүс, насанд хүрсэн хүмүүс, хүүхдүүд, газартай болон газаргүй хүмүүс, бичиг үсэг тайлагдсан хүмүүс зэрэг нийгмийн бүтэц, тухайн нутаг газрын нийгмийн гол байгууллыг зургаар илэрхийлж буй арга юм.

Энэ аргыг дараах зорилгоор ашигладаг:

- Нутгийн иргэдийн газар зүйн байрлалтай холбоотой онцлог шинж, дэд бүтэц, хүн ам зүй, угсаатан, хэл зүйн бүлгүүд, эрүүл мэндийн онцлог, хөрөнгө чинээ гэх мэт;
- Нутгийн хүмүүсийн өөрсдийн үнэлэмж, шалгуур үзүүлэлтүүд дээр үндэслэн янз бүрийн нийгмийн бүлгүүдийг тодорхойлох, нийгмийн бүлгүүдийн дундах хөрөнгийн хуваарилалтыг харах;
- Нутгийн нийгмийн бүтэц, байгууллын тухай олж мэдэх, энэ тухай нутгийн хүмүүс ямар санал бодолтой явдгыг ойлгож мэдэх.

Дараах зүйлсийг олж мэднэ:

- Нутгийн иргэдийн бүтэц, нийгэм-эдийн засгийн байдал;
- Нийгмийн хүчин зүйлсэд суурилсан өрхүүдийн ялгаа;
- Энэ нутагт хэн хаана амьдардаг тухай.

³ http://siteresources.worldbank.org/EXTTOPPSISOU/Resources/1424002-1185304794278/4026035-1185375653056/4028835-1185375678936/3_Social_mapping.pdf

Чиглүүлэх үйл явц

1. Хамгийн багадаа 1х1 метрийн хэмжээтэй том цаас, самбарын үзэгнүүд, янз бүрийн наадаг цааснууд, өнгийн цааснууд, скоч бэлдсэн байна.
2. Дасгалын зорилгыг тайлбарлах. Оролцогчдод ойлгомжтой байгаа эсэх, үргэлжлүүлэхийг хүсч байгаа эсэхийг лавлах.
3. Оролцогчдыг баг эсхүл сумынхаа өрх айл, хүмүүсийн тухай бодохыг санал болгох. Хэн хэн, хаана хаана амьдардаг, ихэвчлэн малчид байдаг уу, төрийн албан хаагчид уу, эсхүл залуу хүмүүс ихтэй юу, ахмадууд ихтэй юу гэх мэт. Хэрэв багийн хүн амын тухай ярьж байгаа бол оролцогчдоос багийн өрх айлуудын байршлыг ойролцоогоор нь бүлэглэн гаргаж хэн нь хэнтэй нэг доор байдгыг харуулахыг оролцогчдоос хүснэ. Харин сумын иргэдийн тухай ярьж байгаа бол айл өрхийн байршлыг бүлэглэн харуулж, тэмдэглэхийг хүсэх.
4. Оролцогчид цаасан дээр айл өрхүүдийн байршлыг тэмдэглэсний дараа өрхүүдийн онцлогыг тэднээс асуух. Жишээ нь, дундаж хүүхдийн тоо, гэрлэсэн/гэрлээгүй өрхийн тоо, ганц бие өрхийн тоо, энэ нутагт төрсөн эсхүл шилжиж ирсэн эсэх, ажил эрхлэлт гэх мэт.
5. Багийн эсхүл тухайн газрын бүх айл өрхийн амьжиргааны тухай оролцогчидтой ярилцах. Ингээд нийт өрхийг амьжиргааны хэдэн бүлэгт хувааж бүлэглэвэл зохистойг тэднээс асуух. Дараа нь бүлэг бүрийн онцлогийг ярилцан тодорхойлох. Жишээ нь: амьжиргаа доогуур өрхийн, чинээлэг өрхийн шинж тэмдэг зэргийг тодорхойлж, тухайн амьжиргааны бүлэгт хамаарах өрхийн тоог барагцаагаар тэмдэглэнэ.
6. Бүрэн хийсэн зураглалыг ашиглан сонирхол татаж буй сэдвийн талаар хэлэлцэх эсхүл статистикийн нэмэлт мэдээлэл цуглуулах, эсхүл оролцогчдыг өөрсдөө дүн шинжилгээ хийж, хэлэлцэх боломж олгодог. Тэмдэглэл хөтлөгч хэлэлцүүлгийн талаар тодорхой бичиж тэмдэглэх хэрэгтэй.



Жишээ: Даланжаргалан сум. Мянгат малчин эрэгтэй хүмүүс оролцсон ЗБУ-д нийгмийн зураглал хийсэн байдал

3.2 Байгалийн нөөцийн зураглал

Байгалийн нөөцийн зураглал⁴ нь дараах мэдээллийг олж авдаг арга юм:

- Байгалийн нөөцийн ашиглалт, хүртээмж, тархалт, давтамж;
- Байр зүй буюу топографи;
- Суурьшил;
- Нутгийн хүмүүсийн өөрсдийнх нь үзэж буйгаар хийж буй ажил.

Энэ аргыг дараах зорилгоор ашиглана:

- Нутгийн байгалийн нөөц, топографи, суурьшил, газар нутагт явагддаг үйл ажиллагаануудын хоорондын харилцаа холбоог тогтоож, шинжилгээ хийх;
- Оролцогчид нутгийнхаа байгалийн нөөцийг зурж, шинж чанарыг нь тодорхойлж, ач холбогдлыг нь ойлгох;
- Асуудал, боломж, бололцоог тодорхойлох.

Дараах зүйлсийг олж мэднэ:

- Нутгийн хүмүүс эргэн тойрны байгал орчноо хэрхэн тодорхойлдгийг мэдэх,
- Нутгийн хүмүүс байгалын нөөц, түүний ашиглалтын талаар дүн шинжилгээ хийх.

⁴ <https://agri-learning-ethiopia.org/wp-content/uploads/2016/06/PRM-Mapping-Guideline.pdf>

чухал хэрэгтэй гэсэн нөөцөө зурж тэмдэглэнэ. Үүнд дэд бүтэц, үйлчилгээний барилга байгууламж (зам, байшин, гүүр, сургууль, эмнэлэг гэх мэт); худаг, уст цэг; хөдөө аж ахуйн газар, ой, уул уурхай явагдаж буй газар, бэлчээр; хөрс, эрэг, өндөрлөг газар; дэлгүүр, зах; шүтлэгтэй уул гэх мэт онцгой газар гэх мэт орно.

4. Зураглалыг хийж дуусгасны дараа чиглүүлэгч оролцогчдыг зургаа тайлбарлахыг хүснэ. Тодорхойгүй байгаа зүйлсийг асууж тодруулах. Чиглүүлэгч өөрт байгаа асуух зүйлсийн жагсаалтын дагуу асууж хариулт авах, зураглал дээр тэмдэглэх. Ийм жагсаалтыг суурь мэдээлэл цуглуулах шатны дараа газрын мэргэжилтний багтай хамтран гаргана. Доорх нүдэнд байгаа жишээг харна уу.
5. Бүрэн хийсэн зураглалыг ашиглан сонирхол татаж буй сэдвээр харилцан ярилцаж хэлэлцэх. Жагсаалтынхаа асуултуудын хүрээнд ярилцах. Эдгээр ярилцлага, хэлэлцүүлгийг тэмдэглэл хөтлөгч бичиж тэмдэглэнэ. Ингэж хийсэн байгалийн нөөцийн зураглалыг нүүдлийн зураглал хийхэд ашиглана. Нүүдлийн зураглал хийх тухай дараагийн хэсэгт тайлбарлав.

Байгалийн нөөцийн зураглал боловсруулж байх явцад олж авах мэдээллийн жагсаалт:

- | | |
|----------------------------------|----------------------------------|
| - Малчны улирлын нүүдлийн хил | - Жимс, жимсгэнэ |
| - Малчны бүлгүүдийн хил | - Жуулчлалын бүс |
| - Багийн хил | - Тусгай зөвшөөрөлтэй уул уурхай |
| - Эрчимжсэн мал аж ахуйн бүс | - Уул уурхайгаас шалтгаалан |
| - Улсын тусгай хамгаалалттай бүс | доройтсон газар |
| нутгийн бүс | - Шинээр гаргасан худаг, усны |
| - Орон нутгийн тусгай | нөөц |
| хамгаалалттай газарт орох бүс | - Шинээр гаргасан цөөрөм |
| - Отрын бүс ба зам | - Бэлчээрийн газар |
| - Ган, зудын нүүдэл | - Хөдөө аж ахуйн барилга |
| - Нөөц газарт орох ёстой газар | байгууламж |
| - Хадлангийн газар | - Усалгаа шаардлагатай бэлчээр |
| - Тариалангийн газар | - Нөхөн сэргээх шаардлагатай |
| - Рашаан, усны хамгаалалт | газар |
| - Цөөрөм хийх бүс | - Бичил уул уурхайн газар |
| - Зэрлэг амьтны бүс | |
| - Эмийн ургамал | |

Байгалийн нөөцийн зураглал хийх хэлэлцүүлэг явуулахад ашиглах асуултуудын жишээ:

- Байгалийн ямар нөөц их эсхүл хомс байдаг вэ? Ямар нөөцийн талаар их маргаан гардаг вэ?
- Бэлчээр, улирлын бэлчээр хаана вэ? Бэлчээр ашиглалтын талаар хэн шийдвэр гаргадаг вэ? Сумын хилээс гадуурх бэлчээрийн талбай бий эсэх?
- Нутгийнхний ашигладаг газар, байгалийн нөөц (бэлчээр, тариалангийн талбай, уст цэг, ой, бичил уурхайн талбай, хашаа хороо гэх мэт). Ашигладаг нөөцөө зурж тэмдэглэх? Эрэгтэйчүүд ямар нөөцийг ашигладаг вэ? Эмэгтэйчүүд ямар нөөцийг ашигладаг вэ? Хүн бүр ямар нөөцийг ашигладаг вэ?
- Ус, түлээний мод зэргийг хаанаас бэлтгэдэг вэ? Хэн хийдэг вэ? Татаж авчрахад хэр хугацаа зарцуулдаг вэ? 5-10 жилийн өмнө хэр их хугацаа ордог байсан бэ? Онцгой өөрчлөлт гарсан бол яагаад?
- Зарим үед ашигладаг нөөц (мод, хадлан, тэжээл, нүүрс, хужир мараа) юу вэ? Хэзээ ашигладаг вэ? Хэн хийж, хэн ашигладаг вэ? 5-10 жилийн өмнө хэр их хугацаа ордог байсан бэ? Онцгой өөрчлөлт гарсан бол яагаад?
- Сумын суурьшлын төв газар хаана вэ? Хэр удаан тэнд байгаа вэ?
- Сүүлийн 5-10 жилийн туршид газар ашиглалтын талаар гарсан өөрчлөлт юу вэ? Яагаад ийм өөрчлөлтүүд бий болсон бэ?
- Уул уурхайн компаниудын байршил хаана вэ? Бичил уурхай явагддаг эсэх? Бусад өөр хөрөнгө оруулагчид хаана байдаг вэ?
- Уул уурхайн компаниуд (эсхүл бусад хөрөнгө оруулагчид) баг/суманд дэд бүтэц хийсэн үү? Энэхүү дэд бүтэц нутгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүст хэрэг болдог уу эсхүл хориг болдог уу?
- Уул уурхайн (эсхүл өөр хөрөнгө оруулалт) үйл ажиллагаанаас шалтгаалан баг юмуу сумын ямар нэгэн байгалийн нөөцийн чанар, хүртэх боломжийг хаасан уу? Энэ нь эрэгтэй эмэгтэй хүмүүст өөр янзаар нөлөөлсөн үү?

Байгалийн нөөцийн зураглалын дасгалын эцэст дараах асуултуудыг асууна:

- Гарсан зураглалтай санал нийлж байна уу? Үгүй бол юуг өөрчилж зурмаар санагдаж байна вэ? Яагаад?
- Зураглалд гарсан зүйлсийг мэддэггүй байсан мэт санагдаж байна уу, эсхүл ийм л юм гарна гэж бодож байв уу?


3.3 Нүүдлийн зураглал

Нүүдлийн зураглал нь бэлчээр, малын нүүдлийн замыг дүрслэн харуулдаг. Энэ нь бэлчээр бусад нөөцийн ашиглалтад гарч болох маргааныг тодорхойлох боломж олгодог. Жишээ нь, усны нөөц гэх мэт. Мөн хэн эдгээр нөөцийг хариуцаж, хянаж, ашигладаг төдийгүй отор нүүдлийн хил хязгаарыг хэн хэрхэн шийдвэрлэдэг тухай ярилцах боломж олгодог. Дараах зүйлсийг ойлгох нь чухал:

- Сум доторх болон гадагш нүүдлийг хэн, хаашаа, яаж хийдэг вэ, яагаад?
- Хэн, ямар нүүдэл хийхийг хянадаг, хариуцдаг, ус, ой, бэлчээр зэрэг нийтийн эзэмшлийн нөөцийг ямар зохицуулалтаар ашигладаг вэ?

Чиглүүлэх үйл явц

1. Өмнөх дасгалаар бэлтгэсэн байгалийн нөөцийн зураглалыг дэлгэж тавих. Эсхүл сумын юмуу багийн албан ёсны хэвлэсэн газрын зураг байвал дэлгэж тавих. Ингэснээр албан ёсоор сум, багийн хил хаагуур явж байгааг харуулна. Ингээд нүүдлийн зураглалыг зурах зорилгоор гэрэлтдэг калькан цаас дээгүүр нь тавина.
2. Оролцогчидтой ямар хэлбэр дүрс, сум, өнгөөр юуг тэмдэглэхийг тохирох. Үүнд отрын зам, улирлын өөрчлөлт, малын төрөл, янз бүрийн өрх айлууд гэх мэт (жишээ нь, эрэгтэй юмуу эмэгтэй өрх толгойлсон өрхийн нүүдэл, ямар багийн хүмүүс хаашаа нүүдэг, өөр сумын хүмүүс орж ирдэг эсэх гэх мэт). Олон төрлийн отор нүүдлийг харуулах зорилгоор нэгээс илүү калькан цаас ашиглаж болно (жишээ нь, ган, зудтай жилийн нүүдэл, янз янзын хүмүүс, малын нүүдэл гэх мэт).
3. Цаасаа цэвэрхэн, хуурай газар тавина.
4. Зураглалыг хийж байх явцад болон дараа нь ярилцлага өрнүүлнэ. Дараах нүдэнд байгаа асуултуудын хүрээнд ярилцаж болох ч тухайн нөхцөл байдлаас шалтгаалан ямар ч сэдвийн хүрээнд хэлэлцэж болно. Боломжтой бол хариултуудыг зураглалд оруулж, тэмдэглэл хөтлөгч бичиж авна.



Жишээ. Даланжаргалан сум. Байгалийн нөөцийн зураглал дээр калькан цаас тавьж хийсэн нүүдлийн зураглал. Элдэв багийн малчин эрэгтэйчүүдтэй хийсэн ЗБУ.

Нүүдлийн зураглал хийх ярилцлагад ашиглах асуултуудын жишээ:

- Малын төрлөөс шалтгаалан бэлчээрлүүлэхийн тулд заавал оторт гарах шаардлагатай байдаг уу? Яагаад?
- Улирлаас шалтгаалан малын отор нүүдэл янз бүр байдаг уу? Хэрхэн?
- Энэ баг юмуу сумын хүмүүс малын отор нүүдэлд гарахдаа нэг ижил зүг рүү явдаг уу? Өрх толгойлсон эрэгтэй эсхүл эмэгтэйтэй өрхийн хувьд отор нүүдэл хийх ялгаа байдаг уу? Хэрэв тийм бол ямар ялгаа байдаг вэ? Шалтгаан нь юу вэ?
- Энэ багийн өрх айлууд хэзээ, яаж малтайгаа нүүхийг хэрхэн зохион байгуулдаг вэ? Жишээ хэлнэ үү?
- Багийн хилээс гадуур нүүх тохиолдолд нүүдлийн зам, шинжийг нөгөө багтай хэрхэн ярилцаж, зохион байгуулдаг вэ?
- Сумын хилээс гадуур нүүх тохиолдолд нүүдлийн зам, шинжийг нөгөө сумтай хэрхэн ярилцаж, зохион байгуулдаг вэ?
- Отор нүүдэл хийхэд маргаан гардаг уу? Тийм бол хаагуур гардгийг зураг дээр тэмдэглэнэ үү? Ямар төрлийн маргаан гардаг вэ? Маргааныг хэрхэн шийдвэрлэдэг вэ?
- Ийм зөрчлийг арилгах ямар арга байна вэ?
- Энэ багийн айл өрхүүдэд отор нүүдэл хэр чухал вэ? 5-10 жилийн өмнөхтэй харьцуулж үзнэ үү? Эсхүл 23-30 (социализмын үетэй) жилийн өмнөхтэй харьцуулбал ямар байна вэ? Яагаад ийм өөрчлөлт гарсан бэ?
- Отор нүүдэл багасахад ямар үр дүн гардаг вэ?

3.4 Н-хүснэгт: байгаль орчин болон амьжиргааны асуудлуудын тухай

Энэ арга⁵-г хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, хяналт-шинжилгээ хийхэд өргөн хэрэглэдэг. Энэ нь олон хүн оролцож буй уулзалтаас олон мэдээллийг базан авч, дүн шинжилгээ хийхэд үндэслэл болгох сайн арга юм. Энэ дасгалыг хийхдээ оролцогчид байгалийн нөөц, амьжиргаа буюу эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой орон нутгийн нөхцөл байдалд үнэлгээ өгнө.

1. Эхлээд одоогийн нөхцөл байдалд үнэлгээ өгнө (0-10-ын хооронд оноо өгнө, 0 хамгийн муу, 10 хамгийн сайн гэсэн үг).
2. Дараа нь оролцогчид эхлээд “сөрөг” шалтгаан (яагаад ийм муу оноо өгсөн) буюу асуудал, саад тотгорыг ярилцана; дараа нь “эерэг” шалтгаан (яагаад оноо ийм өндөр байгаа) буюу амжилт, боломжын тухай ярилцана.

⁵ <https://pubs.iied.org/6150IIED/?s=PLA>

3. Эцэст нь оролцогчид одоогийн байгаа оноог 10 - т хүргэхийн тулд хийх боломжтой ажил, шийдлийн тухай ярилцана.

Төлөвлөгөө боловсруулахад санал оруулах энэхүү зөвлөлдөх уулзалтад Н-хүснэгтийг 2 асуудлын хүрээнд хийж болно. Үүний нэг нь байгаль орчны асуудлуудын хүрээнд, нөгөө нь амьжиргааны асуудлуудын хүрээнд юм. Н-хүснэгтийн голд байрлуулах гол асуулт дараах хэлбэрээр байна:

Н-хүснэгт: байгаль орчны асуудлууд – Бид газар ба байгалийн нөөцөө хэр сайн буюу хэр тогтвортой ашиглаж байгаа вэ?

Н-хүснэгт: амьжиргаа: Энэ сумын иргэд амьжиргаагаа хэр сайн дээшлүүлж байгаа вэ?

Чиглүүлэх үйл явц

1. Н-хүснэгтийг флипчартын цаасан дээр урьдчилан бэлтгэсэн байна. (Хавсралтад загвар 4а (Н-хүснэгт: байгаль орчны асуудлууд), 4б (Н-хүснэгт: амьжиргаа) оруулав.)
2. Жижигхэн цаас, үзэг оролцогчдод тарааж өгнө.
3. Оролцогчдоос Н-хүснэгтийн асуултад хариулж 1 -10 –ын хооронд оноо өгөх, ингэхдээ тарааж өгсөн жижигхэн цаасан дээр оноогоо нууцаар бичихийг хүсэх. Оролцогчдод бодох хугацаа хангалттай өгч, чиглүүлэгчээс асууж тодруулах боломж олгоно.
4. Оноо бичсэн жижиг цааснуудыг хураан авч оноонуудын нийлбэрийг оноо өгсөн оролцогчдын тоонд хувааж дунджыг олно. Жишээ нь, 10 хүн оролцож буй ЗБУ байна гэж бодъё. Тус бүрдээ 6, 7, 4, 5, 5, 6, 7, 2, 1, 3 гэсэн оноо өгчээ. Ингэвэл бүлгийн дундаж оноо 4.6 болох юм. (Тоонуудыг нэмээд аравт хуваана гэсэн үг)
5. Хүснэгтийн эерэг шалтгаан гэсэн баганад оч. Оролцогчдоос энэ оноо яагаад 1 юмуу 3 биш 4.6 байна вэ? Ийм оноо өгөх болсон эерэг шалтгаанууд юу вэ? гэж асууна. Тэдний хариултыг хэлэлцэн эерэг шалтгаан гэсэн баганад жагсаан бичнэ.
6. Хүснэгтийн сөрөг шалтгаан гэсэн баганад оч. Жишээ нь бүлгийн дундаж оноо 6 байсан гэж бодъё. Тэгвэл оролцогчдоос энэ оноо яагаад 10 биш 6 байна вэ? 10 д хүрэхгүй байх ямар шалтгаанууд байна вэ? гэж асууна. Тэдний хариултыг хэлэлцэн сөрөг шалтгаан гэсэн баганад жагсаан бичнэ.
7. Гарах арга зам гэсэн баганад оч. Оролцогчдоос энэ оноог 10 руу дөхүүлэхийн тулд ямар арга хэмжээ авч, юу хийж болох вэ? гэж асууна. Тэдний хариултыг хэлэлцэн баганад жагсаан бичнэ.
8. Гарах арга замыг оролцогчидтой ярилцан нэн тэргүүний хийх ёстой арга хэмжээний дагуу жагсаана.

Жишээ. Н-хүснэгт: байгаль орчны асуудлууд

Сөрөг шалтгаанууд	Бид газар ба байгалийн нөөцөө хэр сайн буюу хэр тогтвортой ашиглаж байгаа вэ? Оноо 0-10 (0 бага-10 их) 0 —————>.....10 Дундаж оноо 4.5	Эерэг шалтгаанууд
- Уул уурхайн компаниуд маш их шороо босгодог - Усны нөөц багасч байна - Уул уурхайн компаниудын ухсан нүхэнд мал унаж үхэж байгаа - Таван худаг ширгэсэн - Рашааны ус бохирдсон, уух аргагүй болсон - Бэлчээр доройтож, олон малын хөлд талхагдаж байна - Малчид хол нүүхээ больсон - Нэг худгаас хэт олон мал усалж байна, ойр тойрных нь бэлчээрийг устгаж байна - Хур тунадас бага - Зуд ойр ойрхон болдог болов	Гарах арга зам - Байгалийн нөөцийн менежментийн тухай малчид, төр захиргаа, уул уурхайн компаниуд хоорондоо харилцан зөвлөлддөг механизм бий болгох - Багийн хурлыг сайн хийж, сайн шийдвэр гаргадаг болох - Уул уурхайн компаниудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэг жилийн тайланг олон нийтэд хурал хийж байж баталдаг болмоор байна - Сумын хайгуулын лицензийн хүсэлтийг олон нийтэд танилцуулах. Иргэд бэлтгэлтэй баймаар байна. - Хайгуулын лицензийн тоог цөөлөх - Буугаар тэнгэр буудаж бороо оруулах	- Малчдын өвөлжөөний газарт эзэмших гэрчилгээ олгож эхэлсэн - Сумдын захиргаадын дунд нүүдлийн гэрээ хийдэг - Малын тоо өсч, амьжиргаа дээшилж байна - Бэлчээрийн менежмент хийх малчдын бүлгүүд байгуулагдаж байгаа - Малчдад малын тоонд биш чанарт анхаарах тухай сургалт орж байгаа

(—)

Гарх аргаар:

(+)

- [illegible]

- УУХ УУРХАЙН ЯВН
БАЙГАА СЭЙМЭГ
ӨРВӨЛХӨР
УРЭГЭЭЛЭМНИЙ ӨЗЭС
ТӨВ БАХУУ
- ДУУН ЗАСВАР ГН
МАШИННИЙ ЗОСООЛ
РУУГАА ТӨВЛӨӨР
(МАШИННИЙ ЧУЛЧЛАГЭ)
- УУХ УУРХАЙН
МАШИНУУДЫН
ТӨВ БАХУУ
- НАГДСАН БОХИРХИЙН
СИСТЕМТЭЙ
БОЛОХ
- ХҮҮХДЭМНИЙН СИСТЕМНИЙ
ТААБАЙН ӨРГӨТӨХ
САНДАЛГАВУХ СУНГАЙ
СЭЙМЭГ САНХҮРҮУЛАХ
- НҮСЭРХЭЭС ХҮСЭР
ЭРХЭА МЭНДЭНИЙ
ХОХИРГА, НӨЛӨӨЛӨНН
СУДАХ
- ХҮРХАЙ, ӨБӨН НҮРГА
ТАЙ ХАНГАР
ТОНИН ХҮБЭА ТН
РӨННЭГЭ АРХИЛХ
- БАНГУЛАГАА УУДИН
УУРХАНТАЙ ХАМТАЙ
БЭГ ТӨХИМҮУЛАХ
ТӨВ БАХУХ
- ЭРҮҮА МЭНДЭН ВЕА
ЧУЛЧЛЭГ ДООЛГОР
АВОХ ЭМ НЭГЭГЭ Н
УЛЧУЛДЭЭНГЭ ГАЗАР
ТӨВТЭЙ БОЛОХ
- НҮРС, УС, ТООСЖИ
ТҮН НӨЛӨӨЛӨӨС
ЭРҮҮА МЭНДЭА
НӨЛӨӨЛГ БҮНГ, УЗЛА
ШИНЖИЛЭЭНД ХАМГАРИН

үзгүчтүү аял тараал
хүрээлүүтүн.
нүүн барыган, бү
нүүн бот хүчтү салт.

2021.6.12-14. Chen Yuyang (moved) Haze	БНД АМБХ ИДГААГАА ХЭР САЙН ДЭЭШЛҮҮХАА ЧАДАХ БАЙНА ВЭ?	FOL9
(-)	+	(+)
-Тогтмол орлоготой	* 406	-ТОГТМОЛ ОРЛОГОТой
-АЖЛЫН БАЙРГҮЙ	66 10	-АЖЛЫН БАЙРТАЙ БОЛОХ
-Эрүүл мэнд, асуудал	<u>Гарах арга зам</u>	-БАГИЙН ХҮН АМ ОЛОН,
-Юмны үнэ өндөр (бензин) зардал	-Цалин нэмэх	
-Орон зайны асуудал	-Зээл-н хув (буцаулах) (Цалин нь зээл-н аслаг)	-Барилгын материал Зарах тов байгуулах (Газар шилдэх)
-Мантай (олон) айлчлал Боломжийн амьдралтай	-Өрхцөн ала эрхлэх (ногдоо) (Хүнийн ала)	-Тосол бичих аргачлал суртал авах
-Тогтмол орлоготой айлчлал Дундаж амьдралтай	-Төсөл хамрагдах (буцаан тоолог, тоологгүй)	-Сум хөгжилтэй төсөл сонгон шалгаруулах баа суманд ала шийдэг болмол байна
-Их муч амьдралтай айл Б/ггүй	-Сүг боловсруулах цех (Зайрмаг хич)	-Шударга сонгодог б/х → Захирааны үзэг ажиллагаа
-Олон хүүхдтэй орлоготой айл Маш цөөн	-Мат, махан бүт бэлдсүүлэх Цехтэй болох (Хийжигдэх граммийн савалдтай) Бүлэг	-Өмнө нь зээл авсан хүүхд-н орлоготой айл Сайхруулах
-Умрын чанартай (жонх салма) Ажилладаг (нур ялгах)	-Хүнс, барилгын зах-тай Болго	
-Ахуйн үйлчилгээнд төртөн Болго	-Зам затаах машин засвар, дугуй засвартай тээврийн байдал Зөмжүүл, сансардтай	

- 119 -

3.5 Уулзалтын үеэр сөхөгдсөн асуудлуудын тухай хэлэлцүүлэг хийж, боломжит шийдэл гаргаж төлөвлөгөөнд оруулах санал боловсруулах

ЗБУ-ын дасгал, хэлэлцүүлэг дээр үндэслэн, чиглүүлэх баг уулзалтын төгсгөл үед нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлуудын талаар хэлэлцүүлэг өрнүүлж, боломжит шийдлүүдийг гаргаж төлөвлөгөөнд оруулах санал боловсруулна.

ЗБУ-ын оролцогчдын чухал хэмээн цохон тэмдэглэж буй асуудал бүрийг чиглүүлэгч уулзалтын төгсгөлд нарийвчлан хэлэлцүүлж боломжит шийдлийг олохыг уриалан чиглүүлнэ. Боломжит арга хэмжээг хэн хариуцах ёстойг анхан шатны байдлаар оролцогчид санал нэгтэй гаргах хэрэгтэй.

Төгсгөлийн хэлэлцүүлэг хийхдээ дараах энгийн хүснэгтийг ашиглаж, санаа оноог цэгцэлж бичиж болно. Оролцогчдын нэгдсэн саналыг авч төлөвлөгөө боловсруулж буй газрын мэргэжилтний багт өгөх юм. (Хавсралтын Загвар 5 –ыг үзнэ үү)

Асуудал	Шалтгаан	Үр дагавар	Боломжит шийдэл (төлөвлөгөөнд тусгуулах)	Хариуцах тал

ХЭСЭГ 4. ДАРААГИЙН АЛХМУУД

Олон нийттэй зөвлөлдөх уулзалтууд (ЗБУ-д, хувь хүний ярилцлагууд) дууссаны дараа газрын мэргэжилтний баг төлөвлөгөөний анхны хувилбарыг боловсруулж сумын иргэдэд нээлттэй болгоно. Энэхүү төлөвлөгөөг нутгийн иргэдтэй баталгаажуулах уулзалтууд зохион байгуулан эцэслэн шийдвэрлэх хэрэгтэй.

4.1. Зөвлөлдөх уулзалтуудын (ЗБУ, хувь хүний ярилцлагууд) дараагийн алхмууд

ЗБУ-уудын үеэр хийсэн бүх тэмдэглэл, тайланг нарийн нямбай, хурдан шуурхай компьютерт шивж, төлөвлөгөө хийж буй газрын мэргэжилтний багт хүргүүлнэ. ЗБУ-аас авсан мэдээллийг хэрхэн нэгтгэж дүгнэх талаар чиглүүлэх баг, газрын мэргэжилтний баг харилцан ярилцаж, төлөвлөгөөний хаана нь оруулахыг тохирох. Иймд чиглүүлэгч баг, газрын мэргэжилтний баг хэд хэдэн удаа уулзан ярилцаж нутгийн иргэдийн санал болгосон нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлуудын боломжит шийдлүүдийг төлөвлөгөөнд оруулах талаар ажиллана.

Анхан шатны баримт бичиг бэлэн болсны дараа ЗБУ-ын оролцогчид, ярилцлага хийсэн хүмүүсийн төлөөллийг уг баримт бичгийг хянаж, саналаа өгөхийг хүснэ.

СНДХТ-ний анхны хувилбарыг олон нийтэд танилцуулж, санал авч болох механизмууд:

- Сумын захиргааны цахим хуудсыг ашиглан мэдээлэл тарааж, санал авч болно.
- Сумын захиргааны зарлалын самбар дээр СНДХТ-ны анхны хувилбар бэлэн болсон тухай зарлал байрлуулах. Банк, дэлгүүр, сургууль гэх мэт өөр бусад газрын үүдэнд байрлуулж болно.
- Багийн засаг дарга нар СНДХТ-ний анхны хувилбар бэлэн болсныг нутгийн иргэдэд дуулгаж, түүнийг үзэж саналаа өгч болох тухай хэл хүргэж болно.

Ямар нэгэн зарлалыг хүн бүр ойлгох энгийн хэлээр бичих хэрэгтэй.

Хэрэв сумын захиргаанаас сумын хэмжээний зөвлөлдөх уулзалт хийхээр шийдсэн бол уулзалтын цагийг нутгийн хүмүүсийн улирлын болон өдөр тутмын ажлын хуваарийг харгалзан гаргах хэрэгтэй. Ингэснээр аль болох олон хүн оролцох боломжтой юм. Санхүү болон бусад нөөц байвал баг бүрт зөвлөлдөх уулзалтыг зохиож болох юм. Гэхдээ сумын төвд багуудаас төлөөллүүд оролцуулан хуралдаж болно. Төлөвлөгөө нь сумын хэмжээний баримт бичиг учир баг бүрээс санал авах нь чухал.

Ямар ч үед, төлөвлөгөөний анхны хувилбарыг иргэдэд таниулж, санал авах зорилгоор сумын захиргаан дээр багадаа нэг сар байрлуулах хэрэгтэй.

Төлөвлөгөөний анхны хувилбарын нутгийн иргэдэд үзүүлж, санал авах хангалттай хугацаа өгсний дараа, газрын мэргэжилтний баг өгсөн саналууд дээр үндэслэн төлөвлөгөөг эцэслэн боловсруулж ГЗБГЗЗГ болон бусад байгууллагууд руу хүргүүлж санал авна. Үүний дараа эцсийн хувилбарыг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар танилцуулж, батлуулах юм.

4.2. Төлөвлөгөөг иргэдэд таниулж, баталгаажуулах уулзалтууд

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар төлөвлөгөөг албан ёсоор батлан хүлээн авсны дараа, сумын бүх иргэнд бодлогын чухал баримт бичиг боловсруулагдсан гэдгийг мэдээлэх нь зүйтэй. Энэ ажлыг нутгийн иргэдтэй баталгаажуулах уулзалтууд зохион байгуулж гүйцээж болно. Ингэж төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг илүү амжилттай эхэлнэ.

Баталгаажуулах уулзалтуудын зорилго

Төлөвлөгөө боловсруулагдсаны дараа нутгийн иргэдтэй баталгаажуулах уулзалт хийх нь нийт процессын чухал хэсэг. Ийм уулзалтууд дараах зорилго агуулна:

1. Уг бичиг баримтад тусгагдсан баг бүрээр гарсан үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагааг баталгаажуулах.
2. Нутгийн иргэдэд энэхүү чухал бодлогын бичиг баримт гарсан гэдгийг

мэдээлж, иргэдийн энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гар бие оролцож, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхийг уриалах.

3. Сумын одоогийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлууд, нөхцөл байдлын тухай мэдлэг олгох.
4. Иргэдэд илүү сайн мэдээлэл түгээж нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

Баталгаажуулах уулзалтад хэнийг урих вэ?

1. Боломжтой бол ЗБУ-д оролцсон бүх хүнийг энэ уулзалтад урих нь зүйтэй. Гэхдээ сумын бусад бүх иргэдийг нэмж урих хэрэгтэй.
2. Төлөвлөгөө боловсруулсан газрын мэргэжилтний баг, эсхүл чиглүүлэх багийнхан оролцож төлөвлөгөөний гол сэдвүүд, төлөвлөгдсөн үйл ажиллагааны тухай танилцуулах хэрэгтэй.
3. Сумын засаг дарга болон бусад холбогдох сумын ажилтнууд (байгал орчны байцаагч, газрын мэргэжилтэн, нийгмийн ажилтан) оролцох.
4. Сум, багт үйл ажиллагаа явуулдаг бизнесийн байгууллагуудын төлөөллийг урих.

Баталгаажуулах уулзалтыг оролцооны аргаар явуулах зөвлөгөө

- Энэ ажлыг хийх чиглүүлэх баг томилох: 1-2 чиглүүлэгч, 1 тэмдэглэл хөтлөгч. ЗБУ-ууд, хувь хүний ярилцлагуудыг зохион байгуулсан чиглүүлэгчид байх хэрэгтэй.
- Чиглүүлэх баг, газрын мэргэжилтний багтай хамтарч уулзалтын хөтөлбөр боловсруулж, уулзалтуудыг зохион байгуулна.
- ЗБУ-уудыг баг бүрт хийж байсны адилаар зохион байгуулах нь зүйтэй. Ингэснээр аль болох олон хүн оролцох боломжтой.
- Чиглүүлэх багийн зүгээс багийн дарга нартай хамтран ажиллаж, цаг, газрыг тогтоно. Нутгийн хүмүүсийн улирлын ажлын ачаалал, өдөр тутмын хуваарийг харгалзан үзэх хэрэгтэй.
- Баталгаажуулах уулзалтын хугацаа 2-3 цаг байна.
- СНДХТ-ний танилцуулгын гол сэдвүүдийг флипчартын цаасан дээр бичиж урьдчилан бэлтгэсэн байна.
- Уулзалтын эхэнд чиглүүлэгч оролцогчдыг өөрсдийгөө танилцуулахыг хүсч, хүрэлцэн ирж, идэвхтэй оролцож байгаа явдалд талархал илэрхийлнэ.
- Уулзалтын туршид чиглүүлэгч оролцогчдоос СНДХТ-ний бичиг баримтын тухай ямар нэгэн асуулт байвал чөлөөтэй асуухыг уриална. Бүх асуултыг тэмдэглэл хөтлөгч бичиж авна. Албан ёсны тэмдэглэл хийж сумын удирдлагуудад танилцуулна. Эдгээр нь СНДХТ-г хэрэгжүүлэхэд чухал хэрэгтэй юм.

Баталгаажуулах уулзалтын үйл явц

1. Сумын засаг дарга, оролцоогүй бол сумын албаны хүн нээж үг хэлнэ. Нээлтийн үгийг хэлсний дараа чиглүүлэгчид хурлаа явуулах эрх өгнө.
2. Чиглүүлэх багийн чиглүүлэгч оролцогчдыг өөрсдийгөө танилцуулах, ЗБУ-д оролцсон эсэхээ хэлэхийг хүснэ. Тэмдэглэл хөтлөгч хүмүүсийн нэрсийг бичиж авна. Харин хэн юу хэлэв гэдгийг бичихгүй байх хэрэгтэй.
3. Дараа нь чиглүүлэгч уулзалтын зорилго, хөтөлбөрийг танилцуулна.

Жишээ. Даланжаргалан сум. Таван багт зохиогдсон нутгийн иргэдтэй хийх баталгаажуулах уулзалтын хөтөлбөр

2:00	Сумын засаг дарга нээж үг хэлэх.
2:15	Оролцогчид, чиглүүлэх баг, газрын мэргэжилтний багийн танилцуулга.
2:30	Уулзалтын зорилго, хөтөлбөрийг танилцуулна.
2:40	СНДХТ-ний гол сэдвүүд, төлөвлөсөн үйл ажиллагааны тухай газрын мэргэжилтний багийн төлөөлөл танилцуулна.
3:10	Оролцогчдын санал, асуулт, хариултын цаг.
3:30	СНДХТ-д тусгасан нийгмийн асуудлуудын тухай танилцуулгыг чиглүүлэх багийн төлөөлөл хийнэ.
4:00	Оролцогчдын санал, асуулт, хариултын цаг.
4:20	СНДХТ-ний талаарх сумын засаг дарга, бусад албаны хүмүүсийн санал, хэрэгжүүлэх тухай танилцуулга
4:50	Асуулт, хариулт Уулзалтын хаалт Чиглүүлэгч Дүгнэлт/санал/хаалт/амлалтыг уншина.

4. Асуулт, хариултын хэсэгт илүү цаг зарцуулбал сайн. Ингэснээр иргэд боловсруулсан бичиг баримтын тухай асууж тодруулж, санал өгөх боломж бүрдэнэ. Даланжаргалан сумын ихэнх багийн уулзалтад оролцсон нутгийн иргэд боловсруулсан төлөвлөгөөний тухай танилцуулж байгаад талархаж, зарим нь уг төлөвлөгөөний хэрэгжилтэд оролцох сонирхлоо илэрхийлж, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийхээр амлалт авсан юм.
5. Болж өгвөл баталгаажуулах уулзалтын үеэр орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэд, бизнесийн байгууллагууд хамтдаа төлөвлөгөөг жендерийн мэдрэмжтэй, хүртээмжтэй, оролцоотойгоор хэрэгжүүлэх амлалт авбал сайн.
6. Эцэст нь хэлэхэд төлөвлөгөө бол “амьд” бичиг баримт. Иймд баталгаажуулах уулзалтын үеэр хэн юу хэрэгжүүлэх, хэн хэрхэн

төлөвлөгөөг хянаж шалгах тухай ярилцан хэлэлцэж болно. Ийм учраас уулзалтын тэмдэглэл хөтлөх нь маш чухал. Хийсэн тэмдэглэлийг хүлээлгэн өгөх хэрэгтэй (уулзалтын төгсгөлд чангаар уншиж, сумын захиргааны төлөөлөгчдөөс санал нэгтэй байгааг лавлах).

ХАВСРАЛТ 1. ЗАГВАРУУД

Загвар 1. Удирдамж
Бүрэн хийсэн жишээг 103-104-р хуудаснаас үзнэ үү

Сумын нэр ба Хөтөлбөр:
Гишүүд/Оролцогчид:
Ивээн тэтгэгчид:
Зорилго:
Гарах үр дүн:
Үүрэг даалгавар:
Дүрэм:

Загвар 2. Хөтөлбөр
Бүрэн хийсэн жишээг 105-р хуудаснаас үзнэ үү.

ЗБУ No.: Бүлгийн тайлбар: Уулзалтын зорилго: Уулзалтын байршил: Оролцогчдын тоо: Огноо [Жил/Сар/Өдөр]: Зарласан цаг: Эхлэсэн цаг: Чиглүүлэгчийн нэр: Тэмдэглэл хөтлөгчийн нэр:		
Үйл ажиллагаа	Хугацаа	Үр дүн

Загвар 3. ЗБУ бүрт оролцох нийгмийн бүлгийн төлөөлөл, уулзалтад ашиглах дасгалуудыг төлөвлөх хуудас. Бүрэн хийсэн жишээг 106-р хуудаснаас үзнэ үү.

Багийн нэр	ЗБУ Но.	Бүлгийн танилцуулга	Ашиглах арга, дасгалын нэр

Загвар 4а. Байгаль орчны асуудлаарх Н-Хүснэгт
Бүрэн хийсэн жишээг 118-119-р хуудаснаас үзнэ үү

Сөрөг шалтгаан	Бид газар ба байгалийн нөөцөө хэр сайн буюу хэр тогтвортой ашиглаж байгаа вэ? Оноо 0-10 (0 бага-10 их) 0 → 10 Дундаж оноо:	Зерэг шалтгаан
	Гарах арга	

Загвар 46. Амьжиргааны асуудлуудаарх Н-Хүснэгт

Сөрөг шалтгаан	Энэ сумын иргэд амьжиргаагаа хэр сайн дээшлүүлж байгаа вэ? Оноо 0-10 (0 бага-10 их) 0... →10 Дундаж оноо:	Эерэг шалтгаан
	Гарах арга зам	

Загвар 5. Асуудлуудыг ярилцан нэгтгэх хүснэгт.
120-р хуудсыг үзнэ үү

Асуудлууд	Шалтгаан	Үр дүн	Боломжит шийдэл/ СНДХТ-д тусгах боломжтой	Хариуцах эзэн

Жишээ: Даланжаргалан суманд зохион байгуулсан ЗБУ-аар боловсруулсан Цомог багийн 20-35 настай эрэгтэй, эмэгтэй хүмүүс оролцсон байгалийн нөөцийн зураглал.



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЦАХИМ СИСТЕМ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.8 дахь заалт, ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг тус газрын холбогдох нэгжүүд, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, сумын Газрын даамлуудад тус тус үүрэг болгосугай.

3. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн мэдээллийн баяжилт, мэдээллийн санг эрхлэж, нийслэл, орон нутгийн мэргэжилтнүүд, аймаг, нийслэл, хотын Ерөнхий архитектор, сумын Газрын даамлуудыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Газар зохион байгуулалтын хэлтэс /Ж.Батсайхан/-т, Хот байгуулалтын хэлтэс /О.Одбаяр/-т системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс /Э.Баярмаа/-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлага хамтын ажиллагааны газар /Р.Ганхуяг/-т даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНХҮҮ

09 200162

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн үйл ажиллагаатай холбогдон гарах харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “Агентлаг” гэх), аймаг, нийслэл, дүүргийн Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “аймаг, нийслэл, дүүргийн газрын алба” гэх), орон нутгийн хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Ерөнхий архитектор), сумын Газрын даамлууд, газрын мэргэжлийн байгууллага хуулийн этгээд энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. Нэр томьёоны тайлбар

2.1 Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 2.1.1 “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем” (цаашид “Систем” гэх) гэж газар зохион байгуулалт, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих болон төлөвлөгөөнд иргэд, олон нийтийн оролцоог хангах, хилийн цэсийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах програм хангамж бүхий цогц үйл ажиллагааг;
- 2.1.2. “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн мэдээллийн сан” (цаашид “Мэдээллийн сан” гэх) гэж бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хот байгуулалтын түүний суурь мэдээлэл болон тэдгээртэй холбогдох баримт бичгийн мэдээллүүдийг нэгтгэсэн санг;
- 2.1.3 “Үндсэн хэрэглэгч” гэж агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, хотын ерөнхий архитектор, сумдын Газрын даамлыг;
- 2.1.4 “Тусгай эрхтэй хэрэглэгч” гэж агентлагийн даргын тушаалаар системд нэвтрэх эрх авсан үндсэн хэрэглэгчээс бусад төрийн байгууллагын албан тушаалтныг;
- 2.1.5 “Мэргэжлийн байгууллага” гэж газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;
- 2.1.6 “Төсөл” гэж боловсруулах шатандаа явж байгаа хуулийн дагуу баталгаажуулах эрх бүхий байгууллагаар хэлэлцэгдэж, батлагдаагүй

газар зохион байгуулалт, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг;

- 2.1.7 “Захиалагч” гэж Газрын тухай хуулийн 25.1.1, 25.1.2, 25.1.3, 25.1.5 заасан газар зохион байгуулалтын баримт бичиг болон сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах эрх бүхий этгээдийг;
- 2.1.8 “Төлөвлөгөөний төлөв” гэж систем дэх газар зохион байгуулалт, хот байгуулалтын баримт бичиг төлөвлөгөөг боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг үе шат, явцыг илэрхийлсэн нэршлийг.

Гурав. Системийн бүтэц, зохион байгуулалт

- 3.1 Системийн хэвийн ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангахад Байгууллагад мэдээллийн технологийг ашиглах дотоод журмыг мөрдөнө.
- 3.2 Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем нь Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн системийн нэг дэд систем байх бөгөөд байгууллагын нэгдсэн удирдлагын серверт байршиж, үндсэн сүлжээнд холбогдсон байна.
- 3.3 Үндсэн хэрэглэгчийн холболтын хаяг, сервер компьютерын нэр нь тогтмол байх ба бүртгэлтэй байна.
- 3.4 Агентлагийн үндсэн сервер дээр мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээлэл нэгтгэгдэж, Улсын хэмжээний нэгдсэн системийг бүрдүүлнэ.
- 3.5 Улсын хэмжээний нэгдсэн системээс веб серверээр дамжуулан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгөх, хяналт тавих, лавлагаа мэдээллээр олон нийтийг хангах үйлчилгээг үзүүлнэ.
- 3.6 Улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн мэдээллийн сангийн бүртгэл, шинэчлэл болон өөрчлөлтүүд нь тухай бүр системд автоматаар бүртгэгдэж хадгалагдана
- 3.7 Серверт хандах админы хэрэглэгчийн нэр, нууц үгийг агентлагийн мэдээллийн систем, сүлжээ хариуцсан мэргэжилтэн хариуцах ба хувийг битүүмжлэн Мэдээллийн төвийн нууцын эрхлэгчид хадгалуулна.
- 3.8 Системийн эх код, админы түвшний системийн техникийн баримт бичигтэй байх ба 3.1-т дурдсан журмын дагуу хөтөлж, хадгална.
- 3.9 Мэдээллийн сан байрлах серверийн үйлдлийн систем болон мэдээллийн санд нэвтрэхэд SSH горимоор зохицуулсан нууц түлхүүр ашиглана.

- 3.10 Системийн болон мэдээллийн сангийн хандалтын түүхийг /Log/ агентлагийн мэдээллийн технологи хариуцсан нэгж тухай бүр нөөцлөн хадгална.
- 3.11 Системийн болон мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалтын асуудлыг агентлагийн мэдээлэл, технологи ашиглах дотоод журмын дагуу шийдвэрлэнэ.

Дөрөв. Мэдээллийн сангийн өгөгдлийн бүтэц

- 4.1 Мэдээллийн сангийн газар зүйн мэдээллийн давхарга таних тэмдгийн загвар, атрибут үзүүлэлтийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй газар зохион байгуулалт, хот байгуулалтын төлөвлөгөөний зурган мэдээлэл боловсруулах заавар, стандартын дагуу үүсгэнэ.
- 4.2 Мэдээллийн сангийн Газар зохион байгуулалт, хотын төлөвлөлтийн давхаргуудыг дараах байдлаар ангилна. Үүнд:
- 4.2.1 Төлөвлөлтийн ерөнхий бүс;
- 4.2.2 Төлөвлөлтийн дэд бүс;
- 4.2.3 Төлөвлөлтийн арга хэмжээ;
- 4.2.4 Хилийн цэсийн мэдээлэл;
- 4.2.5 Хамгаалалт, хязгаарлалтын бүс газрын мэдээлэл.
- 4.3 Төлөвлөлтийн ерөнхий бүсэд хамаарах дэд бүсүүд, дэд бүсүүдэд зөвшөөрөх болон хориглох арга хэмжээнүүдийг холбогдох хууль, тогтоомж заавар, аргачлалын дагуу тохируулна.
- 4.4 Энэ журмын 4.2.1, 4.2.2-т заасан ангилалд хамаарах давхаргын атрибут мэдээ нь Хавсралт 1-т үзүүлсэн агуулгатай байна.
- 4.5 Энэ журмын 4.2.3-т заасан ангилалд хамаарах давхаргын атрибут мэдээ нь Хавсралт 2-т үзүүлсэн агуулгатай байна.
- 4.6 Төлөвлөлтийн давхаргуудын тохиргоог дараах тохиолдолд зөвхөн тухайн төлөвлөгөөний төслийн хүрээнд өөрчилж болно. Үүнд:
- 4.6.1 Төлөвлөгөөг батлах эрх бүхий байгууллагын шийдвэр;
- 4.6.2 Төлөвлөгөөний бүсчлэл болон арга хэмжээнүүд бодит байдал, төлөвлөлтийн стандарт, шаардлагад нийцэхгүй, хэрэгжүүлэх боломжгүй талаар төлөвлөгөөг боловсруулах, хяналт тавих эрх бүхий албан тушаалтан, байгууллагын албан ёсны дүгнэлт, шийдвэр;
- 4.6.3 Хууль тогтоомжид заасан эрүүл ахуй, хориглолт, хамгаалалтын бүс, зурвас газартай давхацсан.
- 4.7 Төлөвлөлтийн арга хэмжээнүүдийг дараах байдлаар ангилна. Үүнд:
- 4.7.1 Өргөдлийн дагуу газрын эрх олгох;
- 4.7.2 Дуудлага худалдааны зарчмаар газрын эрх олгох;
- 4.7.3 Төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар газрын эрх олгох;

- 4.7.4 Газрыг нөхөн сэргээх, хамгаалах;
- 4.7.5 Газар чөлөөлөх;
- 4.7.6 Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа. /нарийвчилсан зураг төсөл боловсруулах, дахин төлөвлөлт хийх гэх мэт/
- 4.8 Энэ журмын 4.7.1-4.7.3-т заасан ангилалд хамаарах арга хэмжээг төлөвлөхөд бусад мэдээллийн сангийн бусад давхаргуудтай орон зайн хувьд давхцалтай эсэх чанарын хяналт хийнэ.
- 4.9 Төлөвлөгөөний давхарга бүр дараалсан давтагдашгүй дугаар авч системд бүртгэгдэнэ.
- 4.10 Төлөвлөгөөний арга хэмжээний давхаргын атрибут өгөгдөл нь тухайн арга хэмжээний давтагдашгүй дугаар, газрын хаяг, байршил, зориулалт, одоогийн түвшин, хүрэх түвшин, эхлэх, дуусах хугацаа, хариуцах эзэн, геометр хэмжээс, шаардлагатай төсөв зардлын мэдээллийг заавал агуулсан байна.
- 4.11 Хот байгуулалтын баримт бичгийн давхаргын загвар атрибут өгөгдлийг холбогдох стандарт, журам зааврын дагуу боловсруулж мэдээллийн санд оруулна.
- 4.12 Мэдээллийн санд дараах баримт бичгүүдийн цаасан эхийг цахим хэлбэрээр архивлана.
 - 4.12.1 Батлагдсан ажлын даалгавар;
 - 4.12.2 Төлөвлөгөөний төсөл боловсруулах үе шатны тайлангууд болон эцсийн тайлан;
 - 4.12.3 Төлөвлөгөөний төслийг баталсан холбогдох байгууллагын шийдвэр, хурлын тэмдэглэл;
 - 4.12.4 Төлөвлөгөөний баримт бичигт гаргасан Агентлагийн мэргэжлийн хэлтсийн болон бусад холбогдох этгээдийн экспертиз, дүгнэлт, санал;
 - 4.12.5 Төлөвлөгөөний баримт бичигтэй холбоотой тооцоо судалгаа, зураг төслийн материалууд;
 - 4.12.6 Төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийн тайлан;
 - 4.12.7 Монгол Улсын иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай Монгол улсын засгийн газрын тогтоол, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санал;
 - 4.12.8 Хилийн цэсийн эргэлтийн цэгийг тогтоосон Улсын их хурлын тогтоол;
 - 4.12.9 Бусад.
- 4.13 Энэ журмын 4.12-т заасан баримт, материалуудыг PDF өргөтгөлтэйгөөр 150 DPI-аас багагүй нягтралтайгаар, цаасны хэмжээ хамаарахгүйгээр нэг нүүрийг 5 МВ-аас дээшгүй хэмжээтэйгээр тоон хэлбэрт хөрвүүлэн мэдээллийн санд оруулна.

- 4.14 Мэдээллийн сангийн төрийн болон албаны нууцад хамаарах өгөгдөл, мэдээлэлтэй холбоотой харилцааг Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу зохицуулна.

Тав. Мэдээллийн санд хандах хэрэглэгч

- 5.1 Системд нэвтрэх болон мэдээллийн санд нэвтрэх эрхийг олгох, өөрчлөх, хүчингүй болгох тохиолдолд агентлагийн даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- 5.2 Энэ журмын 5.1-т заасны дагуу системийн удирдлагын хэсэгт хандах эрх нээлгэх тохиолдолд дор дурдсан шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 5.2.1 Системд хандах эрх нээлгэх, өөрчлөх, хаалгах хүсэлтээ агентлагт албан бичгээр ирүүлэх ба эрх нээлгэх албан хаагчийн холбогдох утасны дугаар, майл хаяг, тухайн албан тушаалд томилогдсон тушаалын хамт хавсаргасан байх;
- 5.2.2 Газар зохион байгуулалт, хот байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлыг гүйцэтгэхээр шалгарсан хуулийн этгээд системд хандах эрх нээлгэх, сунгах хүсэлт гаргах тохиолдолд энэ журмын 5.2.1-т зааснаас гадна тухайн ажлыг гүйцэтгэхээр шалгарсан болохыг тодорхойлсон захиалагчийн албан бичиг, эрх олгосон шийдвэр, захиалагчтай байгуулсан гэрээний хуулбарыг хавсаргасан байх.
- 5.3 Агентлагийн даргын тушаалаар эрх авсан хуулийн этгээдийн төлөөлөлд тухайн төлөвлөгөө боловсруулах нутаг дэвсгэрийн нэгжийн хүрээнд системд төсөл үүсгэх, давхарга зураглах, засварлах, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний мэдээллийг харах эрхийг системийн админ нээж, үндсэн хэрэглэгчээр бүртгэнэ.
- 5.4 Системд нэвтрэх нэр, нууц үгийг холбогдох цахим хаягаар хүргүүлэх бөгөөд нууц үгийн нууцлалыг тухайн этгээд өөрөө хариуцна.
- 5.5 Агентлагийн даргын тушаалаар системд хандах Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлыг гүйцэтгэхээр шалгарсан газар зохион байгуулалт, хот байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн системд нэвтрэх эрхийн хүчинтэй хугацааг тухайн ажлыг гүйцэтгэх гэрээний хүчинтэй хугацаатай ижил байхаар тогтооно.
- 5.6 Энэ журмын 5.1-т заасан системд нэвтрэх эрх бүхий албан тушаалтан өөр албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн хугацаанаас хойш 7 хоногийн дотор өөрөө эсхүл аймаг, нийслэлийн газрын алба системийн админд мэдэгдэж нэвтрэх эрхийг хүчингүй болгох тухай хүсэлт гаргана.
- 5.7 Энэ журмын 5.1-т заасны дагуу системд нэвтрэх эрх авсан тусгай эрхтэй

албан тушаалтан “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ”-гээр дамжуулан системд холбогдоно.

- 5.8 Энэ журмын 5.1-т заасны дагуу Мэдээллийн санд хандах эрх бүхий мэргэжлийн байгууллагын төлөөлөл болсон этгээд нь интернэт сүлжээ ашиглан /PPTP-VPN/-гээр холбогдож болно.
- 5.9 Мэдээллийн сан хандах эрх үүсгэхдээ тухайн этгээдийн компьютерын MAC хаягийг бүртгэж өгнө.
- 5.10 Энэ журмын 5.8-д заасны дагуу системд хандах мэргэжлийн байгууллагын хандах эрх бүхий этгээдийн бүртгэлтэй компьютерын MAC хаягаас өөр хаягтай компьютероос хандахыг хориглоно.
- 5.11 Энэ журмын 5.8-д заасны дагуу системд интернэт сүлжээ ашиглан PPTP-VPN-ээр холбогдох этгээдийн хандах хэрэглэгчийн нэр, нууц үг олгох асуудлыг агентлагийн мэдээлэл, технологийн асуудал эрхэлсэн нэгж хариуцаж гүйцэтгэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зургаа. Системийн үйл ажиллагаа

- 6.1 Систем нь газар зохион байгуулалт, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах, газар зохион байгуулалты төлөвлөгөөний мэдээллээр иргэд олон нийтэд үйлчлэх, хилийн цэсийн мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг явуулна.
- 6.2 Төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх үе шат, явц бүрд тодорхой төлөв хооронд шилжих бөгөөд төлөвлөгөөний үе шатны төлөв нь дараах төрөлтэй байна.
- 6.2.1 Төсөл боловсруулах төлөв;
- 6.2.2 Төсөлд санал авах төлөв;
- 6.2.3 Төлөвлөгөөний төслийн хяналтын төлөв;
- 6.2.4 Төлөвлөгөөний төслийн баталгаажуулах төлөв;
- 6.2.5 Төлөвлөгөөний батлагдсан төлөв;
- 6.2.6 Идэвхгүй төлөв буюу төлөвлөгөө хэрэгжиж дууссан төлөв.
- 6.3 Төлөвлөгөөний үе шатны төлөв тус бүр нь газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахаас баталгаажуулж хэрэгжүүлэх хүртэл бүхий л үе шатуудаас хамаарсан тодорхой тохиргоотой байна.

Долоо. Газар зохион байгуулалт, байгуулалтын баримт бичиг боловсруулах, баталгаажуулах

- 7.1 Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулах
- 7.1.1 Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу газар зохион байгуулалтын дэс дараалсан үйл ажиллагааг аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамал эрхэлнэ.
- 7.1.2 Нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тухайн жилийн төлөвлөгөөний арга хэмжээг төлөвлөхдөө газар зохион байгуулалтын мэдээллийн сан дахь дээд шатны төлөвлөгөөнөөс шинээр эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах, нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээг шууд авч төлөвлөгөөний төсөлд тусгана.
- 7.1.3 Нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө агентлагийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бусад мэдээллийн сангуудтай холбогдож дараах мэдээллүүдийг ашиглана. Үүнд

- 7.1.3.1 Газрын кадастрын мэдээллийн сангаас нөхөх олговортойгоор болон бусад хэлбэрээр чөлөөлөх, эзэмшиж буй газрыг өмчлүүлэх нэгж талбарын мэдээлэл;
- 7.1.3.2 Газрын мониторингийн мэдээллийн сангаас нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай газруудыг төлөв байдал, сэргэх чадавхын мэдээлэл;
- 7.1.3.3 Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангаас барилга, байгууламж, шугам, сүлжээ дэд бүтцийн мэдээлэл.
- 7.1.4 Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийн давхаргыг үнэн зөв, зохих масштабын шаардлага хангасан түвшинд нэгж талбар бүрээр бүрэн зураглаж, давхаргын атрибут өгөгдлийг энэ журмын хавсралт 2-т үзүүлсний дагуу гүйцэд бөглөнө.
- 7.1.5 Системээс өгсөн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийн нэгж талбарын давтагдашгүй дугаарыг нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолын төсөлд заавал тусгана.
- 7.1.6 Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барихын өмнө хэвлэн хуудас бүрийг нь аймаг, нийслэл, дүүргийн газрын албаны мэргэжилтэн, газрын даамал гарын үсгээр баталгаажуулж, тоон хэлбэрт шилжүүлэн төслийн хавсралт материал хэсэгт хавсаргана.
- 7.1.7 Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 12 сарын 5-ны дотор хяналтын төлөвт шилжүүлсэн байна.
- 7.1.8 Сум, дүүргийн тухайн жилийн төлөвлөгөөний төслийг батлуулахын өмнө хяналтын төлөвт шилжүүлж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн газрын албаны хяналтад шилжүүлнэ.
- 7.1.9 Төлөвлөгөөний төсөл хяналтын төлөвт шилжмэгц төслийг засварлах эрх системээс автоматаар хаагдана.
- 7.1.10 Хяналтын төлөвт шилжүүлсэн сум, дүүргийн төлөвлөгөөний төслийг аймаг, нийслэлийн газрын алба, аймаг, нийслэл, хотын ерөнхий архитектор, нийслэлийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг агентлаг, нийслэл, хотын ерөнхий архитектор хянаж үзээд, холбогдох санал, дүгнэлтийг хавсарган баталгаажуулах төлөвт шилжүүлнэ.
- 7.1.11 Баталгаажуулах төлөвт шилжүүлсэн төслийг боловсруулсан этгээд тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар

хэлэлцүүлэн, хурлаас гарсан шийдвэр, хурлын тэмдэглэлийг үндэслэн холбогдох засвар, өөрчлөлтийг хурлын тогтоол гарсан өдрөөс хойш 1 хоногийн дотор оруулж, системийн цахим архивт Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тогтоолыг хавсаргаж төслийг батлагдсан төлөвт шилжүүлнэ.

7.1.12 Төлөвлөгөөний төсөл батлагдсан төлөвт шилжсэн дариуд нийслэл, дүүрэг, сумын тухайн жилийн төлөвлөгөөнд засвар өөрчлөлт оруулах эрх системээс автоматаар хаагдана.

7.1.13 Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийн тайланг энэ журмын Хавсралт 3-т үзүүлсэн загварын дагуу арга хэмжээний төрөл тус бүрээр гаргана.

7.1.14 Улс, аймаг, нийслэлийн хэмжээнд Монгол Улсын иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналын талаарх мэдээллийг нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнөөс татаж нэгтгэн энэ журмын Хавсралт 4-т үзүүлсэн загварын дагуу гаргана.

7.1.15 Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн төлөвлөгөө батлагдсан төлөвт шилжмэгц төлөвлөгөөний арга хэмжээний төрлөөс хамааран холбогдох мэдээллийн сангууд руу шилжинэ.

7.1.16 Үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээ, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өргөдлийн дагуу шууд олгох газруудыг газрын кадастрын мэдээллийн санд ажлын давхаргад шилжинэ.

7.1.17 Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газрын мониторингийн системээс доройтсон газрын мэдээллийг авч, сайжруулах талаар зохих арга хэмжээг сонгож төлөвлөнө.

7.1.18 Мэдээллийн сангаас бусад мэдээллийн сангуудад шилжсэн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг тухайн мэдээллийн сантай холбогдож гаргана.

7.1.19 Батлагдсан төлөвт шилжсэн аймаг, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь тухайн оныг дуустал хүчинтэй байх бөгөөд хэрэгжих хугацаа дууссан төлөвлөгөөг систем автоматаар идэвхгүй төлөвт шилжүүлнэ.

7.1.20 Тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж, тодотгох тохиолдолд шинээр төсөл үүсгэх бөгөөд тухайн төслийг ИТХ-аар баталсан тогтоолыг аймаг, нийслэлийн газрын албаны газар зохион байгуулалт төлөвлөлт, хариуцсан хянаж батлагдсан төлөвт шилжүүлнэ.

- 7.2 Улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулах
- 7.2.1 Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн боловсруулах ажлын захиалагч нь ажил гүйцэтгэхээр шалгарсан мэргэжлийн байгууллагад газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлыг газар зохион байгуулалтын цахим системийг ашиглан боловсруулах талаар шаардлага тавьж ажиллана.
- 7.2.2 Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг гүйцэтгэхээр шалгарсан мэргэжлийн байгууллага нь газар зохион байгуулалтын цахим системийг ашиглан төлөвлөгөө боловсруулах ажлыг гүйцэтгэнэ.
- 7.2.3 Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг гүйцэтгэхээр шалгарсан аж ахуйн нэгж энэ журмын 5.2-т заасны дагуу агентлагт хандаж системд нэвтрэх эрх нээлгэнэ.
- 7.2.4 Системд нэвтрэх эрх нээлгэсэн этгээд системд нэвтэрч төсөл үүсгэн, ажлын даалгаврыг хавсаргаснаар төсөл боловсруулах ажил эхэлнэ.
- 7.2.5 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийн давхаргыг үнэн зөв, зохих масштабын шаардлага хангасан түвшинд нэгж талбар бүрээр бүрэн зураглаж, давхаргын атрибут өгөгдлийг гүйцэд бөглөнө.
- 7.2.6 Төлөвлөгөөний төслийг боловсруулж дууссаны дараа санал авах төлөвт шилжүүлэх бөгөөд санал авах төлөвт шилжсэнээс хойш 30 хоногийн хугацаатайгаар иргэд олон нийтийн саналыг авч хяналтын төлөвт шилжүүлнэ.
- 7.2.7 Хяналтын төлөвт шилжсэн төлөвлөгөөний төсөлд захиалагч болон агентлагийн газар зохион байгуулалт болон хот байгуулалтын асуудал хариуцсан нэгж 14 хоногийн дотор мэргэжлийн дүгнэлт гарган гүйцэтгэгчид хүргүүлж, системд байршуулна.
- 7.2.8 Гүйцэтгэгч захиалагчийн болон агентлагийн мэргэжлийн дүгнэлтийн дагуу засвар өөрчлөлтийг хийж хянуулсны

дараа, хяналт хийсэн этгээдийн зөвшөөрөлтэйгөөр агентлагийн газар зохион байгуулалтын асуудал хариуцсан нэгж баталгаажуулах төлөвт шилжүүлнэ.

- 7.2.9 Баталгаажуулах төлөвт шилжсэн төслийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж баталсан тогтоолыг хавсаргаснаар төлөвлөгөө батлагдсан төлөвт шилжүүлнэ.
- 7.2.10 Хэрэв ИТХ-аас төлөвлөгөөний төсөлд өөрчлөлт хийх, нэмж тусгах санал гарсан тохиолдолд уг өөрчлөлтийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэмдэглэлийн үндэслэн хийх бөгөөд хурлын тэмдэглэлийн хуулбарыг системд заавал хавсаргана.
- 7.2.11 Захиалагч нь иргэд, олон нийтийн болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гарсан саналыг төлөвлөгөөний төсөлд тусгасан эсэхэд хяналт тавина.
- 7.2.12 Батлагдсан төлөвт шилжсэн төлөвлөгөөнд төлөвлөгөөний хэрэгжилтийн давхарга нэмэх, хэрэгжилтийн тайлан нэмж хавсаргахаас бусад ямар нэгэн өөрчлөлт хийх үйлдлийг хориглох бөгөөд системээс засварлах үйлдлийг автоматаар түгжинэ.
- 7.2.13 Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний төслийн тайланг энэ журмын хавсралт 5-т үзүүлсэн загварын дагуу гаргана.
- 7.2.14 Батлагдсан төлөвт шилжсэн газар зохион байгуулалтын төлөвлөгөө түүний хэрэгжих хугацааны явцад нэмэлт өөрчлөлт, тодотгол хийх тохиолдолд тухайн төлөвлөгөөг хэвээр үлдээж шинээр төлөвлөгөөний төсөл үүсгэнэ.
- 7.2.15 Батлагдсан төлөвт буй төлөвлөгөө нь тухайн төлөвлөгөөг тодотгох, шинэчлэн боловсруулж зохих шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан тохиолдолд системээс идэвхгүй төлөвт шилжүүлнэ.
- 7.3 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, түүнийг тайлагнах
 - 7.3.1 Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах замаар хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтийг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусаж хэрэгжсэн байдлаар дүгнэнэ.

- 7.3.2 Энэ журмын 4.7.1-4.7.3-т заасан ангилалд хамаарах арга хэмжээнүүдийг агуулсан нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний төсөл батлагдсан төлөвт шилжмэгц системээс автоматаар газрын кадастрын мэдээллийн санд ажлын нэгж талбар болгон шилжүүлнэ.
- 7.3.3 Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнөөс газрын кадастрын мэдээллийн санд хөрвөж орж ирсэн ажлын нэгж талбарыг өөрчлөх, засварлах үндэслэл нь тухайн ажлын нэгж талбарын эх үүсвэр болсон нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд орсон тодотгол болон дараа оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө болно.
- 7.3.4 Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнөөс газрын кадастрын мэдээллийн санд хөрвөж орж ирсэн ажлын нэгж талбар нь түүний эх үүсвэр болсон нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хамт зөвхөн тухайн жилдээ хүчинтэй.
- 7.3.5 Холбогдох шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталгаажсан Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газар эзэмших, ашиглах, өмчлөх талаар иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг системийн иргэд, олон нийтэд зориулсан цахим хуудсаар дамжуулан авч газрын кадастрын мэдээллийн санд шилжүүлнэ.
- 7.3.6 Аймаг, нийслэлийн Засаг дарга аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан шууд хэрэгжүүлэх боломжтой нарийвчилсан зураг төсөл бүхий арга хэмжээг Газрын тухайн хуулийн 21.2.3, 21.3.2 дахь хэсэгт заасны дагуу шууд хэрэгжүүлж болно.
- 7.3.7 Энэ журмын 7.3.5-д заасны дагуу иргэдийн саналыг агентлагийн даргын тушаалаар баталсан газар эзэмших, ашиглах, өмчлөхийг хүссэн өргөдлийн загварын агуулгын дагуу авна.
- 7.3.8 Иргэдийн өгсөн саналыг ирүүлсэн огноо, цаг, минутаар нь эрэмбэлэн системд бүртгэнэ.
- 7.3.9 Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан газар эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах арга хэмжээний хэрэгжилтийг газрын кадастрын мэдээллийн сангийн мэдээллийн сантай холбогдож авна.
- 7.3.10 Газрыг нөхөн сэргээх, хамгаалах, газар чөлөөлөх, зураг төсөл боловсруулах гэх мэт газар зохион байгуулалтын арга хэмжээний хэрэгжилтийг тусад нь давхарга үүсгэн зураглаж, тайлагнана.

- 7.3.11 Нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг энэ журмын хавсралт 6-д заасны дагуу удирдлагын веб хуудаснаас гаргана.
- 7.3.12 Улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг энэ журмын хавсралт 7-т үзүүлсэн загварын дагуу удирдлагын веб хуудаснаас гаргана.
- 7.3.13 Монгол улсын иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоосон Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын саналын хэрэгжилтийг энэ журмын хавсралт 8-т үзүүлсэн загварын дагуу удирдлагын веб хуудаснаас гаргана.
- 7.3.14 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний баримт бичгийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй бол уг төлөвлөгөөний биелэлтийг цаасан хэлбэрээр гаргаж баталгаажуулан удирдлагын веб хуудасны төслийн бүртгэл хэсэг тухайн төлөвлөгөөний хавсралтад нэмнэ.
- 7.3.15 Энэ журмын 4.7.1-4.7.3-т хамаарахаас бусад арга хэмжээний биелэлтийг газрын алба, газрын даамал системд зураглаж оруулж болно.
- 7.3.16 Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор баталгаажуулан систем дэх төслийн хавсралт материал хэсэгт хавсарган, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

Найм. Газар зохион байгуулалт, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний мэдээллээр иргэд олон нийтэд үйлчлэх, тэдний саналыг авах

- 8.1 Иргэд, олон нийтэд зориулсан нээлттэй веб хуудсаар дамжуулан газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн мэдээллийн сангийн мэдээллээр иргэд, олон нийтэд үйлчлэх, төлөвлөгөөний төсөлд санал авах үйл ажиллагааг явуулна.
- 8.2 Санал авахад бэлэн болсон бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг иргэд, олон нийтэд зориулсан веб хуудсанд 30-аас доошгүй хоногийн хугацаатайгаар байршуулж санал авна.
- 8.3 Иргэн хуулийн этгээд холбогдох шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталгаажсан Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газар эзэмших, ашиглах, өмчлөх тухай саналаа иргэд, олон нийтэд зориулсан цахим хуудсаар дамжуулан өгнө.

- 8.4 Ашигт малтмал, байгаль орчин, батлан хамгаалах хөдөө аж ахуй зэрэг бусад салбарын төрийн байгууллага өөрийн салбарын орон зайн утга бүхий төсөл, төлөвлөгөөг боловсруулах зорилгоор газар зохион байгуулалтын төлөвлөгөөний мэдээлэл авах хэрэгжүүлэх тохиолдолд энэ журмын 5.2т заасны дагуу системд нэвтрэх эрх авна.

Ес. Хилийн цэсийн мэдээллийн сан бүрдүүлэх

- 9.1 Хилийн цэсийн мэдээллийн сан нь байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн дэд сан байна.
- 9.2 Хилийн цэсийн мэдээллийн сан нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн мэдээлэл бүрдүүлэх, хилийн цэсийн өөрчлөлт, болон хилийн цэсийн маргаан түүний шийдвэрлэлтийн талаарх түүхчилсэн бүртгэлийг хөтлөх, баталгаажсан нарийвчлал бүхий мэдээллээр иргэд олон нийтэд үйлчлэх үйл ажиллагааг явуулна.
- 9.3 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн мэдээллийг холбогдох журам зааврын дагуу бүрдүүлж мэдээллийн санд оруулна.
- 9.4 Хилийн цэсийн мэдээллийн сан нь дараах зүйлүүдээс бүрдэнэ. Үүнд:
- 9.4.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэс, баг, хорооны хилийн заагийг цэг, шугам, талбайгаар илэрхийлсэн давхаргууд;
- 9.4.2 аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг тогтоосон Улсын их хурлын тогтоол;
- 9.4.3 баг, хороодын хилийн заагийг тогтоосон аймаг нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол;
- 9.4.4 хилийн цэсийн маргаан түүний шийдвэрлэлтийн талаарх баримт бичиг.
- 9.5 Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн давхаргыг устгах, өөрчлөх, засварлахыг хориглоно.
- 9.6 Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэс өөрчлөгдсөн тохиолдолд хуучин давхаргад ямар нэгэн өөрчлөлт оруулахгүйгээр хэвээр хадгалж шинээр давхарга үүсгэж зураглана.
- 9.7 Хилийн цэсийн эргэлтийн цэгийн байршлыг нарийвчлан, солбилцолжуулах асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЦАХИМ СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Арав. Агентлагийн чиг үүрэг

- 10.1 Агентлагийн газар зохион байгуулалт болон хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжийн мэдээллийн сангийн асуудал хариуцсан мэргэжилтэн системийн админы эрхтэй байна.
- 10.2 Системийн админы эрхийг Агентлагийн даргын тушаалаар нээж, хүчингүй болгоно.
- 10.3 Системийн админ дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
 - 10.3.1 Удирдлагын тохиргоо буюу системийн болон хэрэглэгчийн бүлгийн тохиргоог эрхлэх;
 - 10.3.2 Системд ажиллах /Хавсралт 9/ нэвтрэх эрх олгох, хаах, өөрчлөх, хугацаа сунгах ажлыг зохион байгуулах;
 - 10.3.3 Хэрэглэгчдийн саналын шийдвэрлэлт, төлөвлөгөөнд тусгасан байдлыг хянах;
 - 10.3.4 Цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээ мэдээллийг шинэчлэх;
 - 10.3.5 Газрын алба, аймаг, нийслэлийн ерөнхий архитектор, газрын даамал, газрын мэргэжлийн байгууллага болон системд нэвтрэх эрх бүхий бусад этгээдийн оруулж буй мэдээ, мэдээлэл болон төсөл үүсгэх явцад хяналт тавих;
 - 10.3.6 Газрын алба, даамлуудыг мэргэжил, арга зүйн өдөр тутмын удирдлагаар хангах;
 - 10.3.7 Системийн үйл ажиллагааны явцад доголдол гарвал системийн админ нь агентлагийн мэдээлэл, технологийн үйл ажиллагаа хариуцсан нэгжид мэдэгдэж, доголдлыг арилгах арга хэмжээг даруй авах;
 - 10.3.8 Мэдээллийн санг 3 сар тутамд архивлаж, холбогдох журмын дагуу байгууллагын архивт хадгалуулах;
- 10.4 Агентлагийн газар зохион байгуулалт болон хот төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжүүд дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд
 - 10.4.1 Системийн хэрэглэгчдийг чадавхжуулах гэрчилгээ бүхий сургалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах;
 - 10.4.2 Системийг олон нийтэд сурталчлан таниулах, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;

- 10.4.3 Системийн хэрэглэгчийн гарын авлага, заавар, аргачлал боловсруулах, хэрэглэгчдийн хүртээл болгох;
- 10.4.4 Системийн нэмэлт хөгжүүлэлт хийх, шинэчлэх ажлыг хариуцан зохион байгуулах.
- 10.5 Агентлагийн мэдээлэл, технологийн үйл ажиллагаа хариуцсан нэгж дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
 - 10.5.1 Системд зориулсан серверийг зохион байгуулах, хадгалалт, хамгаалалтыг хариуцах;
 - 10.5.2 Системийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг байнга ханган ажиллах;
 - 10.5.3 Системд алдаа гарсан тохиолдолд нэн даруй засварлах, мэдэгдэх;
 - 10.5.4 Системийн админы эрх бүхий албан тушаалтанд системд хандах эрх нээх, хүчингүй болгох.

Арван нэг. Системийн хэрэглэгчийн чиг үүрэг

- 11.1 Үндсэн хэрэглэгч нь Газрын тухай хуульд заасан эрх хэмжээ, өөрийн харьяаллын нутаг дэвсгэрийн хүрээнд системд дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
 - 11.1.1 Системийн админаас Газар зохион байгуулалтын цахим систем нэвтрэх эрхийг авах /Системд нэвтрэх эрх, нууц үгийг цахим хаягаар авах бөгөөд нууц үгийг авсан даруйдаа солих, ирсэн цахим мэдээг устгах шаардлагатай/;
 - 11.1.2 Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө төсөлд санал өгөх, дүгнэлт гаргах;
 - 11.1.3 Мэдээллийн санд зам, шугам сүлжээний газрын хамгаалалтын бүс, усны сан бүхий газрын хориглолт, хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ойн сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын мэдээллийг оруулах, шинэчлэх;
 - 11.1.4 Системд нэвтрэх боломжгүй болсон, системд алдаа гарсан даруйд системийн админд мэдэгдэх;
 - 11.1.5 Системийн талаар хэрэглэгчдийг мэдээллээр хангах, сурталчилгаа хийх, заавар зөвлөмжөөр хангах;
- 11.2 Системд нэвтрэх эрх бүхий мэргэжлийн байгууллага нь энэ журмын хавсралт 9-т заасан эрхтэйгээр цахим системд хандана.
- 11.3 Тусгай эрхтэй хэрэглэгч нь энэ журмын хавсралт 9-т заасан эрхтэйгээр системд хандана.

- 11.4 Тусгай эрхтэй хэрэглэгч нь өөрийн салбарын хуулиар тогтоосон эрхлэх асуудлуудын хүрээнд газар ашиглалтын тусгай горим дэглэм бүхий хориглолт, хязгаарлалт, хамгаалалтын бүс, зурвас газрууд болон ашигт малтмал эрэх хайх, олборлох тусгай зөвшөөрөл бүхий газрын георон зайн утга бүхий мэдээллийг мэдээллийн санд оруулах, тогтмол шинэчлэх үйл ажиллагааг эрхэлнэ;
- 11.5 Хэрэглэгч нь системийн админд доголдлын тухай мэдээллийг цахим шуудангаар мэдэгдэнэ.

Арван хоёр. Хориглох зүйл

- 12.1 Мэдээллийн сантай холбоотой төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, файлын бүтэц зохион байгуулалтын талаар аливаа мэдээллийг санаатай болон санамсаргүй тараах, бусдад дамжуулахыг хориглоно.
- 12.2 Мэдээллийн санд нэвтрэх эрхийг бусдад дамжуулахыг хориглоно.
- 12.3 Мэдээллийн санд нэвтрэх эрх бүхий албан тушаалтнаас бусад этгээд хандахыг хориглоно.
- 12.4 Мэдээллийн сангийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр бусдад хувиран тараах, дамжуулахыг хориглоно.
- 12.5 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг тухайн төслийг үүсгэсэн этгээдийн зөвшөөрөлгүйгээр засварлах, өөрчлөх, устгахыг хориглоно.
- 12.6 Батлагдсан төлөвт шилжсэн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл, түүний давхаргыг өөрчлөх, устгахыг хориглоно.
- 12.7 Мэдээллийн сангийн давхарга, түүний үзүүлэлтийн талаарх мэдээллийг эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр засварлах, устгах, шинээр үүсгэхийг хориглоно.
- 12.8 Иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах газрыг нэгж талбар бүрээр хуваарилсан нарийвчилсан хэмжилт, зураглал үйлдэлгүйгээр бөөнөөр нь тоймлон зураглаж төлөвлөхийг хориглоно.
- 12.9 Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тухайн жилд тодотгол, өөрчлөлт орохоос бусад тохиолд нэгэн зэрэг нэгээс илүү төсөл үүсгэхийг хориглоно.
- 12.10 Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнөөс газрын кадастрын мэдээллийн санд хөрвөж орж ирсэн ажлын нэгж талбарыг он дамнуулан ашиглаж газрын эрх олгож, баталгаажуулахыг хориглоно.
- 12.11 Нэгж талбарын талбайн хэмжээ өөрчлөх, хуваах зэргээс бусад тохиолдолд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний мэдээллийн

сангаас газрын кадастрын мэдээллийн санд шилжиж орж ирсэн ажлын нэгж талбарыг өөрчлөх, засварлахыг хориглоно.

Арван гурав. Хяналт, шалгалт болон хэвийн үйл ажиллагаа

- 13.1 Агентлаг нь Улсын хэмжээнд мэдээллийн санд хяналт, шалгалт хийнэ.
- 13.2 Системийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг жилд 2-оос доошгүй удаа хийнэ.
- 13.3 Хэрэв хяналт шалгалтаар зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох хууль, журмын дагуу агентлагийн даргын дэргэдэх хурлаар оруулан танилцуулж, шийдвэр гаргуулан зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг авч ажиллана.
- 13.4 Мэдээллийн санд хийсэн хяналт, шалгалт хийсэн материалыг архивлаж хадгална.
- 13.5 Системийн программ хангамж, сервер, сүлжээний аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаанд, мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж хяналт тавих, аюулгүй байдал болон хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг Улсын хэмжээнд бүрэн хариуцаж ажиллана.

Арван дөрөв. Хүлээлгэх хариуцлага

- 14.1 Энэхүү журмын заалтуудыг зөрчсөн албан тушаалтанд төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл хуулийн байгууллагад шилжүүлнэ.
- 14.2 Иргэд, хуулийн этгээдэд үйлчилсэн мэдээллийн үнэн зөв эсэхийг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын албаны холбогдох мэргэжилтнүүд, сумын газрын даамал хариуцна.
- 14.3 Мэдээллийн үнэн зөв эсэх талаар гомдлыг иргэн, хуулийн этгээд нь дээд шатны байгууллагад гаргах бөгөөд гаргаж болно.
- 14.4 Мэдээллийг зөвшөөрөлгүй хувилсан тараасан, бусдад шилжүүлсэн, мэдээллийн санг хуулах, устгах, өөрчлөлт хийхийг оролдсон буюу ажлын хариуцлага алдсан албан тушаалтанд мэргэжлийн зөрчлийн шинж, учруулсан хохирлыг харгалзан зохих хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авахаас гадна шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 14.5 Системээс бусад програм хангамж ашиглаж зохих журам, зааврын дагуу боловсруулаагүй газар зохион байгуулалтын төлөвлөгөөний баримт бичиг нь газар зохион байгуулалтын мэдээллийн санд хөрвөж, хэрэгжих боломжгүй болсонтой холбогдох хариуцлагыг тухайн төлөвлөгөөний баримт бичгийн захиалагч болон боловсруулсан этгээд бүрэн хариуцна.

- 14.6 Батлагдсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний баримт бичигт тухайн орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэргүйгээр өөрчлөлт хийх, шинээр давхарга нэмэх түүний дагуу газар олгосон нь тогтоогдсон бол тухайн албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл болно.
- 14.7 Зохих шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлаагүйн улмаас хэрэгжих боломжгүй болсон газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлтэй холбогдох асуудалд агентлаг аймаг, нийслэлийн газрын алба, газрын даамал ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.
- 14.8 Системд нэвтрэх эрхийг бусдад дамжуулсан нь тогтоогдвол тухайн этгээдийн системд нэвтрэх эрхийг хааж хариуцлага тооцно.

-----oOo-----

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах
журмын 1 дүгээр хавсралт

Төлөвлөлтийн ерөнхий болон дэд бүсүүдийн атрибут агуулга.

№	Баганы нэр	Баганы тайлал	Баганы төрөл	Тайлбар
	Code	Бүсийн код	long integer	Төлөвлөлтийн бүсийн харгалзах 8 оронтой кодыг тавьж өгнө
	Odoo_tuv	Одоогийн түвшин	text	Төлөвлөлтийн одоогийн түвшний талаарх мэдээллийг оруулна. Жишээ нь: Улирлын бэлчээр гэсэн арга хэмжээ төлөвлөхөд тухайн бэлчээрийн даац, ачаалалтай холбоотой мэдээллийг оруулж өгнө.
	hur_tuv	Хүрэх түвшин	text	Цаашид хүрэх түвшний талаарх мэдээллийг оруулна. Жишээ нь: Улирлын бэлчээр гэсэн арга хэмжээ төлөвлөхөд тухайн бэлчээрийн даац, ачаалал төлөвлөлтийн хугацаанд ямар болсон байх талаарх мэдээллийг оруулж өгнө.
	bus_shaard	Бүсчлэлд тавигдах шаардлага	text	Хориглох эсвэл зөвшөөрөх газар ашиглалтын төрөл гэх мэт мэдээллийг оруулна.
	FAR	Давхар талбайн харьцаа	double	Барилгын давхруудын нийт талбайг талбар газрын талбайн хэмжээтэй харьцуулсан дүнг ойлгоно. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд ашиглана.
	BCR	Барилгын бүрхэцийн харьцаа	long integer	Талбар газрын талбайн нийт хэмжээнээс барилгажуулах газрын хэмжээг хувиар илэрхийлсэн дүнг ойлгоно. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд ашиглана.

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах
журмын 2 дугаар хавсралт

Төлөвлөлтийн арга хэмжээний атрибут агуулга.

№	Баганы нэр	Баганы тайлал	Баганы төрөл	Тайлбар
1	Code	Бүс, арга хэмжээний код	long integer	Төлөвлөлтийн бүс, арга хэмжээний харгалзах 8 оронтой кодыг тавьж өгнө
2	Right_form	Арга хэмжээний төрөл	long integer	Дараах арга хэмжээний төрлийн харгалзах дугаарыг тавьж өгнө. 1. Өргөдлийн дагуу газрын эрх олгох; 2. Дуудлага худалдааны зарчмаар газрын эрх олгох; 3. Төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар газрын эрх олгох; 4. Газрыг нөхөн сэргээх, хамгаалах; 5. Газар чөлөөлөх; 6. Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа. /нарийвчилсан зураг төсөл боловсруулах, дахин төлөвлөлт хийх гэх мэт/

3	Right_type	Эрхийн төрөл	long integer	Дараах эрхийн төрлийн харгалзах дугаарыг тавьж өгнө. 1. Ашиглах 2. Эзэмших 3. Өмчлөх 4. Төрийн өмч
4	Gaz_ner	Хаяг/ газрын нэр	text	Газрын нэр, албан ёсны хаяг байршлыг тавина.
5	Landuse	Зориулалт	long integer	Газрын нэгдмэл сангийн ангиллын газар ашиглалтын, арга хэмжээ, үйл ажиллагааны төрөл, зориулалтыг бичнэ. Жишээ нь: үйлдвэрийн газрын төлөвлөлтийн зориулалт нь Ноос угаах үйлдвэр, хүнсний үйлдвэр гэх мэт
6	hemjee,	Геометр хэмжээс, талбай: га, урт: км, м,	double	Геометр хэмжээсийг тавьж өгнө.
7	Odoo_tuv	Одоогийн түвшин	text	Одоогийн түвшин
8	hur_tuv	Хүрэх түвшин	text	Төлөвлөлтийн хугацаанд хүрэх түвшний талаарх мэдээллийг оруулна.
9	hugatsaa	Хэрэгжүүлэх хугацаа	date	Хэрэгжүүлэх хугацаа
10	hariucah	Хариуцах эзэн.	text	Тухайн арга хэмжээг хариуцаж зохион байгуулах, гүйцэтгэх этгээд
11	guicetgegc	Зургийг гүйцэтгэсэн	text	Гүйцэтгэсэн этгээдийн нэр

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журмын
3 дугаар хавсралт

**Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын
төлөвлөгөөний төслийн тайлангийн загвар**

№	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар /арга хэмжээний давтахгүй дугаар/	Газрын зориулалт /Газрын нэгдмэл сангийн ангиллаар/	Хаяг /Баг, хороо/	Байршил /газрын нэр, гудамж/	Талбайн солбилцол	Төлөвлөсөн талбайн хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, улирлаар	Хариуцах эзэн
0	1	2	3	4	5	6	8	9
1								
2								
3								
4								
5								
6								
7								

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журмын
4 дүгээр хавсралт

**Монгол улсын иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг
тогтоосон Засгийн газрын тогтоол, аймаг, нийслэлийн ИТХ-ын саналын
хэрэгжилтийн тайлангийн загвар**

№	Аймаг, Нийслэл, сум, дүүрэг	3Г-ийн 2017 оны 104 дүгээр тогтоол	Иргэдэд өмчлүүлсэн газрын нийт хэмжээ /га-аар /	өмчлүүлсэн газрын зориулалт /га-аар/								өмчлүүлсэн нийт иргэдийн тоо	өмчлүүлсэн иргэдийн тоо																																																																																																																																																																																			
				Иргэдэд үнэгүй өмчлүүлсэн газрын нийт хэмжээ	Үүнээс			Аж ахуйн зориулалтаар өмчлүүлсэн газрын нийт хэмжээ /га/	Үүнээс				ГБХ үнэгүй өмчлүүлсэн иргэдийн тоо	Үүнээс			Аж ахуйн зориулалтаар өмчлүүлсэн иргэдийн тоо	Үүнээс																																																																																																																																																																														
					Одоо эзэмшиж байгаа газрыг нь өмчлүүлсэн нийт хэмжээ	Шинээр өмчлүүлсэн газрын нийт хэмжээ	Улсын чанартай автозамын дагуу өмчлүүлсэн газрын нийт хэмжээ		үр тарианы	төмс, хүнсний ногооны газар тариалангийнхаас бусад	шинээр газар өмчлүүлсэн			Улсын чанартай авто замын дагуу өмчлүүлсэн	үр тарианы	төмс, хүнсний ногооны газар тариалангийнхаас бусад																																																																																																																																																																																
																		0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	1																						2																						3																						4																						5																						6																							Нийт дүн																				
																		0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	1																						2																						3																						4																						5																						6																							Нийт дүн																				
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20																																																																																																																																																																												
1																																																																																																																																																																																																
2																																																																																																																																																																																																
3																																																																																																																																																																																																
4																																																																																																																																																																																																
5																																																																																																																																																																																																
6																																																																																																																																																																																																
	Нийт дүн																																																																																																																																																																																															

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журмын
5 дугаар хавсралт

**Улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний
төслийн тайлангийн загвар**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хаяг / Сум, дүүрэг, Баг, хороо/	Байршил /газрын нэр, гудамж/	Төлөвлөсөн талбайн хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Суурь үзүүлэлт	Хүрэх түвшин	Шаардагдах төсвийн хэмжээ	Хариуцах эзэн	Тайлбар
0	1	2	3	4	5	6	7	8	9	10
1										
2										
3										
4										
5										
6										
7										

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журмын
6 дугаар хавсралт

**Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын
төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангийн загвар**

№	Хаяг / Сум, дүүрэг, Баг, хороо/	Байршил /газрын нэр, гудамж/	Төлөвлөсөн арга хэмжээ	Төлөвлөсөн талбайн хэмжээ, га	Төлөвлөсөн нэгж талбарын тоо	Хэрэгжсэн талбайн хэмжээ, га	Хэрэгжсэн нэгж талбарын тоо	Хэрэгжүүлсэн захирамжийн дугаар
0	1	2	3	4	5	6	7	8
1								
2								
3								
4								
5								

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журмын
7 дугаар хавсралт

**Улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын
нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангийн загвар**

№	ГНС-ын ангилал	Төлөвлөсөн арга хэмжээ	Хаяг / Сум, дүүрэг, Баг, хороо/	Төлөвлөсөн талбайн хэмжээ, га	Хэрэгжсэн талбайн хэмжээ, га	Төлөвлөсөн хугацаа	Хэрэгжсэн хугацаа / нийслэл, сум, дүүргийн хэдэн оны ГЗБТ-нд тусаж хэрэгжсэн талаар/	Хэрэгжээгүй шалтгаан	Цаашид авах арга хэмжээний санал
0	1	2	3	4	5	6	7	8	9
1									
2									
3									

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журмын
8 дугаар хавсралт

**Монгол улсын иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг
тогтоосон Засгийн газрын тогтоол, аймаг, нийслэлийн ИТХ-ын саналын
хэрэгжилтийн тайлангийн загвар**

№	Аймаг, Нийслэл, сум, дүүрэг	Өмчлүүлэх газрын байршил	Өмчлүүлэх газрын зориулалт / га-аар/									Өмчлүүлэх иргэдийн тоо								
			Иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ /га-аар /	Иргэдэд үнэгүй өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Үүнээс		Аж ахуйн зориулалтаар өмчлөх газрын нийт хэмжээ /га/	үр тарианы	Үүнээс		газар өмчлүүлэх нийт иргэдийн тоо	ГБХ үнэгүй өмчлөх иргэдийн тоо	Үүнээс		Улсын чанартай авто замын дагуу өмчлөх	Аж ахуйн зориулалтаар өмчлөх иргэдийн тоо	үр тарианы	Үүнээс		
					Одоо эзэмшиж байгаа газрыг нь өмчлүүлэх нийт хэмжээ	Шинээр өмчлүүлэх газрын нийт хэмжээ			газар тариалангийнхаас бусад	газар өмчлүүлэх нийт иргэдийн тоо			Одоо эзэмшиж байгаа газраа өмчлүүлэх	шинээр газар өмчлөх				газар тариалангийнхаас бусад		
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20
1																				
2																				
	Нийт дүн																			

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журмын
9 дүгээр хавсралт

**Газар зохион байгуулалтын цахим системийн хэрэглэгчийн бүлгийн эрхийн
жагсаалтын маягт**

№	Хэрэглэгчийн эрх Хэрэглэгчийн бүлэг	ГЗБТ-ний мэдээлэл харах	Төсөл үүсгэх	Төсөл устгах	Төслийн тохиргоо	Давхарга үүсгэх	Давхарга устгах	Давхаргын тохиргоо хийх	Давхаргын атрибутагд тохиргоо хийх	Давхарга хоорондын давхцал шалгах, өгөгдлийн чанарын хяналт хийх	Төлөвийн тохиргоо хийх	Батлагдсан төлөв буцаах	Төлөв шилжүүлэх	Хэрэгжилт баталгаажуулах	Хэрэгжилт биелэлийн Тайлан харах	Тайлангийн тохиргоо	Газар ашиглалтын суурь нөхцлийн мэдээллийг нэмэх, шинэчлэх	Хилийн цэсийн мэдээ харах	Хилийн цэсийн маргаан бүртгэх	Хилийн цэсийн маргаан хаах	Хэрэглэгчийн эрх нээх, хаах	Хэрэглэгч бүртгэх	Хэрэглэгч баталгаажуулах	Хэрэглэгч устгах	Мэдээллийн сан архивлах	
	Системийн админ Газрын албаны дарга				✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓		✓	✓	✓	✓	✓	✓		✓	✓	✓	✓	✓	✓
	Агентлагийн газар зохион байгуулалтын асуудал эрхэлсэн нэгжийн мэргэжилтэн		✓	✓						✓			✓	✓	✓	✓			✓	✓	✓					
	Агентлагийн хот байгуулалтын асуудал эрхэлсэн нэгжийн мэргэжилтэн		✓	✓						✓			✓	✓	✓	✓		✓								
	Агентлагийн кадастрын асуудал эрхэлсэн нэгжийн мэргэжилтэн	✓								✓					✓		✓		✓							
	Аймаг, нийслэлийн газрын албаны хэлтсийн дарга	✓	✓		✓					✓		✓	✓	✓	✓		✓		✓	✓						

№	Хэрэглэгчийн эрх Хэрэглэгчийн бүлэг	ГЗБТ-ний мэдээлэл харах	Төсөл үүсгэх	Төсөл устгах	Төслийн тохиргоо	Давхарга үүсгэх	Давхарга устгах	Давхаргын тохиргоо хийх	Давхаргын атрибутад тохиргоо хийх	Давхарга хоорондын давхцал шалгах, өгөгдлийн чанарын хяналт хийх	Төлөвийн тохиргоо хийх	Батлагдсан төлөв буцаах	Төлөв шилжүүлэх	Хэрэгжилт баталгаажуулах	Хэрэгжилт биелэлийн Тайлан харах	Тайлангийн тохиргоо	Газар ашиглалтын суурь нөхцлийн мэдээллийг нэмэх, шинэчлэх	Хилийн цэсийн мэдээ харах	Хилийн цэсийн маргаан бүртгэх	Хилийн цэсийн маргаан хаах	Хэрэглэгчийн эрх нээх, хаах	Хэрэглэгч бүртгэх	Хэрэглэгч баталгаажуулах	Хэрэглэгч устгах	Мэдээллийн сан архивлах
	Аймаг, нийслэлийн газрын албаны газар зохион байгуулалт, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн	✓	✓	✓	✓					✓		✓	✓	✓	✓		✓	✓							
	Аймаг, нийслэлийн газрын албаны кадастрын мэргэжилтэн	✓								✓					✓		✓	✓							
	Аймаг, нийслэлийн газрын албаны суурь судалгаа, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн	✓								✓				✓				✓							
	Орон нутгийн хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтан, аймаг нийслэлийн ерөнхий архитектор	✓	✓		✓					✓			✓	✓	✓		✓	✓	✓	✓					
	Газрын даамал	✓	✓		✓					✓			✓	✓	✓		✓	✓							
	Тусгай эрхтэй хэрэглэгч	✓	✓		✓					✓							✓								
	Мэргэжлийн байгууллага	✓	✓		✓					✓							✓						✓		

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Зөвлөмж батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын тухай хуулийн 19.1.8-д заасан "аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд дүгнэлт өгөх, хэрэгжилтэд хяналт тавих" бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөмжийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг уг зөвлөмжийн дагуу боловсруулахад хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /Ц.Ганхүү/-т даалгасугай.

3. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулахад энэхүү зөвлөмжийг мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын "Арга зүйн заавар батлах тухай" 2007 оны 156 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


Х.БАДЕЛХАН

151010176

Барилга, хот байгуулалтын сайдын
2020 оны 12 дугаар сарын 12-ны
өдрийн 57 тоот тушаалын хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8-д заасан чиг үүргийн хүрээнд Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэхэд энэхүү зөвлөмжийг ашиглана.

1.2. Энэхүү зөвлөмжийн зорилго нь аймаг, нийслэлээс баримталж буй хэтийн бодлогыг газрын нөөцийн төлөвлөлтөөр дэмжин тогтвортой хөгжүүлэх, газрын нэгдмэл сангийн ангилал бүрд эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, байгаль орчинд ээлтэй цогцолбор арга хэмжээг төлөвлөх, иргэд, олон нийтэд хүртээмжтэй, газар ашиглалтын тэгш эрхээр хангах нөхцөлийг бүрдүүлэх боломжийг тодорхойлсон урт хугацааны хөгжлийн баримт бичиг боловсруулахад оршино.

1.3. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах арга зүй нь газар бүсчлэн хуваарилах бөгөөд төлөвлөгөөнд хамрагдаж буй нутаг дэвсгэрийн газрын менежментийн ерөнхий болон тодорхой чиг үүргийн бодлогын бүсүүдийг зөв ялгаж гаргасан байна.

ХОЁР. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗАРЧИМ, ШААРДЛАГА

2.1. Аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг /цаашид "ерөнхий төлөвлөгөө" гэх/ дараах үндсэн зарчимд тулгуурлан боловсруулна. Үүнд:

2.1.1. Аймаг, нийслэлийн хилийн цэс доторх бүх газар нутгийг өмчлөл, эзэмшил, ашиглалтын байдлаас үл хамааран ерөнхий төлөвлөгөөнд хамруулж, газрын нэгдмэл сангийн ангилал бүрээр төлөвлөгөөг боловсруулах;

2.1.2. Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа "Газрын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэгт заасны дагуу 12-16 жил байх ба төлөвлөлтийг ойрын буюу Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан бодитой, дунд буюу төсөөллийн, ирээдүйн буюу таамаглал гэсэн гурван үе шаттай байна;

2.1.3. Ерөнхий төлөвлөгөөний үр ашгийг үнэлж, тухайн үеийн ханшаар мөнгөн дүнгээр илэрхийлсэн байх;

2.1.4. Улс, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрээнд тухайн аймаг/нийслэлд хэрэгжүүлэх хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргасан байх;

2.1.5. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд хамаарах нийгэм, эдийн засгийн зорилго, зорилт, орон зайн байршлын асуудлыг нийцүүлэн тусгасан байх;

2.1.6. Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ нь сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар

зохион байгуулалтын төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж, хэрэгжүүлэх боломжтойгоор төлөвлөгдсөн байх;

- 2.1.7 Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах;
- 2.1.8 Аймаг, нийслэлийн хөгжлийн чиг хандлага, нийгэм, эдийн засгийн хэрэгцээг үндэслэн газар ашиглалтын хэрэгцээт байдлын үнэлгээг боловсруулж ерөнхий төлөвлөгөөнд тусгах;
- 2.1.9 Бүх төрлийн нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл, аж ахуйн салбаруудыг оновчтой байршуулах, төрөлжүүлэх, тэдгээрийн харилцан хамаарал, улс орны хөгжилд оруулах хувь нэмрийг үндэслэл сайтай тогтоох замаар нутагшил, суурьшлыг оновчтой төлөвлөх үндсийг бүрдүүлсэн байх;
- 2.1.10 Ерөнхий төлөвлөгөө нь тогтвортой хөгжлийн зарчмуудыг баримталсан, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангасан, нийгмийн ач холбогдолтой, эдийн засгийн үр ашигтай байх;
- 2.1.11 Тухайн орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, түүний хөрөнгө оруулалтын цар хүрээг тоймлон тогтоосон байх;
- 2.1.12 Иргэдийн тав тухтай, ажилтай, орлоготой, тогтвор суурьшилтай амьдрах нөхцлийг бүрдүүлсэн байх;
- 2.1.13 Бүс нутгийн ландшафт төлөвлөлт, газар бүсчлэн хуваарилах арга зарчмыг зөв хослуулсан байх;
- 2.1.14 Шинжлэх ухааны дэвшилтэт технологийг ашигласан байх;
- 2.1.15 Байгаль, түүх, соёлын дурсгалт болон үнэ цэнэтэй газар нутгийг хамгаалахад чиглэсэн байх;
- 2.1.16 Монгол орны уламжлалт газар ашиглалтын хэв шинжийг харгалзсан байх;
- 2.1.17 Ерөнхий төлөвлөгөөг хил залгаа орших аймаг, нийслэлийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулсан байх;
- 2.1.18 Холбогдох хууль, тогтоомж болон бусад салбарын бодлого, хөтөлбөр, зорилтуудтай нягт уялдуулсан байх;
- 2.1.19 Иргэд, олон нийтийн оролцоог хангасан, тэдгээрийн эрх ашигт нийцсэн байх;
- 2.1.20 Газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахдаа хувилбартай байх зарчмыг баримтлах ба байж болох хувилбаруудаас илүү оновчтойг сонгох боломжийг орон нутгийн удирдлагуудад олгох;
- 2.1.21 Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах газар зохион байгуулалтын үйл ажиллагаа, түүнийг төсөв зардлыг тооцсон байх;

- 2.1.22 Зохих масштабын байр зүйн зураг болон төлөвлөлтийн зургийг Монгол улсын MNS 6315:2012, MNS 6316:2012, MNS 6317:2012 стандартуудын дагуу газарзүйн мэдээллийн системийн програм хангамж ашиглан гүйцэтгэсэн байна.

ГУРАВ. ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 3.1 Ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын удирдлага, зохион байгуулалтыг дараах байдлаар хийнэ. Үүнд:
- 3.1.1 Аймаг, нийслэлийн газрын алба нь ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын зардлыг Засгийн газрын 2018 оны 320 дугаар тогтоолоор батлагдсан “Газар зохион байгуулалтын ажлын үнэлгээ”-ний дагуу тооцож, орон нутгийн төсөвт тусгуулах арга хэмжээг зохион байгуулна;
 - 3.1.2 Ерөнхий төлөвлөгөө боловсруулах “Ажлын даалгавар”-ыг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу боловсруулж, аймаг, нийслэлийн Засаг дарга, Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нар хамтран батална /Хавсралт 1/;
 - 3.1.3 Ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу сонгон шалгаруулна;
 - 3.1.4 Ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгч нь газар зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах эрхтэй мэргэжлийн байгууллага байна;
 - 3.1.5 Аймаг, нийслэлийн газрын алба нь ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих ба ажил гүйцэтгэгчтэй хээрийн тодруулалт, судалгаа хийх, иргэд, олон нийтийн саналыг авах, төлөвлөгөөний төсөл боловсруулах, батлуулах явцад хамтарч ажиллана;
 - 3.1.6 Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ерөнхий төлөвлөгөөний төсөлд санал, дүгнэлт, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч ажиллана;
 - 3.1.7 Аймаг, нийслэлийн газрын алба болон ажил гүйцэтгэгч нар нь Газрын тухай хуулийн дагуу ерөнхий төлөвлөгөөний төслийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар

- хэлэлцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулна;
- 3.1.8 Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ерөнхий төлөвлөгөөнд өгсөн дүгнэлтийг үндэслэн ерөнхий төлөвлөгөөг батална;
- 3.1.9 Энэхүү батлагдсан төлөвлөгөө нь газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн санд бүртгэгдсэнээр хэрэгжиж эхэлнэ;
- 3.1.10 Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад цаг үеийн болон нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, шаардлагаас хамааран ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж болно. 3.1.10-т зааснаар тодотгол хийхдээ саналаа төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн хамт шийдвэрлүүлнэ;
- 3.1.11 Ерөнхий төлөвлөгөөгөөр тухайн аймаг, нийслэлийн байгаль, цаг уур, нутаг дэвсгэрийн онцлог, газар ашиглалтын төрөл, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний шийдэл зэргийг харгалзан дараах үндсэн асуудлуудыг шийдвэрлэнэ. Үүнд:
- 3.1.12 Тухайн нутаг дэвсгэрт тохиромжтой байдлын үнэлгээ болон газар ашиглалтын хэрэгцээт байдлын үнэлгээ хийсний үндсэн дээр газар ашиглалтын зориулалтын бүс тогтоох;
- 3.1.13 Нийгэм, эдийн засгийн эрэлт хэрэгцээг хангахад газар ашиглалтын зориулалтын бүсэд тавигдах ерөнхий шаардлагыг тодорхойлох;
- 3.1.14 Газрын нэгдмэл сангийн ангилал бүрээр газрыг зөв зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөвлөн хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох;
- 3.1.15 Газрын нөөц, чадавхийг үндэслэн салбаруудын газар ашиглах, хамгаалах хэрэгцээг үндэслэн зохистой хэмжээ, оновчтой бүтцийг нь тогтоож, газрын нэгдмэл сангийн удирдлага, төлөвлөлтийн хэтийн төлөвийг тодорхойлох;
- 3.1.16 Ашиглалтгүй, ашиглалт багатай газар нутгийг илрүүлэх, тохиромжтой байдлын үнэлгээ, газар ашиглалтын хэрэгцээт байдлын үнэлгээнд тулгуурлан газар ашиглалтыг нэмэгдүүлэх /хадлан, тариаланд тохиромжтой газрыг илрүүлэн сонгох, хадлан, бэлчээрийг тордож сайжруулах, доройтсон, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, алслагдсан газар нутаг, бэлчээрт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ авах гэх мэт/ замаар тухайн газрын өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээг төлөвлөх;

- 3.1.17 Ашиглалт ихтэй газар нутгийг илрүүлж, ачааллыг бууруулах төсөл, арга хэмжээг төлөвлөх;
- 3.1.18 Газар хамгаалах, түүнийг элдэв элэгдэл, эвдрэл, бохирдол, доройтол болон элсний нүүлт, цөлжилтөөс хамгаалах, сэргээн сайжруулах, байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалах төсөл, арга хэмжээг боловсруулах;
- 3.1.19 Газар ашиглалт, хамгаалалтыг сайжруулахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөөлөл, түүний эдийн засгийн үр ашгийг тодорхойлох;
- 3.1.20 Дүйцүүлэн хамгаалах газрыг тогтоохдоо нөлөөлөлд өртсөн газартай ойр байх, экологийн хувьд дүйцэхүйц байх, дүйцүүлэн хамгаалах хугацааг нөлөөлөл үргэлжлэх хугацаатай харьцуулж тогтоох, урт хугацааны хамгааллыг хангах;
- 3.1.21 Дээрх нийтлэг асуудлаас гадна тухайн нутаг дэвсгэрийн болон нутгийн иргэдийн онцлогт тохируулан шийдвэрлэвэл зохих бусад асуудлыг тусгаж болно.

ДӨРӨВ. ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ҮЕ ШАТ

- 4.1. Ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил нь дараах үе шаттай байна. Үүнд:
 - 4.1.1 Бэлтгэл ажил;
 - 4.1.2. Хээрийн судалгааны ажил;
 - 4.1.3. Орон нутгийн холбогдох албан тушаалтнууд, иргэд, олон нийтийн саналыг авах;
 - 4.1.4. Материал боловсруулалт, төлөвлөлт, үр дүн;
 - 4.1.5. Ерөнхий төлөвлөгөөг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, батлуулах;
 - 4.1.6. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн санд батлагдсан ерөнхий төлөвлөгөөг бүртгүүлэх;
 - 4.1.7. Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
 - 4.1.8. Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.

ТАВ. БЭЛТГЭЛ ҮЕ АЖИЛ

- 5.1. Бэлтгэл ажлын хүрээнд байгаль-нутаг дэвсгэрийн, нийгэм-эдийн засгийн нөхцөл, нөөцийн судалгааг хүснэгт 1-т заасан дэд бүлгүүдээр хийнэ.

Хүснэгт 1. Бэлтгэл ажлын хүрээнд цуглуулах материалын жагсаалт

№	Мэдээний төрөл	Тайлбар
1. Байгаль-нутаг дэвсгэрийн нөхцөл, нөөцийн судалгаа		
1	Газрын гадарга, байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөл	Тухайн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт хотгор гүдгэрийн ямар хэлбэр, хэв шинж зонхилж байгааг тодорхойлж, өндөржилт, налуужилт, атриажилт зэрэг морфометрийн үзүүлэлтүүдийг тогтоон Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын /хуучин нэрээр/ 2015 оны А/200 тоот тушаалаар батлагдсан “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх арга зүй”-г ашиглан хөдөө аж ахуй ба хот байгуулалтад хир зэрэг тохиромжтойг нь үнэлж, талбайн хэмжээ, нийт нутагт эзлэх хувийг тогтоон тэдгээрээс нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг тодорхойлно. Мөн хотгор гүдгэрийг бүрэлдүүлэгч орчин үеийн үйл явцад /хөрсний гулсалт, ул хөрсний улирлын хөлдөлт, гэсэлт, цөлжилт, тэдгээрийн нөлөөлөл/ зохих үнэлэлт өгнө.
3	Гүний ус / Гидрогеологи/	Газрын доорхи усны горим, давхаргын түвшин, усны химийн найрлага, бүтэц, эрдэсжилт, шилжилт хөдөлгөөн / гидрогеологийн нөхцөлийн судалгаа/-нд дүн шинжилгээ хийнэ. Уст цэг бүхий инженерийн барилга, байгууламж бүхий газруудын ерөнхий зураглалыг харуулна.
4	Уур амьсгал	Уур амьсгал, цаг ууртай холбоотой мэдээ, мэдээллийг хур тунадас, агаарын ба хөрсний температур, цочир хүйтрэл ба хүйтрэлгүй үе, агаарын даралт, дулаан, чийг, салхины горим, нарны гийгүүлэлт, байгалийн гамшгийн тохиолдлууд, цасан бүрхүүл гэх мэт үзүүлэлтээр сүүлийн 3-5 жилээр тодорхойлж, тэдгээрийн нийгэм-эдийн засгийн хөгжилд нөлөөлөх эерэг ба сөрөг талуудыг тодорхойлно.
5	Гадаргын ус	Гадаргын болон гүний усны нөөц, байршил, шинж чанар, ашиглалт, хотын ба аж ахуйн газрын усан хангамж, түүнийг нэмэгдүүлэх, усны бохирдол ба бохирдуулагч эх үүсвэр, хамгаалах арга хэмжээ зэргийн судалгааг явуулна. Тайланд бичмэл хэсгээс гадна гол, горхи, нуур, худгуудын байршлын зураг, схем, нөөц болон ашиглалтын диаграмм, усны шинж чанарыг харуулсан хүснэгт оруулсан байна.

6	Хөрс, бүрхэвч	хөрсөн	Хөрсөн бүрхэвчийн судалгаагаар хөрсний ялгарлын хил хязгаар, тархацын хэмжээг хөрс судалгааны дунд ба бага масштабын зураглалын арга зүйн дагуу тодорхойлно. Хөрсний физик, хими, морфологийн болон агроүйлдвэрлэлийн шинж чанарыг хөрсний ялгарал бүрээр ангилан харуулна. Хөрсний ангилгаанд газар зохион байгуулалтын судалгаанд хэрэглэж ирсэн нэршлийн ангилгааг баримтлана. Хөрсний төлөв байдал, чанар өөрчлөлт, элэгдэл эвдрэлд орсон болон орж болзошгүй байдал, хөрсний нийгмийн ачаалал даах болон нөхөн сэргэх, цэвэрших чадвар, экологийн хязгаарлалт шаардлагатай хөрсний тархалтыг харуулна. Тариалангийн зориулалтаар ашиглаж болох үржил шимт хөрсний тархац, хэмжээг зурагт харуулж, агрохимийн болон агроүйлдвэрлэлийн шинж чанарыг тодорхойлохоос гадна хөрс ашигласнаар байгаль орчинд гарч болох сөрөг үзэгдэл, түүнийг бууруулах арга хэмжээг заана. Мөн хөрсний тархалт, агроүйлдвэрлэл, элэгдэл эвдрэл болон экологийн хязгаарлалттай ашиглах хөрсний тархалтын зураг, хүснэгтийн хамт оруулах ба одоогоор газар тариаланд ашиглаж буй хөрсний шинж чанар, элэгдэл эвдрэлийн байдал, мелорацийн арга хэмжээний талаар авах арга хэмжээг зөвлөнө.
7	Ургамлын аймаг, ургамалжилт		Ургамалжилтын хувьд ботаник-газарзүйн мужлалаар тухайн аймаг ямар муж, тойргуудад хуваагдах, тэр нь ямар онцлогтой болох, ямар хэв шинж, бүлгэмдлийн ургамал тархсан болохыг гаргах, түүнээс ямар хэв шинж нь давамгайлах зэргийг тодорхойлон бичнэ. Тухайн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт хэдэн зүйл дээд, доод ургамал тархсан, үүнээс хэдэн зүйл нь монголын улаан номонд орсон хийгээд ховор ба нэн ховор, эндемик, ашигт ургамал болохыг жагсаалтаар гаргах, мөн бусад нутагт элбэг тархалттай боловч тухайн аймаг орон нутагт ховор, нэн ховорт орох ямар ургамал байгааг тодорхойлно. Тайланд бичмэл хэсгээс гадна ботаник-газарзүйн болон ургамалжилтын зургийг хүснэгтэн мэдээллийн хамт оруулсан байна.

8	Ан амьтан	Тухайн аймаг, нийслэлийн байгалийн төлөв байдлыг тодорхойлоход чухал ач холбогдолтой сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн, зонхилох овгууд, нэн ховор, ховор ан амьтдын тархалт, тоо толгойн асуудлыг өмнөх үеийн судалгааны мэдээ, баримтад түшиглэн авч үзнэ. Мөн амьтдын зүйлийн бүрдлийг гаргахаас гадна ан амьтдыг эрх зүйн хамгаалалтад авсан байдал болон тухайн аймагт өргөн тархсан, элбэг зүйл, хязгаарлагдмал тархалттай, цөөн тоогоор тохиолдох, ховор зүйл, тоо толгой нь нэн цөөн, устан сөнөж болзошгүй байгаа ан амьтны зүйлийг нэмэлт хүснэгтээр харуулна. Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байнга болон нүүдэллэн ирж амьдардаг ан амьтад, тэдгээрийн байршил, тоо толгой, өсөлт, бууралтын сүүлийн үеийн чиг хандлагыг судалгаанд хамруулсан байна. Мөн түүнчлэн ховордсон ургамал, амьтны аймаг, зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх боломжийг газрын бүсчлэлийн бодлогод тусгах зорилгоор газар бүсчлэлийн судалгааны нутаг дахь ховордсон буюу устгах аюул нүүрлэсэн амьтны аймаг, тэдгээрийн төрөл, зүйлийн нэр төрөл, тоо хэмжээ, байршил, тэдгээрийн оршин байгаа болон ховордох устгах болсон нөхцөл шалтгаан нь газар ашиглалттай холбоотой эсэх, газар ашиглалтыг өөрчилснөөр тэдэнд ямар нөлөөлөл учирч болохыг сайтар судалж, хангалттай мэдээ, мэдээлэлтэй болох ёстой. Мөн нүүдлийн болон зэрлэг ан амьтдын тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах боломжийг бүрдүүлнэ. Судалгааны явцад ховор ховордсон ургамал, амьтны аймаг, төрөл зүйлийг хадгалах, нөөцийг нөхөн сэргээх шаардлагын үүднээс хамгаалалттай газар, бүс болгон авах, газар ашиглалтыг зогсоох, ашиглалтын төрөл хэлбэрийг өөрчлөх, тодорхой үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох, газар зүйн таатай орчин буй болгох, газрын хувьсал өөрчлөлтийг хянах, тухайн хэв шинжийн нутаг усыг төлөөлүүлэн аж ахуйн эргэлтээс гаргаж чөлөөлөх замаар уугуул байдлаар нь үлдээх шаардлагатай газар нутаг байгаа эсэх, ийм бололцоо байгаа эсэхийг биологийн хүчин зүйлийн судалгаатай хамт гүйцэтгэнэ. Тайланд бичмэл хэсгээс гадна ан амьтны төрөл, нутагшлыг харуулсан схем болон хүснэгт оруулсан байна.
9	Ашигт малтмал	Эрдэс баялаг, уулын чулуулаг, нөөц нь тогтоогдсон ашигт малтмалын орд, түүний нөөц, байршилд дүн шинжилгээ хийх, хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдсон ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын орд, байршлын зураглал үйлдэх, газар ашиглалтын бусад ангилал, зориулалттай давхцуулан дүн шинжилгээ өгөх ажил хийгдэнэ.

10	Түүх, археологи, өв соёл	Тухайн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгаль дээр ил задгай орших хүний гараар бүтээгдэн бий болсон эртний булш, бунхан, хиргисүүр, хөшөө чулуу, хадны сүг зураг, сүм хийдийн туурь гэх мэт дурсгалт газрыг дараах байдлаар ангилж бүртгэн, холбогдох мэдээллийг цуглуулан, байршлыг зурагт оруулах ажил хийгдэнэ. Үүнд: Хөшөө дурсгал: түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд нэрд гарсан, бүх талын үнэт ач холбогдол бүхий уран барилга, сүрлэг чимэглэлийн уран баримал, уран зургийн бүтээл, археологийн олдвор, бичээс, агуй болон цогцолбор дурсгал Архитектурын чуулга: түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд нэрд гарсан бүх талын үнэт ач холбогдол бүхий салангид буюу нэгдмэл барилга байгууламж, уран барилгын цогцолбор Дурсгалт газар: хүний болон хүн, байгалийн хамтарсан бүтээлүүд, мөн түүх, гоо зүй, угсаатны судлалын хувьд нэрд гарсан бүх талын үнэт ач холбогдол бүхий археологи, түүхийн дурсгалт газар.
11	Орчны бохирдол	Агаар, хөрс, усны бохирдлын өнөөгийн байдал, бохирдуулагч эх үүсвэр, тэдгээрийн байршил, бохирдлын төрөл, хэмжээ, сөрөг нөлөөлөл бүхий нутаг дэвсгэрийг бүсчлэн тогтооно.
12	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэс	Тухайн аймаг, нийслэлийн хилийн цэсийн мэдээллийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас албан ёсоор авч үйл ажиллагаандаа ашиглах бөгөөд тухайн орон нутагт хилийн цэсийн маргаан байгаа эсэх судалгааг сум, дүүрэг, хороо, баг тус бүрээр гаргаж, зурагт тэмдэглэнэ.
2. Нийгэм-эдийн засгийн суурь нөхцөлийн судалгаа / Сүүлийн 5 жилийн статистик тоо баримтад тулгуурлан хөгжлийн хэтийн төлөвийг төлөвлөлтийн үе шат бүрээр нь тодорхойлно./		
13	Хүн ам зүй	Тухайн орон нутгийн хүн амын тоо, өсөлт, нас, хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, гэрлэлт, цуцлалт, үрчлэлт гэх мэт хүн амын ердийн хөдөлгөөний статистикийн үзүүлэлтийг судалж, цуглуулна. Ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаа аймаг, нийслэлийн нийт хүн амыг хүйсээр, насны бүлгээр, хот, хөдөөгийн хүн ам гэсэн ангиллаар хэтийн өсөлтийг нь төлөвлөлтийн хугацаагаар тооцоолж гаргаж ирнэ.
14	Хөдөлмөр, эрхлэлт	Хөдөлмөрийн насны хүн ам, ажиллах хүч, ажиллагчид, ажилгүй иргэдийн талаарх мэдээллийг тусгана. Эдгээр үзүүлэлтийг судлахдаа Үндэсний статистикийн хорооноос жил, улирал тутам гаргадаг "Ажиллах хүчний судалгаа", "Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын цалингийн мэдээ", "Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний талаарх статистикийн тойм" зэрэг хөдөлмөрийн статистикийн холбогдолтой түүвэр судалгаа, мэдээ тайлангийн үр дүнг ашиглана. Хүн амын насны бүлгийн өсөлтөд үндэслэн төлөвлөлтийн хугацаанд хөдөлмөрийн насны хичнээн хүн ам бий болох тооцоог тусгаж өгнө.

15	Мал аж ахуй	Хөдөө аж ахуйн нийт үйлдвэрлэлийн хэмжээг жилийн туршид мал, амьтдыг өсгөн үржүүлсний болон ургамал, тариа, хүнсний ногоо тарьж ургуулсны үр дүнд бий болсон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн нийлбэр дүнгээр тодорхойлдог. Мал аж ахуй, малын тооллого, малын зүй бус хорогдол, нутгийн эрлийз, цэвэр үүлдрийн малын тоо, мөн хашаа хороо, худгийн тооллого, судалгаа, малчин өрх, малчдын тоог сүүлийн 5 жилээр цуглуулж одоогийн байдлыг тодорхойлно. Үүний дараа мал болон тэжээвэр амьтдын хэтийн өсөлтийг төлөвлөлтийн хугацаагаар тооцоолж гаргаж ирнэ.
16	Аж үйлдвэр	Аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагааг аж ахуйн нэгж, байгууллагын ажилчид, зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ (биет болон үнийн дүнгээр), борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдээр илэрхийлж, аж ахуйн нэгжийн сар, жилийн тайлан, тооллого, судалгааны үр дүнгийн тоон мэдээллийг ашиглан тэдгээрийг нэгтгэн гаргана.
17	Боловсрол	Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын тоо, суралцагчид, төгсөгчид, элсэгчид, багш нарын тоо, боловсролын түвшинг аймаг, сумаар гаргана. Ерөнхий боловсролын сургуульд хамрагдалтын сургалтын хувь, сурагч-багшийн харьцаа, сургууль завсардалтын хувь, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн анхан, дунд шатны сургуульд суралцагчид, төгсөгчдийн тоог боловсролын олон улсын стандарт ангиллын дагуу гаргана.
18	Эрүүл мэнд	Эрүүл мэндийн байгууллагын тоо, эмнэлгийн орны тоо, эрүүл мэндийн байгууллагад ажиллагчдын тоо, их эмчийн тоо, эмнэлгийн дунд мэргэжилтний тоо мэргэжлийн төрлөөр, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөл, нас барсан хүний тоо, өвчний ангиллаар нэгтгэгдэнэ.
19	Дэд бүтэц, нийгэм хангамж	Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал: Цахилгаан, дулаан хангамжийн салбарын сүүлийн 5 жилийн төлөв байдал, тулгамдаж байгаа асуудал, хүндрэл, бэрхшээлийг болон эрчим хүчний эх үүсвэр, сэргээгдэх эрчим хүч /нар, салхи, ус, хөрсний дулаан/ дамжуулах сүлжээ /хүчин чадал/, үнэ тариф түүний нөлөөллийн талаар мэдээлэл, нотолгоонд суурилан судалж тодорхойлно. Зам тээврийн салбарын өнөөгийн байдал: Тухайн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт авто болон төмөр зам, агаар, усан замын аль төрлийн тээврийн салбарууд үйл ажиллагаа явуулж байгааг судлах бөгөөд авто тээврийн статистикийн мэдээллийг зорчигчийн тоо, зорчигч, ачаа эргэлт, тээврийн төрөл, тухайн орон нутагт байх авто машины тоо, төрлийг судална. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын өнөөгийн байдал: Тухайн аймаг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй мэдээлэл, харилцаа, холбооны байгууллага, аж ахуйн нэгжийн бүртгэл судалгаа, тэдгээрийн хэрэглэгчдийн тоо, салбарын нийт орлого, хөрөнгө оруулалт зэргийг сүүлийн 5 жилээр судалж, нэгтгэх ажил хийгдэнэ.

20	Газар тариалангийн үйлдвэрлэл	Тухайн орон нутагт тариалан эрхлэлт байдаг бол тариалалт хийсэн талбайн хэмжээ, 1 га-ын ургацын хэмжээг таримлын төрлөөр судалж, тогтооно. Мөн таримлын төрлөөр ургац хүраалтын нийт болон 1 га талбайн хэмжээг сүүлийн 5 жилээр харуулна. Түүнчлэн хүн амын гурил, гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээний хичнээн хувийг хангаж байгааг судлан хүснэгтээр оруулна. Газар тариалан эрхэлдэггүй бол хүн амын хүнсний хэрэгцээгээ хаанаас авч хангаж байгаа талаарх судалгааг гаргана. Дээрх мэдээллүүдийг орон нутгийн статистикийн байгууллага болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл эрхэлсэн байгууллагаас авч нэгтгэн судална.
----	-------------------------------	---

5.2. Мөн бэлтгэл үе шатанд дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- 5.2.1 Тухайн аймаг, нийслэлийн өмнө батлагдсан ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг судална;
- 5.2.2 Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний материалууд, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны материалуудыг цуглуулж, уялдуулна;
- 5.2.3 Улс, бүс, аймаг, орон нутгаас баталсан хөгжлийн бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн судалгааны тайланг судалж, уялдуулна;
- 5.2.4 Бусад салбарын үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн баримт бичиг, тайлан, өгөгдөл, суурь зураг зэрэг хоёрдогч мэдээллийг албан ёсны эх сурвалжаас хамгийн сүүлийн үеийн байдлаар авч ашиглана.
- 5.2.5 Байгалийн нөхцөл, нөөцийн судалгааны мэдээллийг цуглуулж боловсруулалт хийнэ. Үүнд:
 - 5.2.5.1 Улс, аймаг/нийслэлийн нутаг дэвсгэр дээр хийгдэж байсан бүх төрлийн байгалийн нөхцөл, нөөцийн судалгааг судалж, нэгтгэн газарзүйн мэдээллийн системийг ашиглаж, тоон хэлбэрт оруулж, сэдэвчилсэн зургийн эхний хувилбарыг бэлтгэнэ.
 - 5.2.5.2 Уур амьсгалын үзүүлэлтэд олон жилийн дундаж хур тунадас /мм/, агаарын болон хөрсний температур, агаарын чийгшил, агаарын даралт, шороон болон цасан шуургатай өдрийн тоо, ерөнхий салхины чиглэл, жилийн дундаж хурд, цасан бүрхүүлтэй өдрийн тоо, нартай өдрийн тоо багтана. Олон жилийн дундажийг 10-аас дээш жилийн дунджаар, жилийн үзүүлэлтийг сүүлийн 5 жилээр тооцож зураглана.
 - 5.2.5.3 Газрын гадаргын төрх байдлын үзүүлэлтэд өндөржилт, налуужилт, байршлын зүг чигийг үзүүлэх бөгөөд 30 метр

- болон түүнээс өндөр нарийвчлалтай тоон өндрийн загвар / DEM/-ыг ашиглаж өндөржилт, зүг зовхисыг тус тус зураглана.
- 5.2.5.4 Усан хангамжийн үзүүлэлтэд гадаргын болон гүний усны мэдээлэл, усны ай сав, хагалбар, гол мөрний урсацын эх бүрэлдэх газар зэрэг усан сан бүхий газрын мэдээллийг байр зүйн зураг, агаар, сансрын зураг болон холбогдох судалгаа шинжилгээний материалаас авч зураглана. Түүнчлэн газрын доорх усны горим, давхаргын түвшин, усны химийн найрлага, бүтэц, эрдэсжилтийн мэдээллийг цуглуулна. Мөн уст цэг бүхий инженерийн барилга байгууламж бүхий газруудыг ерөнхий зураглаж, бэлчээр, газар тариалан, олборлох үйлдвэр, хүн амын усан хангамжийн нөхцөлийг тодорхойлно.
- 5.2.5.5 Зэрлэг амьтны төрөл, зүйл, ерөнхий тархац, байршлын үзүүлэлтээр зураглана.
- 5.2.5.6 Малын бэлчээр, ан амьтдын идээшлэх, шилжилт хөдөлгөөн, өсч үржих газар нутаг, бэлчээрийн төрөл, ургамлын экологийн үндсэн хэв шинж, чадавхийн хил заагийг зураглана.
- 5.2.5.7 Хөрсний үзүүлэлтэд хөрсний хэв шинж, механик бүрэлдэхүүн зэргийг зураглана.
- 5.2.5.8 Аймаг, нийслэлийн хэмжээнд бэлчээрийн экологийн чадавхийг “Монгол орны бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварууд” болон “Бэлчээрийн экологийн чадавхийг зураглах заавар”-ын дагуу зураглана.
- 5.2.5.9 Газар хөдлөлт, байгалийн гамшиг, аюултай үзэгдлийн давтамжийг зураглана. Үүнд гамшигт үзэгдэл болж байсан байршлууд, үер, ган, зуд, газар хөдлөлт гэх мэт зүйлсийг хамруулна.
- 5.2.6 Газар ашиглалт, хамгаалалт, түүний үр ашгийн мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийнэ. Үүнд:
- 5.2.6.1 Газрын нэгдмэл сангийн тооллогын мэдээнд өнөөгийн газар ашиглалтын судалгаа, агаар сансрын зураг болон хээрийн судалгаа тодруулалтын аргаар тодотгол, сайжруулалт хийж, хамгийн сүүлийн үеийн байдлаар нэгдмэл сангийн ангиллын тооллого судалгааг боловсруулж, шаардлага хангах нарийвчлалтайгаар зураглана.
- 5.2.6.2 Газрын эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбарууд, түүний үнэлгээ, төлбөр, газрын зах зээлийн үнийн мэдээг цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.
- 5.2.6.3 Ногоон байгууламж болон бусад нийтийн эзэмшлийн

- газрын ашиглалт, хамгаалалтын мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.
- 5.2.6.4 Хөдөө аж ахуйн газрын (хадлан, тариалан, бэлчээр, атаршсан газар, жимс, жимсгэнэ гэх мэт) ашиглалт, хамгаалалтын мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.
- 5.2.6.5 Хөдөө аж ахуйн газрын доройтол /хөрс, усны элэгдэл, ялзмаг болон шим тэжээлийн хомсдол/, бэлчээрийн даац хэтрэлт, уул уурхайн сөрөг нөлөөллийн тооцоо судалгааг хийж зураглана.
- 5.2.6.6 Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.
- 5.2.6.7 Дэд бүтцийн газрын (олон улс, улс, тусгай зориулалтын, орон нутгийн чанартай зам, шугам сүлжээний газрын байршил, эрчим хүч, холбоо мэдээллийн шугам сүлжээний газрын ашиглалт, хамгаалалт, байршил, үр ашиг гэх мэт) ашиглалт, хамгаалалтын мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.
- 5.2.6.8 Тусгай хамгаалалттай газар нутгийн байршил, хэмжээ, аялал жуулчлал, амралт сувиллын газрын судалгаа, байршлын мэдээлэл, плантеологи, археологийн олдвор, үл хөдлөх эд өлгийн зүйлс, түүх, соёлын дурсгалт газрын байршил, талбайн хэмжээний мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.
- 5.2.6.9 Хот, тосгон, бусад суурин газрын экологийн судалгаа, зураг /агаар хөрс, усны бохирдол, тоосжилтын мэдээлэл/-д анализ хийж, үзүүлж буй сөрөг нөлөөллийг зураглана.
- 5.2.6.10 Зам шугам сүлжээний газрын зэрлэг амьтны байршил, шилжилт хөдөлгөөнд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, малчдын нүүдэлд учруулж буй бэрхшээлийн судалгааг хийж, зураглана.
- 5.2.6.11 Ойн ашиглалтаас байгаль орчны тэнцвэрт байдалд үзүүлж буй сөрөг нөлөөллийн судалгааг хийж, зураглана.
- 5.2.6.12 Газар ашиглалтаас усны нөөцийн хомсдол, бохирдолд үзүүлж буй сөрөг нөлөөллийн судалгааг хийж, зураглана.
- 5.2.7 Нийгэм, эдийн засгийн хэрэгцээт байдлын үнэлгээ хийнэ. Үүнд:
- 5.2.7.1 Нийгэм, эдийн засгийн судалгаанд ашиглагдах мэдээг байрлалд суурилсан "Нийгэм, эдийн засгийн мэдээллийн сан"-гаас болон холбогдох байгууллагуудаас авч, цуглуулна.
- 5.2.7.2 Нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэл, түүнд хийсэн дүн шинжилгээг эдийн засаг, үйлдвэрлэлийн салбар бүрээр болон иргэдийн эрэлт хэрэгцээний чиг хандлагыг тогтоох SWOT болон бусад шинжилгээг хийнэ.

- 5.2.7.3 Нийгэм, эдийн засгийн хэрэгцээг дараах чиглэлүүдээр тодорхойлно. Үүнд:
- 5.2.7.4 Нийгмийн дэд бүтцийн газрын хэрэгцээ /сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёл, урлаг гэх мэт төрийн байгууллага, ногоон байгууламж, эмийн сан, банк, халуун ус, сүм хийд гэх мэт/
- 5.2.7.5 Инженерийн дэд бүтцийн газрын хэрэгцээ /цахилгаан дамжуулах шугам, зам, халуун, хүйтэн усны шугам гэх мэт/
- 5.2.7.6 Амины болон нийтийн орон сууцны газрын хэрэгцээ
- 5.2.7.7 Ажлын байрны хэрэгцээ шаардлага /салбар бүрээр/
- 5.2.7.8 Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ
- 5.2.7.9 Хадлан, малын тэжээлийн ургамлын хэрэгцээ
- 5.2.7.10 Худаг, усан сангийн хэрэгцээ гэх мэт.
- 5.2.8. Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг холбогдох заавар, аргачлалын дагуу газар ашиглалтын дараах төрлүүдээр хийнэ. Үүнд:
 - 5.2.8.1 Хөдөө аж ахуйн газрын тохиромжтой байдлын үнэлгээ
 - 5.2.8.2 Хот, сумын төв, тосгон, бусад суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ
 - 5.2.8.3 Ой тарьж ургуулахад тохиромжтой газрын үнэлгээ
 - 5.2.8.4 Хөв цөөрөм байгуулахад тохиромжтой газрын үнэлгээ
 - 5.2.8.5 Тусгай хамгаалалтад авахад тохиромжтой газрын үнэлгээ
- 5.2.9 Иргэд, олон нийтийн оролцоог хангах асуулга, санал авах хуудас, сэдэвчилсэн суурь зураг, бичгийн хэрэгсэл, хээрийн судалгаанд ашиглах тоног төхөөрөмж (зөөврийн компьютер, проектор, зургийн аппарат, гар GPS гэх мэт), газар зүйн мэдээллийн системийн болон бусад программ хангамжийг бэлтгэнэ.

ЗУРГАА. ХЭЭРИЙН СУДАЛГАА

- 6.1 Газар дээр нь очиж ажиллах, хэмжилт, зураглал, тодруулалт хийх баг бүрэлдэхүүн нь ажил гүйцэтгэгч болон аймаг/нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүдээс бүрдэнэ.
- 6.2 Ажлын хэсэгт аймаг/нийслэлийн харьяа агентлагуудын холбогдох дарга, мэргэжилтнүүд, тариалан эрхлэгчид, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид, малчид, нутагтаа олон жил амьдарсан нутгийн иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамруулсан байвал зохино.
- 6.3 Хээрийн хэмжилт, тодруулалтын ажилд аймаг/нийслэл, сум/дүүргийн

удирдлага, газрын албаны мэргэжилтэн нарыг оролцуулах ба шаардлагатай бусад мэргэжилтнүүдийг тохиролцсоны үндсэн дээр оролцуулж, газрын нэгдмэл сангийн ангиллын дагуу байршил, хил заагийг зураглана.

- 6.4 Газар дээр нь хэмжилт, зураглал, тодруулалт хийхдээ байршил тогтоох /GPS/ багаж, агаар, сансрын зураг зэргийг ашиглана.
- 6.5 Хиймэл дагуулын зураг 15 метр болон түүнээс өндөр нарийвчлалын, 6 сар болон түүнээс богино хугацаанд авсан мэдээг ашиглана.
- 6.6 Газар ашиглалт, байгалийн нөхцөл, нөөцийн байршил, заагийг бэлтгэл үе шатанд бэлтгэсэн суурь зураг, сэдэвчилсэн зураг дээр тодруулан гараар болон компьютерээр нэмж зураглана.
- 6.7 Газар ашиглалтын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээний зургийн таарцыг газар дээр нь шалгахад шаардлагатай хэмжилтийг хийнэ.
- 6.8 Хөдөө аж ахуйн газрын бүтэц, ашиглалт, хамгаалалт: Бэлчээр, хадлан, тариалангийн болон бусад зориулалтын газруудын байршил, хуваарилагдсан байдлыг хамруулна.
 - 6.8.1 Тариалангийн газар, түүний ашиглалт, хамгаалалт: Тариалангийн газар ашиглалтын өнөөгийн байдлыг тодорхойлох, зураглах, түүнчлэн тариаланд тохиромжтой газрын хайгуул судалгаа хийх газрын хил заагийг тогтооно.
 - 6.8.2 Тариалангийн эргэлтэд ашиглаж байгаа болон бүртгэлтэй боловч атаршсан талбайн эргэлтийн цэг, хил заагийг нягтлах, талбайн төрх байдал болон төлөв байдлын дэлгэрэнгүй судалгааг газар дээр нь нарийвчлан гүйцэтгэж, тэмдэглэл хөтөлж бүртгэлжүүлнэ.
 - 6.8.3 Тариаланд одоо ашиглаж байгаа газрын төлөв байдал, чанар, ашиглалт, өмчлөлийн хэлбэр, таримлын бүтэц, сэлгээ, аж ахуйн үйл ажиллагааны чиглэл, үр ашгийг тооцоолон, зураглана.
 - 6.8.4 Тариалангийн талбайн хэрэгцээт байдлыг тодорхойлохдоо “Тариалангийн газрын хэрэгцээт байдлын үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу тооцох бөгөөд тариалах талбайгаас гадна сэлгээ, уриншийн талбайн хэмжээг нэмж тооцож гаргана.

Хүснэгт 2. Тариалангийн газрын агро үйлдвэрлэлийн шинж чанар, чадавхи*

№	Сумын нэр	Нэгж талбарын /талбайн/ дугаар, нэгж талбар/	Хэмжээ, га-аар	Тохиромжтой байдлын зэрэглэл	Хөрсний нөхцөл	Мелорацийн нөхцөл	Гадаргын нөхцөл	Тарьсан талбай, га-аар	Тайлбар

Тайлбар: Үзүүлэлт бүрийг дэлгэрүүлэн мэдээлэлд боловсруулалт хийх замаар тухайн газрын чадавхийг тодорхойлох

Хүснэгт 3. Тариалангийн талбайн ашиглалтын өнөөгийн байдал

№	Сумын нэр	Нэгж талбарын дугаар	Хэмжээ, га-аар	Ургамлын аж ахуйн төрөл	Тарьсан хэмжээ, га-аар	Жилийн дундаж ургац, цн/га-аар
				Төмс, хүнсний ногооны аж ахуй		
				Үр тарианы аж ахуй		
				Жимс жимсгэний аж ахуй		
				Техникийн ургамал		
				Тэжээлийн аж ахуй		
				гэх мэт...		

Хүснэгт 4. Нөхөн сэргээлт, сайжруулалт хийсэн болон хийхээр төлөвлөж буй тариалангийн газрын судалгаа

№	Арга хэмжээ	Сумын нэр	Газрын байршил	Талбайн хэмжээ, га-аар	Зарцуулсан ба зарцуулах хөрөнгө	Хөрөнгийн эх үүсвэр
1	Ойн зурвас байгуулах					
2	Хөрсний ялзмаг, үржил шимийг дээшлүүлэх					
3	Агротехнологийн сайжруулалт					
4	Услалтын системийг сэргээн засварлах					
5	гэх мэт...					
	Бүгд					

Хүснэгт 5. Тариалангийн газрын өмчийн болон бусад эрхийн хуваарилалтын байдал

№	Газрын харилцааны хэлбэрүүд	Сумын нэр	Тоо хэмжээ					
			Иргэн		ААНБ		Гадаадын байгууллага	
			Тоо	га	Тоо	га	Тоо	га
1	Монгол улсын иргэний өмчийн газар							
2	Төрийн өмчийн газрыг гэрээгээр эзэмшиж буй тариалангийн газар							
3	Төрийн өмчийн газрыг гэрээгээр ашиглаж буй тариалангийн газар							
	Бүгд							

Хүснэгт 6. Жимс, жимсгэний газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал

№	Сумын нэр	Талбарын дугаар	Хэмжээ, га-аар	Таримал жимсний модны төрлүүд	Ургац, цн/га-р	Шимт чанар	Ашиглалтын өнөөгийн байдал
1							
2							
		Бүгд					

- 6.8.5 Усалгаатай газар тариалангийн байршил, заагийг зураглах: Усалгаатай газар тариалангийн талбайн солбицол, хил заагийг газар дээр нь тулгахаас гадна усалгааны ямар арга хэлбэр ашиглаж байгаа талаар судална. Хуучин ашиглагдаж байсан услалтын системийн барилга байгууламж, түүний бүрэн бүтэн байдал, хүчин чадал, хариуцах эзэн зэрэг мэдээллийг бүрдүүлнэ.
- 6.8.6 Хадлангийн газар, түүний ашиглалт, хамгаалалт: Тухайн аймгийн газрын нэгдмэл сангийн тайланд бүртгэлтэй хадлангийн талбайн одоогийн ашиглалтын байдлыг газар дээр нь тулган хил зааг, хэмжээ, байршлыг тодорхойлж зураглахаас гадна 1 га талбайн ургацын дээж авч, ургамлын бичиглэл үйлдэнэ.
- 6.8.7 Мөн хур бороо ихтэй жилд өвс ургамал сайн ургадаг ургацын хэмжээ ихтэй хадлан авахад тохиромжтой цаашид хадлангийн зориулалтаар ашиглах бэлчээрийн талбайн хэмжээ, байршлыг газар дээр нь тодорхойлж, зурагт буулгахаас гадна 1 га талбайн ургацын хэмжээг тодорхойлно.

Хүснэгт 7. Хадлангийн нөөцөөр тогтоогдсон газруудын одоогийн төлөв байдал, чанар

№	Талбайн дугаар	Хэмжээ, га-р	Зонхилох ургамлын төрлүүд	Ургац, цн/га	Шимт чанар	Ашиглалтын өнөөгийн байдал
1	01					
2	02					
	Бүгд					

Хүснэгт 8. Хадлан бэлтгэх боломжтой бусад ангиллын газруудын судалгаа

№	Талбайн дугаар	Сумын нэр, байршил	Газрын зориулалт	Хадаж болох газрын хэмжээ, га-р	Бэлтгэх арга
	01				
	02				
	Бүгд				

Хүснэгт 9. Хадлан бэлтгэх боломжтой бусад газруудын төлөв байдал, чанар

№	Талбарын дугаар	Сумын нэр, байршил	Газрын зориулалт	Хадаж болох газрын хэмжээ, га-р	Бэлтгэх өвсний хэмжээ, тн	Бэлтгэх арга
	01					
	02					
	Бүгд					

Хүснэгт 10. Нөхөн сэргээлт, тордолт хийх хадлангийн газрын судалгаа

№	Арга хэмжээ	Газрын байршил	Талбайн хэмжээ, га-р	Зарцуулсан хөрөнгө* мян/төг	Хөрөнгийн эх үүсвэр
1	Услах				
2	Тордон сайжруулалт хийх				
3	Тарималжуулах				
4	Гэх мэт...				
	Бүгд				

*- Сайжруулах арга хэмжээ авсан бол хөрөнгийн хэмжээг бичих

Хүснэгт 11. Хадлангийн эзэмшилт, ашиглалтын өнөөгийн байдал

№	Газрын харилцааны хэлбэрүүд	Тоо хэмжээ		
		Иргэн	ААНБ	Гадаадын байгууллага
1	Эзэмшүүлсэн			
2	Ашиглуулсан			
3	Өмчлүүлсэн			
	Бүгд			

- 6.8.8 Бэлчээрийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын байдал: Тухайн орон нутгийн бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал, өвөлжөө, хаваржааны байршил, багийн нарийвчлалтайгаар аймгийн хэмжээнд бэлчээрийн даац багтаамж, хүрэлцээ, түүнийг нэмэгдүүлэх арга зам, нөхөн сэргээлт, тордон сайжруулалт хийх болон тарималжуулах бэлчээрийн газруудын байршил, хэмжээ, төрөл, бэлчээр сайжруулах талаар авч буй арга хэмжээ, улирлын бэлчээрийн зааг зэрэг мэдээллүүд орно.
- 6.8.9 Малчин өрхийн өвөлжөө, хаваржаа: Өвөлжөө, хаваржааны байршлын мэдээллийг сүүлийн үеийн байдлаар бэлэн мэдээлэл ашиглаж хил зааг тогтооно.
- 6.8.10 Бэлчээр усжуулалт: Тухайн аймаг, орон нутгийн бэлчээр дэх уст цэг /худаг, булаг, шанд, гол горхи, нуур, хөв цөөрөм/-ийн тооллого, ашиглалтын байдлын судалгааг хөдөө аж ахуй болон байгаль орчин хариуцсан мэргэжилтнээс авч зурагт тэмдэглэнэ.
- 6.8.11 Отрын нөөц нутаг: Одоогийн ашиглаж байгаа отрын нутгийг тодорхойлж зураглах, цаашид отрын зориулалтаар ашиглах газрын байршлыг зураглах. Тухайн аймагт одоо байгаа отрын бүс нутаг дахь малын тоо, 1 га талбайн ургацын хэмжээ, даац, багтаамж, төлөв байдал, уст цэгийн тоо, ашиглалтын байдлыг тодорхойлж, зурагт оруулна.
- 6.8.12 Бэлчээрийг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх: Хүний үйл ажиллагаагаар болон байгалийн бусад хүчин зүйлүүдийн нөлөөгөөр доройтож, талхлагдсан бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлж, цаашид хамгаалах, сайжруулах, усжуулах, нөхөн сэргээх, хортон мэрэгчтэй тэмцэх арга хэмжээнүүдийг тодорхойлох ажил хийгдэнэ. Үүнд:

Хүснэгт 12. Нөхөн сэргээлт, тордон сайжруулалт хийх газар, хэмжээ /га-гаар/

№	Газрын доройтлын хэлбэрүүд	Байршил /Газар, усны нэр/	Хэмжээ, га-р	Тайлбар
1	Талхлагдсан бэлчээр-бүгд			
2	Үүнээс: Их			
3	Дунд зэрэг			
4	Элсжсэн			
5	Намагжилт, давсжилт үүссэн			
6	Хортон мэрэгчид тархсан			
7	Үйлдвэр уурхайн үйл ажиллагаагаар ухагдаж төнхөгдсөн			
8	Үйлдвэр уурхайн үйл ажиллагаагаар бохирдсон			

9	Ахуйн бохирдлууд			
10	Гэх мэт...			
	Бүгд			

*-Сайжруулалт хийсэн бол талбай ба хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тавих

*Хүснэгт 13. Бэлчээр ашиглалтыг сайжруулахаар
авч хэрэгжүүлэх арга хэмжээ*

№	Авах арга хэмжээ	Газрын байршил	Хөрөнгө мян/төг	Тайлбар
1	Худаг, усан санг барих			
2	Худаг, усан санг засварлах			
3	Зам харгуйг сайжруулах			
4	Хашиж хамгаалах			
5	Гэх мэт . . .			
	Бүгд			

Тайлбар: Дээрх үзүүлэлтийг сум бүрээр нэгдсэн тайланд хавсаргана.

6.8.13 Эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуй: Тухайн аймаг/нийслэлд одоогийн байдлаар эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн судалгааг авч, аж ахуйн төрөл, хүчин чадал, зах зээлийн талаарх мэдээллийг бүрдүүлнэ. Мөн малчин өрхийн малын гаралтай мах, сүүн бүтээгдэхүүний хэмжээ, борлуулж ашиг олдог эсэх, цаашдын бодол зэргийг судална.

Хүснэгт 14. Эрчимжсэн мал аж ахуйн чиглэл, тоо

№	Үйл ажиллагааны чиглэл	Тоо ширхэг	Хүчин чадал
1	Сүүний		
2	Гахай тахиа үржүүлгийн		
3	Махны		
4	Гэх мэт		

6.8.14 Мал тууврын зам: Мал тууврын замын маршрут, заагийг зураглах. Аймгийн хэмжээнд сум хооронд дайран өнгөрдөг мал тууврын замын чиглэлийг зурагт тэмдэглэх, уг тууврын замыг аль улиралд ашигладаг эсэх, замын маршрутын дагуух газар нутгийг нутгийн малчин өрх ямар улиралд ашигладаг эсэх, хичнээн тооны малчин өрх болон мал хамрагддаг эсэх талаарх судалгааг гүйцэтгэнэ.

6.8.15 Ашиглалтгүй бэлчээр: Тухайн орон нутагт огт ашиглалт явуулдаггүй ба ашиглахад бэрхшээлтэй газрыг судалж, тогтоох ажлыг гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл уулын эгц хажуу, элс

царманд дарагдсан газар, цөлжилтөд орсон гэх мэт шалтгааны улмаас хөдөө аж ахуйд ашиглахад тохиромжгүй буюу худаг усны хүрэлцээгүйгээс, хэт алслагдсан, зам харгуй байхгүйгээс ашиглагдахгүй байгаа газруудыг илрүүлэн тогтоож, зурагт оруулан ялгана.

- 6.8.16 Бусад ангиллын газраас бэлчээрт шилжсэн газар: Түүнчлэн бэлчээрээс бусад эдэлбэрт шилжсэн газрын байршил, бусад ангиллаас бэлчээрт ашиглагдаж буй газрын байршил зэрэг орно. Эдгээрээс ялангуяа тусгай хамгаалалттай газарт хамрагдаж буй бэлчээрийг тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод бүсчлэлтэй уялдуулан нарийвчлан авч үзэх, тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдах нутгууд тухайн аймгийн бэлчээрийн хүрэлцээ, хангамжид хэрхэн нөлөөлж байгааг тусгана.

Хүснэгт 15. Бэлчээрээс бусад ангилалд шилжих газар, хэмжээ

№	Бусад ангилалд шилжих бэлчээрийн хэмжээ, га-р					
	Хадлан	Фермерийн аж ахуйн бэлчээр	Газар тариалан, га-р	Тусгай хэрэгцээ, хамгаалалт	Уул уурхай	Гэх мэтээр дэлгэрүүлэх

Хүснэгт 16. Бусад ангиллаас бэлчээрт ашиглагдаж буй газар, хэмжээ

№	Газрын сангийн ангилал	Талбай, га-р	Цаашдын ашиглалтын төлөв

- 6.8.17 Хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламж: Барилга, байгууламжийн зориулалтаар ашиглаж буй газрын заагийг зураглах. Хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаа барилга, байгууламжийн байршил, хэмжээ, зориулалтыг тулган шалгах, одоогийн ашиглалтын байдлыг тодорхойлж, бүрэн бүтэн эсэх, эвдэрч тоногдсон эсэх, байгууламжийг барьж байгуулсан огноо, хүчин чадал, багтаамж, хариуцдаг этгээд зэрэг мэдээллийг тодруулан судална.

- 6.9 Хот, тосгон бусад суурины ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалт: Хот суурин газрын газар ашиглалтыг аймгийн төв болон цаашид бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтөөр аймаг, улсын зэрэглэлд хамрагдах сумын төвүүдэд дараах судалгааны ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:
- 6.9.1 Хотын барилгажсан газрын балансыг хотын хүн амд ногдох үзүүлэлтээр тооцон гаргах;
- 6.9.2 Хотын ногоон байгууламжийн нийт хэмжээ, нэг хүнд ногдож байгаа үзүүлэлт;

- 6.9.3 Хотын ерөнхий төлөвлөгөө болон одоогийн байдал, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, хотын функциональ бүсүүд /үйлдвэржилтийн бүс, орон сууцны бүс, засаг захиргаа, бизнесийн бүс, гэр хороолол/-ийн хил заагийг зохих масштабын байр зүйн зурагт тэмдэглэж, талбайн хэмжээг тодорхойлох;
- 6.9.4 Хот, суурины суурьшлын бүс нутгийн хот байгуулалтын үнэлгээг хийх;
- 6.9.5 Хотын функциональ бүсүүдийн хуваарилалт, түүнийг хот байгуулалтанд хэрхэн мөрдөж байгаа талаар дүгнэх;
- 6.9.6 Аймаг, нийслэл дэх нийт сум, дүүргийн хот суурин газрын өргөжин тэлэх цаашдын хандлагыг газар ашиглалтын хэрэгцээт болон тохиромжтой байдлын үнэлгээнд үндэслэн тогтоож, нийгэм, эдийн засаг, байгаль, газар зүйн нөхцөл нөөцтэй уялдуулан судалж, зурагт тусгах;
- 6.9.7 Амралт сувилал, аялал зугаалгын бүс, хог хаягдал, оршуулгын газар, уламжлалт ёс, заншил, түүх соёлын өвийг хадгалан хамгаалах газруудын одоогийн төлөв байдал, байршлыг зохих масштабын байр зүйн зурагт тусгах;
- 6.9.8 Дагуул хотыг хөгжүүлэх бүсийг тогтоох: Хотын байгаль орчин, ногоон бүсийн ашиглалт, хамгаалалтын байдал, бохирдлын зэрэг тогтоож, үнэлэлт дүгнэлт өгөх.

Хүснэгт 17. Хот суурин газрын шилжилт хөдөлгөөн ба хотын барилгажих нөөц газар

№	Газрын зориулалт	Аль ангиллын газраас шилжих	Хэмжээ, га-аар
1	Барилгажихаар төлөвлөгдсөн нөөц		
2	...		
	Бүгд		

Хүснэгт 18. Хотын газрын доройтлын байдал

№	Газрын доройтлын хэлбэрүүд	Байршил /газар, усны нэр/	Хэмжээ, га-р	Тайлбар
1	Хөрсний гүний ба өнгөн бохирдол			
2	Уруйд идэгдсэн			
3	Өнгөн бүрхэвч нь зулгарсан			
4	Элсжсэн			
5	Намагжилт, давсжилт үүссэн			
6	Хортон мэрэгчид тархсан			

7	Үйлдвэр уурхайн үйл ажиллагаагаар ухагдаж төнхөгдсөн			
8	Үйлдвэр уурхайн үйл ажиллагаагаар бохирдсон			
9	Гэх мэт...			
	Бүгд			

Хүснэгт 19. Нөхөн сэргээлт, тордолт хийх газрын судалгаа

№	Арга хэмжээ	Газрын байршил	Талбайн хэмжээ, га-р	Зарцуулсан хөрөнгө* мян/төг	Хөрөнгийн эх үүсвэр
1	Ойн зурвас байгуулах				
2	Эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээх				
3	Зүлэгжүүлэх, цэцэрлэгжүүлэх				
4					
6	гэх мэт...				
	Бүгд				

Хүснэгт 20. Хот суурингийн газрын харилцааны өнөөгийн байдал

№	Газрын харилцааны хэлбэрүүд	Тоо хэмжээ		
		Иргэн	ААНБ	Иргэн
1	Эзэмшүүлсэн			
2	Ашиглуулсан			
3	Өмчлүүлсэн			
	Бүгд			

6.9.9 Амралт, рашаан сувиллын газрын ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал: Тухайн орон нутагт хичнээн хэмжээний амралт, сувилал болон хүүхдийн зуслангийн газар байршиж байгаа ба тэдгээрийн эдэлбэр газарт болон орчин тойрны газар ашиглалтын байдалд хамтад нь үнэлэлт, дүгнэлт өгнө.

6.9.10 Үйлдвэр уурхайн газрын ашиглалт, хамгаалалтын байдал: Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмалын ашиглалтын болон түгээмэл тархацтай ашигт малтмал болон тоосгоны үйлдвэр, бусад карьеруудын газар ашиглалтын өнөөгийн байдал, тэдгээрийн орчны газарт хамтад нь үнэлэлт, дүгнэлт өгч, судалгааны ажлыг гүйцэтгэнэ.

6.10 Зам, шугам сүлжээний ангиллын газар, түүний ашиглалт: Авто замын зориулалт хэмжээ, төрөл, төмөр замын эдэлбэр газар, хамгаалалтын зурвас, төмөр замын өртөөний орон сууц, үйлчилгээний зориулалттай газрын ашиглалтын байдал багтана.

Хүснэгт 21. Авто болон төмөр замын зурвас газар

№	2009 оны байдал				Төлөвлөгдөж буй					
	Замын ангилал	Замын чиглэл	Замын урт км-р	Замын зурвас газрын тооцоо	Замын чиглэл	I-II	III-IV	Урт км	Зурвасын тооцоо	Нийт дүн
Авто зам	Улсын чанартай									
	Аймаг орон нутгийн чанартай									
	Сум хоорондын									
	Аж ахуйн хоорондын чанартай									
Төмөр зам										

- 6.10.1 Төмөр замын өртөөн дээрх орон сууц, үйлчилгээний зориулалтын газрын хэмжээ, ашиглалтын байдалд үнэлэлт, дүгнэлт өгнө.
- 6.10.2 Орон нутгийн зам дагаж үүссэн олон салаа зам болон хээрийн замын ашиглалтын байдлыг судалж, байршил, төлөв байдлыг тодорхойлж, зурагт оруулна.
- 6.11 Ойн сан бүхий газрын ашиглалт, хамгаалалт: Тухайн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн зохих масштабын байр зүйн зураг дээр ойн сангийн бүс, тусгай хамгаалалттай газрын ой, төв суурин газрын ногоон бүсийн ойн хил зааг, тархалтыг тэмдэглэн хээрийн судалгааны ажлын зураг бэлтгэнэ. Энэ нь ойн сан бүхий газарт орсон өөрчлөлтийг тодотгох болон ой зохион байгуулалт хийх төлөвлөгөөг боловсруулах ажлын суурь болж өгнө.
- 6.11.1 Ойн сангийн өөрчлөлтийг тодотгох хээрийн ажлаар тухайн ойн тархалт, ойн бүтэц, бүрэлдэхүүн, ойн хэв шинж хөрс, ургамлын нөмрөг, газрын налуу, зүг чиг, байрлал зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлон ойн төлөв байдалд үнэлэлт өгөхөөс гадна ойн талбайн ангилал, нөөцийг шинэчлэн тогтоож, өөрчлөлт гарсан хэсэглэл, ялгарлын зураглал үйлдэж, ойн аж ахуйн арга хэмжээний чиглэлийг тогтооно.

Хүснэгт 22. Ойн ашиглалт, хамгаалалтын ангилал

Экологи-эдийн засгийн ангилал	Бүрэлдэхүүнд багтах газар	Хэмжээ, га-р	Тайлбар
1. Онцгой бүсийн ой	1. Дархан газрын онгон бүсийн ой		
	2. Байгалийн цогцолборт газрын онцгой бүсийн ой		
	3. Цармын бүсийн ой		
2. Хамгаалалтын бүсийн ой	1. ДЦГ-ын хамгаалалтын бүсийн ой		
	2. ДЦГ-ын хязгаарлалтын бүсийн ой		
	3. БЦГ-ын аялал жуулчлалын бүсийн ой		
	4. БНГ-ын хязгаарлалтын бүсэд байгаа ой		
	5. БНГ-т байгаа ой		
	6. БДГ-т байгаа ой		
	7. Хот, тосгон суурингийн ногоон бүсэд хамрагдах ой		
	8. Ойн хориотой зурвас		
	9. Ширэнгэ		
	10. Төгөл мод		
	11. Сөөг		
	12. Гучин хэмээс налууд ургасан ой		
	13. Мод сөөг бүхий баян бүрд		
3. Ашиглалтын бүсийн ой	1. Ой зохион байгуулалт хэрэглээний мод бэлтгэх зориулалтаар тогтоогдсон ой бүхий газар		
	2. Орон нутгийн зөвшөөрлөөр бэлтгэдэг газар		
4. Бусад ой бүхий газар	1. Мод үржүүлгийн газар		
	2. Ойн цоорхой		
	3. Мод бэлтгэсэн талбай		
	4. Түймэрт шатсан ой		
	5. Ойн захаас гадагш 100 м хүртэл өргөнтэй өвслөг ургамалт зурвас		
	6. Ойн санд шилжүүлээгүй зурвас		
	7. Тариалангийн талбайн ойн зурвас		

6.11.2 Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр дэх ойн дагалт баялгийн нөөц, тархац, ургацын хэмжээг ойн ангийн дүгнэлт, ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн тогтоох бөгөөд ойн анги байхгүй нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагчийн тайлан мэдээ, судалгааг ашиглаж болно. Мөн тухайн нутаг дэвсгэрийн хуш модны самар, эмийн болон хүнс, тэжээл, техникийн ургамлын ургацын байдал, мэдээ, дүгнэлтийг "Ойн судалгаа хөгжлийн төв"-өөс авч тогтооно.

Хүснэгт 23. Ойн дагалт баялгийн тархац, нөөц

№	Ойн дагалт баялаг	Тархалтын хэмжээ /га/	Нөөцийн хэмжээ /тн/	Ургацын хэмжээ цн/га	Тайлбар
1	Самар				
2	Жимс				
3	Эмийн ургамал				
4	Хүнс тэжээл, техникийн ургамал				
	Гэх мэт				

6.12 Усны сангийн ангиллын газар, түүний ашиглалт, хамгаалалт: Гадаргын ба гүний усны эх үүсвэрүүдийн бохирдлын нөхцөл шалтгаан, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн ашиглалтын байдалд үнэлэлт өгч, тодруулга хийнэ. Хамгаалалтын бүс дотор үйл ажиллагаа явуулж байгаа чиглэл тэдгээрийн газар ашиглалт, усны эхийг бохирдуулагч эх үүсвэрийн гарал үүсэлд үнэлгээ өгч дүгнэлт гаргах ажлыг гүйцэтгэнэ.

Хүснэгт 24. Гадаргын усны судалгаа

Гол нуурын нэр	Эзлэх талбай, м3	Усны нөөц	Усны чанар
	Усан толио	Эрэг орчмын газар	
1.			
2.			

Хүснэгт 25. Гүний ус ашиглалтын судалгаа*

Худгийн төрөл	Газрын байршил	Усны нөөц	Ашиглалтад орсон он	Ашиглалтын өнөөгийн байдал

*- Цаашид гаргах худгийн байршилг оруулах

6.13. Тусгай хэрэгцээний ангиллын газар, түүний ашиглалт хамгаалалтын одоогийн байдал: Үйлдвэр, уурхай, амралт сувилал болон тусгай хамгаалалттай газрын ашиглалт хамгаалалт, цаашид тусгай хамгаалалт, хэрэгцээнд авах боломж, шаардлага, хэмжээ, хил заагийг зурагт харуулна.

Хүснэгт 26. Тусгай хэрэгцээний газрын судалгаа

№	Газрын нэр	Ашиглалтын зориулалт	Олгогдсон газрын хэмжээ, га-р	Цаашид олгогдох хэмжээ, га-р
1. Үйлдвэр уурхайн газар				
1				
2				
Аялал жуулчлал амралт, сувилал, зугаалгын газар				
1				
2				

3				
Газрыг хадгалан хамгаалах бүс				
1		Байгалийн ховор нандин тогтоц		
		Түүх соёл, антропологийн		
		Батлан хамгаалах, аюулгүй байдлын		

Аялал жуулчлал, амралт, сувилал, ангийн отог хөгжүүлж буй болон цаашид хөгжүүлэхээр төлөвлөж буй газруудын судалгаа, аялалын маршрутыг зурагт тэмдэгжүүлсэн байна.

Хүснэгт 27. Тусгай хамгаалалтад авсан болон авахаар төлөвлөж буй газрын судалгаа

Тусгай хамгаалалттай газрын нэр	Ангилал	Хамрах талбай, га-р	Тусгай хамгаалалтад авсан үндэслэл

- 6.13.1 Улсын хилийн зурвас газрын ашиглалтын байдал: Хилийн зурвас газарт үйл ажиллагаа явуулж байгаа чиглэл, зурвас газрын хэмжээг багасгах нөхцөл шаардлага тухайн орон нутагт байгаа эсэх талаар дүгнэлт өгнө.
- 6.13.2 Шинжлэх ухаан, технологийн сорилт туршилт болон байгаль орчин цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбайн ашиглалтын байдал: Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй объектууд болон газруудын байршлыг зурагт оруулж тэмдэглэнэ.
- 6.13.3 Газрын нөөц, газар ашиглалтын бэлтгэл болон хээрийн тодруулалт судалгааны эцэст газар ашиглалт-газрын бүрхэвчийн зураг үйлдэх бөгөөд энэ нь цаашид газрыг бүсчлэн хуваарилах төслийн суурь зураг болж ашиглагдана. Газар ашиглалтын зурагт тухайн нутагт судалгаа явуулах үед байсан газар ашиглалтын бүх л хил хязгаарыг байгаль орчны болон газрын экологийн нөхцөлийн хамт зураглан харуулна. Үүнд:
 - 6.13.4 Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын байршил /хадлан, тариалан, жимс жимсгэний талбай, атаржсан газар, сайжруулсан, хашиж хамгаалсан газрууд/
 - 6.13.5 Улирлын бэлчээрийн зааг, ашиглагдахгүй байгаа, усжуулагдаагүй, талхлагдсан бэлчээрийн байршил
 - 6.13.6 Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн барилга байгууламжууд /өвөлжөө, хаваржаа, үр тарианы аж ахуйн байршил гэх мэт/

- 6.13.7 Мал тууврын зам, аймаг, сум дундын отрын нутгууд, тэдгээрийн төв суурин, дамжин өнгөрөх цэгүүд
- 6.13.8 Тусгай хэрэгцээний зориулалтаар ашиглагдаж байгаа бүх газрууд /үйлдвэр, уурхай, амралт сувилал, тусгай хамгаалалттай газар нутгууд, батлан хамгаалах зориулалтын газар гэх мэт/
- 6.13.9 Инженерийн ба энгийн хийцтэй уст цэгүүд, байгалийн ил задгай ус, /нуур, гол горхи, булаг шанд гэх мэт/ бэлчээр усжуулалтын хил зааг
- 6.13.10 Ой, заг, элс, ойн аж ахуйн байгууллагууд гэх мэт.

ДОЛОО. ОРОН НУТГИЙН ХОЛБОГДОХ АЛБАН ТУШААЛТНУУД, ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН САНАЛЫГ АВАХ

- 7.1 Хээрийн судалгааны үеэр аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагуудтай уулзалт, иргэд, олон нийттэй ярилцлага зохион байгуулж, тэдэнд ерөнхий төлөвлөгөөний талаар мэдээлэл өгч, үүнээс гарах үр дүн, ач холбогдол, үр өгөөжийг танилцуулж ойлгуулна. Энэхүү хээрийн судалгаанд Хавсралт 2-д харуулсан аймаг/нийслэлийн хөгжлийн шинжилгээний төслийг боловсруулж, танилцуулна.
- 7.2 Иргэд, олон нийтийн саналыг ерөнхий төлөвлөгөөнд тусгахдаа уулзалт, ярилцлага, бүлгийн хэлэлцүүлэг, санал асуулгын судалгаа авах зэрэг аргуудыг ашиглах ба “Социологийн судалгааны аргачлал”, “Асуудлын шинжилгээ”-ний аргыг хослуулан ашиглана.
- 7.3 Уулзалт: Уулзалтыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Засаг даргын орлогч, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгчид, аймаг, нийслэлийн харьяа хэрэгжүүлэгч агентлагуудын холбогдох албан тушаалтан болон нутаг орноо сайн мэддэг нутгийн иргэдтэй урьдчилан тохиролцсоны дагуу зохион байгуулна. Уулзалтад оролцсон хүмүүсийн бүртгэлийг загвар 1-ээр, мөн иргэд, олон нийтээс гарсан санал, хүсэлтийг загвар 2-ын дагуу авна.

..... аймгийн/нийслэлийн сумын/дүүргийн уулзалтад оролцогчдын бүртгэл

Бүртгэл хөтөлсөн: / / 20__ оны __ сар __ өдөр

гарын үсэг овог, нэр

№	Овог нэр	Нас	Хүйс	Албан тушаал	Утасны дугаар	Гарын үсэг
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						

Загвар 1. Уулзалтад оролцогчдын бүртгэл

..... аймгийн/нийслэлийн сумын/дүүргийн уулзалтын тэмдэглэлийн хуудас

Тэмдэглэл хөтөлсөн: №..... 20__ оны __ сар __ өдөр

Овог, нэр

Уулзалт ... цаг ... минутад эхэлж, ... цаг ... минутад дуусав.

Уулзалтад хүн оролцов. газарт зохион байгуулав.

Асуулт 1:

.....

Хариулт 1:

.....

Санал 1: албан тушаал овог, нэр:

Санал 2: албан тушаал овог,

нэр:.....

Тэмдэглэлтэй танилцсан: / /

..... /гарын үсэг/ /овог, нэр/

..... /албан тушаал/

Загвар 2. Уулзалтын тэмдэглэлийн хуудас

- 7.4. Ярилцлага: Орон нутгийн иргэдтэй нээлттэй, өргөн хүрээнд ярилцлага хийнэ. Ярилцлагад тухайн аймаг, нийслэлийн бүх сум, дүүргийн төлөөллийг оролцуулбал зохино. Урьдчилан ярилцлага хийх бэлтгэлийг хангаж, хэнээс ямар асуулт асуухаа ерөнхий төлөвлөгөө боловсруулах зорилго, зарчим, тэргүүлэх чиглэлүүдэд тулгуурлаж асуултуудыг бэлтгэнэ. Ярилцлагад оролцогчдын саналыг тэмдэглэлээр баталгаажуулна /Загвар 3, 4/.

..... аймгийн/нийслэлийнсумын/дүүргийн ярилцлагад оролцогчдын бүртгэл

Бүртгэл хөтөлсөн: / / 20__ оны __ сар __ өдөр

гарын үсэг

овог, нэр

№	ОВОГ НЭР	Нас	Хүйс	Албан тушаал	Утасны дугаар	Гарын үсэг
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						

Загвар 3. Ярилцлагад оролцогчдын бүртгэл

..... аймгийн/нийслэлийн сумын/дүүргийн уулзалтын тэмдэглэлийн хуудас

Тэмдэглэл хөтөлсөн: №..... 20__ оны __ сар __ өдөр
Овог, нэр

Уулзалт ... цаг ... минутад эхэлж, ... цаг ... минутад дуусав.

Уулзалтад хүн оролцов. газарт зохион байгуулав.

Асуулт 1:

Хариулт 1:

Санал 1: албан тушаал овог, нэр:

Санал 2: албан тушаал овог,

нэр:.....

Тэмдэглэлтэй танилцсан: / /
/гарын үсэг/ /овог, нэр/

.....
/албан тушаал/

Загвар 4. Ярилцлагын тэмдэглэлийн хуудас

7.5. Хэлэлцүүлэг: Тухайн аймаг/нийслэлийн газар ашиглалтын өнөөгийн

нөхцөл байдалд нөлөөлж буй дотоод, гадаад хүчин зүйлийг үнэн зөв тодорхойлох, газар ашиглалтын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, газар ашиглалтын онцлогийг тодруулах үүднээс зорилтот бүлгүүдийг хамарсан хэлэлцүүлгийг зохион байгуулна. Хэлэлцүүлгийг дараах бүлгүүдтэй хийнэ.

- 7.5.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын ажилтан /Удирдах болон гүйцэтгэх түвшний албан хаагчид/;
- 7.5.2. Төрийн үйлчилгээний ажилчид /Багш, эмч, туслах үйлчилгээний ажилтан гэх мэт/;
- 7.5.3. Төрийн бус байгууллагууд /Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, залуучуудын эрх ашгийг хамгаалдаг байгууллагын төлөөлөл гэх мэт/;
- 7.5.4. Банк, санхүү, үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэгчид;
- 7.5.5. Нийгмийн эмзэг бүлгийн иргэд /Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон иргэд, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрх, иргэд гэх мэт/;
- 7.6. Хэлэлцүүлэгт оролцогчдоор ерөнхий болон дэлгэрэнгүй газар ашиглалтын бүсчлэлийн хил заагийн төслийг хэлэлцүүлж, саналыг зуруулна.
- 7.7. Нийгэм, эдийн засгийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан шинээр бий болгох жуулчны бааз, отог, амралт, сувиллын газрын байршлыг тогтоох, зураглах болон тухайн сумын онцлогоос хамаарсан бусад асуудлуудыг нэмж тодорхойлж, зураглана.
- 7.8. Хэлэлцүүлэг хийхэд анхаарах асуудлууд:
 - 7.8.1. Хэлэлцүүлэг, ярилцлагыг судлаач өөрийнхөө үзэл бодлын үүднээс хөтөлж, өөрийн байр сууринаас асуудалд хандахгүй байх;
 - 7.8.2. Зөвлөмж дээр байгаа хариултын хувилбаруудыг оролцогчдод хэлэлгүй, зөвхөн оролцогчдыг өдөөх, санаа өгөх зорилгоор судлаач өөрөө ашиглана.
 - 7.8.3. Ярилцлагаас аль болох чанартай үр дүнг авахад анхаарах
 - 7.8.4. Чиглүүлж буй асуудлуудад хэтэрхий товч хариултууд авахгүй байх. Тухайлбал бэрхшээл байгаа эсэх гэсэн асуултад тийм, үгүй гэсэн хариулт нь хангалтгүй юм.
 - 7.8.5. Хүмүүсийг аль болох бүгдийг нь ярилцлагад татан оролцуулах, саналыг тусгах
 - 7.8.6. Хэлэлцүүлэг, ярилцлага зорилгоосоо өөр зүйлд хөтлөгдөх гээд байвал асуудлаа зөв чиглүүлэхэд анхаарах. Өөрөөр хэлбэл хүмүүс сэдвээс хазайж, хадуурч, хэтэрхий улс төржих, ярилцлагыг үймүүлэх, цаг хугацаа дэмий үрэхээс зайлсхийх хэрэгтэй.
 - 7.8.7. Бүлгийн хэлэлцүүлгийг удирдагч асуултыг өдөөх, асуултын далд утгыг илрүүлэх чиглэлээр тавина.

- 7.8.8. 1 асуултын хариултаар гарсан олон хувилбарыг бүгдийг нь бичиж тэмдэглэж авна.
- 7.8.9 Бүлгийн хэлэлцүүлгээр гарсан саналууд нь нэгтгэж үнэлэлт, дүгнэлт гаргах боломжтой байх шаардлагатай.
- 7.8.10. Сумын удирдлага, мэргэжилтнүүд, иргэдийн төлөөлөлтэй хийх бүлгийн хэлэлцүүлгийн асуултуудын жишээг загвар 5-д харуулав.

Хэлэлцүүлгийн асуултууд /Жишээ/

1. Тухайн аймаг/нийслэл, сум/дүүргийн газар ашиглалтын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиг хандлага?
2. Танай аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын чиглэлээр баримтлах бодлого?
3. Газар нутгаа ямар ямар зориулалтаар ашиглах хүсэлтэй байгаа, үндэслэл нь юу вэ?
4. Танай суманд хөдөө аж ахуйн чиглэлээр хөгжүүлэх санал бодол?
 - Бэлчээр
 - Хадлан
 - Тариалан
 - Усжуулах тариалан
 - Эрчимжсэн аж ахуй
 - Хөдөө аж ахуйн барилга байгууламж гэх мэт.
5. Хот суурин газрын хөгжлийн чиг хандлага, санал бодол?
 - Суурин газрын байршил
 - Төрийн байгууллагын байршил
 - Аж ахуйн нэгжийн газар ашиглах байршил
 - Үйлдвэр, үйлчилгээний газрын байршил
 - Гэр хорооллын газрын байршил
 - Зүлэг, цэцэрлэгт хүрээлэн, амралтын газрын байршил гэх мэт.
6. Зам, шугам сүлжээний газрын санал бодол?
 - Шинээр барих авто зам
 - Шинээр барих цахилгааны шугам
 - Инженерийн шугам, сүлжээ гэх мэт.
7. Усан сангийн газрын санал бодол?
 - Шинээр гаргах уст цэгийн санал, байршил
 - Усан сан байгуулах санал, байршил гэх мэт
8. Ойн сангийн газрын санал бодол?
 - Ой мод тарих
 - Мод үржүүлгийн газар гэх мэт
9. Тусгай хэрэгцээний газар ашиглалтын тухай гэх мэт.

Загвар 5. Зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн асуултууд

- 7.9 Асуулгын судалгаа: Аймаг, нийслэлийн нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааг нийт өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөллөөс авна. Тэднээс газар ашиглалт, байгалийн нөөц, баялгийн ашиглалттай холбоотой саналыг авахдаа загвар 6-г ашиглана.

Санал авах хуудас	
№	
Овог, нэр:	/иргэн, хуулийн этгээд/ 20__ оны __ сар __ өдөр
<u>доогуур зурах</u>	
Аймаг:	Сум: Баг: Утас:
Санал:	
.....	
Тэмдэглэл:	
.....	
САНАЛ ӨГСӨН: / /	
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: / /	

Загвар 6. Санал авах хуудас

- 7.10 Уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг, санал асуулгын судалгаанд тухайн аймаг/нийслэлийн бүх сум, дүүргийн төлөөллүүдийг хамруулбал зохино.
- 7.11 Ерөнхий төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээ болон ерөнхий төлөвлөгөөний төслийн эцсийн хувилбарт сум, дүүргийн Засаг дарга нараас албан бичгээр санал авна.


НАЙМ. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН БАЙДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

- 8.1. Аймаг, нийслэлийн нийгэм, эдийн засаг, байгаль орчин, дэд бүтэц, газрын харилцааны чиглэлүүдээр SWOT (SWOT), ПЭСТЭЛ (PESTEL) болон асуудлын шинжилгээний аргуудыг хослуулан ашиглаж, одоогийн байдал, тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх нөөц боломжуудыг тодорхойлно.
- 8.2. SWOT шинжилгээ нь гадаад, дотоод орчныг судлан шинжлэх бөгөөд асуултыг аймаг, нийслэлийн онцлогт тохируулан боловсруулж, нийгэм, эдийн засгийн судлаач, социологич зэрэг мэргэжлийн хүмүүсийг оролцуулна.

- 8.3. ПЭСТЭЛ шинжилгээ нь улс төр, нийгэм, эдийн засаг, технологи, хууль эрх зүй, байгаль орчны хүчин зүйлсийн ерөнхий төлөв байдал зэрэг макро орчны нөхцөл байдлыг судлан шинжилнэ.
- 8.4. Асуудлын шинжилгээн асуудлыг үүсгэж буй байж болох бүх шалтгаанууд тэдгээр шалтгаануудын цаадах шалтгаануудыг тодорхойлсны үндсэн дээр аймаг, нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд өөрчилж, сайжруулах боломжтой шалтгаануудыг нь тодруулж, шийдлүүдийг тодорхойлдог аргачлал юм.

Мөн үүнээс гадна “Асуудлын мод” аргачлалыг ашиглан аймаг, нийслэлийн хөгжилд тулгарч буй асуудал тус бүрээр нь схем 1-д үзүүлсний дагуу асуудлыг үүсгэж буй шалтгаан, хүчин зүйл тэдгээрийн үр дагавруудыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын удирдлага, ажилтнууд, газрын даамал, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, байгаль орчны байцаагч, малчин өрх гэх мэт тодорхой зорилтод бүлгүүдийн оролцоотойгоор тодорхойлно. Үүний дараа асуудлууд тэдгээрийн шалтгаан, үр дагаврыг арилгах арга хэмжээнүүдийг оролцогчдын тусламжтайгаар тодорхойлж, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хэн ямар оролцоотой байх талаар оролцогч талуудын үүрэг хариуцлагыг хуваарилна.

Схем 1. Асуудлын шинжилгээ



Схем 1. Асуудлын шинжилгээ

ЕС. МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТ, ҮР ДҮН

- 9.1 Өмнө нь хэрэгжсэн ерөнхий төлөвлөгөөнд хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан аймаг/нийслэлийн хөгжлийн дүн шинжилгээг хавсралт 2-д үзүүлсний дагуу хийсэн байна.
- 9.2 Ерөнхий төлөвлөгөөгөөр дараах асуудлуудын шийдлийг олж, төлөвлөлтийн хил заагийг зураглаж, үр ашгийг тухайн үеийн ханшаар мөнгөн дүнгээр илэрхийлсэн байна. Үүнд:
 - 9.2.1 Аймаг/нийслэлийн эдийн засаг, аж ахуйн хөгжлийн үндсэн чиглэл, төрөлжилтийг тогтоосон байна.
 - 9.2.2 Салбаруудын хөгжлийн чиг хандлагад үндэслэн газрын нэгдмэл сангийн ангилал, шилжилт, өөрчлөлтийг тогтооно.
 - 9.2.3 Газар ашиглалтын ерөнхий бүсчлэлийг тогтоож өгсөн байна. Энэхүү бүсчлэл нь аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн байгаль, экологи, нийгэм, эдийн засгийн чиг үүргийг урьдчилан тогтоох

зорилго бүхий бодлогын ерөнхий бүс болон ерөнхий бүсийн чиг үүргийг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй бүс гэсэн үндсэн 2 түвшинтэй байна /Хүснэгт 28/.

Хүснэгт 28. Газар ашиглалтын ерөнхий болон дэлгэрэнгүй бүсчлэлийн төрөл

№	Газар ашиглалтын ерөнхий бүсчлэл	Газар ашиглалтын дэлгэрэнгүй бүсчлэл
1	Уламжлалт мал аж ахуйн ерөнхий бүс	Уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд ашиглах өвөл, хавар, зун, намрын бэлчээрийн газрын, цаа бугын бэлчээрийн газрын, зэрлэг амьтны бэлчээрийн газрын, нийтээр ашиглах уст, цэг, хужир, мараа бүхий газрын, отрын нөөц бэлчээрийн, хадлангийн газрын, бэлчээрт тохиромжгүй газрын, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн газрын бүс
2	Эрчимжсэн суурин аж ахуйн ерөнхий бүс	Тариалангийн газрын, жимс, жимсгэнэ тариалах газрын, хүлэмжийн аж ахуй эрхлэх газрын, өндөр ашиг шимт суурин болон хагас суурин мал аж ахуй эрхлэх, хөдөө аж ахуй барилга байгууламжийн цогцолбор газрын бүс
3	Хот, тосгон бусад суурины ерөнхий бүс	Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баримтална.
4	Дэд бүтцийг хөгжүүлэх бүс	Харилцаа холбоо, мэдээллийн зориулалттай зурвас газар, барилга байгууламжийн, түлш, эрчим хүчний зориулалттай зурвас газар, барилга байгууламжийн, цэвэрлэх, боловсруулах байгууламжийн зориулалттай зурвас, талбарын ундны усан хангамжийн зориулалттай зурвас газар, барилга байгууламжийн бүс
5	Үйлдвэр, уурхайн бүс	Шинээр байгуулах, өргөтгөх хөнгөн, хүнд, уул уурхайн үйлдвэрийн газрын, ашигт малтмал олборлолтын газрын бүс
6	Ойн сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын ерөнхий бүс	Хамгаалалтын бүсийн ой бүхий газар, ашиглалтын бүсийн ой бүхий газар, ой тэлэн ургах боломжийг хангахуйц газрын бүс
7	Усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын ерөнхий бүс	Гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалах, усархаг намгархаг газруудыг хамгаалах, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, усны сан бүхий газрын эрүүл ахуйн бүс
8	Тусгай хэрэгцээний газар нутгийн ерөнхий бүс	Улсын хилийн зурвас газар, шинжлэх ухаан сорилт туршилтын газар, цаг уур орчны шинжилгээний газар, цөмийн төхөөрөмж барих зориулалтаар олгох газар, аймаг болон сум дундын отрын бэлчээр, чөлөөт бүс, хилийн боомтын бүс, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газрын, тусгай хамгаалалттай газар нутгийн бүс
9	Аялал жуулчлал, амралт зугаалгын ерөнхий бүс	Экологийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бүс, түүх соёлын дурсгалт газрыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх бүс, рашаан сувиллын аялал рекреацийн бүс, олзворын ангийн аялал рекреацийн бүс

9.2.4 Бүсчлэлд баримтлах хөгжлийн чиг хандлагын хувилбаруудыг тогтоохдоо асуудлын шийдэл олох шинжилгээний аргыг ашиглана. Энэхүү арга нь бэлтгэл болон хээрийн судалгааны ажлын үе

шатанд болон бүх шатны ярилцлага, хэлэлцүүлэг, санал асуулгын үеэр ажиглагдсан нөхцөл байдал, шалтгаан, шийдвэрлээгүй тохиолдолд үүсэх үр дагавар дээр тулгуурлан бүсийн хөгжлийн чиг хандлагын хувилбаруудыг дэвшүүлдэг /Хүснэгт 29/. Хөгжлийн чиг хандлагын хувилбаруудаас сонгон газар ашиглалтын ерөнхий бүсэд баримтлах бодлогыг тодорхойлж өгнө.

Хүснэгт 29 Асуудлын шийдэл олох шинжилгээний загвар

№	Ажиглагдсан нөхцөл байдал	Тайлбарууд / шалтгаанууд/	Шийдвэрлэгдээгүй тохиолдолд үүсэх үр дагавар	Хөгжлийн чиг хандлага, хувилбарууд
Газар өмчлөл				
1	Иргэнд 1 удаа үнэгүй өмчлүүлэх газар нутаг хязгаарлагдмал	Нийт газар нутгийн 84 хувь нь тусгай хэрэгцээний газар нутаг	Нутгийн иргэд олон жил амьдарсан газраа өмчлөх эрхээ эдэлж чаддаггүй Хөрөнгө оруулагчид өмчлөх эрхийн гэрчилгээгүй газрыг хөгжүүлэхээс татгалздаг Ядуу, бага орлоготой иргэдэд газрын төлбөр өндөр тусдаг	Суурин газрын хил заагийг тогтоож, бүртгэлжүүлэх Иргэд суурьшсан суурин газрыг тусгай хамгаалалттай газраас гаргах, өмчлүүлэх Нийт газар нутгийн 3 хувийг нутгийн иргэдэд өмчлүүлэх
2				
3				Гэх мэт.

- 9.2.5 Аймгийн Засаг даргын шийдвэрээр газрыг эзэмшүүлэх, ашиглуулах газрын хил зааг буюу аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудын хил заагийг тогтоож өгнө. Мөн нийслэл хотын суурьшлын бүсийн инженерийн шугам, сүлжээ бүхий болон сүлжээнд холбогдохоор төлөвлөгдсөн газруудын хил заагийг тогтоож зураглаж өгнө.
- 9.2.6 Ерөнхий төлөвлөгөөгөөр аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан газар ашиглалтын ерөнхий бүсчлэлийг тогтоож, зураглана.
- 9.2.7 Ерөнхий төлөвлөгөөгөөр тогтоосон ерөнхий бүсчлэлийн хөгжлийн чиг хандлагын хувилбарууд болон баримтлах бодлого, бүсэд тавигдах шаардлага, түүний дэглэм горим, зөвшөөрөх болон хориглох газар ашиглалтын төрлүүдийг тухайн аймаг, нийслэлийн онцлогт нийцүүлэн боловсруулж, зурагласан байна.
- 9.2.8 Ерөнхий төлөвлөгөөний үр ашгийг арга хэмжээний төрөл бүрээр холбогдох аргачлалын дагуу мөнгөн дүнгээр тооцсон байна.

- 9.2.9 Хот, тосгон бусад суурин газрын газар ашиглалтын дэлгэрэнгүй бүсчлэлийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр, аймгийн хэмжээнд газар ашиглалтын дэлгэрэнгүй бүсчлэлийг сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөгөөр гаргана.
- 9.2.10 Аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газрын хил заагийг аймгийн төвийн сумын хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл болон одоогийн газар ашиглалтын нөхцөл байдалд нийцүүлэн тогтоож, хил заагийг нарийвчлан зурагласан байна.
- 9.2.11 Хүн амын өсөлтийн үзүүлэлтийг харгалзан аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт нийт тэлэх болон шинээр байгуулах хот, тосгон бусад суурин газрын хэмжээ, байршил, хил заагийг тооцож төлөвлөсөн байна.
- 9.2.12 Газрын тухай тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2-т заасны дагуу аймгийн Засаг дарга аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудад эзэмшүүлэх, ашиглуулах газрын хэмжээ байршил зориулалтыг хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тогтоож, зураглаж, төлөвлөсөн байна.
- 9.2.13 Улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн зорилт, салбаруудын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилалд орох өөрчлөлтийг тогтоож, зураглан уг ажлын хүрээнд хийгдэх газар зохион байгуулалтын ажлын хэмжээ, төсөв зардлын тооцоог хийсэн байна.
- 9.2.14 Монгол улсын газрын нөөц, нэгдмэл санг төрөөс удирдах бодлого төлөвлөлтийн хүрээнд хуулийн үндэслэл, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн зорилт, салбаруудын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан газрын нийгэм, эдийн засаг, экологид гүйцэтгэх үүргээр нь газрын байршил, хэмжээг тогтоох шийдлийг зураглаж, газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилалд орох өөрчлөлтийг тогтоож, газар зохион байгуулалтын хүрээнд хийгдэх ажлын хэмжээ, төсөв зардал, эх үүсвэрийг урьдчилан тооцсон байна.
- 9.2.15 Уламжлалт бэлчээрийн аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх, нүүдлийн амьдралын хэв маяг, соёлыг хадгалан үлдээх бүс нутгийн схемчилсэн байршил, хэмжээ, хил заагийг зураглаж, холбогдох шийдэл, тооцоолол, бүс нутагт тавигдах шаардлага, баримтлах бодлогыг төлөвлөсөн байна.
- 9.2.16 Орон нутгийн чанартай услалтын систем, ус дамжуулах хоолой байгуулах газар, усалгаатай болон усалгаагүй ургамлын аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх бүс нутгийн схемчилсэн байршил, хэмжээ,

хил заагийг зураглаж, цаашид хөгжих шийдэл, тооцооллыг хийсэн байна.

- 9.2.17 Орон нутгийн түвшний эрчимжсэн мал, амьтны аж ахуй эрхлэх, агротехнологийн төрөлжсөн парк байгуулах нутаг дэвсгэрийн схемчилсэн байршил, хэмжээ, хил заагийг зураглаж, цаашид хөгжих шийдэл тооцооллыг хийсэн байна.
- 9.2.18 Суурин аж ахуйг бэлчээрийн мал аж ахуйтай хослон хөгжүүлэх бүс нутгийн схемчилсэн байршил, хэмжээ, хил зааг, бүс нутагт тавигдах шаардлага, баримтлах бодлогыг төлөвлөсөн байна.
- 9.2.19 Жимс, жимсгэний аж ахуй хөгжүүлэх бүс нутгийн нутаг дэвсгэрийн схемчилсэн байршил, хэмжээ, хил заагийг зураглаж, цаашид хөгжих шийдэл тооцоолол, бүс нутагт тавигдах шаардлага, баримтлах бодлогыг төлөвлөсөн байна.
- 9.2.20 Аймгийн чанартай сум дундын отрын бүс нутаг, улс, аймгийн нөөцийн хадлангийн талбай бүхий бүс нутгийн байршил, хэмжээ, хил заагийг зураглаж, холбогдох шийдэл тооцооллыг хийсэн байна.
- 9.2.21 Хот, тосгон, суурины нутаг дэвсгэрт орших болон тэдгээрээс нүүлгэн шилжүүлэх, шинээр байгуулах, өргөтгөх хүнд, хөнгөн үйлдвэрийн газрын схемчилсэн байршил, хэмжээ хил заагийг зураглаж, холбогдох шийдэл тооцооллыг хийсэн байна.
- 9.2.22 Хот тосгон бусад суурины газраас бусад газарт шинээр байгуулах хүнд, хөнгөн үйлдвэрийн схемчилсэн байршил, хэмжээ хил заагийг зураглана.
- 9.2.23 Шинээр баригдах олон улсын болон улс, бүс, орон нутгийн чанартай төмөр зам, авто зам, эрчим хүч, цахилгаан, харилцаа холбооны шугам сүлжээ байгуулах газрын схемчилсэн байршил, хэмжээ хил заагийг зураглаж, цаашид хөгжих шийдэл, тооцооллыг хийсэн байна.
- 9.2.24 Газрын тос, байгалийн хий, ус дамжуулах хоолой, барилга байгууламж, тэдгээрийн зурвас газар, усан зам, нисэх буудлын газрын схемчилсэн байршил, хэмжээ, хил заагийг зураглаж, цаашид хөгжих шийдэл тооцооллыг хийсэн байна.
- 9.2.25 Ой, ус, биологийн төрөл зүйлийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх бүс нутгийн схемчилсэн байршил, хэмжээ, хил заагийг зураглаж, цаашид хөгжих шийдэл, тооцооллыг хийсэн байна.
- 9.2.26 Аймгийн хэмжээнд усны сан бүхий газар, усны эх үүсвэр, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зурвас газрын хамгаалалт,

ашиглалтын схемчилсэн байршил, хэмжээ, хил заагийг зураглаж, холбогдох шийдэл тооцооллыг хийсэн байна.

- 9.2.27 Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалах зорилгоор улс, орон нутгийн тусгай хэрэгцээнд авах газрын байршил, хэмжээ, хил заагийг зураглаж, цаашид хөгжих шийдэл, үндэслэл, тооцооллыг хийсэн байна.
- 9.2.28 Газрыг доройтлоос хамгаалах, ашиглалтаас чөлөөлөх, нөхөн сэргээх, сайжруулалт хийх газар нутгийн байршил, хэмжээ, хил заагийг зураглаж, холбогдох шийдэл, тооцооллыг хийсэн байна.
- 9.2.29 Амралт, рашаан сувилал, аялал жуулчлал, ан агнуурын бүс нутгийн байршил, хэмжээ, хил заагийг зураглаж, холбогдох шийдэл тооцооллыг хийсэн байна.
- 9.2.30 Аймаг, нийслэлийн хэмжээнд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулалт явуулах газрын бүс, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох газрын хэмжээ, байршил, хил заагийг төлөвлөсөн байна.
- 9.3. Засгийн газрын болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 жилээр боловсруулах бөгөөд аймгийн/нийслэлийн газрын алба 4 жил тутамд 1 удаа тодотгол хийх асуудлыг хариуцан зохион байгуулна. /Хавсралт 3/.

АРАВ. ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗУРАГ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 10.1. Ерөнхий төлөвлөгөөний зурган мэдээлэл нь Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан солбицол, өндөр, тусгагт тулгуурласан байх ба бүх төрлийн масштабтай суурь болон төлөвлөлтийн зургийг стандартын дагуу газарзүйн мэдээллийн системийн болон орон зайн мэдээллийн дэд бүтцийн программ хангамж, технологид бүрэн нийцсэн, сүлжээнд холбогдох боломжтой байдлаар боловсруулагдсан байна.
- 10.2. Ажлын үе шатуудад ашиглаж буй мэдээллийн суурь зураг нь орон зайн мэдээлэлд үндэслэсэн байна.
- 10.3. Төлөвлөлтийн тоон мэдээллийг холбогдох журам, зааврын дагуу боловсруулна.

- 10.4. Ерөнхий төлөвлөгөө боловсруулсны үр дүнд дараах баримт бичиг, зураг үйлдэгдэх ба тухайн орон нутгийн онцлогоос хамааран зургийн агуулга, төрөл өөрчлөгдөж болно. *Хүснэгт 30. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий*

төлөвлөгөөний үр дүнд гарах баримт бичиг, зургийн жагсаалт

№	Баримт бичгийн нэр	Тайлбар бичиг	Зургийн нэр	Зургийн масштаб
Газар ашиглалтын одоогийн байдал				
1	Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний одоогийн байдал	Тайлан, судалгаа тооцоо	Газар ашиглалтын одоогийн байдлын зураг	1:100000
2	Хүрээлэн буй орчны суурь судалгаа	Тайлан, судалгаа тооцоо	Гадаргын Усны зураг /гидрологи/	1:100000
			Хөрсний зураг	1:100000
			Ургамлын зураг	1:100000
			Ойн зураг	1:100000
			Уур амьсгалын зураг	1:100000
			Амьтны тархалтын зураг	1:100000
3	Геологийн суурь судалгаа	Тайлан, судалгаа тооцоо	Түүх, археологи, өв соёлын зураг	1:100000
			Геологийн тогтоцын зураг	1:100000
			Ашигт малтмалын зураг	1:100000
			Геоморфологийн зураг	1:100000
			Дөрөвдөгч хурдасын зураг	1:100000
			Инженер геологийн нөхцөлийн зураг	1:100000
4	Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ	Тайлан, судалгаа тооцоо	Гүний усны зураг /Гидрогеологи/	1:100000
			Тектоник болон шинэ тектоникийн зураг /чичирхийлэл/	1:100000
			1. Хөдөө аж ахуйн газар ашиглалт -Бэлчээр, хадлан, тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	1:100000
			2. Хот, суурины газар ашиглалт -сумын төв, багийн төв болон бусад суурин газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	1:5000-25000
			3. Зам, шугам, сүлжээний газар ашиглалт - улс, аймаг, сум, багийн чанартай зам болон сумын төвийн шугам, сүлжээний газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	1:5000-25000
			4. Ойн сан бүхий газар ашиглалт -аймгийн нутаг дэвсгэр дээрх ой болон суурин газар доторх ногоон байгууламжийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	1:100000

			5. Усны сан бүхий газар ашиглалт -аймгийн нутаг дэвсгэр дэх гол, горхи, булаг, шанд болон суурин газрын унд, ахуйн хэрэгцээний усны тохиромжтой байдлын үнэлгээний зураг	1:100000
			6. Тусгай хэрэгцээний газар ашиглалт -аймгийн нутаг дэвсгэр дэх тусгай хамгаалалттай болон тусгай хэрэгцээний газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	1:100000
Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө				
1	Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	Тайлан, судалгаа тооцоо	Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний нэгдсэн зураг	1:100 000
2	Хөдөө аж ахуйн газрын хэтийн төлөвлөгөө	Тайлан, судалгаа тооцоо	Бэлчээр зохион байгуулалтын хэтийн төлөвлөгөө Бэлчээрийн ачааллын зураг 4 улирлаар болон жилийн дунджаар Бэлчээрийн усан хангамжийн зураг Бэлчээрийн улирлын хуваарийн зураг Бэлчээрийн даацын зураг Бэлчээрийн даацын үнэлгээний зураг	1:100000 эсвэл 1:200000
		Тайлан, судалгаа тооцоо	Хадлан, тариалангийн газрын ашиглалт, хамгаалалтын хэтийн төлөвлөгөөний зураг	1:25000
3	Хот, тосгон, бусад суурины газрын хэтийн төлөвлөгөө	Тайлан, судалгаа тооцоо	Хот, суурин газрын ашиглалтын хэтийн төлөвлөгөөний зураг	1:10000, 1:5000, 1:1000
			Хот, суурингийн төвийн суурьшлын бүсийн тэг гортигийн зураг	1:1000
			Хүн амын суурьшил ба нягтралын зураг	1:2000
			Сум дундын бүлэг суурингийн тогтолцооны зураг	1:50000
4	Зам, шугам, сүлжээний газрын хэтийн төлөвлөгөө	Тайлан, судалгаа тооцоо	Зам, шугам, сүлжээний газрын ашиглалт, хамгаалалтын хэтийн төлөвлөгөөний зураг	1:5000, 1:10000
5	Ой болон усны сан бүхий газрын хэтийн төлөвлөгөө	Тайлан, судалгаа тооцоо	Ой болон усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын хэтийн төлөвлөгөөний зураг	1:200000, 1:100000, 1:50000

6	Аялал жуулчлалын бүс газрын хэтийн төлөвлөгөө	Тайлан, судалгаа тооцоо	Аялал жуулчлалын бүсийн ашиглалт, хамгаалалтын хэтийн төлөвлөгөөний зураг	1:200000, 1:100000, 1:50000
7	Тусгай хамгаалалттай газрын хэтийн төлөвлөгөө	Тайлан, судалгаа тооцоо	Тусгай хамгаалалттай газрын ашиглалт, хамгаалалтын хэтийн төлөвлөгөөний зураг	1:100000, 1:50000, 1:25000 гэх мэт.

АРВАН НЭГ. ГАЗРЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙГ ХҮРГҮҮЛЭХ, ДҮГНЭЛТ ГАРГУУЛАХ

- 11.1 Ажил гүйцэтгэгч ерөнхий төлөвлөгөөний төслийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.
- 11.2 Ажил гүйцэтгэгч нь Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлөөр ерөнхий төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж, зөвлөлөөс гаргасан саналыг харгалзан төслийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дүгнэлт гаргана.
- 11.3. Дүгнэлтийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага албан бичгээр ажил гүйцэтгэгчид болон аймаг, нийслэлийн газрын албанд хуулийн хугацаанд хүргүүлнэ.

АРВАН ХОЁР. ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЖ, БАТЛУУЛАХ

- 12.1 Ажил гүйцэтгэгч иргэд, олон нийтийн саналыг тусган ерөнхий төлөвлөгөөний анхдагч хувилбарыг боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлж, санал авна.
- 12.2. Ерөнхий төлөвлөгөөний эцсийн хувилбарт аймаг, нийслэлийн иргэдийн Тэргүүлэгчдийн Хурлын санал, иргэд, олон нийтийн санал, Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг тус тус тусгаж аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлнэ.
- 12.3. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэж, шийдвэрлэнэ.

АРВАН ГУРАВ. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД БАТЛАГДСАН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БҮРТГҮҮЛЭХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ

- 13.1 Ажил гүйцэтгэгч нь аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан төлөвлөгөөний иж бүрэн тайланг тоон болон хэвлэмэл байдлаар аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, нийслэлийн газрын албанд тус бүр 3 хувийг, Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 2 хувийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хүлээлгэн өгнө. Ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг боловсруулахдаа MNS 5140-2:2011 стандартыг баримтална.
- 13.2 Ерөнхий төлөвлөгөөг газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн санд бүртгэх асуудлыг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журмаар зохицуулна.
- 13.3 Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн санд бүртгэгдсэний дараа аймаг, нийслэлийн газрын алба ерөнхий төлөвлөгөөг иргэд, олон нийтэд сурталчлах, хэрэгжилтийг хангах, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болон нийслэл, дүүрэг, сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд холбогдох арга хэмжээнүүдийг тусгах ажлыг тус тус зохион байгуулна.

АРВАН ДӨРӨВ. ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

- 14.1 Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж, биелэлтийг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.
- 14.2 Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний нэгдсэн мэдээллийн санг удирдаж, хяналт шинжилгээний ажлыг хариуцна.

-----oOo-----

Хавсралт 1

ЗӨВШӨӨРӨВ

БАТЛАВ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА

..... АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА

Ц.ГАНХҮҮ

..... АЙМАГ /НИЙСЛЭЛ/-ИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВРЫН ЗАГВАР

20... оны...сарын ...-ны өдөр

Дугаар

ХЯНАСАН:

ЗӨВШӨӨРСӨН:

БОЛОВСРУУЛСАН:

Хавсралт 2

Аймаг, нийслэлийн хөгжлийн дүн шинжилгээний загвар

Үндсэн мэдээлэл		
Нутаг дэвсгэр: 5,5 км ²	Хүн ам: 17399	Хүн амын нягтрал: 3,14 хүн/км ²
Хүн амын жилийн дундаж өсөлт: (сүүлийн 10 жилээр) 0,57 хувь (1995-2005), 2,73 хувь (2005-2017) гэх мэт.	Малын тоо, толгой, төрлөөр: Бүгд 427.46, адуу 20.59, үхэр 14, тэмээ 1.06, хонь 208.08, ямаа 183.72	
ДНБ, салбараар: ХАА 24 хувь, аж үйлдвэр, барилга 38 хувь, үйлчилгээ 38 хувь гэх мэт.		
Газар ашиглалт: Ойн сан 0 хувь, Тариалангийн талбай 38,7 га (үр тариа 0 га, малын тэжээл 4,3 га, 2017 оны байдлаар) гэх мэт.		
Одоогийн байдал		

Газар зүйн нөхцөл байдал: Тал хээр нутагтай, газар нутгийн 80 хувийг бэлчээрийн зориулалтаар ашиглах боломжтой, ойн сангүй. Эх газрын уур амьсгалтай, жилийн дундаж температурын хэлбэлзэл өндөр: +37-оос -37 градус Жилийн дундаж температур: 200-250 мм Далайн түвшнээс дээш: 1000-1200 м өргөгдсөн Говьсүмбэр аймагт нутагшдаг ан амьтан: Цагаан зээр гэх мэт.	Нийгмийн асуудлууд: Ажиллах хүчний оролцооны түвшин: 52.4 хувь (20-р байр) Дундаж цалингийн хэмжээ өндөр буюу 800000 төгрөг (2-р байр) Ажилгүйдлийн түвшин өндөр буюу 18.1 хувь (20-р байр) Төрийн албан хаагчдын нийт ажиллагсдад эзлэх хувь хамгийн өндөр буюу 24.4 хувь гэх мэт.	
Эдийн засаг: Төсөв зарцуулалтын харьцаа өндөр буюу 106.5 хувь Бүсийн түвшинд 1 хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 4901000 (2016), 7-р байр Эдийн засгийн идэвхитэй хүн амын түвшин: 37.1 хувь Ажил эрхлэлтийн түвшин: 82.3 хувь, 20-р байр Бүс нутгийн ДНБ-д эзлэх аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 55 хувь, 3-р байр гэх мэт.	Дэд бүтэц: Зам тээврийн дэд бүтэц харьцангуй хөгжсөн гэх мэт.	
Тулгарч буй бэрхшээл		
Газар нутгийн хэмжээ бага Эдийн засаг жижиг, төрөлжөөгүй Үр тарианы үйлдвэрлэлийн хэмжээ бага, мал аж ахуй голлосон гэх мэт.	Дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ хангалтгүй Ашигт малтмалын нөөцөө олборлож, эдийн засгийн эргэлтэд оруулаагүй гэх мэт.	
Хөгжлийн хэтийн зорилт		
УБ- Замын Үүд чиглэлийн зам дагуу байрласан Чойр хотын байршлыг ашиглаж, хотыг хөгжүүлэх Ашигт малтмалыг боловсруулах зорилгоор чөлөөт бүсийг ашиглах гэх мэт.	Улаанбаатар хотыг мах, махан бүтээгдэхүүнийг хангах эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх гэх мэт.	
Газар ашиглалтын бодлогын ерөнхий бүсчлэл, түүнд тавигдах шаардлага, дэглэм, горим (зөвшөөрөгдөх, хязгаарлагдах болон хориглох газар ашиглалтын төрлүүдийг агуулсан байна.)		
Газар ашиглалтын бодлогын ерөнхий бүсчлэл: Уламжлалт мал аж ахуйн ерөнхий бүс гэх мэт.	Тавигдах шаардлага, дэглэм, горим: Уул уурхай, хүнд үйлдвэр барьж байгуулахыг хориглох гэх мэт.	Үр ашиг: Одоогийн ханшаар мөнгөн дүнгээр илэрхийлсэн байх
Газар ашиглалтын хөгжлийн чиг хандлагын хувилбарууд, баримтлах бодлого		

Малын бэлчээр, тэжээлийн газрыг эзэмшүүлэх замаар түүний ашиглалтыг сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх Хөдөөгийн усан хангамж, хүрэлцээг сайжруулах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
Мал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах нөхцөлийг бүрдүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг 2020 онд 2016 оны үзүүлэлтээс 2,5 хувиар нэмэгдүүлэх гэх мэт.
Үр ашгийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн төсөөлөл
Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээс олох ашиг шим төгрөг гэх мэт.

Хавсралт 3

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний загвар

БАТЛАВ

..... аймгийн/нийслэлийн ИТХ-ын 20.... оны дугаар тогтоолын хавсралт

Аймаг/нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Гарах үр дүн			Төсвийн төсөөлөл /сая төг/	Эх үүсвэр	Хариуцах эзэн
			Шалгуур үзүүлэлт /хэмжих нэгж/	Суурь үзүүлэлт	Хугацааны эцэст			
0	1	2	3	4	5	6	7	8
13	Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа /Хянан баталгаа, байрзүйн зураг хийх, хэсэгчилсэн төлөвлөгөө хийх гэх мэт/	Төлөвлөлтийн хугацаанд	Төлөвлөлтийн хүрээнд хүрэх үр дүнгийн	Одоогийн нөхцөл байдлын үзүүлэлт				ЗДТГ, Газрын алба,
14	Нэгдмэл сангийн үндсэн ангилал хооронд шилжүүлэх арга хэмжээ /хот суурины газрыг тэлэх, шинээр үүсгэх, шинээр атар газрыг эргэлтэд оруулах, зам шугам сүлжээний газрыг бий зорилгоор газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэх санал гаргах гэх мэт/	Төлөвлөлтийн хугацаанд жил бүр гэх мэт	Ангилалд шилжүүлэх газрын хэмжээ, га					

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэг-жүүлэх хугацаа	Гарах үр дүн			Төсвийн төсөөлөл /сая төг/	Эх үүсвэр	Хариуцах эзэн
			Шалгуур үзүүлэлт /хэмжих нэгж/	Суурь үзүүлэлт	Хугацаа-ны эцэст			
15	Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой аймаг/нийслэлийн ИТХ, Засаг даргын зүгээс гаргах журам, бодлого шийдвэрийн баримт бичгүүд /бэлчээр ашиглах, суурин болон бэлчээрийн мал аж ахуйн бүсэд мөрдөгдөх дэглэм, горимыг тогтоосон журам боловсруулж батлуулах гэх мэт/							ЗДТГ, Газрын алба, ХАА-н газар, Байгаль орчны газар гэх мэт
16	Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой аймаг/нийслэлийн ИТХ, Засаг даргын зүгээс хил зааг, бүс нутаг тогтоох шийдвэр гаргах /Тухайн аймаг/ нийслэлийн хил зааг, улирлын бэлчээр, бэлчээрийн болон суурин мал маллагааны бүс нутаг, тууврын зам, дамжин өнгөрөх бэлчээрийн хил зааг, хуваарийг батлах/							

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэг-жүүлэх хугацаа	Гарах үр дүн			Төсвийн төсөөлөл /сая төг/	Эх үүсвэр	Хариуцах эзэн
			Шалгуур үзүүлэлт / хэмжих нэгж/	Суурь үзүүлэлт	Хугацаа-ны эцэст			
17	Газрыг нөхөн, сэргээх, хамгаалах арга хэмжээ /Бэлчээр, хадлангийн өнжөөж, амраах, сайжруулах, сэлгэх арга хэмжээ, хортон мэрэгчтэй тэмцэх, элэгдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх гэх мэт/		Шалгуур үзүүлэлтийг төлөв байдал чанарыг тодорхойлох аргачлал, сэргэх чадавхийн дагуу					
18	Аймаг дундын отрын нөөц нутаг бий болгох /Шинээр отрын нөөц нутаг бий болгох, орон нутгийн тусгай хэрэгцээнд авах/							
19	Газрыг аймаг, нийслэлийн орон нутгийн тусгай хэрэгцээнд авах							
20	Усжуулах бэлчээрийн газар /Шинээр худаг гаргах, засварлах, хөв цөөрөм байгуулах/							ГЭХ МЭТ.

БАГ, ХОРООНЫ ХИЛИЙН ЗААГИЙГ ТОДОРХОЙЛОХ, БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН АРГАЧЛАЛ



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/249

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай


"Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.21 дэх заалт, тус Газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хурлын 19 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Баг, хорооны хилийн заагийг тодорхойлох, баталгаажуулах аргачлал"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү аргачлалыг сум, дүүргийн баг, хорооны хилийн заагийг тодорхойлох, баталгаажуулахад мөрдөж ажиллахыг аймгуудын Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газрын алба, сумдын Газрын даамал нарт үүрэг болгосугай.

3. Аргачлалыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Газар зохион байгуулалтын хэлтэс /Ж.Батсайхан/-т даалгасугай.

ДАРГА



ЦТАНХҮҮ

08 00869

НЭГ. Үндэслэл:

- 1.1 Энэхүү аргачлалыг Монгол улсын үндсэн хуулийн 57.1 дэхь заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3.4, 4.2. дахь заалт, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ийг тус тус үндэслэн боловсруулав.

ХОЁР. Зорилго

- 2.1. Баг, хорооны хилийн заагийг тодорхойлох, аргачлалын зорилго нь сумын баг, дүүргийн хорооны хилийн заагийг газар дээр нь тодорхойлон газар зүйн мэдээллийн системийн програм хангамж ашиглан боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу баталгаажуулан нэгдсэн мэдээллийн санд бүртгэж иргэд, олон нийтийг мэдээллээр хангаж ажиллах

ГУРАВ. Баг, хорооны хилийн заагийг тодорхойлох

- 3.1. Баг, хорооны хилийн заагийг газар дээр нь ажиллаж тодорхойлох ажлын хэсгийг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгуулна. Ажлын хэсгийг сум, дүүргийн Засаг даргаар ахлуулж, бүрэлдэхүүнд нь баг, хорооны Засаг дарга, дүүргийн Газрын албаны мэргэжилтэн, сумдын Газрын даамал, байгаль орчны байцаагч, иргэдийн төлөөлөгчийг оруулна.
- 3.2. Ажлын хэсгийн тодорхойлсон хилийн заагийг баг, хорооны Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн санал авч сум, дүүргийн Засаг даргад өргөн барина.
- 3.3. Сум, дүүргийн Засаг дарга нь саналыг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн санал авч аймаг, нийслэлийн Засаг даргад өргөн барина.
- 3.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь баг, хорооны хилийн заагийн саналыг аймаг, нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулна.
- 3.5. Аймаг, нийслэлийн ИТХ-аар батлагдсан баг, хорооны хилийн заагийн мэдээллийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлнэ.

ДӨРӨВ. Баг, хорооны хилийн заагийг тодорхойлох, баталгаажуулах ажлын үе шат.

Баг, хорооны хилийн заагийг тодорхойлох, баталгаажуулах ажлыг дараах үе шатуудаар хийж гүйцэтгэнэ.

1. Суурин судалгаа
2. Хэмжилт тодруулалт
3. Боловсруулалт, баталгаажуулалт
4. Нэгдсэн мэдээллийн санд бүртгэх
5. Хэрэгжилт, хяналт

4.1. Суурин судалгааны ажил

4.1.1. Энэхүү үе шатанд баг, хорооны хилийн заагийг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсэг нь баг, хорооны хилийн заагийн талаарх урьд онуудад батлагдаж байсан тогтоол, шийдвэр, зураг, солбицол зэрэг мэдээ материал байгаа эсэх судалгааг боловсруулж дараах баримт бичиг, мэдээ, материалыг цуглуулна. Үүнд:

- а. Тухайн баг, хороог байгуулсан тогтоол, шийдвэр.
- б. Мөрдөгдөж байгаа баг, хорооны хилийн заагийг хэрхэн тодорхойлсон эсэх талаарх мэдээ, материал.
- в. Гадаадын төсөл хөтөлбөрөөр хийгдэж байсан баг, хорооны хил заагийн талаарх зураг, мэдээлэл, солбицол
- г. Одоо байгаа баг, хорооны хилийн заагийн зураг, Shp файл.
- д. Хэрэв багийн хилийн заагийг огт баталгаажуулж байгаагүй бол энэ талаар дүгнэлтэд дэлгэрэнгүй тайлбарыг бичнэ.

4.1.2. Цуглуулсан мэдээ, материалд үндэслэн дүн шинжилгээ хийж, дүгнэлт бичнэ. Дүгнэлтэд дараах асуудлыг тусгана.

- а. Сум, дүүргийн товч танилцуулга
- б. Баг, хорооны талаарх танилцуулга /хэдэн баг, хэсэгтэй, газар нутгийн хэмжээ, хүн ам, нийгэм, эдийн засаг, мал сүргийн тоо, толгой гэх зэрэг/
- в. Тухайн баг, хорооны хилийн заагийг баталсан ИТХ-ын тогтоол, шийдвэр гарсан эсэх
- г. Баталсан тогтоол нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон зөрчил, маргаангүй байгаа талаар
- д. Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа сум, дүүргийн хилийн цэсийн шугамтай давхцаж байгаа эсэх
- е. Хил залгаа баг, хороодын нутаг дэвсгэртэй нэг шугамд хил залгаж байгаа эсэх

4.2. Хэмжилт, тодруулалт

4.2.1 Бэлтгэл үе шатанд цуглуулсан мэдээ, материалдаа дүгнэлт хийсний үндсэн дээр өмнө нь огт баг, хорооны хилийн заагийг тодорхойлж байгаагүй болон газар нутгийн давхцал үүссэн, өөр сум дүүрэг, баг хорооны хилтэй зөрсөн хилийн заагийг шинэчлэх, өөрчлөх, тодотгох зорилгоор хээрийн хэмжилт тодруулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ. Хээрийн хэмжилт судалгааны ажлыг хийж гүйцэтгэхдээ дараах бэлтгэл ажлыг хангана. Үүнд:

- а. Одоо мөрдөгдөж байгаа хилийн заагийн зургийг харуулсан 1:100000 /Хүн амын нягтаршил ихтэй төв, суурин газарт 1:1000/ масштабтай ажлын зураг;
 - б. Зурагт зурж тэмдэглэх улаан болон хар өнгийн тод гаргацтай бал;
 - в. Байршил тогтоох багаж /гар GPS, 2 долгионы GPS /Trimble/ , батарей, дагалдах хэрэгсэл, /;
 - г. Эргэлтийн цэгийг бичих хүснэгт /Хавсралт-1/
 - д. Фото зургийн аппарат /батарей, цэнэглэгч, дагалдах хэрэгсэл/;
 - е. Тэмдэглэл, протокол хөтлөх загвар хүснэгт /Хавсралт-2/
- 4.2.2 Ажлын хэсэг нь хээрийн хэмжилтээр ажиллахдаа хил залгаа баг, хорооны Засаг дарга, ИНХ-ын дарга, малчид, ард иргэдийн төлөөллийг байлцуулж тэмдэглэл, протокол хөтлөнө.
- 4.2.3. Хил заагийн эргэлтийн цэгийг сонгохдоо байгалийн хөдлөшгүй объектууд болох уулын орой, даваа, гүвээ, худаг, булаг шанд, геодезийн хатуу цэг, тоот өндөрлөг гэх зэргээр сонгон авна.
- 4.2.4. Баг, хорооны хил нь сум, дүүргийн хилийн цэстэй давхцаж байгаа хэсэгт эргэлтийн цэгийн мэдээллийг сум, дүүргийн хилийн цэсээр авна. Сум, дүүргийн хилийн цэс нь УИХ-аас албан ёсны тогтоол, зарлигаар баталгаажсан байдаг тул баг хорооны хилийн зааг нь сум, дүүргийн хилийн цэсээр хязгаарлагдана.
- 4.2.5. Хэмжилт, тодруулалтын ажлыг гүйцэтгэхдээ байршил тодорхойлох багаж буюу гар GPS-ыг ашиглах бөгөөд 4-өөс багагүй хиймэл дагуулын мэдээ бүртгэгдсэний дараагаар хэмжилтийн алдаа ± 3 метрээс ихгүй үед солбилцлыг авна.
- 4.2.6. Солбилцолыг гар GPS-д хадгалах бөгөөд давхар хэмжилтийн тэмдэглэл хөтлөх хүснэгтэд гаргацтай тод бичиж тэмдэглэнэ. Хэмжилтийг тэмдэглэхдээ нутаг дэвсгэрийн баруун дээд цэгийг эхлэл цэг гэж үзэн нар зөв тэмдэглэлийг хөтөлнө.
- 4.2.7. Эргэлтийн цэгийг илэрхийлж буй объектуудыг хэмжихдээ төв цэг дээр хийж гүйцэтгэхийг хичээнэ. Жишээ нь: Уул, даваа, гүвээний чулуун овоолгоны гол цэг дээр, худаг булаг, шандны амсар болон эх ундаргын

дээр, мод, шон зэргийн ёроолд гэх мэт. Уулархаг нутаг болон, Хангайн бүс нутгуудаар уулын оройд хүрэх боломжгүй бол 1:100000 масштабтай байр зүйн зурагт тэмдэглэж ArcGis програм ашиглан эргэлтийн цэгийн солбилцолыг авна. Ингэхдээ байр зүйн зургийн газар зүйн холболтыг нарийвчлалтай холбосон байна. Тухайн цэгийн солбилцолыг авахдаа 1:300 масштаб хүртэл томруулсны /zoom/ дараа төв цэг дээр курсорыг байршуулж солбилцол байрлах хэсгээс тэмдэглэн авч нэгтгэнэ.

4.2.8. Зурагт тэмдэглэгдсэн зарим эргэлтийн цэг нь газар дээрээ ямар нэгэн объектгүй бол тухайн цэгийг мал, амьтанд саад болхооргүй газар дээр нь найдвартай хөдлөшгүй байдлаар цементэн суурьтай шон босгох, пайз хатгах, чулуун овоо босгох зэргээр тэмдэгжүүлж болно.

4.3 Боловсруулалт, баталгаажуулалт

Энэ үе шатанд хээрийн хэмжилт тодруулалтын ажлын үр дүнг ArcGis програм хангамж ашиглаж баг, хорооны хилийн заагийг зураглан, баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

4.3.1 Боловсруулалт:

- а. Хээрийн хэмжилтийн үр дүнг гар Gps болон хэмжилтийн солбилцол тэмдэглэсэн хүснэгтээс Word excel програмд шивнэ.
- б. Эргэлтийн цэгүүдийг Arcgis програмд оруулж баг, хороо тус бүрийн хилийг полигон үүсгэж эргэлтийн цэгүүдийг холбож зураглана.
- в. Ингэхдээ сум, дүүргийн хилийн цэсийн мэдээллийг /shp/ давхар оруулж хэмжилтийн алдаа /сум, дүүргийн батлагдсан хилээс зөрүүтэй эсэх/-г нарийвчлан шалгана.
- г. Шинээр зурагласан баг, хорооны хилийн заагийн мэдээллийг ArcGis програмын хүснэгтэн мэдээнд оруулж хэвлэлийн эх бэлтгэн баг, хорооны хил заагийн зургийг бэлэн болгоно.

4.3.2. Баталгаажуулалт

- а. Боловсруулалтын үе шатнаас бэлэн болсон баг, хорооны хилийн заагийг тус аргачлалын 3.2 дах заалтын дагуу баг, хорооны Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн оршин суугч, ард иргэд, малчидад танилцуулан санал авна.
- б. Баг, хорооны ИНХ-аар хэлэлцэн саналыг аргачлалын 3.3 дахь заалтын дагуу сум, дүүргийн ИТХ-аар хэлэлцүүлнэ.
- в. Аймаг, нийслэлийн ИТХ-аар батлуулах ажлыг аргачлалын 3.4 хэсгийн дагуу зохион байгуулж ажиллах бөгөөд баг хорооны хилийн заагийг батлуулахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлэн хэлэлцүүлнэ. Үүнд:

- Баг, хорооны хилийн заагийг батлуулах болсон үндэслэл.
 - Баг, хорооны ИНХ-аар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, тогтоол.
 - Сум, дүүргийн ИТХ-ын тогтоол, шийдвэр.
 - Баг, хорооны хилийн заагийн зураглсан газрын зураг.
 - Баг хорооны хилийн заагийн эргэлтийн цэгийн координат /хүснэгтээр/.
 - Бусад шаардлагатай мэдээ, материал.
- г. Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 4.2 дахь заалтад “Баг, хороо байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.” гэж заасны дагуу ИТХ-аас албан ёсны тогтоол гаргуулан баталгаажуулна.
- д. Хэрэв өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарсан бол энэхүү аргачлалын дагуу ажлыг үе шаттайгаар зохион байгуулж ажиллана..

4.4. Нэгдсэн мэдээллийн санд бүртгэх

4.4.1. Орон нутгийн газрын асуудал эрхэлсэн байгууллага нь баг, хорооны хилийн заагийг баталсан аймаг, нийслэлийн ИТХ-ын тогтоолыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад /ГЗБГЗЗГ/ дараах материалыг бүрдүүлэн 30 хоногийн дотор хүргүүлнэ.

- а. Тогтоолын эх хувь
- б. Батлагдсан солбицол
- в. Баг, хорооны батлагдсан хил заагийн зураг
- г. Баг, хорооны хилийн заагийн Shp. Файл
- д. Бусад холбогдох баримт бичгүүдийг бүрдүүлэн хүргүүлнэ.

4.4.2. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ирүүлсэн материалд хяналт хийж улсын хэмжээний хилийн цэсийн мэдээллийн санд бүртгэнэ.

4.4.3. Бүртгэсэн тухай хариуг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 14 хоногийн дотор хүргүүлнэ.

4.5. Хэрэгжилт, хяналт

4.5.1. Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Нийслэлийн газрын алба болон сумын газрын даамал, дүүргийн газар зохион байгуулагч нар нь батлагдсан баг, хорооны хил заагийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах бөгөөд орон нутгийн удирдлага, иргэд, малчид, ард иргэдэд үнэн зөв мэдээллээр хангаж ажиллана.

4.5.2. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улсын хэмжээнд хилийн цэсийн нэгдсэн мэдээллийн санг хөтөлж төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэд, ААН-ийг мэдээллээр хангаж ажиллана.

4.5.3. Баг, хорооны хилийн заагийг тодорхойлох, баталгаажуулах ажилд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгах ба гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийн тусламжтайгаар гүйцэтгэж болно.

4.5.4. Батлагдсан баг, хорооны хилийн заагт оршин суугч, газар эзэмшигч, ашиглагч, малчид, иргэдийн дунд бэлчээр, хадлангийн болон газар ашиглалтаас үүссэн зөрчил, маргааныг өмнөх жилүүдэд хэрхэн ашиглаж байсан тэр хэвээр тохиролцон ашиглана.

- оОо -

Хавсралт 1

Хэмжилтийн цэгийн хүснэгт

.....аймгийн.....сум, дүүргийнбаг, хорооны
..... цэг

№	GPS-дэх дугаар	Эргэлтийн цэгийн нэр	Хэддэх эргэлтийн цэг болох	Газрын нэр	Байршлын координат						Эргэлтийн цэгийг илэрхийлж буй объект /тайлбар/
					Өргөрөг N			Уртраг E			
					Гр°	Мн'	Сек'	Гр°	Мн'	Сек'	
1											
2											
3											

Хэмжилт хийсэн хүний нэр...../

/

Хавсралт 2

**.....сум, дүүргийн баг, хорооны хилийн заагийг
тодорхойлсон тухай хурлын протокол**

..... оны сарынөдөр цаг

Хуралд: Ажлын хэсгийн гишүүд:

.....
.....

**Хэлэлцэх асуудал: Сумын багийн хилийн заагийг газар дээр нь тодотгосон
ажлын тухай**

.....
.....
.....

Асуулт, хариулт

.....
.....
.....

Санал:

.....
.....
.....

Шийдвэрлэсэн нь:

.....
.....
.....

Солбицлыг зөвшөөрсөн:

.....
.....
.....

... оны ... сарын ... өдрийн ... цагт дуусав.

ХИЛИЙН ЦЭСИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЗААВАР



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/209

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хилийн цэсийн маргаан шийдвэрлэх заавар"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргүүдийн Газрын алба, сумдын Газрын даамал нарт үүрэг болгосугай.
3. Зааврыг хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Газар зохион байгуулалтын хэлтэс /Ж.Батсайхан/-т даалгасугай.

ДАРГА



Д.ГАНХҮҮ

08 181050

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Тус зааврын зорилго нь аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд үүссэн хилийн цэсийн маргаанд дүн шинжилгээ хийж бодит болон бодит бус маргааныг ангилан тодорхойлох, зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай бодит маргааныг хууль, журмын дагуу саналыг боловсруулж холбогдох байгууллагад уламжлах, бодит бус маргааныг орон нутгийн удирдлага, малчид, иргэдэд үнэн зөв мэдээллийг хүргэж, ойлголтын зөрүүг шийдвэрлэхэд оршино.

ХОЁР. ХИЛИЙН ЦЭСИЙН МАРГААНЫГ ТОДОРХОЙЛОХ

2.1. Хилийн цэсийн маргааныг үүсэж буй шалтгаанаас нь хамааруулан бодит болон бодит бус гэж хоёр ангилна. Үүнд:

2.1.1. “Бодит маргаан” гэж: Хилийн цэсийн зарлиг, тогтоол, газар усны нэрийн алдаанаас үүссэн буюу зарлиг, тогтоолд өөрчлөлт оруулахаас өөрөөр шийдвэрлэх боломжгүй нь нотлогдсон маргааныг ойлгоно.

2.1.2. “Бодит бус маргаан” гэж: Сум, дүүргийн удирдлага, иргэд, олон нийт нь хилийн цэсийн талаарх нарийвчилсан мэдээлэл дутмаг байдгаас газар нутгаа баримжаалах, таамаглах, зурган мэдээлэл зөрөх зэрэг ойлголтын зөрүү үүссэн буюу хилийн цэсийн зарлиг, тогтоолд өөрчлөлт оруулах шаардлагагүйгээр олон нийтэд хилийн цэсийн үнэн бодит мэдээллийг тайлбарлан таниулж мөрдүүлснээр шийдвэрлэгдэх маргааныг ойлгоно.

2.2. Бодит маргаан нь дараах шалтгаануудаас үүснэ. Үүнд:

2.2.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг шинэчлэх, өөрчлөх шийдвэр гаргахдаа хил залгаа сум, дүүргийн хилийн цэсийг харилцан шинэчлээгүй, хуучин тогтоолыг нь хүчингүй болгоогүй, алдаатай шийдвэр гарснаас үүссэн маргаан;

2.2.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тодорхойлохдоо нэг сумын нутаг дэвсгэрт хоёр сумын төвийг оруулж хувиарласан маргаан;

2.2.3. 1968 оны 1:100000 масштабтай байр зүйн зурагт газар усны нэр алдаатай тэмдэглэгдсэн маргаан/зөвхөн алдаатай тэмдэглэгдсэн нь нотлогдсон тохиолдолд/;

2.2.4. Суурин газрын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын нягтралаас үүдэн зэргэлдээх сум, дүүргийн нутаг дэвсгэрт суурьшсан маргаан;

2.3. Бодит бус маргаан нь дараах шалтгаануудаас үүснэ. Үүнд:

2.3.1. Хилийн цэсийг баталсан, өөрчилсөн, шинэчилсэн зарлиг, тогтоол

- гарах бүрт сум, дүүргийн удирдлага, малчид, иргэдэд сурталчлах, таниулах, мөрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаагүйн улмаас малчид, иргэд өөрсдийн нутаглаж байсан газар нутгаар баримжаалах, хил заагаа таамаглах зэргээс үүссэн маргаан;
- 2.3.2. Улсын Их Хурал /УИХ/-аас баталсан газар усны нэрийн зураг болон хилийн цэс баталсан зарлиг, тогтоолд тэмдэглэгдсэн газар усны нэрүүдийг малчид, иргэд буруу нэрлэж заншсан маргаан;
- 2.3.3. Монгол Улсын малын тоо толгой өсөж бэлчээрийн даац хэтэрч, газар нутгийн эрэлт хэрэгцээ ихэссэнтэй холбоотойгоор үүссэн маргаан;
- 2.3.4. Хилийн цэсийн эргэлтийн цэгийг газар дээр нь тэмдэгжүүлэхдээ шон №1, шон №6 гэх мэтээр дугаарлан тэмдэгжүүлсэн боловч тэдгээр шонгууд нь устаж үгүй болсноос үүссэн маргаан / ихэвчлэн тариалангийн бүс нутаг, зарим сум, дүүрэгт/;
- 2.3.5. Сум, дүүргийн засаг дарга нарт хадгалагдаж байдаг “Газар эдэлбэрийн зураг”-ын алдаатай байдлаас үүдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зарлиг, тогтоолоос зөрсөн маргаан;
- 2.3.6. Хадлан, тариалангийн газрын хэрэгцээ, шаардлага ихэссэнтэй холбоотойгоор газар нутаг булаацалдахь маргаан;
- 2.3.7. Батлагдсан зарлиг, тогтоолыг үгүйсгэх, буруу ойлгосноос үүссэн маргаан;
- 2.3.8. Дур мэдэн сум, дүүргийн хилийн цэсийг тэлэх, хуваах, нэгтгэх санал гаргаснаас үүссэн маргаан;
- 2.3.9. Бусад;

ГУРАВ. ХИЛИЙН ЦЭСИЙН МАРГААНЫГ БҮРТГЭХ

- 3.1. Аймаг, нийслэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь нийт сум, дүүргийн хэмжээнд, Сум, дүүргийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь өөрийн сум, дүүргийн хэмжээнд одоо байгаа болон шинээр үүсч байгаа маргааныг энэ зааврын хавсралтад заасан хүснэгтийн дагуу бүртгэлжүүлнэ. Бүртгэхдээ тухайн маргаан үүсгэж буй талуудаас дараах материалыг бүрэн хангасан өргөдлийг албан ёсоор гаргуулж авна. Үүнд:
- 3.1.1. Хилийн цэсийн маргаан үүсэх болсон шалтгааныг дэлгэрэнгүй тайлбарласан өргөдөл;
- 3.1.2. Хилийн цэсийн маргаан үүссэн бүс нутгийн тойм зураг;
- 3.1.3. Хэрэв нэгж талбар болон худаг, уст цэг гэх зэрэг тодорхой объектуудын байршлаас үүдэн маргаж байгаа бол тэдгээрийн солбицол. Тухайн солбицлыг байршил тодорхойлох багажаар /

GPS/ UTM тусгагт хэмжсэн байна. /Энэ нь маргааныг нарийвчлан шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой/;

- 3.2. Ирүүлсэн өргөдлийг хянаж үзэн тус зааврын 2.1 дэх хэсэгт заасан аль төрлийн маргаанд хамаарах эсэхийг Газар зохион байгуулалтын систем болон Газрын кадастрын мэдээллийн санд суурилсан “Хилийн цэсийн мэдээллийн сан”-д шалгаж тодорхойлно.
- 3.3. “Хилийн цэсийн мэдээллийн сан” нь өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах, маргааныг хянах, шийдвэрлэх санал боловсруулах зорилгоор дараах мэдээллүүдийг агуулсан байна.
 - 3.3.1. Хилийн цэсийн эргэлтийн цэгийн тоон мэдээлэл /Shp файл/;
 - 3.3.2. Эргэлтийн цэгүүдийг холбосон хилийн шугамын тоон мэдээлэл / Shp файл/;
 - 3.3.3. 1:100000-ны масштабтай байр зүйн зураг;
 - 3.3.4. 1:25000-ны масштабтай байр зүйн тоон зураг;
- 3.4. Дараах архивын баримт материалыг бүрдүүлж мэдээллийн сантай хамт үйл ажиллагаанд ашиглана. Үүнд:
 - 3.4.1. Тухайн сум, дүүргийн хилийн цэсийн хамгийн сүүлд батлагдсан буюу одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зарлиг, тогтоолын хуулбар;
 - 3.4.2. Газар усны нэрийн зураг;
 - 3.4.3. Шаардлагатай тохиолдолд 1959 он болон 1975 оны Аж ахуй хоорондын газар зохион байгуулалтын ажлын баримт материал;
- 3.5. Дээрх мэдээллүүдийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгээр хандан авна.

ДӨРӨВ. СУМ, ДҮҮРГИЙН ХИЛИЙН ЦЭСИЙГ ШАЛГАХ

- 4.1. Хилийн цэсийн тоон мэдээллийг архивын баримт бичигтэй тулгаж шалгах.
 - 4.1.1. Хилийн цэсийн эргэлтийн цэгийг энэ зааврын 3.4.1. дахь хэсэгт заасан зарлиг, тогтоолыг 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн газар усны нэр, тоот өндөрлөгийн дугаар, голын голдирол, уулын орой гэх зэрэг эргэлтийн цэгүүдийн тэмдэглэлийг зарлиг, тогтоолоор баталсан нэршилтэй таарч байгаа эсэхийг нарийвчлан шалгана. Мөн газрын кадастрын мэдээллийн сангийн програм хангамжийн агаар, сансрын зурагтай давхардуулан нарийвчлан шалгаж болно.
 - 4.1.2. Хилийн шугамыг агаар, сансрын зурагтай давхардуулан шалгах үед зөвхөн голын голдирлоор, жалгыг дагаж гэх мэт чиглүүэн

заасан хилийн шугам нь агаар, сансарын зургаас өөрөөр /зөрөх/ зурагдсан байх тохиолдол үүсч болно. Энэ нь хилийн цэсийн шугамыг анх зураглахдаа 1968 оны 1:100000-ны масштабтай байр зүйн зургийг ашиглан зурагласан нь нарийвчлал болон масштабын хувьд зөрүүтэй байдлаас шалтгаалж үүссэн механик алдаа юм. Энэ тохиолдолд Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгээр хүсэлтээ гаргаж шийдвэрлүүлэх бөгөөд хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана. Үүнд:

а. Тухайн хилийн шугам нь газар дээрээ зөрж байгаа зөрүүг давхардуулан харуулсан 1:100000-ны масштабтай байр зүйн зураг болон агаар, сансрын зураг;

б. Тухайн бүс нутаг дахь газар ашиглалтын мэдээл /нэгж талбар тус бүрийн эзэмшил, ашиглалт, өмчлөлийн талаарх мэдээлэл/;

4.1.3. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын асуудал хариуцсан мэргэжилтэн хүсэлтийг хянаж үзэн зөвхөн хилийн шугамд шаардлагатай засварыг оруулах төслийг боловсруулан тус байгууллагын “Даргын дэргэдэх зөвлөлийн хурал”-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

4.1.4. Хурлын шийдвэр гармагц газрын кадастрын мэдээллийн санд өөрчлөлтийг албан ёсоор оруулж хурлын шийдвэрийг холбогдох аймаг, нийслэл, сум, дүүргийн асуудал хариуцсан мэргэжилтэнд албан бичгээр хүргүүлнэ

4.2. Хилийн цэсийн эргэлтийн цэг, шугамыг хээрийн судалгаагаар хянаж шалгах.

4.2.1. Эргэлтийн цэгийг хээрийн хэмжилтээр тодруулах үед тухайн эргэлтийн цэгийн солбицлыг газрын байршил тодорхойлох /GPS/ багажны тусламжтайгаар тодорхойлно.

4.2.2. Эргэлтийн цэгийн солбицлыг газар дээр нь тулгах, шалгах явцад солбицол нь тухайн эргэлтийн цэгийг илэрхийлэх объектын төв цэгээс зөрөх тохиолдол үүсэх магадлалтай. Үүнийг анх эргэлтийн цэгийг солбицжуулах ажлын механик алдаа гэж үзнэ. Жишээ нь “Хараат уул” гэх эргэлтийн цэг нь тухайн уулын яг орой дээр биш /ойролцоогоор 10 метрээс 30 метрийн зайд/ бэлд заах. Энэ тохиолдолд хилийн цэсийн зарлиг, тогтоолд заасан нэрийг тодорхойлох объектын төв цэгээр /Хараат уулын оройгоор/ эргэлтийн цэгийг ойлгож үйл ажиллагаанд ашиглана.

4.2.3. Хилийн цэсийн шугам нь батлагдсан зарлиг, тогтоолд “...Голын баруун эргээр уруудаж, ...Уулыг хяраж, ...гудамжаар, ...машин замаар, ...морин замаар,жалгаар,жимээр” гэх зэрэг чиглэл зааснаас бусад тохиолдолд шулуун шугамаар холбогдоно.

ТАВ. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

5.1. Бодит маргааныг шийдвэрлэх санал боловсруулах

5.1.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг “Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг батлах, өөрчлөх асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ” гэж заасны дагуу хилийн цэсийн эргэлтийн цэгт зайлшгүй өөрчлөлт оруулах нь тогтоогдсон бодит маргааныг Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газар зохион байгуулалт хийж журам”-ын хоёрдугаар бүлэгт заасан үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

5.1.2. Хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх санал боловсруулахдаа дараах баримтыг бүрдүүлнэ.

Үүнд:

- Аймаг, нийслэлийн ИТХ-аас мэргэжлийн комисс байгуулсан шийдвэрийг хавсаргах;
- Маргааны шалтгааныг дэлгэрэнгүй тусгах;
- Газрын өмчлөл, эзэмшил, ашиглалтын судалгаа хийгдсэн байх;
- Ажлын хэсгийн дүгнэлт;
- Ажлын хэсгийн санал;
- Гарах шийдвэрийн төсөл /Эргэлтийн цэгийн нэрийг жагсаасан хүснэгтэн мэдээлэл байх ба цэг тус бүрийн солбицлыг хүснэгтэд харуулах/;
- Хавсралт материал /шаардлагатай гэж үзсэн материалыг хавсаргах/;
- Сум, дүүргийн ИТХ-аас аймаг, нийслэлийн засаг даргад уламжлах тухай тогтоол гарсан байх /эх хувиар/;
- Аймаг, нийслэлийн ИТХ-аас асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүсэлтийг уламжилсан тогтоол гарсан байх /эх хувиар/;
- Хилийн цэсийн тухайн үеийг харуулсан болон шинэчилсэн байдлыг харуулсан зураг /давхцуулсан байдлаар хуучин хилийг хар өнгөөр, шинэ хилийг улаан өнгөөр зураглаж хуучин хилийг улаан өнгөөр чагт тавьж тэмдэглэсэн байх/;
- Шинэчлэгдэх хилийн цэсийн нэрийг нарийвчлан тэмдэглэж бичих;
- Хоёр талын газар нутгийн ГНС-ийн талбайн хэмжээнд орж байгаа өөрчлөлтийг ангилал тус бүрээр нарийвчлан боловсруулж харьцуулан харуулсан хүснэгтийг хавсаргах /экспликаци/;

5.2. Бодит бус маргааныг шийдвэрлэх

5.2.1. Энэ зааврын 2.1.2.-т заасны дагуу ойлголтын зөрүүгээс үүссэн буюу хилийн цэсийн зарлиг, тогтоолд өөрчлөлт оруулах шаардлагагүйгээр олон нийтэд үнэн бодит мэдээллийг тайлбарлан таниулснаар шийдвэрлэгдэх маргааныг энэ зааврын 3.3 дахь хэсэгт заасан “Хилийн цэсийн мэдээллийн сан”-д үндэслэн нарийвчлан шалгаж холбогдох тайлбарыг өгнө.

5.2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлага, иргэд нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зарлиг, тогтоолыг хүлээн зөвшөөрөхгүй байх, дур мэдэн хилийн цэсийг өөрчлөх, тэлэх, хуваах зэрэг санал гаргаж маргалдаж байгаа нөхцөлд дараах байдлаар маргааныг тайлбарлан шийдвэрлэнэ.

а. Хууль, журмын дагуу тухайн орон нутгийн хилийн цэсийг боловсруулах, батлах ажлыг анх Улсын хэмжээнд “Аж ахуй хоорондын газар зохион байгуулалтын ажил”-аар боловсруулсан байдаг бөгөөд үүнээс хойш хилийн цэсийн өөрчлөлт, тодотголын ажлыг тодорхой шаардлага, судалгаанд үндэслэн орон нутгийн удирдлага, газар нутгаа сайтар мэдэх иргэдийн төлөөлөлтэй хамтран шинэчилж тухайн үеийн Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолоор баталгаажуулсан байдаг. Тухайн хилийн цэсийг шинэчилсэн зарлиг, тогтоол гарахдаа өмнөх онуудын шийдвэрийг хүчингүй болгож баталсан байдаг тул хуулийн дагуу хамгийн сүүлд батлагдсан буюу одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тогтоол, зарлигийг мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

5.2.3. Нэгж талбар болон өвөлжөө, хаваржааны доорх газар, худаг уст цэг гэх мэт газар нь бусдын нутаг дэвсгэрт байрласан болон хилийн цэсийг дамнан байрласан эсхүл тухайн объектууд дээр хоёр талаас гэрчилгээ олгосон зэрэг маргаан үүсгэсэн нөхцөлд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж тайлбар хүргүүлнэ.

а. Маргаантай байгаа бүс нутагт байрлах тодорхой газар ашиглалтын байршил болон бусад объектуудын солбицлыг хилийн цэсийн мэдээллийн санд шалгаж хилийн гадна болон дотор талд эсхүл дамнан байрлаж байгааг нарийвчлан шалгаж тодорхойлно.

б. Хэрэв тухайн нэгж талбар, өвөлжөө, хаваржааны доорх газар нь бусдын нутаг дэвсгэрт бүрэн оршиж байвал малчид, иргэдэд үнэн зөв мэдээллийг хүргэх бөгөөд зөвшилцөх, ойлголцох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл тухайн малчид, иргэдийг хөөх, тухайн орон нутагт шилжиж ирэхийг шаардахь, татвар, төлбөр ногдуулах зэрэг амьдралын хэв маягт нь шууд болон шууд бусаар нөлөөлөхийг хориглоно.

- в. Тухайн нэгж талбар нь хилийн шугамыг дамнан байрласан тохиолдолд топологийн аргаар хянан үзэж шийдвэрлэх бөгөөд топологийн алдаа нь 10 см-аас доош бол програм хангамжаар шийднэ. Харин 10 см-аас дээш бол тухайн хилийн цэсийн шугамаар зааглаж тус бүрийн харьяалагдах нутаг дэвсгэрт хамруулан шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд хилийн цэсийн эргэлтийн цэгийг энэ зааврын 4.2 дахь заалтын дагуу хилийн шугамыг үүсгэж буй эргэлтийн цэгүүдийг нарийвчлан тодорхойлсон байна. Энэ нь уг маргааныг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй.
- г. Хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийг анх тодорхойлохдоо байгалийн болон хүний гараар бий болсон хөдөлшгүй объектууд /худаг, булаг, шанд, уулын орой, тоот өндөрлөг гэх мэт/-аар тодорхойлсон байдаг тул хилийн цэсийн эргэлтийн цэгийг илэрхийлж буй зөвхөн худаг, уст цэгээс үүссэн маргаануудад талууд ижил тэнцүү эрх, үүрэгтэй.
- 5.2.4. Хилийн цэсийн шугамаас хоёр тийш 3-аас 5 км доторх зайг “Хилийн цэсийн бүс нутаг” гэж үзэх бөгөөд тус бүс нутагт уламжлалт аргаар мал маллаж буй иргэдийн зөвхөн мал бэлчээрлэх, худаг, уст цэг ашиглах эрх нь орон нутгийн хилийн цэсээр хязгаарлагдахгүй бөгөөд тус бүс нутагт талуудын санаачлагаар гурвалсан гэрээ байгуулж бэлчээр, худаг, уст цэгийг тохиролцон ашиглаж болно.
- 5.2.5. Хэрэв тус зааврын дагуу бодит бус маргааныг шийдвэрлэх явцад маргалдагч талууд гарсан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдолд албан бичгээр газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандаж асуудалд тодруулга авч болно.

ЗУРГАА. ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ

- 6.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь хилийн цэсийн маргаан үүссэн бүс нутагт энэхүү зааврыг мөрдлөг болгон ажиллаж иргэд, олон нийтийг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.
- 6.2. Маргааны бүртгэлийг тухай бүрт нь хөтөлж нэгдсэн дүгнэлтийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 11 сарын 15-ны дотор хүргүүлнэ.
- 6.3. Хилийн цэсийн маргаантай холбоотой үүсэх зардлыг холбогдох талууд бүрэн хариуцна.
- 6.4. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын хэмжээний хилийн цэсийн мэдээллийн санг хөтөлж жил бүр хяналт, шалгалтыг гүйцэтгэнэ.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

- 7.1. Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан албан ёсны хилийн цэсийн мэдээлэл /эргэлтийн цэг, хилийн шугам/-ийг дур мэдэн өөрчлөх, засварлахыг хатуу хориглоно.
- 7.2. Хэрэв хилийн цэсийн эргэлтийн цэг болон шугаман мэдээлэлд өөрчлөлт оруулан засварлах, дагаж мөрдөхгүй байхыг иргэд, олон нийтэд уриалах зэрэг буруу мэдээллээр хангасан тохиолдолд Газрын тухай хуулийн 63 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 7.3. Хуулийн дагуу Улсын Их Хурлаас шийдвэрлэгдэж өөрчлөлт орсон хилийн цэсийн өөрчлөлтийг Газрын тухай хуулийн 8.4 -т заасны дагуу журмаар зохицуулна.

- оОо -

“Хилийн цэсийн маргаан шийдвэрлэх заавар”-ын хавсралт

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн маргааны бүртгэл

.....аймаг, нийслэлсум, дүүрэг

№	Багийн нэр	Маргалдаж буй аймаг, сум	Маргаан үүсэх шалтгаан /товч утга/	Өргөдөл, гомдол гаргасан этгээд	Хавсаргасан материал	Маргаан бүртгэсэн он сар өдөр	Маргаан бүртгүүлсэн хүний гарын үсэг
1							
2							
3							
4							
5							
6							

Бүртгэл хөтөлсөн:

Асуудал хариуцсан мэргэжилтэн /

"Хилийн цэсийн маргаан шийдвэрлэх заавар"-ын хавсралт

.....аймаг, нийслэлийн хэмжээнд үүссэн хилийн цэсийн маргааны бүртгэл

№	Сумын нэр	Маргалдаж буй аймаг, сум	Маргаан үүсэх шалтгаан /товч утга/	Суманд бүртгэгдсэн байдал	Хавсаргасан материал	Маргаан бүртгэсэн он сар өдөр	Тайлбар
1							
2							
3							
4							
5							
6							

Бүртгэл хөтөлсөн:

Асуудал хариуцсан мэргэжилтэн /

ХИЛИЙН ЦЭСИЙН ЗУРГИЙГ ХАДГАЛАХ, АШИГЛАХ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ТУСГАХ ЖУРАМ



Засгийн газрын тусгай
актын улсын нэгдсэн санд
2020 оны 02 сарын 06-ны
одрийн 469/ дугаарт бүртгэг.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг тус тус үндэслэн тусгах журам...

1. "Хилийн цэсийн зургийг хадгалах, ашиглах, тэдгээрт орсон өөрчлөлтийг тусгах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалаар батлагдсан журмыг иргэн, хуулийн этгээдэд сурталчлах, мэдээлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /Ц.Ганхүү/-т даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Гүнболд/-т даалгасугай.


Х.БАДЕЛХАН

151010020

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэс /цаашид “хилийн цэс” гэх/-ийн зургийг хадгалах, ашиглах, тэдгээрт орсон өөрчлөлтийг тусгах харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба” гэх), сумын Газрын даамлууд энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.
- 1.3. Хилийн цэсийг тогтоосон үндсэн бичиг баримт нь 1959 оны Аж ахуй хоорондын газар зохион байгуулалтын материалд суурьлан боловсруулсан 1977 оны Аж ахуй хоорондын газар зохион байгуулалтын үндсэн материал, калькан зураг, боть ном зэрэг иж бүрдэл байна.
- 1.4. Хилийн цэсийн тоон зургийн үндсэн материал нь “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн эргэлтийн цэгийг солбицолжуулах, баталгаажуулах ажил” гэрээт ажлын үр дүнд боловсруулсан хилийн цэсийн тоон хэлбэр, ажлын тайлангийн иж бүрдэл байна.
- 1.5. Хилийн цэсийн үндсэн материал нь Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төрийн архивт хадгалагдана.
- 1.6. Хилийн цэсийн зургийн үндсэн баталгаа нь хуулийн дагуу хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ардын Их Хурлын зарлиг, Улсын Их Хурлын тогтоол байх бөгөөд үнэн зөв зурагдсан эсэхийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.
- 1.7. Ардын Их Хурлын зарлиг, Улсын Их Хурлын тогтоол шийдвэрийн дагуу эрх бүхий байгууллагаас боловсруулсан хилийн цэсийн зураг нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн албан ёсны хил хязгаарыг илэрхийлэх үндсэн баримт бичиг болно.

Хоёр. Хилийн цэсийн зургийг хадгалах

- 2.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн зургийг Газрын тухай хуулийн 8.3 дугаар зүйлд заасны дагуу тухайн шатны засаг дарга хадгалах бөгөөд улсын хэмжээний иж бүрэн хувийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төрийн архивт хадгална.
- 2.2. Хилийн цэсийн зургийг хадгалахад Архивын ерөнхий газрын даргын 2007 оны 59 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”, 2009 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ыг тус тус мөрдөж ажиллана.

- 2.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг эрхлэх, орон нутгийн удирдлага, иргэд, олон нийтийг мэдээ, мэдээллээр хангах зорилгоор албан хэрэгцээнд Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал тус бүр цаасан болон тоон хэлбэрээр хадгална.
- 2.4. Хилийн цэсийн цаасан зургийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бэлтгэж, хэвлүүлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.
- 2.5. Хилийн цэсийн цаасан зураг нь дор дурдсан ерөнхий шаардлагыг хангасан байна.
 - 2.5.1. Хилийн цэсийн зураг нь Улсын хэмжээнд бүрхсэн дунд масштабын байрзүйн зурагт суурилсан байна.
 - 2.5.2. Ардын Их Хурлын зарлиг, Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан эргэлтийн цэгийг тус бүрт нь тэмдэглэж, нэршлийг харуулах бөгөөд цэгүүдийг шулуун болон нэршлийн дагуу холбож зурагласан байна.
 - 2.5.3. Хилийн цэсийн зургийн гарчиг нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн нэршлээр нэрлэгдсэн байна. /Жишээ нь: Төв аймгийн Лүн сумын хилийн цэсийн зураг/
 - 2.5.4. Өөрчлөлт оруулах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн зураг дээрх хуучин хилийн цэсийг хар өнгөөр, шинэчилсэн хилийн цэсийг улаан өнгөөр ялган тодорхой зурж, хүчингүй болсонд тооцох хилийн цэсийг улаан өнгөөр чагт тавьж зураглана.
 - 2.5.5. Хилийн цэсийн эргэлтийн цэгийг баруун хойт талын цэгээс эхлэн цагийн зүүний дагуу нар зөв тойруулан зөвхөн газар усны нэр, газрын өндрийн тэмдэгтийн тоот зэргээр тэмдэглэсэн уул, даваа, толгодын нэр болон усны түвшний өндөрлөгийн ард байгаа тоотыг хаалтад бичсэн, өндөрлөг нь нэргүй бол тухайн тоотоор тэмдэглэж зураглана.
 - 2.5.6. Таних тэмдэгт хилийн цэсийн эргэлтийн цэг, хилийн шугам, хил залгаа сумдын нэршил байх бөгөөд тайлбар хэсэгт тухайн хилийн цэсийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ардын Их Хурлын зарлиг, Улсын Их Хурлын тогтоол шийдвэрийн он, сар, дугаарыг тэмдэглэнэ.
 - 2.5.7. Тухайн нэгжтэй хил залгаж буй аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн эхлэл, төгсгөл хэсгийг кирилл үсгээр /А-Б/ тэмдэглэж таних тэмдэгт нэг бүрчлэн бичнэ.

Гурав. Хилийн цэсийн зургийг ашиглах

- 3.1. Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолын дагуу хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон өөрчлөлт орж шинэчлэгдсэн хилийн цэсийг төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд ашиглана.
- 3.2. Хилийн цэсийн зураг нь иргэд, олон нийтэд нээлттэй байх бөгөөд Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын Газрын даамал нь орон нутгийн удирдлага болон иргэд, олон нийтийг үнэн зөв, бодит мэдээллээр цаг тухайд хангаж ажиллана.
- 3.3. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамал нь хээрийн хэмжилт тодруулалтын ажил, маргаан шийдвэрлэх зорилгоор хилийн цэсийн цаасан зургийг бэлтгэж үйл ажиллагаандаа ашиглаж болох бөгөөд энэ журмын 2.5-т заасан ерөнхий шаардлагыг хангасан байна.

Дөрөв. Хилийн цэсэд орсон өөрчлөлтийг зураглах

- 4.1. Зарлиг, тогтоолын дагуу хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хилийн цэсэд дараах шийдвэр гарсан тохиолдолд өөрчлөлтийг оруулна. Үүнд:
 - 4.1.1. Холбогдох хууль, журмын дагуу хилийн цэсийг өөрчлөх, шинэчлэх, тодотгох талаар Улсын Их Хурлаас тогтоол гарсан тохиолдолд;
 - 4.1.2. Хилийн цэс нь архивын баримт бичиг болон хээрийн хэмжилт тодруулалтын ажлын үр дүнд зөвхөн алдаатай зураглагдсан нь нотлогдож Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас шийдвэрлэсэн эсхүл эрх бүхий ажлын хэсгийн шийдвэр гарсан тохиолдолд;
- 4.2. Хилийн цэсийн өөрчлөлт, оруулах, тодотгох ажлыг Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхэлнэ.
- 4.3. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хилийн цэсийн мэдээллийн санг боловсруулан хөтлөж өөрчлөлт, бүртгэл, мэдээллийг эрхлэх бөгөөд аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.
- 4.4. Хилийн цэсийн мэдээллийн сан нь “Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний цахим систем” -д суурилах бөгөөд системийн үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан асуудлыг “Газар зохион байгуулалтын цахим систем хөтлөх журам”-аар шийдвэрлэнэ.

- 4.5. Хилийн цэсэд өөрчлөлт оруулах шийдвэрийг үндэслэн Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шинэчлэн зураглаж холбогдох аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт хүргүүлнэ.
- 4.6. Өөрчлөлт орж хүчингүй болсон хилийн цэсийн цаасан зургийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь албан бичгээр Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 30 хоногийн дотор ирүүлнэ.
- 4.7. Хүчингүй болсон хилийн цэсийн цаасан зургийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээн авч тайлбар мэдээллийг тэмдэглэн архивт хүлээлгэн өгч хадгалуулна.

Тав. Бусад

- 5.1. Улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн мэдээллийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаал, шийдвэрийн дагуу 10 жил тутам аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба зохион байгуулан хянаж, шалгах ажлыг гүйцэтгэнэ.
- 5.2. Хилийн цэсийн мэдээллийг хянаж, шалгах ажлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэнэ.
- 5.3. Хилийн цэсийн тогтоосон эрх зүйн баримт бичгийг иргэд, хуулийн этгээд үндэслэлгүйгээр маргаан үүсгэх, дагаж мөрдөхгүй байх, олон нийтэд худал ташаа мэдээлэл хүргэж үймээн, маргаан үүсгэхийг хориглоно.
- 5.4. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

-оОо-